**АМИН I.** vital, mortal, ~ **бодис** (~ **дэм**) vitamin, ~ **газар** (~ **гол газар**) fatal spot, mortal spot, ~ **гол** aorta; vital, mortal, ~ **голоос хайртай** terribly in love, ~ **зуулга** (see **амь зуулга**), ~ **сүнс** soul, ~ **холбоотой** (~ **хүйн холбоотой**) intimately connected, ~ **чухал** vital, ~ **чухал хэсэг** vital part, vital spot, ~ **чухал эрх** ашиг vital interests

**АМИН II.** own, personal, **аминд өгөх** (**аминд тараах**) to privatize (collectivized livestock, etc.), ~ **хувийн** private, personal, ~ **хувьдаа** for oneself, to oneself, § **аминд маань хэдэн төгрөг байдаг** we have a bit of money of our own, **эднийх** ~ **цөөвтр** **богтой юм** they had just a few small livestock of their own

**АМИНДАЙ** namesake

**АМИНДЭМ** vitamin

**АМИНЗҮЙ** biology

**АМИНЗҮЙН** biological

**АМИН ХҮЧИЛ** (see **хүчил**), **үл орлогдох** ~ essential amino acids

**АМИНЦАР** selfish, egoistic, self-centred

**АМИНЧ 1.** selfish, egoistic, self-centered **2.** private, ~ **дотноор** privately, confidentially

**АМИНЧИР** (see **аминцар**)

**АМИНЧИРХАХ** to be selfish, to act selfishly

**АМИНЧИРХУУ** (see **аминцар**)

**АМИНЧЛАН** confidentially, on the quiet

**АМИНЧЛАХ ЁС** animism

**АМИНЧХАН** **1.** private, intimate **2.** selfish, ego-centric, ~ үзэл egoism

**АМИНЫ** own, private, personal, ~ **ашиг сонирхол** private interests, ~ **мал** personal cattle, ~ **өмч** private property, ~ **өмчний мал** personal cattle, ~ **хэрэг** private business, ~ **эд хөрөнгө** private property

**АМЛАЛТ** promise, ~ **үүрэг** agreed task, promised task, **амлалтанд хүрэх** to keep one's promise

**АМЛАХ** **I.** to promise, to pledge, **хоосон** ~ to make an empty promise, **амласандаа хүрэх** to fulfil one's promise, to keep one's word

**АМЛАХ II.** to begin to suck (newborn child or beast)

**АМЛАХ III.** to form an opening or mouth in something

**АМЛАХ IV.** to take on, to challenge (wrestling, etc.)

**АММЕТР** square metre

**АМОЙ** is, are, was, were

**АМРААХ** **1.** to rest (*trans.*), **нүдээ** ~ to rest one's eyes **2.** to leave in peace

**АМРАГ** **1.** lover **2.** dear, beloved, ~ **сэтгэл** love, ~ **сэтгэлтэн** lover, **амрагийн явдал** affair

**АМРАГЛАЛЦАХ** to be in love, to love one another

**АМРАГЛАХ** to love

**АМРАГЛАХУЙ** love, loving

**АМРАГЧ** holiday-maker

**АМРАЛТ** **1.** rest, **амралтын цаг** rest period, **амралтын үе** free time **2.** holiday, **цалинтай** ~ holiday with pay, **амралтын газар** holiday home

**АМРАЛТТАЙ** on holiday, on leave

**АМРАХ** **1.** to rest, ~ **байр** rest-room **2.** to be on holiday, to have a holiday

**АМРУУ** pustular dermatitis (*also* **дардан**, **шөвөг яр**, see **сувдлаа**)

**АМРУУЛАХ** to rest, to relieve, to give a rest (to), **морио** ~ to rest one's horse

**АМРУУТАХ** to suffer from pustular dermatitis

**АМСАР** **1.** mouth, opening **2.** stigma (*bot.*) **3.** stoma (*bot.*)

**АМСАРЦАХ** to take by the rim

**АМСАРЛАХ** to form a mouth or rim

**АМСАХ** **1.** to taste **2.** (**амсаж эдлэх**) to experience, to enjoy, to suffer

**АМСУУРГА ТӨДИЙ** just a morsel, just a trifle, a snippet, ~ **мах** a mere bite of meat

**АМСХИЙЛТ** rest, breather

**АМСХИЙХ** to have a rest, to take a breather, **сэтгэл** ~ to feel relieved

**АМТ** taste, flavour, ~ **авах** (**амтанд болох**) to get a taste for, **амтыг засах** to flavour, **саахар нэмж амтыг засна** add sugar to taste, ~ **оруулах** to flavour, to give a taste (to), ~ **оруулагч** (~ **оруулагч бараа**) flavouring, ~ **сонирхол** taste, interest, ~ **сонирхол төрүүлэх** to awaken an interest, ~ **шимт** taste, ~ **шимтгүй** tasteless, with no flavour, ~ **шимт сайтай** (~ **шимтгэй**) tasty, nice-tasting, delicious, § **хүүхдийг уран зохиолын ~ шимтэнд гүнзгий оруулах** to give the children a profound taste for literature

**АМТАГДАХ** to taste (*intrans.*), to taste of, **гашуун амт** ~ to taste bitter, to have a bitter taste, **мод** ~ to taste of wood

**АМТАЙ** gossipy, talkative

**АМТАРХАГ** tasty

**АМТАРХАХ** to enjoy, to relish, **амтархан идэх** to eat with relish

**АМТАТ** sweet, tasty, ~ **идээ** sweets, ~ **ундаа** (~ **уц**) soft drink

**АМТГҮЙ** tasteless, insipid

**АМТЛАГ** tasty, nice-tasting, sweet, ~ **чанар** flavour

**АМТЛАГЧ** flavouring, spice

**АМТЛАХ** **1.** to taste, ~ **эрхтэн** organs of taste **2.** to flavour, to sweeten, **элсэн чихрээр** ~ to sweeten with granulated sugar, ~ **зүйл** flavouring

**АМТЛУУР** seasoning

**АМТТАЙ** **1.** tasty, with a taste **2.** sweet

**АМТТАН** sweetmeat

**АМТШИХ** to get a taste for, to develop a liking for, **шанд** ~ to get keen on rewards, **амтшсан хэрээ арван гурав эргэнэ** the more you have the more you want

**АМУУ** (~ **будaa**, ~ **тариа**) grain, corn, cereal, **монгол** ~ millet

**АМУУНЫ** grain, cereal (*adj.*)

**АМЬ** life, ~ **аврах** to save (someone's) life, ~ **авар** help!, ~ **алдах** to lose one's life, **амиа аргалах** (**амиа аргацаах**) to get by, ~ **бие** life, person, ~ **биеэ даатгуулах** to insure one's life, ~ **биеэ хайрлалгүй** (~ **бие хайргүй**) regardless of life



and limb, **амин бодис** vitamin, **амиа бодох** to think of one's own interests, to be self-centred, ~ **бөхтэй** tenacious of life, robust, ~ **бөхтэй орших** to be in fine fettle, ~ **бусниулах** (~ **насыг бусниулах**, ~ **бүрэлгэх**) to kill, to murder, ~ **гарах** to escape with one's life; to die, ~ **мэнд гарах** to escape with one's life, **амины гарз** loss of life, ~ **голтой алиа**, ~ **дүйх** (~ **дүйцэх**) to risk one's life, ~ **дүйсэн тулалдаан** a desperate fight, ~ **дүйн тэмцэх** to engage in a desperate struggle, ~ **зайлах** to get away, to escape with one's life, ~ **зогоох** to scrape a living, to survive, **амиа золих** (~ **биеэ золих**) to give one's life, to sacrifice one's life, ~ **зулбах** (~ **зулбан зугадах**) to flee, to run for one's life, ~ **зуулга** livelihood, means of living, ~ **зуух** to get a living, ~ **наана там цаана** in a flap, rattled, in a state, ~ **нас** life, ~ **нас аврах** to save someone's life, ~ **насаа алдах** (~ **нас эндэх**) to lose one's life, ~ **насыг бусниулах** (~ **насыг бүрэлгэх**, ~ **нас хохирох**, ~ **нас хөнөөх**) to kill, ~ **насыг даах** to prolong (someone's) life (*Buddh.*), ~ **нэгтэй** close, intimate, ~ **нэхэх** to demand recompense for a killing, ~ **орох** to be restored to life, **аминд орох** to save someone's life, ~ **оруулах** to put life into, to restore to life, **аминд өгөх** (**аминд тараах**) to privatize (collectivized livestock, etc.), **аминд өлзийтэй** healthy, advisable, good for one, ~ **өнгөрөх** to die, **амиа өргөх** to devote one's life (to), **эх орны төлөө амиа өргөх** to devote one's life to one's country, ~ **өрөөстэй** desperate, fraught with danger, ~ **өрөх** to risk one's life, ~ **өрсөх** to fight for one's life, ~ **өршөөх** to relieve, ~ **судлагч** biologist, ~ **судлал** (*see* **амьсудлал**), ~ **сүйдэх** to lose one's life, ~ **сүнс** soul, spirit, ~ **тавих** to make great efforts, to struggle hard; to die, ~ **таслах** to slaughter, ~ **тасрах** to die, **амиа тэжээх** to get a living, ~ **тэмцэх** to choke, to fight for breath; to struggle for dear life, **амиа тээх** to make one's living, to survive, ~ **улжих** to subsist, to scrape a living, ~ **уучлахыг гуйх** to appeal for clemency (*jur.*), ~ **үлдэх** to survive, ~ **үнэнч авгай худалч** every man for himself and the devil take the hindmost, ~ **үрэгдүүлэх** (~ **үрэх**) to destroy, to do to death, ~ **үрэгдэх** to lose one's life, ~ **хайргүй** regardless of one's life, selflessly, for dear life, **амиа хичээх** to look after one's own interests, ~ **хоргодох** to run for cover, to take shelter, ~ **хорлох** to kill, **амиа хорлох** (**амиа хороох**) to kill oneself, to commit suicide, **хүний** ~ **хорлох** to kill someone, **хүний** ~ **хорлогч** killer, murderer, **амийг хороох** to put to death, **амийг хохироох** to kill, to murder, ~ **хохирох** to lose one's life, ~ **хураах** to die, ~ **хүн** private individual, **аминд хүрэх** (~ **насанд хүрэх**) to kill, to be the death of, ~ **хэлтрэх** to be relieved, **амины хэрэг** fatality, case of murder, ~ **эрсдэх**

to lose one's life

**АМЬГҮЙ** inanimate, lifeless, ~ **төрсөн** stillborn

**АМЬД** alive, live, living, ~ **байгаа** alive, ~ **булах** to bury alive, ~ **гарах** to escape with one's life, ~ **ертөнч** the living world, ~ **жин** (*see* **жин 1.1.**), ~ **мэнд** living, alive, ~ **мэнд байх** to be alive, ~ **мэнд гарах** to escape with one's life, ~ **сэрүүн** living, alive, ~ **сэрүүндээ** in one's lifetime, when alive, ~ **ус** running water, ~ **үлдэх** to survive, ~ **хүн аргатай** never say die, ~ **хүч** manpower (*mil.*) (*Russ.* живая сила), ~ **хэл** (*see* **хэл 2. 5.**) ~ **явах** to live, to stay alive, ~ **явбал алтан аяганаас ус ууна** while there's life there's hope

**АМЬДААР** alive, ~ **барих** to take alive, to capture alive

**АМЬДАЙ** namesake

**АМЬДЛАГ** living

**АМЬДРАЛ** (~ **ахуй**) life, **амьдралаар дорой** poorly off, ~ **залгах** to get one's living, ~ **зүй** ecology, **амьдралын мөнх бусыг үзүүлэх** to pass away, **амьдралын мөрөө хөөх** to go one's own way in life, **амьдралын орчин** habitat, ~ **хангах систем** life support system

**АМЬДРАХ** to live, ~ **орчин** habitat (*nat. hist.*), ~ **чадвар** viability, ~ **чадвартай** viable

**АМЬДРУУЛАХ** to revive, to bring back to life, to put life into

**АМЬДЧИЛАЛ** personification (*liter., etc.*)

**АМЬДЧИЛАХ** to personify

**АМЬЖИРГАА** living, livelihood, **амьжиргааны өртөг** cost of living, **амьжиргааны түвшин** standard of living, **амьжиргааны хэрэгцээнд нэвтрэх** to become part of everyday life

**АМЬЖИРЛАГА** living, livelihood

**АМЬЖРАЛ** livelihood, wherewithal

**АМЬСАХ** to be in agreement, to be at one

**АМЬСГАА** breath, **битүү** ~ circular breathing (*in flute-playing*), ~ **авах** to breathe in, to take a breath, to get one's breath, **амьсгаагаа барих** to hold one's breath, ~ **давчдах** (~ **давчдах**) to feel suffocated, to have constricted breathing, **амьсгаагаа дарах** to hold one's breath, ~ **дээрдэх** (~ **нь дээгүүр байх**) to gasp, ~ **орох** to get one's breath, **амьсгаагаа татах** (~ **түгжих**) to hold one's breath, ~ **хураах** to breathe one's last, to die; to hold one's breath

**АМЬСГААДАХ** to pant, to breathe heavily

**АМЬСГААДУУХАН** a bit out of breath

**АМЬСГААЛАХ** to breathe deeply, to breathe slowly

**АМЬСГАЛ 1.** breath, breathing, **гүн** ~ deep breathing, **зохиомол** ~ artificial respiration, **өнгөц** ~ shallow breathing, **амьсгалаа барих** to hold one's breath, ~ **боогдох** (~ **бүтэх**) to suffocate, to be unable to breathe, ~ **боогдуулагч** asphyxiant, **амьсгалаас бусдыг нь бүрэн ашиглах** to make use of everything but the breath (livestock, marmot, etc.), ~ **давхцах** to be short of breath, to be out of breath, to pant, **амьсгалаа дарах** to hold one's breath, ~ **тасрах** to die, to breathe one's last, ~ **татах** to draw breath, **амьсгалын тоо гүйцэх** to have one's days numbered, **амьсгалаа түгжих** to hold one's breath, ~ **хураах** to breathe one's last, to die; to hold one's breath **2.** climate, **цагийн** ~ the current climate

**АМЬСГАЛАХ** to breathe, to respire, **өнгөц** ~ to breathe shallowly

**АМЬСГАЛУУЛАХ** to cause to breathe, **зохиомол амьсгалаар** ~ (**хиймлээр** ~) to give artificial respiration

**АМЬСГАЛУУР** spiracle (*anat.*)

**АМЬСГАЛЫН** respiratory, ~ **зам** respiratory tract, ~ **дээд зам** upper respiratory tract, ~ **эрхтэн** respiratory organs

**АМЬСУДЛАЛ** biology

**АМЬСУДЛАЛЫН** biological

**АМЬТАЙ** animate, living, ~ **голтой** alive

**АМЬТАН 1.** living creature, creature, ~ **хүн** people, other people **2.** animal, ~ **судлал** zoology, ~ **судлаач** zoologist, ~ **сургагч** animal trainer

**АМЬТНЫ** animal (*adj.*), ~ **аймаг** animal kingdom, ~ **гаралтай** of animal origin, ~ **хүрээлэн** (~ **цэцэрлэг**) zoological gardens, zoo

**АН I.** (~ **амьтан**, ~ **араатан**, ~ **гөрөөс**) game, beasts of the chase, **үслэг** ~ fur-bearing animals, ~ **ав** (~ **агнуур**, ~ **гөрөө**) hunting, ~ **авлагч** (~ **агнагч**) hunter, ~ **авлах** (~ **ав хийх**, ~ **агнах**, ~ **гөрөө авлах**, ~ **гөрөө агнах**, ~ **гөрөө хийх**, ~ **хийх**, **анд явах**) to hunt, to go hunting, ~ **агнах эрхийн тасалбар** hunting permit, **ангийн буу** hunting gun, **ангийн үс** furs

**АН II.** (~ **гав**, ~ **завсар**, ~ **цав**) crack, fissure, cleft, gap, ~ **цав суулгах** to cause a split (*polit.*, etc.), § ~ **цав сууж болно** cracks may occur

**АНААШ** Giraffe

**АНАГ** gorge, ravine, V-shaped valley

**АНАГААХ** to treat, to heal, to cure, ~ **ухаан** medicine (as a practice), **Анагаах Ухааны Дээд Сургууль** Medical College, **Анагаах Ухааны Хүрээлэн** Institute of Medicine (of the

Academy of Sciences)

**АНАЛИЗ** analysis, **чанарын** ~ qualitative analysis (*Russ.*)

**АНА МАНА** the same, to a draw, without either winning, ~ **тулалдах** to fight to a draw

**АНАР 1.** Pomegranate (*also* **Сэмбэрүү**) **2.** (~ **эрдэнэ**) garnet (*min.*), **төмөрт** ~ almandite (*min.*)

**АНАРХИ** (~ **байдал**) anarchy

**АНАХ I.1.** to go carefully **2.** to follow, to shadow

**АНАХ II.** to get better

**АНАХАЙ** evil spirit (*Bur.*)

**АНГААЛАХ** to take in a pincers movement, to intercept from both sides

**АНГААХАЙ** fledgling, nestling, **ангаахайг намар тоолох** to count one's chickens before they're hatched

**АНГАА ЦАНГАА** thirst

**АНГАГАР** wide open

**АНГАЙЛТ** gape, yawn

**АНГАЙЛТТАЙ** gaping, yawning

**АНГАЙХ** to gape, to open wide, **ам** ~ to gape, **амаа ангайгаад** with gaping mouth

**АНГАЛ** gap, fissure, opening, cleft, **хадны** ~ a cleft in the rocks

**АНГАЛЗАХ** to keep opening, **ам** ~ to gape, to keep opening the mouth

**АНГАЛЗУУР I.1.** *Lagochilus* (*bot.*), **Ямаан** ~ *L. ilicifolius* **2.** *Jurinea mongolica*

**АНГАЛЗУУР II.** fledgling, nestling

**АНГАМАЛ** (~ **цангамал**) arid, parched, ~ **газар** (~ **нутаг**) arid land, arid area

**АНГАР** hangar, shed (*Russ.*)

**АНГАРАГ** (~ **гариг**) Mars (*Skr.*)

**АНГАР АНГАР** opening and shutting

**АНГАРХАЙ** gap, crevice, opening

**АНГАС ХИЙХ** to keep opening and shutting

**АНГАХ** (**ам** ~, **ангаж цангах**) to be thirsty

**АНГИ I.i.** class (in general) **ii.** class (*polit.*), ~ **давхарга** (~ **давхраа**) class, stratum (of society)

**iii.** class (in school), **ахлах** ~ senior class(es), **бага** ~ bottom class(es), ~ **ахих** (~ **дэвших**) to go up, ~ **улирах** to be kept down, ~ **улируулах** to keep down; to stay down, ~ **хам** classmates

**iv.** class (*nat. hist.*), **доод** ~ sub-class **2.** (**цэргийн** ~) unit (*mil.*), ~ **нэгтгэлүүд** units and formations, ~ **салбар** units and sub-units **3.**

movement (*mus.*) **4.** clause (of an article, *зүйл*) (*jur.*) **5.** (~ **хэсэг**) part, component (*mech.*), **явах**

~ running gear **6.** separate

**АНГИГҮЙ** classless, ~ **нийгэм** classless society

**АНГИД** separate (from), apart (from)

**АНГИДМАЛ** specialized, specific

**АНГИЖРАХ 1.** (ангижран арилах, ангижран холдох) to get free (of), to get away (from)  
**2.** reduction (chem.)

**АНГИЖРУУЛАГЧ** reducing agent (chem.)

**АНГИЖРУУЛАХ 1.** (ангижруулан холдуулах) to free (from), to make independent (of), to separate (from), to dissociate (from), муу зуршлаас ~ to break (someone) of a bad habit **2.** to reduce (chem.)

**АНГИЙН** class (adj.), ~ аялгуу cant, jargon, ~ дайсан class enemy, ~ тэмцэл class struggle, ~ явцуу ашиг сонирхол narrow class interests

**АНГИЛАЛ 1.** classification, categorization, ~ зүй (see ангилалзүй) **2.** class, group, насны ~ age-group, § тухайн ангиллын тээврийн хэрэгслийг жолоодох эрхийн үнэмлэх licence to drive a vehicle of the group concerned

**АНГИЛАЛЗҮЙ** taxonomy, systematics

**АНГИЛАЛТ** classification

**АНГИЛАХ 1.** to classify, to sort out, to divide up, ангилан ялгалт classification, ангилан ялгах to classify **2.** (ангилан хадах, ангилан хураах) to harvest in two stages, ангилан хураалт (see хураалт)

**АНГИНА** tonsillitis

**АНГИНАТАХ** to have tonsillitis

**АНГИР** Ruddy Shelduck, *Tadorna ferruginea* (also Лам шувуу), ~ шар reddish yellow, ~ шар уураг mother's first milk

**АНГИТ** class (adj.), ~ нийгэм class society

**АНГИЧ** class (adj.), пролетарийн ~ үзэл proletarian class attitude, § нийгмийн өмч хөрөнгөнд социалист ёсоор хандах ~ байр суурь a class basis for a socialist approach to public property

**АНГЛИ** England

**АНГЛИЙН** English

**АНГУУЧИН** hunter

**АНГУУЧЛАХ** to go hunting

**АНД** (~ найз, ~ нөхөр) sworn brother, friend, mate, ~ нөхөрлөл close friendship

**АНДАГАР** big-buttocked, fat-tailed

**АНДАЛЦАХ** to become sworn brothers, to become close friends

**АНДАР** tray for drying ааруул

**АНДАХ** to be mistaken, to make a mistake, to err, андахаа байх to know perfectly well, § хэн эс ~ билээ everybody knows

**АНДАХГҮЙ** (~ мэдэх) to know well, to make no mistake (about)

**АНДАШГҮЙ** unmistakable

**АНЦГАЙ** (~ тангарга) oath, ~ тавих to take an oath

**АНЦГАЙЛАХ** to take an oath, to swear

**АНДИС** (see анжис)

**АНДЛАХ** to become brothers, to become close friends

**АНДРАГА** throwing-piece in some anklebone games

**АНДУУ I.** wooden water vessel

**АНДУУ II.** (~ ташаа) wrong, mistaken, erroneous, in error

**АНДУУТҮЙ** without a mistake, unflinching

**АНДУУРАГДАХ** to be mistaken (for), § өөр эрдэс мэт ~ to be mistaken for another mineral

**АНДУУРАХ** to make a mistake, to err, to muddle up, to mistake (for), гэж ~ to mistake for, § би хүн андуураад ийм боллоо it happened because I mistook who it was, хэн нэгийг л надтай андуураад байна даа he must have mixed me up with someone else

**АНЖГАЙ** friend, mate

**АНЖИС** plough, анжисны хошуу (see хошуу 3.)

**АНЖИСЧИН** ploughman

**АНЗ** a fine (hist.), ~ торгох to fine, to impose a fine

**АНЗАА** size

**АНЗААРАГДАМ** noticeable

**АНЗААРАХ** to notice, to pay attention (to)

**АНЗААРГА** attention, ...талаар ~ тавих to turn one's attention to ...

**АНЗААРГАГҮЙ** slow to notice, unperceptive

**АН ЗАН** nature, characteristics, habits

**АНЗАН** molybdenum

**АНЗЛАХ** to fine (hist.), § дөрвөн есөөр анзлав fined him four "nines" (of livestock)

**АНИА** Uncle (a respectful term of address for an elder relative)

**АНИАСТАЙ** closed, shut

**АНИАТАЙ** (see аниастай)

**АНИВАЛЗАХ** to keep blinking

**АНИВХИЙЛЭХ** to blink

**АНИВЧААН** blinking (n.)

**АНИВЧИХ 1.** to blink, нүдийг ~ to blink the eyes **2.** to flash, to flash on and off, to flicker, to twinkle, анивчсан шар гэрэл дохио flashing amber light (traf.)

**АНИВЧУУЛАХ** to flash (*trans.*), **хөх гэрлээ** ~ to put on one's blue flashing light (*traf.*)

**АНИГНАХ** to keep blinking

**АНИГАР** narrow, ~ **нүд** slit eyes

**АНИЙЛГАХ** to screw up (the eyes), **нүдээ** ~ to screw up the eyes, to squint

**АНИЛЦАХ** (**нүд** ~) to be heavy eyed

**АНИР I.** noise, sound, ~ **гүм** silence, ~ **чимээгүй** (~ **тайван**) silent, silently, without a sound, ~ **чимээтэй** noisy, noisily

**АНИР II.** extraordinarily, extremely

**АНИРДАХ** to pick up (a sound)

**АНИРЛАХ** (see **анирдах**)

**АНИРТАХ** (see **анирдах**)

**АНИС** (see **Алирс**)

**АНИСХИЙХ** to blink (the eyes), **нүдээ** ~ to blink the eyes

**АНИХ 1.** to close (the eyes, etc.), **нүдээ аних** to close one's eyes **2.** to close over (wound, freezing water, etc.)

**АНКЕТ** form, questionnaire (*Russ.*)

**АНТЕНН** aerial (*Russ.*)

**АНУ** (*subject or topic indicator*)

**АНУУХАН** (~ **тэнхлүүн**) hale and hearty

**АНХ** first, for the first time, ~ **түрүүн** (~ **удаа**) initially, for the first time, **анхан шатны** primary, elementary, basic

**АНХААРАЛ** attention, **анхааралдаа авах** to take into account, to take into consideration, ~ **болгоомж** carefulness, ~ **сарниулах** to distract, to divert (someone's) attention, ~ **тавих** to pay attention, **анхааралыг татах** to attract (someone's) attention, **анхаарлын тэмдэг** exclamation mark, ~ **халамж** care and attention

**АНХААРАЛТАЙ** attentive, ~ **бай** pay attention!

**АНХААРАМЖ** attention, notice

**АНХААРАМЖТАЙ** attentive

**АНХААРАНГУЙ** attentive

**АНХААРАХ** to pay attention to, **анхааран тэмдэглэх** to observe, to note

**АНХААРУУЛАХ** to warn, ~ **гал нээх** to fire a warning shot

**АНХААРУУЛГА** warning, ~ **дохио** санамж warning signal, warning

**АНХААРУУШТАЙ** noteworthy

**АНХАНДАА** at first, to begin with

**АНХДАГЧ 1.** primary, ~ **ороомог** (see **ороомог**), ~ **үндэс** primary stem, root (*ling.*) **2.** the first

**АНХДУГААР** first, ~ **Жавсандамба** the first Jebisundamba, ~ **удаа** for the first time

**АНХИАГҮЙ** good for nothing, ne'er do well, shiftless

**АНХИА МУУТАЙ** (see **анхиагүй**)

**АНХИАТАЙ** diligent

**АНХИЛАМ** fragrant, ~ **үнэр** fragrance, ~ **үнэртэй** fragrant, ~ **сайхан үнэртэй цэцэг** sweet-smelling flowers

**АНХИЛАХ** to smell, to emit a scent

**АНХИЛГАНА** *Anthoxanthum* (*bot.*)

**АНХИЛМАЛ** (see **анхилуун**)

**АНХИЛ МУУТАЙ** (see **анхиа муутай**)

**АНХИЛУУН** fragrant, aromatic, ~ **үнэрт** aromatic (*chem.*, etc.), ~ **үнэртэн** perfume, scent

**АНХИЛ ЦЭВЭР** neat, tidy

**АНХЛАН** first, at the beginning

**АНХНЫ** first, primary, elementary, ~ **мэдэгдэхүүн** elementary knowledge, basic facts, ~ **төрмөл эрин** Palaeozoic era, ~ **тусламж** first aid, ~ **хайр** first love, ~ **хэрэг** first offence

**АНХНЫХ** the first, the first one, ~ **нь** the first of them

**АНЧ 1.** huntsman, skilled hunter **2.** hunting (*adj.*), ~ **бүргэд** hunting eagle, ~ **нохой** hunting dog

**АНЧИЛГА** hunting

**АНЧИН** hunter

**АНЧЛАГА** hunting

**АНЧЛАХ** to hunt, to go hunting

**АНЬС** (see **Алирс**)

**АНЬСГА** eyelid

**АППАРАТ 1.** apparatus, ~ **хэрэгсэл** apparatus, equipment **2.** camera, **тольт** ~ reflex camera, **ганц дурантай тольт** ~ single-lens reflex camera, **нарийн хальсны** ~ (**бага хэмжээний** ~) miniature camera **3.** (official) organ, **албан аппаратууд** official organs, official bodies (*Russ.*)

**АПТЕК 1.** pharmacy, chemist's **2.** medicine chest, first-aid kit

**АР 1.1.** back (*n.*) (*anat.*, etc.), **сандлын** ~ the back of a chair, **араараа алга болох** (**арын хаалгаар алга болох**) to go out the back way (goods sold illegitimately), ~ **гол** the middle of the back, ~ **нуруу** back, spine (*anat.*), **ардаа орхих** to leave behind one, to outdistance, ~ **өвөргүй** on both sides, **араар нь тавих** (**араар нь тавьж өврөөс нь гохдох**) to cheat, to deceive, to take in, ~ **хударгаар** behind, ~ **хударгаар нь** behind them, behind their backs; in its wake, § **хүүхнүүд** ~ **өвөрт минь гүйж байлаа** the girls used to run after me **2.** back,

rear, home, ~ араасаа one behind the other, ~ гэр home, цэргийн ~ гэр бүлийнхэн (цэргийн хүмүүсийн ~ гэр) troops' families, the families left behind, ~ гэрийнхэн family, family members, ~ дэвсгэр background (picture, etc.), ~ өврийн front and back, in front and behind, ~ өврийн хаалга string-pulling, ~ өврийн хаалга татах to pull strings, ~ тал back (of something); rear (*mil.*), ~ талын rear (*adj.*), ~ талын хаалга tail-gate (*auto.*), ~ тийшээ back, backwards, back home **3.** north, north side, уулын ~ north side of a mountain **4.** northern, north, Ар Богд (see богд), ~ газар the north, Mongolia, Ар Монгол (see Монгол)

АР II. pattern, lines

АРАА I. (том ~) molar, molar tooth, агт ~ wisdom tooth, бага ~ pre-molar, араагаа зуух (араандаа зуух) to have it in for, арааны шүлс асгаруулам mouth-watering, арааны шүлс нь гоожих to make one's mouth water **2.** cog-wheel, sprocket-wheel, gear-wheel, gear, хүнд ~ low ratio, хүнд ~ залгах to put into low ratio, араатай дугуй toothed wheel, cog-wheel, ~ залгах to put into gear, ~ салгах to put out of gear, ~ солих to change gear

АРААЖАВ (see радио)

АРААЛАХ to be in line, to stand in a row

АРААЛДАХ (see араалах)

АРААТАН carnivore, wild beast, ~ амьтан (~ гөрөөс) wild beasts, араатны дүрст урлаг animal style art, ~ маллагч animal tamer, ~ тоглуулагч performer with wild animals (circus, etc.)

АРАВ ten, аравны адаг долооны дорой the worst of the worst, арван нэгдүгээр eleventh, арван нэгдүгээр сар November, арван тавны цагдаа (see цагдаа), арваа төгсөх to finish the tenth class (at school), арван төрөлт decathlon, арван хар нүгэл the ten black sins (*Buddh.*), арван хоёр twelve, арван хоёр жил the years of the twelve-year animal cycle; a game of dominoes played especially at New Year, арван хоёр хуруу гэдэс (see гэдэс), арван хоёрдугаар twelfth, арван хоёрдугаар сар December, арван хуруу тэгш jack of all trades, арван хуруу шиг мэдэх to know like the back of one's hand, арван цагаан буян the ten white virtues (*Buddh.*)

АРАВГАНАХ to writhe, to wriggle

АРАВГАР (~ саравгар) ragged, untidy, dishevelled

АРАВДАХЬ tenth

АРАВДУГААР tenth, ~ сар October

АРАВЖИН (see равжин)

АРАВНАЙЛАХ (see равнайлах)

АРАВТ I. tens (*math.*), аравтны дэвсгэр ten jugrig note, аравтны мөнгө ten mungu coin **2.** unit of ten men (*mil.*) (*hist.*)

АРАВТНЫ (see аравтын)

АРАВТЫН decimal, ~ бутархай decimal fraction, ~ систем (~ тогтолцоо) decimal system

АРАВЧ back (of a chair, etc.), backboard, backcloth, орны ~ wall-hanging behind a bed, суудлын ~ back of a seat

АРАВЧЛАХ to shoulder, to carry on the back

АРАГ I. basket for collecting dried dung, ~ шээзгий dung-baskets **2.** (~ яс) skeleton, framework, цээжний ~ яс rib-cage

АРАГШ backwards, back

АРАГШАА (see арагш)

АРАГШЛАХ to go backwards, to retreat

АРАЙ rather, somewhat, a bit, ~ биш hardly, not quite, ~ голтой half dead, only just alive, ~ гэж (~ хийж, ~ чамай, ~ чарай, ~ чармайн, ~ чүү, ~ ядан) just about, only just, hardly, with difficulty, as best one can, ~ дөнгүүр a bit better, ~ л just about, almost, quite, not quite, ~ өөр a bit different, ~ ч hardly, § таныг эмнэлгээс гаргах арай болоогүй it is rather too early to discharge you from hospital

АРАЙТАЙ hardly, only just

АРАЙХАН just about, somehow or other, only just

АРАЛ I. island

АРАЛ II. (арлын гуя) shaft (of a cart)

АРАЛ III. buckle, бүсний ~ belt-buckle

АРАЛ IV. sturdiness, vigour

АРАЛЛАХ to buckle

АРАЛТАЙ sturdy, vigorous

АРАМ frame, framework (*Russ.* рама)

АРАМНАЙЛАХ (see равнайлах)

АРАНГА I. superfluous tooth (horse, etc.)

АРАНГА II. scourge, bane

АРАНГА III. tower

АРАНГА IV. burial place of a shaman

АРАНГАТАЙ baneful

АРАНГАТАХ to have a superfluous tooth, to suffer from superfluous teeth (horse, etc.)

АРАНГА ТӨМС name of a plant of the Lily Family, described variously as *Lilium tenuifolium* and *L. dahuricum*

АРАНДАГ bother, nuisance, trouble

АРАНЖИН pure, native (metal), ~ зэс native

copper

**АРАНЗ** pack (*mil.*)

**АРАНЗАЛ УЛААН** fiery red

**АРАНЗАЛ ЦЭЦЭГ** Phlox (*bot.*)

**АРАНШИН** nature, character (see **ааш**, **зан**, **төрх**) (*Tib. rang-bzhin*)

**АРАХ** to represent, to act for

**АРВААД** ten odd, ten or so, ~ **настай хүү** a boy of ten or so, ~ **хоногийн дараа** ten days or so later

**АРВААЛЖ** a poisonous arthropod found in the Transaltai Gobi

**АРВАГАНАХ** (see **аравганах**)

**АРВАЙ** Barley, *Hordeum*, **Ахар сорт** ~ *H. brevisubulatum* (also **Зурман сүүл**), **Халтар** ~ a species of barley used as a food

**АРВАЙЛГАХ** to spread (the fingers, etc.)

**АРВАЙХ** to be spread out

**АРВАЙХЭЭР** **1.** name of a legendary swift race-horse **2.** Arvaikheer (*p.n.*)

**АРВАЛЗАХ** to writhe, to wriggle

**АРВАН** unit of ten men (*mil.*) (*hist.*)

**АРВАСХИЙХ** to bristle (hair)

**АРВИ** abundance, plenty, ~ **гамтай** careful, sparing, ~ **нөөц** resources, reserves

**АРВИДАЛ** plenteousness

**АРВИДАХ** (see **арвижих**)

**АРВИЖИХ** to grow, to increase, to become more plentiful

**АРВИЖУУЛАЛТ** increase, enrichment

**АРВИЖУУЛАХ** to increase, to enrich, to multiply

**АРВИЛАХ** (**арвилан хэмнэх**) to use sparingly, to save, to economize on, **арвилан хэмнэлт** economy, frugality, **арвилан хэмнэлттэй** economical, frugal

**АРВИН** **1.** (~ **дарвин**) plentiful, abundant **2.** rich in

**АРВИТАЙ** **1.** plentiful, abundant, luxuriant **2.** economical, frugal

**АРВИТАХ** to increase, to multiply (*intrans.*)

**АРВИТГАХ** to increase, to multiply (*trans.*)

**АРВИЧ** (~ **гамч**, ~ **хямгач**) economical, thrifty

**АРВУУЛ** ten together, all ten

**АРГА** **1.** way, method, means, ~ **ажиллага** process, way of working, operation, **технологийн** ~ **ажиллага** technological process, ~ **алдах** (~ **алдрах**, ~ **барагдах**, ~ **барах**, **аргаа барах чаргаа гээх**) to be at one's wits' end, to

be at the end of one's tether, to be desperate, ~ **барил** (~ **дадлага**) practice, work methods, ~ **бололцоо** (~ **боломж**) ways and means, possibilities, ~ **буюу** inevitably, with no choice, ~ **дом** magic means, magic methods, magic, ~ **дүйтэй** skilful, ~ **дэг** method, practice, ~ **жор** recipe, ~ **зам** ways and means, paths, ~ **зүй** methodology, ~ **зүйн** methodological, ~ **зүйч** methodologist, ~ **маяг** way, mode, method, ~ **метод** method, ~ **мухардал** bafflement, frustration, ~ **оньс** knack, hang, ~ **оньсыг оло.** (~ **олох**) to get the knack of, to get the hang of, to manage, ~ **саам** pretext, way out, way round, ~ **саам хайх** to find a way round (something), ~ **саам хайж төлөхөөс зайлсхийх** to find an excuse not to pay, ~ **сүв** way, possibility, ~ **сүвэгчлэх** (~ **сүйхээлэх**) to find a way, to manage, ~ **сүйхээ** trick, ~ **тасраа** to be at one's wits' end, ~ **ухаан** method, practice, skill, ~ **хэлбэр** methods and forms, ~ **хэмжээ** steps, measures, ~ **хэмжээ авах** to take steps, ~ **хэрэглүүр** (~ **хэрэгсэл**) means, facility, ~ **чадвар** capabilities, ~ **чадалтай** capable, ~ **чарга** ways and means, ~ **ширэг** method, device, ruse, ~ **эв** knack, hang, ~ **эвийг олох** to get the hang of, ~ **явууллага** steps, measures, manoeuvres, ~ **ядах** to be desperate, to be at one's wits' end, to lack hope, ~ **ядсан** ~ a desperate measure **2.** (~ **бааш**, ~ **башир**, ~ **заль**) trick, ruse, cunning, ~ **бачиг** cunning, ~ **мэх** trick, ruse, cunning; throw, trick (in wrestling), **аргад орох** to get taken in, ~ **самбаа** scheme, stratagem **3.** male, major (*mus.*), solar (*cf.* **билиг**), ~ **билиг** male and female principles, complementary opposites, wisdom and method (*Buddh.*), yin and yang, ~ **билиг хослуулсан өнгө** paired male and female colours, **аргын тоолол** solar calendar, ~ **эгшиг** major, **соль** ~ **эгшиг** G major

**АРГААХ** to tan, ~ **бодис** tannin

**АРГАГҮЙ** **1.i.** inevitable, unavoidable, necessary, ~ **хамгаалалт** necessary defence (*jur.*), **аргагүйн эрхэнд** unavoidably, forced by circumstance **ii.** of course, § **энэ чинь** ~ naturally **2.** unable to, without the means of, **байх суухын** ~ **халуун** too hot for anything, ~ **байдал** an impossible situation, § **намар**, **хамар өмсөхөөс өвөл өмсөх** ~ **байна** they can be worn in autumn and spring, but no way in winter **3.** very, absolutely, ~ **зөв** absolutely right, too true

**АРГАГҮЙДЭХ** to be compelled (to), to have no other way than (to)

**АРГАДАНГУЙ** coaxing (*adj.*)

**АРГАДАХ** to coax, to cajole, to wheedle, to talk into, **аргадаж өхөөрдөх** to make up to, **аргадан хуурах** to inveigle, to trick

**АРГАЙ I.** ankle-bone of a large beast, **үхрийн**  
~ ankle-bone of an ox

**АРГАЙ II.** orthoclase feldspar

**АРГАЙ III.** concrete

**АРГАЛ I.** dried cow dung (as used for fuel),  
**үхрийн** ~ dried cowpats, ~ **түүх** to gather  
dung (for fuel)

**АРГАЛ II.** (see **Аргаль**)

**АРГАЛАХ** (**аргалж чаргалах**) to manage, to  
wangle, to fix, to contrive, § **чамайг албанаас**  
**аргалж үзнэ** I'll try and wangle you out of duty

**АРГАЛСХИЙХ** (see **аргалах**)

**АРГАЛЧИН** collector of dried dung (for fuel)

**АРГАЛ ШАРГАЛ** (see **шаргал**)

**АРГАЛШГҮЙ** unmanageable

**АРГАЛЫН УНД** *Zygophyllum Potaninii* (bot.)  
(see **Хотир**)

**АРГАЛЬ I.** (~ **угалз**) Wild Sheep, *Ovis ammon*  
**2.** female of the wild sheep (see **Угалз I.**)

**АРГАМАГ** thoroughbred, ~ **морь** a fine horse

**АРГАМЖ** rope, tether

**АРГАМЖАА** tether, **аргамжааны мод** tether-  
post

**АРГАМЖААТАЙ** tethered, moored

**АРГАМЖИХ** to tie up, to tether (a horse), to  
moor (a boat), to anchor (a trap)

**АРГАМЖЛАХ** to tie, to tether

**АРГАТАЙ I.** cunning, sly, resourceful **2.** fawn-  
ing, ingratiating

**АРГАХ I.** to get dry, to feel dry, **ам хатаж** ~ to  
have a dry mouth **2.** (**нүд** ~ ) to have a sharp  
pain in the eyes

**АРГАЦААХ** to manage, to get by, to make do,  
to make shift, to fix, to wangle, § **цай тамхийг**  
**яаж аргацааж байсныг дурдъя** let me tell  
how we managed for tea and tobacco

**АРГАЧЛАЛ** methods, methodology

**АРГАЧЛАХ** to do methodically

**АРГИЛ I.** big, large **2.** bass (mus.), ~ **хоолой**  
bass voice, bass

**АРГИЛАХ** (**аргилан хамгаалах, аргилан**  
**хямгадах**) to take care of, to look after

**АРГИХ** to age, to get senile

**АРГУЙ I.** Woundwort, *Stachys* **2.** *Gnaphalium*

**АРГУУ** dry, hard, stale

**АРГУУН** (see **аргуу**)

**АРД I.** people, the people, ~ **иргэд** citizens, ~  
**нийт** the public, the nation, ~ **нийтийн** gen-  
eral, public, nation-wide, ~ **олон** people, the  
public, ~ **түмэн** people, the masses

**АРД II.** behind, **ширээний** ~ behind the table,  
~ **минь** behind me

**АРДАА I.** behind, back home **2.** behind one,  
**ардаа орхих** to leave behind (in a race, etc.),  
§ **жаран жилийг** ~ **орхиж** won't see sixty  
again

**АРДАГ** (~ **ярдэг**) unbroken, fiery

**АРДАН** *Astragalus dahuricus* (bot.)

**АРДАЧ** popular, democratic, ~ **чанар** national  
character (Russ. **народность**)

**АРДЧИЛАЛ I.** democracy **2.** democratization

**АРДЧИЛАХ** to democratize

**АРДЧИЛСАН** democratic, ~ **ёс** democracy, ~  
**нам** Democratic Party (USA), ~ **төвлөн удирдах**  
**ёс** democratic centralism, ~ **улс** democratic  
country

**АРДЫН** people's, popular, democratic, folk  
(adj.), ~ **аман зохиол** popular oral literature, ~  
**ардчилсан орон** (~ **ардчилсан улс**) people's  
democracy, ~ **билэг** (~ **билэг зүй**) folklore, ~  
**билэг зүйч** folklorist, **Ардын Депутатуудын**  
**Хурал** (see **хурал**), ~ **дуу** folk-song, ~ **засаг** (~  
**засгийн газар**) people's government, **Ардын**  
**Их Хурал** (see **хурал 2.**), ~ **нөхөрлөл**  
(**нийгмийн хэв журмыг хамгаалах** ~  
**нөхөрлөл**) People's Associations (for defending  
public order), ~ **төлөөлөгч** people's assessor  
(jur.), ~ **үлгэр** folk-tale, folk-story, ~ **эмнэлэг**  
folk-medicine, ~ **эрхт** democratic

**АРЗ** a spirit twice distilled, a spirit distilled from  
**архи**, § **шимийн архийг нэрж архи**  
**гаргадаг**, **үүнийг** ~ **гэдэг** milk spirit is distilled  
and a spirit produced; this is called ~

**АРЗАЙЛГАХ I.** to roughen up **2.** (**арзайлган**  
**барзайлгах**) to let (the hair) bristle, to let (the  
hair) be shaggy

**АРЗАЙХ I.** (**арзайж барзайх, арзайн сарвайх,**  
**арзайж сарзайх, арзайн сэрийх**) to bristle, to  
be uneven, to stick out **2.** to feel shivery, to have  
gooseflesh

**АРЗАЛЗАХ** (see **арзганах**)

**АРЗАСХИЙХ** (see **арзайх**)

**АРЗГАЙ** rough, coarse, uneven, jagged

**АРЗГАНАХ I.** to teem, to swarm **2.** to get goose-  
flesh, to feel uneasy

**АРЗГАР I.** (~ **барзгар**) (see **арзгай**)

**АРЗГАР II.** Bur-Reed, *Sparganium*

**АРИВ** (see **арви**)

**АРИГ** fresh, pure, clear, ~ **нуур** freshwater lake,  
~ **цэнгэг ус** fresh water

**АРИГ ГАМГҮЙ** wasteful, uneconomical, careless

**АРИГ ГАМТАЙ** (**ариг хямгатай**) economical, careful

**АРИГЛАХ** to save, to spare

**АРИГТАЙ** economical, careful

**АРИГЧ** (~ **хямгач**) (see **аригтай**)

**АРИЛАЛТ** disappearance

**АРИЛАХ** **1.** to disappear, to vanish, to clear off, to make oneself scarce **2.** to be purified, **арилсан дотортой** carefree, indifferent, **арилсан орон** (see **тагшин**) **3.** to clear, to clear up (rain, etc.)

**АРИЛГАХ** to get rid of, to sweep away, to remove, to eliminate, to rub out, to clear (a reading, etc.)

**АРИЛД** sword (*Tib. ral-gri*)

**АРИЛЖАА I.** (~ **наймаа**) barter, trade

**АРИЛЖАА II.** change from one gait to another (horse)

**АРИЛЖААЛАХ** to trade, to deal in

**АРИЛЖААНЫ** commercial

**АРИЛЖИХ** to exchange, to change, to barter

**АРИЛШГҮЙ** irredeemable, indelible

**АРИУДАХ** to be purified

**АРИУЛАХ** to purify

**АРИУН I.** (~ **дагшин**, ~ **нандин**) pure, sacred, noble, holy, ~ **тансаг** lovely, ~ **тунгалаг** honest, noble; clear, ~ **цагаан** (~ **шудрага**) honest, noble, ~ **шүтээн** holy places **2.** clean, pure, ~ **цэврийн** hygienic, sanitary, ~ **цэврийн байдал** hygiene, cleanliness, ~ **цэврийн дүрэм** rules of hygiene, ~ **цэврийн нөхөрлөл** public health group (local first-aid and health organization), ~ **цэврийн өрөө** toilet, WC, ~ **цэврийн хэрэглэл** sanitary towel, ~ **цэврийн эргүүл** public health patrol (active in factories, co-operatives, state farms, etc.), ~ **цэвэр** hygiene, cleanliness, **хувийн** ~ **цэвэр** personal hygiene, ~ **цэвэрч** hygienic, ~ **цэвэрч байдал** hygiene

**АРИУСАЛ** cleansing, purification

**АРИУИСАХ** to get clean, to get pure

**АРИУСТАХ** to clean up, **сэтгэл** ~ to purify one's mind

**АРИУТГАГЧ** (~ **бодис**) disinfectant

**АРИУТГАЛ I.** (~ **устгал**, ~ **цэвэрлэгээ**) cleaning, disinfection, decontamination **2.** sterilization

**АРИУТГАХ** **1.** (**ариутган цэвэрлэх**) to clean up, to cleanse, to purify, to treat, to disinfect, **нүгэл хилэнцээ** ~ to purge one's sins, **сэтгэлээ** ~ to purify one's mind, ~ **орон** Purgatory **2.** (**ариутган шүүх**) to read or check copy for xylography, **ариутган шүүгч** copy reader

**АРИУХАН** pure

**АРЛАЛТ** backing (of a composite bow using sinews)

**АРЛАН ТАРЛАН** (see **тарлан**)

**АРЛАХ I.** to go along the north side (of something)

**АРЛАХ II.** to back, **зузаан банзаар** ~ to back with a thick board

**АРМАГ I.** (~ **тармаг**, ~ **таруу**) scattered, sparse, patchy, ~ **тармаг сахал** a sparse moustache, ~ **тармаг ургах** to grow patchily

**АРМАГ II.** framework (*Bur.*)

**АРМАТУР** steel framework (of a building) (*Russ.*)

**АРМАТУРЧИН** steel erector, spiderman

**АРМИ** army, **Монголын Ардын** ~ the Mongolian People's Army, **армийн генерал** General of the Army (*Russ.*)

**АРСАЙХ** (**арсайж барсайх**) to bristle, to go all over the place

**АРСАЛДАХ** to stick out in all directions

**АРСГАР** (~ **барсгар**, ~ **сарсгар**) rough, sticking out all over

**АРСЛАН** **1.** Lion **2.** title given to a champion wrestler

**АРСЛАН ЗААН** Mammoth, ~ **мод** Giant Sequoia

**АРСЛАН ТИВ** Ceylon (*hist.*)

**АРТАЙ** patterned, lined

**АРТАХ** to be lined, to be rippled

**АРТЕЛЬ** craft co-operative (*Russ.*)

**АРТЕРИ** (**артерийн судас**) artery, **артерийн цус** arterial blood (*Russ.*)

**АРТИЛЛЕРИ** artillery, **зенитийн** ~ anti-aircraft artillery, **артиллерийн цэрэг** gunners (*Russ.*)

**АРУУ ТАРУУ** sparse, dispersed, scattered

**АРУУХАН** **1.** sharp, bright, intelligent **2.** (**зүс** ~, **өнгө зүс** ~) attractive, good-looking

**АР-ҮР** Myrobalan (*bot.*)

**АРХАГ I.** big, huge, massive, ~ **зузаан биетэй** massive, hulking

**АРХАГ II. I.** (~ **хууч**) chronic illness, ~ **суусан** (~ **тогтсон**) chronic, chronically **2.** chronic, chronically, ~ **архичин** chronic alcoholic, ~ **өвчин** chronic illness, ~ **өвчтэй** chronically ill



**АРХАГШИЛ** chronicity

**АРХАГШИХ** to become chronic

**АРХАГШСАН** chronic, ~ **ялтан** hardened criminal

**АРХАД I.1.** Arhat, Buddhist saint, enlightened one **2.** apostle (Christian)

**АРХАД II.** leather sack for kumis

**АРХАЙХ** to be bulky, to be unwieldy, **архайж дархайх** to be in disorder, to be higgledy-piggledy

**АРХЕОЛОГЧ** archaeologist

**АРХИ** spirits, drink, strong drink, alcohol, **жимсний** ~ wine, fruit-wine, **сүүний** ~ (тоогооны ~, шимийн ~) spirits distilled from milk, **хар** ~ hard spirits, **цагаан** ~ vodka, ~ **дарс** drink, alcoholic beverage, **архины лүү** (архины хөнөг) heavy drinker, wine-bibber, ~ **нэрэх** to distil (milk) spirits, **архинд орох** to take to drink, ~ **өнгө** women and wine, ~ **савнаасаа бусдыг дийлнэ** drink gets the better of anyone but its bottle, **архины үе** the stage during distillation at which the second-best spirits are taken off, usually at three to six changes of water in the **жалавч** (see **охийн үе**), ~ **үйлдвэрлэгчид** moonshiners

**АРХИАГ** rough, broken (land)

**АРХИВ** archive (Russ.)

**АРХИВИЙН** archival, ~ **баримт бичиг** archival documents

**АРХИВЛАХ** to file

**АРХИВЧ** archivist

**АРХИГҮЙ** non-alcoholic, dry, § **баяр ёслол, хурим найр** ~ **хийх** to hold dry celebrations and wedding feasts

**АРХИДАЛТ** alcoholism

**АРХИДАХ** to drink, to booze, **архидан согтуурагч** drunkard, **архидан согтууралт** drunkenness, **архидан согтуурах** to get drunk, to be drunk, **архидан согтуурах явдал** drunkenness, alcoholism

**АРХИЛАГ** alcoholic, ~ **ундаа** alcoholic drink

**АРХИРАХ** to growl, to snarl

**АРХИТЕКТОР** architect (Russ.)

**АРХИЧ** drunkard, drinker, alcoholic, boozier, **архаг** ~ chronic alcoholic

**АРХИЧИН** (see **архич**)

**АРЦ** Juniper, *Juniperus*, *J. communis*, **Хонин** ~ *J. sabina*, *J. pseudosabina*, **Ямаан** ~ *J. sibirica*

**АРЦАЛДААН** (~ **маргаан**) quarrel, dispute

**АРЦАЛДАГЧ** opponent

**АРЦАЛДАХ** to quarrel, to wrangle

**АРЦАХ** (see **арцалдах**)

**АРЦАШГҮЙ** indisputable

**АРЧАА** self-reliance, resourcefulness, **арчаагаа алдах** to be unable to stand on one's own two feet, ~ **муутай** (see **арчаагүй**)

**АРЧААГҮЙ I.** helpless, weak **2.** (аминдаа ~) careless, feckless

**АРЧААГҮЙТЭХ** to be helpless

**АРЧААТАЙ** resourceful, **аминдаа** ~ independent, self-sufficient

**АРЧГАР** wrinkled, furrowed

**АРЧГҮЙ** (see **арчаагүй**)

**АРЧИЙХ** to be wrinkled, to be furrowed

**АРЧИЛГАА** care, looking-after, **малын** ~ **маллагаа** animal husbandry, **техникийн** ~ **үйлчилгээ** service (auto.), **усан** ~ hydrotherapy, ~ **сувилгаа** nursing, ~ **тордлого** care, cultivation

**АРЧИЛТ** wiping, rubbing

**АРЧИХ** to wipe, to wipe off, to rub, to rub up, to polish

**АРЧЛАХ** (арчлан сувилах, арчлан тордох) to look after, to take care of, **арчлан маллах** to care for (livestock), **арчлан хамгаалах** to protect, to look after, to care for, **арчлан хэрэглэх** to use with care

**АРШ** hermit (Skr.)

**АРШААН** holy water (Skr.)

**АРШААНТАХ** to have the pox

**АРШИЙН НУДАРГА** Cactus

**АРЬС I.** skin, **жинхэнэ** ~ dermis, **арьсан доорхи** subcutaneous, **арьсан доогуур** (арьсан дор) subcutaneously, ~ **нөхөх засал** skin-grafting, **арьсны өвчин** skin disease, **арьсны өнгөн хөрс** epidermis, ~ **өнгөний венерал**, ~ **өнгөний өвчин** venereal disease, ~ **өнгөний эмч** venereologist, ~ **судлал** dermatology, ~ **шир** skins and hides, ~ **яс болсон** nothing but skin and bones, § **ширд нэг наснаас дээш бол малын арьсыг оруулна; харин нэг наснаас дооших малынхыг арьс гэнэ** the skins of beasts more than one year old count as hides; those of beasts less than one year old are called skins **2.** (~ **өнгө**) race, **арьсны өнгөөр гадуурхах** (арьсны өнгөөр ялгаварлах, арьсны өнгөөр ялган гадуурхах явдал, арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл) racial discrimination, **арьсны үзэл** racism, **арьсны үзэлт дэглэм** racist régime, ~ **үзэлтэн** racist (n.), ~ **үндэсний ялгаа** racial and national difference

**АРЬСАРХАГ** leathery

**АРЬСЛАГ** (see **арьсархар**)  
**АРЬСЛИГ** (see **арьсархар**)  
**АРЬСТАС** dermatitis  
**АРЬЯВАЛ** Aryabala (epithet of **Хоншим**) (Buddh.) (Skr.)  
**АРЫН** rear (adj.) ~ **хаалгаар** "through the back door", by pulling strings, ~ **хаалгадах** to let in "by the back door"  
**АРЫН ХҮРЭЭ** Urga (p.n.)  
**АСААГУУР 1.** switch (elec.), ~ **царах** to press a switch, **асаагуурын ороомог** ignition-coil, coil, **асаагуурын систем** ignition system **2.** cigarette-lighter, lighter, **хийн** ~ gas lighter **3.** starter  
**АСААЛГААТАЙ** burning, alight  
**АСААЛТ** ignition  
**АСААЛТГАЙ** switched-on, running  
**АСААЛТЫН** ignition (adj.) (mech.), ~ **байгуулалт** (~ **систем**) ignition system, ~ **барил** starting handle, ~ **түлхүүр** ignition key, ~ **түрүүлэлт** advancing the ignition  
**АСААСТАЙ** burning, alight, on  
**АСААХ I.1.** to light, **лаа** ~ to light a candle, **түймэр** ~ to start a fire **2.** to start (a car, etc.), ~ **түлхүүр** ignition key, ~ **хөдөлгүүр** starting motor **3.** to switch on  
**АСААХ II.** to dress, to put on (resp.), § **номын бүрэн хувцсыг түүний шарилд асааж** dressing his remains in full religious dress  
**АСАГ** accumulation of blood and serum in the feet of camels resulting in lameness  
**АСАМТГАЙ** flammable, inflammable  
**АСАН 1.** was, were **2.** former **3.** late  
**АСАР I.** very, extremely, ~ **удалгүй** before very long  
**АСАР II.1.** rectangular cloth tent, marquee, pavilion, **битүү** ~ cloth tent with walls, **задгай** ~ cloth tent without walls **2.** gatehouse, roof over a gate  
**АСАР БАСАР ХОЁР НОХОЙ** Asar and Basar (names given to a pair of dogs in Mongolian folk-tales)  
**АСАРГАА** (~ **сувилгаа**) care, nursing, looking after  
**АСАРЛАХ** to set up (a tent)  
**АСАХ I.1.** (**асч авирах**) to climb, **модонд** ~ to climb a tree **2.** to stick (to), to cling (to)  
**АСАХ II.1.** to catch fire, to ignite, to start burning **2.** to light up, to come on, to be on, § **улаан гэрэл дохио ассан үед** when the red light is

showing **3.** to burn **4.** to start (car, etc.)  
**АСГА** (~ **хад**) scree, talus  
**АСГАДАХ** to suffer from **асар**  
**АСГАЛАХ** to keep spilling  
**АСГАР** puddles by a well  
**АСГАРАЛТ** spilling, spillage  
**АСГАРАХ** to pour, to pour out, to be shed  
**АСГАРГА** placer deposit (geol.)  
**АСГАРУУЛАХ** to pour out, to shed, **цус** ~ to shed blood  
**АСГАТ** rocky  
**АСГАХ** to spill, to pour, to let out  
**АСМАЛ** climbing (plant)  
**АСМАЛЖИН** diorite  
**АСМАН 1.** cryptorchid (animal) **2.** uneducated, crude  
**АСРАГЧ** nursing auxiliary  
**АСРАЛ** care, protection  
**АСРАЛТ** kind, caring  
**АСРАМЖ** care, protection, **улсын асрамжинд авах** to take into state care, **асрамжийн газар** home, institution, ~ **сувилгаа** care, nursing, ~ **хамгаалалт** care and protection  
**АСРАМЖЛАГЧ** guardian (jur.)  
**АСРАМЖЛАХ 1.** to take care of, to care for, to look after **2.** to act as guardian (jur.)  
**АСРАНГУЙ** kind, caring  
**АСРАХ** (**асран тэтгэх**) to look after, to take care of, to care for, **биеэ** ~ to take care of oneself, **асран сувилах** to tend, to nurse, to look after, ~ **сургууль** orphanage, **асран хамгаалагч** guardian, **асран хамгаалах** to act as guardian (jur.), **асран хүмүүжүүлэх** to bring up  
**АСРУУУЛАГЧ** inmate of a home or institution  
**АССАМБЛЕЙ** assembly (Russ.)  
**АСУРА** asura (one of the six states of rebirth) (Buddh.) (Skr.)  
**АСУУДАЛ** question, **гол гогцоо** ~ key question, key issue, **асуудлын гогцоо** the nub of the matter, ~ **тавих** to put a question, to ask  
**АСУУДЛААРХИ** on the question of  
**АСУУЛГА** questioning  
**АСУУЛТ** question, **илтгэгчийн** (~ **яруу** ~) rhetorical question, ~ **тавих** to put a question, to ask, ~ **хариултын журмаар** in question and answer form, **асуултын тэмдэг** question mark  
**АСУУХ** to ask, **асууж лавлах** to enquire, ~ **нуруу яс** bones at the meeting of spine and sacrum, ~ **өгүүлбэр** interrogative sentence, ~ **үг** interrogative word

АСФАЛЬТЛАХ to asphalt

АСХАН evening (west Mongol)

АТ (атан тэмээ) camel gelding in and after the fifth year, гүйцмэл настай атан тэмээ fully grown camel gelding

АТАА (~ жетөө, ~ найдангуй, ~ парагдаг) envy, jealousy

АТААРХАЛ (see атаа)

АТААРХАМ enviable

АТААРХАНГУЙ envious, jealous

АТААРХАХ (атаархан жөтөөрхөх) to envy, to be envious, § тэдэнд ~ to be envious of them

АТААРХМААР enviable

АТААРХУУ envious, jealous

АТАА ТАВАН ТЭНГЭР name of a pre-lamaist god or group of gods believed to protect horses

АТААТАН envious person, jealous person, enemy

АТААХАЙ Shrew, *Sorex*, Бэсрэг ~ Large-toothed Shrew, *S. daphaenodon*, Дааган ~ Laxmann's Shrew, *S. caecutiens*, Өөдсөн ~ Least Siberian Shrew, *S. minutissimus*, Тавшгар ~ Flat-skulled Shrew, *S. vir*, Хэвлүүн ~ Common Shrew, *S. araneus*

АТААЧ envious

АТАВЧ ring for securing the stirrup on a camel saddle

АТАК attack, эсрэг ~ counter-attack (mil.) (Russ.)

АТАКЛАГЧ attacking, assault (adj.), ~ явган цэрэг assault infantry

АТАКЛАХ (атаклан дайрах) to attack

АТАЛ while, though

АТАМАН boss of a gang (Russ.)

АТАМАНДАХ to run a gang

АТАНЦАР young camel gelding

АТАР 1. virgin (adj.), ~ газар virgin land, ~ газрыг эзэмших to reclaim virgin land, to bring virgin land under the plough, ~ онгон free, wild 2. untrodden, ~ өвс untrodden grass

АТАРДУУ uncultivated, uncultured

АТАРЖИХ 1. to revert to a wild state, атаржсан газар land which has long lain fallow 2. to get rusty, to get out of practice

АТАРЖУУЛАХ (атаржуулан хаях) to allow (land) to revert to a wild state

АТАР СУУРЬ flocks, flocks and herds (Russ. отара)

АТАРЧИН virgin-lands worker

АТАРШИХ (see атаржих)

АТАРШУУЛАХ (see атаржуулах)

АТГА (~ чимх) 1. handful 2. hold, grasp, grip

3. a measure taken across the clenched fist, ~ эрхий fistmele, a measure comprising the fist and raised thumb

АТГААЛ (~ чөмөр) humerus, upper arm, атгаалын дээд булуу head of the humerus

АТГААЛЖИН ХАР МАНГАС a name of the ogre in Mongolian epics

АТГАГ 1. hidden, veiled, concealed, ~ санаа ulterior motive 2. jealous, suspicious

АТГАЛАХ to keep grasping

АТГАЛТ grasp, grip

АТГАХ 1. to grasp 2. to clench, атгасан гар clenched fist

АТГУУЛАХ to hand over, to pass over, to put into (someone's) hand

АТИГАНАХ to wriggle, to fidget

АТИГАР short, undersized, dwarfish

АТИГДААХАЙ Dwarf Jerboa, *Salpingotus*, *Cardiocranius*, Козловын ~ *S. Kozlovi*, Өөхөн сүүлт ~ Three-toed dwarf Jerboa, *S. crassicauda*, Таван хуруут ~ Five-toed dwarf Jerboa, *C. paradoxus*

АТИЙЛГАХ to draw up, to draw in, хөлөө ~ to draw up one's legs

АТИЙХ 1. to draw up, to contract, хөлөө ~ to draw up the legs 2. to be drawn up

АТИРАА crease, fold, wrinkle, crinkle, ~ болсон магнай wrinkled brow

АТИРААЛЖИЛТ folding

АТИРААТ wrinkled, creased, folded

АТИРААТАХ to be wrinkled

АТИРАЛДАХ to be creased up

АТИРАХ 1. (атирч үрчийх) to wrinkle 2. to coil up, to curl up (intrans.)

АТИРУУЛАХ 1. to wrinkle (trans.), хөмсгөө ~ to knit one's brow 2. to draw up, to draw in, үе мөчөө ~ to draw up one's limbs

АТЛАА (see атал), тийм ~ yet, however

АТЛАГА curved blade adze

АТЛЕТИК athletics, хөнгөн ~ field and track events, хүнд ~ heavy athletics (weight-lifting, etc.) (Russ.)

АТОМ atom, тэмдэгт ~ radioactive tracer, атомын бөмбөг atomic bomb, ~ жин atomic weight, атомын зуух nuclear reactor (Russ. атомный котёл), ~ сургаал atomic theory

АТРАХ to bring

АТРИА (see атираа)

АТРИАЖИХ to fold, to become folded (geol.)

АТРИАТ (see **атираат**)

АТРИАТАХ (see **атираатах**)

АТРИАШИЛТ folding (geol.)

АТТЕСТАТ certificate (Russ.)

АТТЕСТАТЧИЛАЛ certification

АТТЕСТАТЧИЛАХ to certify

АТУГАЙ **1.** however, whatever, **бага ч** ~ however small, **ямар ч** ~ whatever happens, anyway, **тэр ч** ~ and what is more **2.** let alone, not to speak of

АУГАА (~ **их**) immense, mighty, great

АФРИК Africa, **Африкийн эвэр** Horn of Africa

АХ **1.** elder brother, ~ **дүү** (**ахан дүүс**) brothers, siblings, ~ **дүү олон ард түмэн** fraternal masses, ~ **дүүгийн** (~ **дүү ёсний**, ~ **дүүлэг**, ~ **дүүсэг**) fraternal **2.** senior, elder, **зэрэг** ~ senior in rank, ~ **зах** (~ **ихэс**) older people, seniors, ~ **захаа алдах** to be undisciplined, to be uncontrolled, ~ **захч** respectful, ~ **захын ёс** principle of seniority, ~ **зах тааруу** undisciplined, uncontrolled

АХАЙ **1.** lady of rank, title of address to an elderly lady

АХАЙ **II.** O.K., right!

АХАЙТАН (see **ахай I.**)

АХАР (~ **богино**) **1.** short, ~ **богино хугацаа** a short space of time, ~ **ноос** (**ахрын ноос**) short wool, wool from the second shearing, ~ **сүүл** cossyx, ~ **сүүл дээр нь хутгаа хугалах** to be ripped at the post **2.** short wool, wool from the second shearing, ~ **урт** wool from the first and second shearings

АХАРДАХ to be too short

АХАРЛАЛТ second shearing

АХАРЛАХ **1.** to shear for the second time, to shear the short autumn wool **2.** to shorten, to cut

АХАРХАН pretty short, ~ **бодолтой** short-sighted, lacking vision

АХАС elders, older persons, ~ **ихэс** the older generation

АХАС УХАСХИЙХ to bow and scrape

АХДАХ to be too much for one, to be beyond one's powers, to be more than one can manage, **хүчиндээ ахадсан даалгавар** a task beyond one's capacities

АХДУУ excessive, too much for one

АХИАД (see **ахин**)

АХИЖ (see **ахин**)

АХИМАГ (~ **настай**, ~ **насны**) elderly

АХИМАГДАХ to be too old

АХИМАГДУУ elderly, **насаар** ~ getting on in years

АХИН again, ~ **дахин** again and again

АХИРАЛДАХ to make a row, to row

АХИУ more, extra

АХИУЛАЛТ advancement, promotion, upgrading

АХИУЛАХ to advance, to raise, to increase, to push forward, **нормыг** ~ to raise the norm, to raise the standard

АХИУХАН pretty good, well up, rather more

АХИХ to advance, to go forward, **нас** ~ to get older, **нас ахихад** (**нас ~ тутам**) with advancing years, **цол** ~ to get a higher title (wrestling)

АХИЦ (~ **дөхөц**, ~ **дэвшил**) progress, advance, advancement

АХИЦГҮЙ bad, unsuccessful

АХИЦГАЙ successful

АХЛАГЧ **1.** foreman, chief, captain (sport), **суурийн** ~ boss of a "camp", ... **ахлагчтай баг** team captained by ... **2.** company sergeant major (mil.) **3.** leader (of a group)

АХЛАЛ seniority

АХЛАХ **1.** to head, to be in charge **2.** senior, leading, ~ **анги** senior class, ~ **ангийн сурагчид** senior pupils, ~ **захлах хүмүүс** seniors, superiors, ~ **тал** the left-hand team in wrestling (cf. **удаалах**), ~ **цолтон** superior in rank (mil.) [cf. **бага цолтон**] **3.** ахалж хүндлэх to respect (one's seniors)

АХМАД **1.** senior, elder, older, **зэргээр** ~ senior in rank, ~ **буурлууд** old people, senior citizens, ~ **насны хүн** older person, elders, ~ **үе** the older generation, ~ **хүмүүс** seniors **2.** captain (army, police, ship, etc.)

АХУЙ **1.** to be, **хүүхэд** ~ **нас** childhood years **2.** life, living, existence, being, ~ **амьдрал** life, ~ **амьдралын нөхцөл** living conditions, ~ **байдал** way of life, living conditions, situation, ~ **нөхцөл** conditions, **хөдөлмөрийн** ~ **нөхцөл** working conditions

АХУЙН domestic, home (adj.), ~ **гэмтэл** accident in the home, ~ **соёл** (~ **соёлжилт**) amenities of life, cultured living, ~ **үйлчилгээ** services, amenities, ~ **үйлчилгээний пүүс** public service industry, ~ **үйлчилгээний тасалгаа** amenities room (for ironing, hair-cutting, boot and clothes repairing, etc.) (mil.), ~ **үйлчилгээний удирдах газар** services office, ~ **үйлчилгээний цэг** services point, ~ **хангамж** domestic services (gas, electricity, etc.)

АХУЛ if

АХУУНА Diver, *Gavia*

**АХЧЛАХ** (~ дүүчлэх) to respect older people

**АЦ 1.** fork **2.** (~ санал) dilemma, ацан нийлэх to arbitrate, ацан шалаанд орох (ацан шалаанд суух) to be in a dilemma, to be in two minds, to be in a dither, § гайхал оюутан л дуулгаагүй бол би юунд энд ацан шалаанд суух вэ if that wretched student hadn't told me, I wouldn't be all of a dither here, would I?

**АЦАГ I.** (see шүд 4.)

**АЦАГ II.** (~ хөлс) pay, payment, fee, wage

**АЦАГЛАХ** to pay a stand-in

**АЦАТ** forked

**АЦДАХ** to fork up.

**АЦЛАХ** to fork, to form a fork

**АЦРАХ** to bring

**АЦТАЙ** (see ацат)

**АЦТҮРҮҮ** Canary-Grass, *Phalaris* (bot.), нишингэдүү ~ Reed Canary-Grass, *P. arundinacea*

**АЧ I.1.** grandchild, grandson, granddaughter, (son's child, cf. зээ), агул ~ great-grandson, ~ гуч grandchildren and great-grandchildren, posterity, ~ үр descendant, posterity, ~ хөвүүн (~ хүү) grandson; nephew **2.** nephew, niece (on the male side)

**АЧ II.1.** kindness, goodness, benevolence, ачийг бачаар хариулах to repay good with evil, ~ буян kindness, benefits, ~ буянтан benefactor, ~ дэм help, support, ~ ивээл favour, kindness, ~ ивээлтэй kind, beneficent, ~ нөлөө influence, effort, ~ тус benefit; a kindness, өрсөлдөөний ~ тус the benefits of competition, ~ тусаар thanks to, ~ тусыг хүргэх to do a kindness, ~ тустай useful, beneficial; kind, benevolent, ~ хариулах to repay a kindness, ~ холбогдол significance, importance, ~ холбогдолтой significant, important **2.** (~ гавьяа) merit, ~ гавьяагаар thanks to **3.** reward **4.** (~ үр) result, ~ үрээр thanks to, as a result of

**АЧАА 1.** load, ашигтай ~ payload, дамжин өнгөрөх ~ (нэвтрэн өнгөрөх ~) through freight, ~ бараа freight, load, ачааны машин (ачааны авто машин, ачааны тэрэг) lorry, truck (Amer.), ~ тээвэрлэлт freight transport, ~ хүлээн авах чадал load-bearing capacity, ~ эргэлт freight turnover **2.** (~ хөсөг) transport, carts, ~ тээвэр (~ тээвэрлэлт) transport, ~ тээш baggage

**АЧААЛАГДАХ** to be loaded, хэт ~ to be overloaded

**АЧААЛАЛ 1.** load, weight, loading, автомашины тэнхлэгт оногдох ~ vehicle axle weight, бүрэн ачаалалтай ажиллах to work at full capacity, хэт ачаалалтай overloaded

**2.** pressure, stress, strain, burden, нуруу хөлийн ачаалал strain on the back and legs

**АЧААЛАЛТ** (see ачаалал)

**АЧААЛАЛТТАЙ** load-bearing

**АЧААЛАХ** to load, to load up

**АЧААР** thanks to, үүний ~ thanks to this, as a result of this

**АЧААТАЙ** loaded, хэт их ~ overloaded

**АЧИГЧ** loader, baggage-handler

**АЧИЛГА** (see ачлага)

**АЧИЛТ** loading

**АЧИНЦАР** great-grandchild (child of ач)

**АЧИР ДЭЭРЭЭ** actually, as a matter of fact

**АЧИТ** kind, benevolent

**АЧИХ 1.** to load, to load up, to take on board, гэрээ ~ to load up one's tent (for a move), ачиж тээвэрлэх to transport **2.** name of a type of cross-buttock throw in wrestling

**АЧЛАГА** (~ уналга) transport, ~ ачих to load up, ачлагын тэмээ baggage camel

**АЧЛАЛ 1.** filial respect, dutifulness **2.** benevolence

**АЧЛАЛГҮЙ** undutiful

**АЧЛАЛТ** dutiful

**АЧЛАЛТ НОМ** Xiaojing (Classic of Filial Piety)

**АЧЛАЛТАЙ** dutiful, эцэг эхдээ ~ dutiful towards one's parents

**АЧЛАХ** to requite, to return a favour

**АЧМАГ** saddle-bag

**АЧТАЙ** (~ тустай) kind, benevolent

**АЧТАН** benefactor

**АЧ ТАЧ** to a draw, to a dead heat

**АШГҮЙ** fortunately, by good luck, ~ дээ what a good thing!, what luck!

**АШДЫН** eternal, lasting for ever

**АШИГ I.** (~ завшаан, ~ олз, ~ хожоо, ~ хонжил, ~ хонжоо) profit, gain, ~ алдагдал profit and loss, хувийн ~ завшаан private profit, ~ завшаан эрэгч (~ хонжоо хайгч) profiteer, ~ орлого income, takings; profit, ~ орлогын татвар income tax, ~ өгөөж (~ унац) yield, ~ сонирхол interests, ~ тус benefit, usefulness, utility; interests, ~ тустай useful, ~ унамаар profitable, ~ хонжооны profiteering, profit-making, ~ хуваарилалт distribution of profits, ~ шим yield, productivity, ~ шимт (~ шимтэй) productive, өндөр ~ шимт үхэр сүрэг high-yielding herds of cows, ашгийн шимтгэл income deduction

**АШИГ II.** growth, lump, tumour  
**АШИГТҮЙ** unprofitable, useless, no use, pointless  
**АШИГЛААНЫ** pragmatic, ~ **ёс** pragmatism  
**АШИГЛАГЧ** embezzler  
**АШИГЛАЛ** 1. use, exploitation 2. embezzlement, **ашиглалын гэмт хэрэг** the crime of embezzlement  
**АШИГЛАЛТ** use, exploitation, operation, **цаг** ~ use of time, **ашиглалтанд орох** to go into operation, to go into use, to be commissioned, **ашиглалтанд оруулах (ашиглалтанд өгөх)** to put into operation, to put into use, to commission  
**АШИГЛАХ** 1. to make use of, to exploit, ~ **заавар** directions for use, operational instructions, ~ **хугацаа** product life 2. (ашиглан завших, ашиглан шамшигдуулах) to embezzle, **ашиглан шамшигдуулагч** embezzler  
**АШИГЛАХУЙЦ** exploitable, **үйлдвэрлэлд** ~ **хэмжээгээр** in quantities suitable for industrial exploitation  
**АШИГТ** useful, profitable, ~ **ажиллагаа** efficiency, ~ **малтмал** minerals, deposits, ~ **ургамал** useful plants, ~ **үйлийн илтгэлцүүр** coefficient of efficiency  
**АШИГТАЙ** profitable, advantageous, beneficial, useful, ~ **хурд** economic speed  
**АШИД** for ever, always, ~ **мөнхийн** eternal, everlasting  
**АШЛАХ** to relax, to sit at ease  
**АШЛУУ** relaxing, taking a rest  
**АШТАЙ** nice, a good thing, **юун** ~ **вэ** what a good thing  
**АЮУЛ** (~ **хор**, ~ **хөнөөл**) danger, peril, disaster, threat, **байгалийн** ~ (байгалийн гэнэтийн ~) natural disaster, **гэнэтийн** ~ calamity, emergency, ~ **гамшиг** disaster, peril, misfortune, ~ **занал** threat, ~ **занал учруулах** to pose a threat, ~ **осол** accident, disaster, **зам тээврийн** ~ **осол** traffic accident, ~ **осол гарсан газар** scene of an accident, ~ **осолгүй ажиллах арга** safe working practices, ~ **осолд нэрвэгдсэн хүмүүс** accident casualties, **аюулд учрах** to run into danger, to have an accident, **аюулаас хамгаалах хүчийнхэн** security forces, **аюулын харанга дэлдэх** to sound the alarm, ~ **хүргэх** to endanger, **аюулд хүрэх** to run a risk, to run the risk (of), **хөгцрөх аюулд хүрэх** to run the risk of going mouldy  
**АЮУЛГҮЙ** safe, harmless, not dangerous, ~ **байдал** security, safety, ~ **байдлыг хангах** to

ensure safety, ~ **болох** to make safe, **Аюулгүйн зөвлөл** Security Council

**АЮУЛТ** dangerous, dreadful, terrible, terrifying, ~ **өвчин** dangerous disease  
**АЮУЛТАЙ** (see **аюулт**)  
**АЮУЛХАЙ** pit of the stomach, epigastrium  
**АЮУЛЫН** pretty good, all right, smashing, ~ **хөөрхөн ааштай хүүхэн** a really charming girl  
**АЮУМШИГТҮЙ** (see **аймшигтүй**)  
**АЮУМШИГТАЙ** (see **аймшигт**)  
**АЮУХ** (see **айх**)  
**АЮУШ БУРХАН** the Buddha Ayushi (the "god of long life")  
**АЯ I.1.** (~ **дан**, ~ **хөг**) tune, melody, **дууны** ~ melody of a song, **оноот** ~ leitmotiv, **шүлгэнд** ~ **хийх** to set a poem to music, ~ **аялгуу** tune, ~ **дан** tune, tone, accent, ~ **дангүй** tuneless, ~ **дуу** tune, song, ~ **оруулах** to set to music, ~ **татах** to play a tune, ~ **хөгжим** music, ~ **хөгжим барих** to make music 2. song, ~ **барих** to sing a song, ~ **дуу** song, tune  
**АЯ II.** situation, circumstances, trend, tone, mood, **салхины аяар** with the wind, in the wind, ~ **гав** chance, opening, possibility, **аяыг даах** to stand up to, to stand the test of, **гарын аяыг даах** to stand up to it, to last out, **замын аяыг даах**, to stand the journey, ~ **дагах** to yield to, to follow, to go along with, ~ **зан** nature, disposition, ~ **зөнд нь** in one's own time, as one wishes, ~ **зүйгээ олох** to manage, **хөрш-тэйгөө** ~ **зүйгээ ололцох** to get along with the neighbours, ~ **нийлэмжтэй** congenial, ~ **нь таарвал** all being well, if all goes well, ~ **нь таарсан хэрэг** a matter of chance, just as it takes one, ~ **олох** to deal with, to manage, **юмны** ~ **олох** to deal with things, ~ **тааваар** as one wishes, at one's own pace, ~ **тав** comfort, ~ **тав алдах** to be uncomfortable, ~ **тавтай** comfortable, ~ **тал засах** (~ **засах**) to play up to, to suck up to, to curry favour with, **империализмд** ~ **тал засах** to suck up to imperialism, ~ **тохитой** comfortable, comfy, ~ **тух** comfort, ~ **тухтай** comfortable, ~ **хөг** tone, mood, ~ **шалтар (аян шалтар)** excuse, pretext, ~ **эв** knack, ~ **эвийг олох** to get along, to manage, ~ **эвийг нь олох** to get the hang of it, **хүнтэй** ~ **эвийг олох** to get along with people  
**АЯ III.** a species of wormwood (*Bur.*)  
**АЯА** oh dear!, oh!  
**АЯАР** 1. gently, softly, quietly 2. piano (*mus.*), **дунд зэрэг** ~ mezzo-piano  
**АЯАРТАХ** to get softer, to get quieter  
**АЯАРХАН** 1. quite gently, quite softly, quite quietly 2. **их** ~ pianissimo (*mus.*)

**АЯГ** (~ ааш, ~ араншин) character, ~ алдах to go wrong, ~ жаяг bearing, manner

**АЯГА** bowl, cup, **мөнгөн** ~ silver bowl; wooden bowl decorated with silver, **нүдний** ~ (see **нүд 1.**), **Петрийн** ~ Petri dish, **аяганы амсар зуух** to have something to eat, **аяганы гэр** case for a bowl, ~ **ёроолдох** to sit a long time over tea, **аяганд орох** to be weaned, ~ **сав** (~ **таваг**) crockery, dishes, ~ **тагш юм** a drop of something, a drink, **аяганы уут** (**аяганы хавтага**) pouch for a bowl, **аяганы хариу өдөртөө агтны хариу жилдээ** one good turn deserves another, **аяганы ширээ** cup-rack

**АЯГАЛАХ** to pour out, to pour into a cup, to serve out, **цай хоолоо** ~ to serve out the tea and food

**АЯГАТАЙ** a bowl of, ~ **цай** a bowl of tea

**АЯГА ТЭХЭМЛИГ** monk (*Buddh.*)

**АЯГАЧ** (**аягачин хүүхэн**) handmaiden, maid-servant

**АЯГЛАЛ** behaviour

**АЯГЛАХ 1.** to behave **2.** to play up, to put on an act **3.** to scold

**АЯГҮЙ 1.** unpleasant, ~ **бол** perhaps, maybe, if you don't look out, if you're not careful **2.** upset, ~ **тавгүй** uncomfortable

**АЯГҮЙДВЭЛ** (see **аягүй бол**)

**АЯГҮЙРХЭХ 1.** to feel uncomfortable **2.** to feel embarrassed

**АЯГҮЙЦЭЛ** displeasure

**АЯГҮЙЦЭХ** to feel unhappy, to be upset

**АЯДАХ 1.** to calm down, to cool off **2.** to fall in with, to go along with **3.** (after the participle in **x**) to manage to

**АЯДУУ** gentle, soft, mild

**АЯДУУЛАХ** to get through, § **найз нь эндээ бага сага ажил аядуулж байя** I'll finish off some odds and ends here

**АЯЭ** piece (*mus.*), **завсар** ~ interlude

**АЯ ЗАНА** job

**АЯЛАГ** pleasant, agreeable, suitable, ~ **тавлаг** nice and comfortable

**АЯЛАГЧ** traveller, **далайн** ~ voyager

**АЯЛАЛ 1.** journey, expedition, excursion, travel, **далайн** ~ voyage, **сансрын** ~ space travel, journey into space, ~ **жуучлал** tourism, ~

**жуучлалын төв** four operator **2.** flight, **гадаадын** ~ international flight, **дотоодын** ~ domestic flight, § **ОМ-130 дугаар** ~ flight number ОМ-130

**АЯЛАХ I.** to travel, to journey

**АЯЛАХ II.** to sing, to hum

**АЯЛГА 1.** intonation, accent **2.** ~ **үг** (see **үг 1.**)

**АЯЛГАЖУУЛАХ** to accent, to give an intonation

**АЯЛГАЛАХ** (see **аялах II.**)

**АЯЛГУУ 1.** tune, melody, **нэвт гарах** ~ leit-motiv, ~ **оруулах** to set to music **2.** dialect, **нутгийн** ~ local dialect, **Халх** ~ Khalkha dialect

**АЯЛГУУЛАГ** melodious, melodic

**АЯЛГУУЛАХ** to sing, to let sound

**АЯЛДАХ** to fall in with, to go along with, **аялдан дагагч** (**аялдан дагалдагч**) yes-man, crony, hanger-on, stooge, henchman, **аялдан дагах** (**аялдан дагалдах**) to gang up with, to go along with, **бусдыг аялдан дагалдах** to gang up with others, **аялдан эвлэрэх** to go along with, not to make a stand against

**АЯЛУУЛАХ** to arrange, to put in order, to clear up

**АЯЛУУН** nice, pleasant, agreeable

**АЯН 1.** journey, ~ **жин** caravan, cartage, ~ **жин тээх** to do caravanning, ~ **зам** journey, ~ **замын хүн** traveller, wayfarer **2.** march **3.** campaign (*polit., etc.*), ~ **дайн** campaign (*mil.*)

**АЯНГА** thunder, thunderbolt, lightning, ~ **буулгах** to be furious, ~ **буух** to strike (lightning), **аянгын дуу** thunderclap, ~ **зайлуулагч** lightning conductor, **аянгад ниргүүлэх** (**аянгад цохиулах**) to be struck by lightning, ~ **ниргэх** to strike (lightning), **аянгын цахилгаан** lightning, **цэлмэг тэнгэрийн** ~ a bolt from the blue

**АЯНДАА** automatically, spontaneously, naturally, of itself, in the course of things, § ~ **гайгүй болох биз** it will probably put itself right

**АЯНД НЬ** (see **аяндаа**)

**АЯНЧИН** (~ **жинчин**) caravaner, traveller, ~ **жуулчин** traveller, tourist

**АЯНШИХ** to be travel-worn, to be travel-stained

**БА** and

**БАА I.** harrow (*Chin.*)

**БАА II.** (~ хулс) Bamboo

**БАА III.** penalty

**БАА IV.** sore place, **хамрын** ~ sore place where a peg has been inserted in a camel's nose

**БАА БҮРЭН** we all, all of us (*hist.*)

**БААВАЙ** (a respectful term of address for a senior)

**БААВАР** ornamental saddle-stud

**БААВАРЦЭЦЭГ** Scabious, *Scabiosa*

**БААВГАЙ** Bear, *Ursus*, **Хүрэн** ~ Brown Bear, *U. arctos*, **Цагаан** ~ Polar Bear, *U. maritimus*, ~ **цардам хүйтэн** bitter cold, **Баавгайн язгуур** Bears, *Ursidae*

**БААГИУЛАХ** to puff out (smoke, etc.), **тамхи** ~ to puff one's pipe

**БААГИХ** to be smoking, to puff out (smoke)

**БААДАГНАХ** (see **ваадагнах**)

**БААДАН** (see **ваадан**)

**БААДУУ** spring (*mech.*), ~ **эргүүлэх** to wind up a spring

**БААДУУЛАХ** to make (a camel's nose) sore (from the insertion of a peg)

**БААЗ I.** a string of camel carts in a caravan worked by one team (**гал II.**)

**БААЗ II.1.** base (*mil.*, etc.) **2.** resources, **материаллаг** ~ material resources **3.** base, basis, § **энэ** ~ **суурь дээр тулгуурлан** relying on this basis

**БААЗ III.** ordinary, middling, mediocre

**БААЗЛАХ** to team up, to pair off (camel caravanners), § **гал дотроо хоёр хоёроор** ~ to pair off in a camel caravan team

**БААЗХАН** not up to much, nothing to speak of

**БААЛАХ I.** to harrow

**БААЛАХ II.** (**баалан цээрлүүлэх**) to punish, § **Гочоог ганц хонины махаар баалжээ** Gochoo was fined the flesh of a single sheep

**БААЛАХ III.** to go pussy

**БААМЛИЙ** name of a type of gun, **усан** ~ water-cooled ~ gun (*Chin.*, *prob.* 8 mm.)

**БААР** bar (drinking)

**БААРАА АЛАХ** to examine one's loot (thieves' cant)

**БААРАГ** careless, sloppy

**БААРАГГҮЙ** without fail, unerring, sure, certain, reliable

**БААРАЛТ 1.** failure **2.** misfire

**БААРАН** loose-bowelled

**БААРАХ 1.** to fail **2.** to misfire

**БААРГАНАХ** to appear unclearly, to show up indistinctly

**БААРГАР** wide, broad

**БААРИН** Baarin (Inner Mongolian people)

**БААРЦАГЛАХ** to be all squashed together, to get in a lump

**БААС 1.** excrement, faeces, shit (*vulg.*), ~ **хаагдах** (~ **хатах**) constipation, ~ **хатавч өмхийгөө тавихгүй** the leopard cannot change its spots **2.** (**төмрийн** ~) slag **3.** swarf, § **муу билүүний** ~ **их, муу ламын багш олон** a poor grindstone makes a lot of swarf, a poor lama has many teachers

**БААСАН** (~ **гариг**) **1.** Venus **2.** Friday (*Tib.* pa-sangs)

**БААТАР I.1.** hero **2.** (~ **эрийн**) heroic, ~ **хуйх** the skin between the horns of an animal

**БААТАР II.** plug, washer

**БААТАРЛАГ** heroic, ~ **тууль** heroic epic, ~ **үйлстэн** hero

**БААТАРЛАЛ** heroism

**БААТАРЛАХ** to act heroically

**БААТАРЧУУД** "Heroes" (pre-pioneer organization for children)

**БААХ** to excrete, to shit (*vulg.*)

**БААХАН 1.** somewhat, considerably, rather, pretty, ~ **сууж байгаад** having stayed some time **2.** a number of, a quantity of, ~ **агт морьд** a number of horses

**БААЦГАНАХ** to toddle, to teeter

**БААЦГАР** teetering, unsteady on one's feet

**БААШ** pretence, deceit, ruse, trick, ~ **гаргах** to dissemble, to use a trick

**БААШИРХАХ** to pretend, to make out, to feign

**БААШЛАХ** (see **бааширхах**)

**БААЮУ** kiln (*Chin.*)

**БАВ** (*intensifying particle*), ~ **бараан** quite dark

**БАВАЙХ** to be hairy, to be shaggy, to be tousled

**БАВГАР** hairy, shaggy, tousled

**БАВНАХ** (see **бавтнах**)

**БАВРАН** Bracken, *Pteridium*

**БАВТНАХ 1.** to bleat "ba ba" (rutting billy goat) **2.** to bleat, to babble, to talk nonsense, **ухна мэт майлан** ~ babbling like a rutting billy goat



**БАГ I.1.** a sub-unit of the **Их Шавь** of the *Jebsundamba Khutuktu*, subordinate to an **их отог** **2.** a unit of the **Их Шавь** directly controlled by the office of the **Шанзодва** **3.** a sub-unit in the **шавь** of a **тамгатай хутагт** **4.** a unit of **хамжлага** **5.** a sub-unit of a **сум** in the MPR (till 1959), and again in Mongolia (in the 1990's)

**БАГ II.1.** group, **том том багаар** in big groups, ~ **бүлэг** group, ~ **цэцэг** inflorescence, **нийлмэл ~ цэцэг** compound inflorescence **2.** order (*nat. hist.*), **давхцал ~ superorder**, **дэд ~ (салбар ~) suborder**

**БАГ III.1.** crew **2.** team, **эзэн ~ home side**, **багт наадам** team game, **багийн тэмцээн** team event

**БАГ IV.** mask, **багт наадам** fancy-dress ball (*Tib.* 'bag')

**БАГА 1.** small, little, a little, minor, ~ **балчираасаа эхлэн** from early childhood, ~ **бус** not a little, quite a bit, ~ **буурай** small and weak, minor, ~ **гарын** small-sized, minor, third rate, ~ **дарга** (see **дарга**), ~ **зэрэг** a little, a bit, a while, ~ **нас** youth, ~ **насандаа** in one's youth, ~ **сага** a little, a trifle, this and that, odds and ends, ~ **терц** minor third (*mus.*), ~ **үд** (see **үд**), ~ **хатан** secondary queen, secondary wife, ~ **хурал** (see **хурал**), ~ **цолтон** subordinate (*n.*) (*mil.*) (*cf.* **ахлах цолтон**), ~ **эхнэр** secondary wife **2.** a little, slightly, ~ **багаар** little by little, in small numbers, § **хур бороо ~ орж** with a little rain falling

**БАГААХАН** a little, not much

**БАГАВТАР 1.** smallish, minor, slight **2.** a little, not much

**БАГАГҮЙ** not a little, quite, quite a lot, ~ **ач холбогдолтой** not unimportant

**БАГАД** when small, in childhood,

**БАГАДАЛТ** deficiency

**БАГАДАХ 1.** to decrease **2.** to be too little, to be too small

**БАГАЖ** tool, implement, **гар ~ hand tool**, ~ **зэвсэг (~ зэмсэг)** tools, implements, ~ **техник** machinery, equipment, ~ **төхөөрөмж (~ хэрэгсэл)** tools, apparatus, equipment, instruments, implements (*Russ.*)

**БАГАЛЗУУР** throat, windpipe, **багалзуурыг шахах** to squeeze the windpipe, to throttle

**БАГАЛЗУУРДАХ** to throttle

**БАГАЛУУР** *Anabasis* (*bot.*) [also **Хорон Заг**], **Марцын ~ A. salsa**, **Навчгүй ~ A. aphylla**, **Түжгэр ~ A. brevifolia**

**БАГАЛУУРТАХ 1.** a disorder of camels (bloat resulting from eating too much **Багалуур** in early summer) **2.** to suffer from this condition

**БАГАНА I.i.** pillar, post, column, **мөнгөн усны ~ mercury column**, **нурууны ~ spinal column**, **тал ~ pilaster**, **уураг тархины ~ brain stem**, **баганын толгой** capital of a column, § **найман ханатай дөрвөн баганатай том өргөө** a large tent with eight wall sections and four pillars **ii.** column (in a table) **2.** style (*bot.*)

**БАГАНАДАХ** to prop up, to support

**БАГАНАНЦАР** column

**БАГАНХ** (see **баганхи**)

**БАГАНХИ** minority

**БАГАСАЛТ** decrease, reduction

**БАГАСАХ** to decrease, to decline, to shrink, to get fewer, to get smaller

**БАГАСГАЛ** litotes

**БАГАСГАХ** to reduce, to decrease, **хурдаа ~ to reduce speed**, to slow down

**БАГАТАЙ** little, not much, with little, § **эрх мэдэл ~ хүн** a man of little authority

**БАГАТГАХ** to reduce, to decrease

**БАГАХАН 1.** fairly small **2.** a little, a bit **3.** a few

**БАГАЧУУД** children, little ones

**БАГАШААРХАН** rather small

**БАГВААХАЙ** Bat, Little Brown Bat, Mouse-eared Bat, *Myotis*, **Сахалт ~ Whiskered Bat**, *M. mystacinus*, **Усны ~ Daubenton's Bat**, *M. daubentoni*

**БАГВААХАЙ ЦЭЦЭГ** Dandelion, *Taraxacum officinale*

**БАГВАР** a dish with a cover (*Tib.* bag-phor)

**БАГДАЙ** *Dontostemon* (*bot.*), **Бүхэннавчит ~ D. integrifolius**

**БАГ ИДЭЭ** a food which causes forgetfulness

**БАГИЙНХАН** crew-members, team-members

**БАГИЛ** grey-black, dirty black, blackened

**БАГИР** (see **багил**)

**БАГЛАА** pack, bale, bundle, **цэцгийн ~ (~ цэцэг)** bunch of flowers, bouquet, ~ **боодол** packing

**БАГЛАГАР** clustered, with clusters

**БАГЛАЙХ** to curl, to wreathe, to swirl

**БАГЛАЛТ** packing, packaging

**БАГЛАХ I.** (**баглаж боох**) to pack, to pack up, to tie up, to package, **баглаж хүлэх** to tie up

**БАГЛАХ II.** to form a **баг 1.**

**БАГЛУУР** (see **Багалуур**)

**БАГС** brush, **будгийн ~ paint-brush**, **даавуун ~ brush made of layers of partly frayed cloth**, used

- for inking a printing block (*xyl.*), **сахлын** ~ shaving-brush (*Tib. phag-ze*)
- БАГСАЙХ** to be loose, to be fluffy, to be shaggy
- БАГСАРМАЛ** combined, mixed, ~ **тэжээл** combined feed, mixed feed, **хорголжин** ~ **тэжээл** combined pellet feed
- БАГСГАР** bushy, shaggy
- БАГСДАХ** to brush
- БАГСРААТАЙ** mixed, mixed up
- БАГСРАЛТ** combination, mixture
- БАГСРАХ** to combine, to mix
- БАГТААМЖ** capacity, **усан** ~ displacement (of a ship)
- БАГТААМЖТАЙ 1.** capacious **2.** of the capacity of, able to contain
- БАГТААХ** to include in, to contain, to accommodate, § **гурван жил багтаан** within three years, **энэ өдөрт багтаан** this very day
- БАГТАЛЦАА** capacity
- БАГТАХ** to be contained in, to find room in, to get into, § **маргааш буюу нөгөөдөр багтаж** by tomorrow or the next day, **тэвэрч багтахгүй бүдүүн** too thick to get one's arms round
- БАГТАЦ** capacity
- БАГТАШГҮЙ** impossible to contain
- БАГТРАА** (~ **өвчин**) asthma, **бронхийн** ~ bronchial asthma, **зүрхний** ~ cardiac asthma
- БАГТРАХ** to suffocate, to feel choked, **багтарглаа уурлах** to choke with anger
- БАГТРУУАХ** to choke, to throttle
- БАГЦ 1.** bundle, bunch, cluster, packet, package, ~ **хууль** a packet of laws **2.** lot (at auction) **3.** holding (shares), **хяналтын** ~ controlling interest **4.** set (*phil.*)
- БАГЦАА** (~ **баримжаа**) approximation, ~ **тойм** outline
- БАГЦААЛАХ** to estimate, to get a rough idea of
- БАГЦАГ** inflorescence (*bot.*)
- БАГЦАРХУУ** bunched
- БАГЦЛАХ 1.** to pack up, to put in bundles **2.** to be bunched, to be matted
- БАГШ** teacher, master, **их сургуулийн** ~ university teacher, **цэрэгжлийн** ~ pre-military instructor (reserve officer or NCO appointed to the staff of a school to give military training), ~ **зааварлагч** supernumerary instructor in the pre-military training centre of a factory, etc. (see **цэргийн сургалтын байр**)
- БАГШЛАХ** to teach, **монгол хэл** ~ to teach Mongol
- БАГШРАХ** to swarm, to crowd, to flock together
- БАГЫН** childhood (*adj.*), ~ **найз** childhood friend
- БАД I.** Banyan (*bot.*)
- БАД II.** the name of a certain pattern
- БАДААН** *Bergenia* (*bot.*), **Падгар** ~ *B. crassifolia*
- БАДААС** a sweetmeat made with boiled sugar
- БАДАГ** stanza, verse (*Skr.*)
- БАДАГЧИЛСАН** strophic
- БАДАЙРАХ 1.** to swell **2.** to tingle, to have pins and needles
- БАДАМ** (~ **лянхуа**, ~ **лянхуа цэцэг**) Lotus, Lotus-flower (*Skr.*)
- БАДАН** coloured bands of material hung in front of a Buddha-image (*Tib. ba-dang*)
- БАДАР** (~ **аяга**) mendicant's begging bowl, ~ **барих** to go begging for alms, to beg, ~ **баригч** mendicant, beggar (*Skr.*)
- БАДАРГАНА** (see **Шарбударгана**), **Навчирхаг** ~ *Kalidium foliatum*, **Туяхян** ~ *K. gracilis*
- БАДАРГУУЛТ ТӨР** (see **Бадруулт төр**)
- БАДАРГУУН** (see **бадриун**)
- БАДАРЛАХ** to beg, to go begging, **мөнгө** ~ to beg for money
- БАДАРЧИН** (~ **шавираачин**) mendicant, wandering beggar lama, **бадарчны үлгэр** mendicant tale (*liter.*)
- БАДАРЧЛАХ** to wander as a mendicant
- БАДГАНА 1.** phlegm (a vital principle in Tibetan and Mongolian traditional medicine) **2.** (**нарийн** ~) cancer of the oesophagus or stomach
- БАДГАНАТАХ** to have cancer of the oesophagus or stomach
- БАДИГАР** strong, muscular
- БАДМААРАГ** (see **бадмарага**)
- БАДМАЛАХ 1.** to look like a lotus-flower (lamp-flame, etc.) **2.** to grow straight up
- БАДМАР** dolomite
- БАДМАРАГА** ruby, corundum (*Skr.*)
- БАДРАА УГАЛЗ** name of a type of "flower-pattern"
- БАДРААХ 1.** to light, to let burn **2.** (**бадраан хөгжүүлэх**) to promote
- БАДРАЛ** flourishing, blossoming (*n.*), **бадралт баг бишгүүр** organ (*mus.*)
- БАДРАНГУЙ** blazing, flourishing, enthusiastic
- БАДРАХ 1.** to flare up, to blaze, to shine **2.** (**бадран дэлгэрэх**) to flourish

**БАДРИУН** stout, well-built, sturdy

**БАДРУУЛАХ 1.** to cause to flourish, to cause to flare up **2.** to inspire, to enthuse

**БАДРУУЛТ ТӨР** reign title of the Manchu emperor Guangxu

**БАЖГАДАХ** to be worried, to be flustered, to be in a tizzy

**БАЖГАДУУЛАХ** to worry, to dismay

**БАЖГАР** (see **бажгир**)

**БАЖГИР** wrinkled, crinkly, ~ **дурдан** crepe

**БАЖИГ АЛДАХ** to be at a loss, to be wrong-footed

**БАЖИЙ** a board game played on a board similar to a ludo board

**БАЖУУНА** Gobi Rhubarb, *Rheum nanum*

**БАЗ I.** (see **бааз II.**)

**БАЗ II.** brothers-in-law, husbands of sisters, **гуя** ~ two husbands of one wife

**БАЗААЛТАЙ** satisfactory, acceptable, all right

**БАЗААЛТГҮЙ** (see **базаахгүй**)

**БАЗААЛТГАЙ** (see **базаалтай**)

**БАЗААР** (~ **зах**) market

**БАЗААХ** to see to, to deal with, to get ready, to prepare

**БАЗААХГҮЙ** bad, not so good, § **би нэг л** ~ I don't feel too good

**БАЗАЛТ** spasms, labour-pains

**БАЗАРВААНЬ 1.** Vajrapani (*Buddh.*) **2.** oh my goodness!

**БАЗАХ** to press, to squeeze, to wring, to grab, to grasp, to pound, to manipulate

**БАЗЛАЛТ** spasm, contraction

**БАЗЛАХ 1.** to knead, to wring, **зүрхийг** ~ to wring the heart **2.i.** (**гэдэс** ~) to have colic, to have the gripes **ii.** colic **3.** to have spasms

**БАЙ I.** (~ **шав**) target, ~ **буудах** to do target practice, ~ **нэхий харвах** to shoot at sheep-skin targets, ~ **онох систем** homing system, target-seeking system, **байт сур** (**байт харваа**) archery, **байн төв** bull's-eye, **байт харваач** archer, § **Хонины тарзан нэхий дээр элдэв амьтны дүрсийг зурж түүнийг нум сумаар харвадаг байжээ. Үүнийг бай нэхий буюу сарампай харвах гэж нэрлэдэг болжээ. Хонины үсгүй хатаасан нэхийг тарзан гэдэг** Figures of all sorts of creatures would be drawn on a **тарзан** sheep-skin, and they would shoot at them with bows and arrows. This was called **бай нэхий** or **сарампай харвах**. **Тарзан** is the word for a dried, hairless sheep-skin

**БАЙ II.** (~ **шагнал**) prize, trophy

**БАЙВАН** vitriol, sulphate, **зэсийн** ~ copper sulphate, **төмрийн** ~ iron sulphate, **цагаан** ~ white vitriol, zinc sulphate

**БАЙВРАГА** necrobacillosis (in camels) (see **догол**)

**БАЙГ** let it be, stop!, enough!

**БАЙГАЛ НУУР** Lake Baikal

**БАЙГАЛИЙН** natural, ~ **гаралтай** of natural origin, ~ **гэрэл** natural light, ~ **зохицол** ecology, ~ **зохицлын сүйрэл** ecological disaster, ~ **объект** natural feature, ~ **ухаан** natural sciences, ~ **үзэсгэлэнт газар** (~ **дурсгалт газар**) area of outstanding natural beauty, ~ **хий** natural gas, ~ **чулуу** stone, rock, natural stone, ~ **шалгарал** natural selection, ~ **шинжлэл** (~ **шинжлэх ухаан**) natural sciences, ~ **шинжлэлийн түүх** natural history, ~ **эмчилгээ** natural cure

**БАЙГАЛЬ** (~ **бодис**, ~ **дэлхий**, ~ **ертөнц**, ~ **түмэн бодис**) nature, **байгалиас давсан** super-natural, ~ **орчин** the environment, ~ **орчны бохирдол** environmental pollution, ~ **орчныг хамгаалах** protection of the environment, ~ **хамгаалал** nature conservancy, ~ **шинжээч** naturalist

**БАЙГАЛЬЧ** naturalist

**БАЙГУУЛАГЧ** founder, builder

**БАЙГУУЛАЛ** structure, § **нийгмийн өөр өөр байгуулалтай улсууд** states with different social structures

**БАЙГУУЛАЛТ 1.** building, construction **2.** structure **3.** system, **асаалтын** ~ ignition system, **хөргөлтийн** ~ cooling system (*auto.*)

**БАЙГУУЛАМЖ** structure, **нийгмийн** ~ social structure, **төрийн** ~ state structure

**БАЙГУУЛАХ** to build, to set up, to organize, to construct, to found, to establish

**БАЙГУУЛЛАГА** organization, institution

**БАЙГУУЛЛАГАРХАХ** to favour one's colleagues, to favour people from one's own organization

**БАЙГУУЛМАЛ** built, constructed

**БАЙДАГ** all, what there is of

**БАЙДАЛ 1.** (~ **төлөв**, ~ **төрх**, ~ **янз**) state, condition, situation, appearance, attitude, ~ **биш болох** to turn out badly, ~ **иймээс** (~ **ийм байхад**) this being so, in this situation, ~ **үзүүлэх** to pretend, to look as if **2.** aspect (*gram.*)

**БАЙДАЛТАЙ** with the appearance of, looking like, looking as if, § **бидний үгийг сайн**

- итгэхгүй ~ байв** he looked as if he did not really believe us
- БАЙДАС 1.** barren mare **2.** a mare in the third or fourth year
- БАЙДГААРАА** as hard as possible, for dear life
- БАЙЗ (~ гэм)** wait a minute!, hang on!
- БАЙЗААРАЙ** (see байз)
- БАЙЗНАСХИЙХ** to pause
- БАЙЗНАХ** to wait a moment, to hang on, to hold on, § **за байзна л даа** hang on a moment, **хэсэг байзнаад** after a bit
- БАЙК** flannelette (Russ.)
- БАЙЛАА 1.** was, were **2.** (after the participle in x) would
- БАЙЛАХ** to check
- БАЙЛГАХ 1.** to let be, to allow to be, to keep, to leave, **бат нууц ~** to keep (something) a strict secret, **өлөн чийгтэй ~** to keep (something) damp, § **хүүхэд багачуудыг мэсийн зүйлд ойр байлгахгүй байх юмсан** children and young people should not be left near sharp instruments, **хэсэг байлгасны дараа** after leaving it for a bit **2.** to dismiss, **тушаалаас ~** to dismiss from office
- БАЙЛГҮЙ (~ яах вэ)** certainly, of course, must, bound to, § **ирэх ~ дээ, жаахан хүлээе** he's bound to come, let's wait a little, **та их ядарч байгаа ~ дээ** you must be very tired, **яваандаа зүгээр болох ~ дээ** it's bound to get all right in time
- БАЙЛДААН** battle, combat, engagement, **давших ~** offensive battle, **тулгарах ~** encounter battle, **хориглох ~** defensive battle, **~ зогсоох** to cease hostilities
- БАЙЛДААНЧ** pugnacious, belligerent
- БАЙЛДААНЫ** military, battle, combat (adj.), live, ~ **ажиллагаа** military operations, ~ **анги** combat unit, ~ **боломж** military capability, ~ **буу (~ зэвсэг)** combat weapon, ~ **буудлагын хурд** effective rate of fire, ~ **бүрэлдэхүүн** forces, complement, ~ **бэлтгэл** combat training, ~ **бэлэн байдал** war footing, readiness for action, ~ **галт хэрэгсэл** live ammunition, ~ **жижүүр** service, ~ **жижүүрээс буулгах** to decommission, ~ **журам** battle formation, ~ **машин** personnel carrier, ~ **нислэг** air mission, sortie, ~ **сум** (see сум 3.), ~ **талбар** field of battle, ~ **туг** colours, ~ **хангалт** security (mil.), ~ **хөлөг онгоц** warship, ~ **цагийн байдал** **тогтоох** to declare martial law, ~ **цагт** in time of war, ~ **цэнэгт хошуу** warhead, ~ **чадал (~ чадвар)** military capability

- БАЙЛДАГЧ** private (mil.), **ахлах ~** lance-corporal, private first-class (Amer.)
- БАЙЛДАХ** to fight, to wage war, **байлдан авах** to capture, to take by storm, **байлдан дагуулагч** conqueror, **байлдан дагуулал** conquest, **байлдан дагуулах (байлдан дарах)** to conquer, **байлдан ололт** gain, conquest, **байлдан олох** to win in battle, to gain by fighting, **эрх чөлөөгөө байлдан олох** to gain one's freedom in battle, **байлдан тулалдах** to fight, **байлдан эзлэгч** conqueror, **байлдан эзлэх** to conquer
- БАЙЛИНЗ** lark (Chin.)
- БАЙЛТАЙ** should be, must be, cannot but be
- БАЙЛЦАХ** to be present (at), to attend
- БАЙМААЖИН (баймааж нь)** only when, once
- БАЙМААР** probable, **орос ~ хүн** someone who might be a Russian
- БАЙМААРГҮЙ** unlikely, improbable
- БАЙМГАЙ** full-sized
- БАЙМГҮЙ** must not be, should not be, cannot be
- БАЙМЖ** modal (gram.)
- БАЙМХАЙ** frequenting
- БАЙН БАЙН** again and again, keeping on
- БАЙН БАЙСААР** finally, in the end
- БАЙНГА (~ тогтмол)** permanently, constantly, regularly, ~ **буюу түр** permanently or temporarily
- БАЙНГАЛАН** regularly
- БАЙНГЫН** permanent, constant, regular, ~ **бус** irregular, ~ **үзэсгэлэн** permanent exhibition
- БАЙР 1. (~ байдал)** appearance, manner, **ажилсаг байрын хүн** a hard-working looking man, ~ **нь** it looks like it, apparently, ~ **үзүүлэх** to pretend, to look as if
- БАЙР II. 1.** room, apartment, quarters, **гурван өрөө ~** three-room flat, **байрны дулааны хэмжээнд байгаа бүлээн ус** warm water at room temperature, ~ **оромж** a shelter, ~ **сууц** dwellings, ~ **сууцгүй** homeless, ~ **сав** buildings, accommodation **2. (~ байц)** position, place, **ажлын ~** post, job, **нэгдүгээр байранд орох (тэргүүн ~ эзлэх, эхний байрт шалгарах)** to come in first, to take first place, **сул ~** vacancy, job vacancy, ~ **дээрээ** on the spot (mil.), ~ **дээрээ алхах** marching on the spot, ~ **дээрээ эргэх** turning on the spot, ~ **суурь** position, place, stand (polit., etc.), **олон улсын ~ суурь** international position, **чухал ~ суурь эзлэх** to occupy an important position, **байраа тавих** to yield (to), to give way (to), ~ **эзлэх** to occupy a position (mil., etc.); to gain a place (in a competition); to position oneself, to get in lane (auto.)

**БАЙРАН I.** regular, ~ суурин resident, permanent (*adj.*) **2.** all the time, permanently, ~ маллагаа farmyard rearing (of livestock), хагас ~ маллагаа semi-farmyard rearing (alternating with periods of open grazing) **3.** local

**БАЙРГАШИХ** to grow up, to mature

**БАЙРГАСУУ** mature, adult, ~ насны of mature years

**БАЙРЗҮЙ** topography

**БАЙРЗҮЙН** topographical, ~ зураг topographical map

**БАЙРЛАЛ** position, arrangement, § шудрага хөгжим гурван байрлалтай the шудрага has three positions

**БАЙРЛАЛТ** (see байрлал)

**БАЙРЛАХ I.** to be located, to be situated, to live, to dwell, to be positioned, to be arranged **2.** to take up quarters, to be stationed

**БАЙРЛУУЛАЛТ** stationing, quartering, arrangement

**БАЙРЛУУЛАХ I.** to instal, to position, to put, to put up, to locate, үсэг дарааллаар ~ to arrange in alphabetical order **2.** to station, to quarter (troops, etc.)

**БАЙРНЫ** (see байрын I.)

**БАЙРТАЙ** looking like, in the manner of, as if

**БАЙРШИЛ** location, siting, stationing

**БАЙРШИЛТ** (see байршил)

**БАЙРШИХ** to be located, to be placed, to be sited, to be positioned, to settle down, to be settled

**БАЙРШУУЛАХ** to station, to site, to locate

**БАЙРЫН I.** local, ~ мэдээ алдуулагч бодис local anaesthetic

**БАЙРЫН II.** looking, чийрэг ~ өвгөн a tough-looking old man

**БАЙСХИЙГЭЭД I.** in a moment, a moment later **2.** keeping on, again and again, frequently

**БАЙТАЛ** while, though

**БАЙТУГАЙ** let alone, not to speak of, тэр ч ~ let alone that, even apart from that, or even, and moreover, § манай хүүхэд чавхаар цонх хагалах нь ~ гэртээ нэг ч аяга хагалж үзээгүй юм шүү our children have never so much as broken a cup at home, let alone smashed windows with a catapult

**БАЙТУУ** priming (in painting)

**БАЙТУУДАХ** to prime, to lay a ground

**БАЙТУУЛАХ** to have a mishit in Mongol archery

**БАЙХ I.** to be (something, somewhere), to exist, байж сууж чадахаа болих (байж ядах) to be impatient, to find it hard to bear, § асуудлыг

шийдэх хэрэгтэй байна it is necessary to decide the question, багажны жин гурван кг байна the weight of the apparatus is three kg., комиссын даргын байхгүйд in the absence of the chairman of the committee, Чойжин ламыг байхад in the lifetime of the Oracle Lama **2.** (following a *converb* in ж, ч, аад to express a *continuing sense of the verb*), § вандан дээр сууж байсан Нацаг Natsag who was sitting on a bench, шалтгааныг судалж байна they are studying the reasons, яваад бай keep going! **3.** (following the *participle* in сан to express a *future in the past*), § та нар үзсэн байх аа you will have seen **4.** (following a *participle* in х or даг to express "would", "should", "could" etc.), § ийм аргууд хэрэв гараагүй бол цөмийн физик одоогийн том амжилтанд хүрэхгүй байсан if such methods had not emerged, atomic physics would not have achieved today's successes, олон хүний яриаг иш татаж болох байна I could quote what many people say, угаасаа бид эхнээсээ ерөнхий боловсролын дунд сургуульд оруулдаг байж дээ we really ought to have put him in a general education middle school to begin with, чи миний үгэнд ордог л байсан юм you should have done as I said **5.** (following the *participle* in х or the *finite suffix* in на to express a *sense of possibility*), § байлдааны талбараас зайлж болох байсан боловч although he could have left the field of battle, Гэрэлийгээ эргээд ирнэ байх гэж итгээд hoping that his Gerel might come back, зөвшөөрөл олгох байх they may well give permission **6.** to stop, to give up, § дахин очихоо байсан юм he gave up going there any more

**БАЙХГҮЙ I.** not to be, to be absent, ~ болох to die, § комиссын даргын байхгүйд in the absence of the chairman of the committee **2.** байхгүй юу of course, § харьдаг юм ~ юу I'm going home, aren't I?

**БАЙХУУ** black tea, pekoe (*Chin.*)

**БАЙЦ I.** (~ цохио) cliff, crag, ~ хадтай craggy

**БАЙЦ II.** line, stand (where archers stand in a contest)

**БАЙЦ III.** adverb

**БАЙЦ IV.** situation, state of affairs

**БАЙЦАА** cabbage, бөөрөнхий ~ round cabbage, исгэсэн ~ pickled cabbage, sauerkraut, цэцэгт ~ cauliflower (*Chin.*)

**БАЙЦААГЧ** inspector

**БАЙЦААЛ I.** evidence **2.** documentation

**БАЙЦААЛГА** examination, interrogation

**БАЙЦААЛТ** investigation, interrogation

**БАЙЦААХ** to investigate, to examine, to go into, to question, to interrogate, **гэрчийг** ~ to examine witnesses, **байцаан өнгөрүүлэхийнхэн** immigration officers, **байцаан өнгөрүүлэх газар checkpoint**, **байцаан шийтгэх хууль procedural law**, **иргэний байцаан шийтгэх ажиллагаа** civil procedure

**БАЙЦАХ** (see **байцаах**)

**БАЙШИН** building, house, ~ **барилга** (~ **сав**) buildings

**БАКТЕРИ** bacteria, **жинхэнэ** ~ eubacteria, **уйланхай** ~ slime bacteria, mycobacteria, **хүхрийн** ~ sulphur bacteria

**БАЛ I. 1.** (~ **чулуу**) graphite **2.** lead (of a pencil), **тосон** ~ ball-point

**БАЛ II. 1.** metallic taste **2.** metallic mark, ~ **болгох** to make a metallic mark on something

**БАЛ III.** (**зөгийн** ~) honey, **амгат** ~ syrup, ~ **бурам** treacle, syrup, ~ **сар** honeymoon, ~ **сар өнгөрүүлэх** to honeymoon

**БАЛАГ I.** fault, **үүний балгаар** thanks to that **2.** trouble, nuisance, ~ **тарих** to make trouble, to be a nuisance

**БАЛАГТ** harmful, destructive, deleterious

**БАЛАГТАЙ** (see **балагт**)

**БАЛАЙ I.** blind **2.** silly, foolish, stupid

**БАЛАЙРАХ I.** to be silly **2.** to talk nonsense

**БАЛАНСЖИГДАХ** to be balanced, **балансжигдсан төсөв** balanced budget

**БАЛАНСЖИЛТ** balancing (*fin.*)

**БАЛАНСЖУУЛАХ** to balance (*fin.*), **төсвийг** ~ to balance the budget

**БАЛАНСЛАЛТ** (see **балансжилт**)

**БАЛАНСЛУУЛАХ** (see **балансжуулах**)

**БАЛАР I. 1.** thick, dense, dark, impenetrable, ~ **ой** dense forest, ~ **харанхуй** pitch dark **2.** primitive, ~ **цаг** (~ **эрт цаг**) primitive times, prehistoric times, ~ **цагийн** (~ **эртний**) primitive, ~ **цагийн хүмүүс** primitive man, ~ **цагт** in primitive times, in prehistoric times, ~ **эртнээс нааш** from primitive times, § ~ **эртний тэртээнээс өнөөг хүртэл** from primitive times up to the present

**БАЛАР II.** (see **ээ балар**)

**БАЛАРДАХ I.** to be confused, to be stupefied **2.** to be effaced, to be rendered unclear (tracks, etc.)

**БАЛАРДУУЛАХ** to confuse

**БАЛАРТАХ I.** to be confused, to be stupefied,

**ухаан** ~ (see **ухаан 2.**) **2.** to be dark

**БАЛАРХАЙ** blurred, indistinct, unclear

**БАЛАРХАЙШИХ** to become blurred

**БАЛБА** (~ **улс**) Nepal

**БАЛБАГАНАХ** to hobble

**БАЛБАЛЗАХ** to shake, to quiver, to palpitate

**БАЛБАС ГЭХ** to stump along

**БАЛБАХ** to hammer, to beat, § **хаалгыг чанга балбан цохив** hammered heavily on the door

**БАЛБАЧУУД** Nepalese (people)

**БАЛБЫН** Nepalese (*adj.*), § ~ **дархан балбаж хийсэн** hammered out by a Nepalese smith (*liter.*)

**БАЛГА** a mouthful (of), a gulp (of), ~ **цай** a mouthful of tea

**БАЛГАЛЗАХ** to be lavish, to be open-handed

**БАЛГАНА** *Myricaria* (*bot.*)

**БАЛГАС** ancient city, ruined city, ruins, **эвдэрхий** ~ ruins **2.** town

**БАЛГАХ I.** to swallow, to gulp down **2.** to have a drink, § **би жаахан балгасан** I had a bit of a drink

**БАЛГАЧИХАХ** to have a drink, § **би жаахан балгачихсан юм** I had one or two

**БАЛДАРГАНА** Hogweed, *Heracleum*

**БАЛЕТЧИН** ballet-dancer

**БАЛЖИНГАРАМ** (see **Хамбашарилж 3.**)

**БАЛЖИННЯМТАЙ** auspicious, fortunate (*Tib.*)

**БАЛИАМ** young of **Ортоом**

**БАЛИАР I.** dirty **2.** (~ **бүдүүлэг**) coarse, rough, clumsy

**БАЛИАРТАХ** to get dirty, to get messed up

**БАЛИАРТУУЛАХ** to make dirty, to mess up

**БАЛИН** (~ **тахил**) sacrificial offering shaped out of dough (*Buddh.*) (*Skr.*)

**БАЛИНЧ** lama responsible for the **балин** in a lamasery

**БАЛИУС I.** cleaver, broad-bladed knife **2.** trimming knife (*ysl.*)

**БАЛЛ** point, number (on a scale, etc.) (*Russ.*)

**БАЛЛАХ I.** to rub out, to erase, to expunge, to obliterate **2.** to ruin, to destroy

**БАЛЛУУР** rubber, eraser

**БАЛЛУУРДАХ** to erase

**БАЛМАГДАЛ** fright, scare, anxiety

**БАЛМАГДАХ** (**балмагдан сүрдэх**, **балмагдан тэвдэх**) to be scared, to be worried, to be anxious

**БАЛМАГДУУЛАХ** to frighten

**БАЛМАД** mad, crazy, wild, adventurer, ~ **ЭТГЭЭД**  
trouble-maker

**БАЛМАДЛАХ** to go wild, to go mad

**БАЛНАД** (гэдэсний ~) typhoid, иж ~ paratyphoid, эсэргэнэт ~ spotted fever, typhus

**БАЛРАГДАХ** (see **балрах**)

**БАЛРАХ** 1. to be effaced, to become indistinct, to be erased, to be rubbed out 2. to fail, to be ruined, to collapse, to come to nothing, to be dashed (hopes), **балран сүйрэх** (баларч унах) to fail, to collapse (policy, etc.), § **баларсан юм** it's all up then, **муу ах чинь баларсан хүн дээ** I've had it then, **тэр мэдчихвэл баларна шүү** once he hears of it there'll be hell to pay

**БАЛТ** axe

**БАЛТАГ** bolster (of a blade)

**БАЛТАЙХ** (балтайн хэвтэх) to lie low, to keep one's head down

**БАЛТАС ХИЙХ** to waddle, to stagger

**БАЛТГАР** short and fat, squat, tubby

**БАЛТГАРДУУ** (see **балтгар**)

**БАЛТЫН ТЭНГИС** Baltic Sea

**БАЛУУН** Hyssop, *Hyssopus*

**БАЛУУНА** lungwort, *Pulmonaria*

**БАЛХАЛЗАХ** to waddle

**БАЛЦГНАХ** to waddle

**БАЛЦГАР** (see **балтгар**)

**БАЛЦРУУ** necrobacillosis (in sheep and cattle) (see **догол II.**)

**БАЛЧИГ** muddy place, bog

**БАЛЧИГНАХ** to squelch

**БАЛЧИР** young, tender, infant, ~ **ахуй цагаас** from infancy, ~ **багадаа** in one's infancy

**БАЛЧИРГАНА** 1. (see **Агширгана**) 2. *Angelica* (bot.), **Санжгар** ~ *A. decurrens*

**БАЛЧИРДАХ** to be immature, to be too young

**БАЛЪВИ** *Caltha* (bot.) (also **Цан цэцэг**)

**БАМ** (~ **өвчин**, ~ **чийгийн өвчин**) scurvy (see also **чийг**)

**БАМБАГАР** thick and soft, well-padded

**БАМБАЙ** I. Valerian, *Valeriana*, **Гацмал** ~ *V. dubia*, **Эмийн** ~ *V. officinalis*, **Бамбайн овог** (**Бамбайн язгуур**) Valerian family, Valerianaceae (*Tib. spang-spos*)

**БАМБАЙ II. 1.** shield, ~ **барих** to shelter behind, **бусдыг** ~ **болгон барих** to shelter behind others, ~ **булчирхай** (see **булчирхай**), **бамбайн дайвар булчирхай** (see **булчирхай**) 2. load-pad for a camel 3. mattress 4. (~ **баг цэцэг**) corymb (bot.)

**БАМБАЙЖ** Buckler Fern, *Dryopteris*, **Үнэрт** ~

Fragrant Buckler Fern, *D. fragrans* (also **Үнэрт Ойм**)

**БАМБАЙЛАХ** 1. to pad out, to make puffy, to get puffy 2. to shield, to shelter

**БАМБАЙЛГАХ** to stuff, to pad out

**БАМБАЙРХУУ** shield-shaped, peltate (leaf, etc.)

**БАМБАЙТ ЗАМБАГАНА** Fringed Waterlily, *Nymphoides peltata*

**БАМБАЙХ** to be thick and soft, to be puffy, **бамбайн хавагнах** to swell up, to puff up, § **толгой нь бамбайн манарч, хоолой ам нь хатна** he had a thick head and his throat and mouth felt dry

**БАМБАЙ ХОНШООРТ** a species of Pit-viper

**БАМБАЛЗАХ** to quake, to be springy

**БАМБАЛЗУУР** 1. quagmire, bog 2. squashy, flabby, spongy

**БАМБАР I.** tiger-cub

**БАМБАР II.** torch (of combustible material on a stick), **Олимпийн** ~ Olympic torch

**БАМБАРДАХ** to flame (a surgical instrument, a cold motor, etc.)

**БАМБАРЛАХ** to form or look like a torch, to be in a cluster (frost on plants, etc.)

**БАМБАРУУШ** bear-cub

**БАМБАРЦАГЛАХ** to form droplets (fat on a liquid)

**БАМБАРЧИН** torch-bearer

**БАМТАХ** to have scurvy

**БАН** (~ **мод**) plank (*Chin.*)

**БАНАГ** spare tent

**БАНГА I.** Hawksbeard, *Crepis*

**БАНГА II.** (~ **донго**) reprimand

**БАНГАДАХ** to tell off, to tear a strip off

**БАНДАЙХ** to get fat, to fill out

**БАНДАН I.** (~ **ширээ**) bench, **аймгийн** ~ booth for selling objects for offerings in an Urga aimag 2. board for worshippers to prostrate themselves on in a lamasery

**БАНЦГАНАХ** to wag, to swing

**БАНЦГАР** big, thick, fat

**БАНДИ** 1. Buddhist novice, pupil of a lama 2. young chap, young fellow, lad, **сүрхий** ~ a fine little fellow 3. catamite (*Skr.*)

**БАНДИД** pandit, Buddhist savant, ~ **малгай** hat with long ear-pieces, worn by high lamas (*Skr.*)

**БАНДИДАХ** (see **бандичлах**)

- БАНДИЧЛАХ** pederasty, buggery
- БАНЖИХ** to prepare, to get ready (*trans.*)
- БАНЗ I.1.** board, plank, sawn timber, **бөөр** ~ half-round log, **наамал** ~ (see **наамал**) **2.** cudgel or truncheon used for beating in Manchurian times (*hist.*) (*Chin.*)
- БАНЗ II.** furrow
- БАНЗАЛ** skirt, **мини** ~ mini-skirt, ~ **эм** a bit of skirt, tart (*Skr.*)
- БАНЗДАХ** to beat with a **банз**
- БАНЗДОО** Sawwort, *Saussurea*, **Нөмрөгт** ~ *S. involucrata* (also **Вансэмбэрүү**)
- БАНЗЛАХ** (**банзлан зүсэх**) to saw into planks or boards
- БАНЗЧИН** beater, **банз-wierder** (*hist.*)
- БАНК I.** bank (*fin.*), **арилжааны** ~ commercial bank, **дэлхийн** ~ World Bank, ~ **дээрэмдэх** bank robbery, ~ **хоорондын төлбөр тооцооны төв** clearing-house
- БАНК II.** jar (*Russ.*)
- БАНЛАГ** (~ **өвс**) Orchid, *Orchis*, *O. militaris*, *O. salina* (see **Цэгрэм**)
- БАНТАГНАХ 1.** to make gruel, to mix (flour and fat, etc.) **2.** to make a muddle
- БАНТАН 1.** gruel, soup with flour, **хурган** ~ a sort of fine gruel **2.** (**холир** ~) muddle, in a muddle, ~ **хутгах** to muck things up
- БАНТАХ** to look guilty, to be embarrassed
- БАНУУ** stalactite
- БАНУУНЦАР** stalagmite
- БАНХАР** snub-nosed
- БАНХГАР** (see **банхар**)
- БАНЦАНБҮРҮҮ** (see **Вансэмбэрүү**)
- БАНЧИН БОГД** Panchen Lama
- БАНЧИН ЭРДЭНЭ** (see **Банчин Богд**)
- БАНШ** boiled meat dumplings, **азын** ~ lucky dumpling containing silver (at New Year)
- БАНЬД** kid, youngster
- БАР I.1.** Tiger, **цаасан** ~ paper tiger, **Хутган соёот** ~ Sabre-toothed Tiger, **барын сүүл байснаас батганы толгой байсан дээр** better to reign in hell than serve in heaven **2.** newly industrialized country
- БАР II.** printing-block, **зэс** ~ copper printing-block, **модон барын ном** blockprint, xylograph, **ойрын** ~ recently cut blocks, **холын** ~ old stock of blocks, ~ **ван** master-printer in a woodblock printery, **барын зураг** woodcut, ~ **сийлбэр** xylography, **барын сүм** printery in a lamasey (*Tib. par*)

**БАР III.** bar (drinking)

**БАРАА I.** (~ **таваар**) goods, merchandise, **өргөн хэрэгцээний** ~ consumer goods, ~ **материалын тооллого** stock-taking, ~ **солилцоо** barter

**БАРАА II.** shape, sight, glimpse, outline, **барааны газар** as far as the eye can see, ~ **дур** (~ **дүрс**, ~ **зүс**) sign, sight of, glimpse, ~ **сураггүй** (~ **сураг алга**) without a sign, without a trace, ~ **сүртэй** handsome, imposing, ~ **тасрах** to disappear, to vanish, to drop out of sight, ~ **туруу** trace, sign, ~ **туруугүй** without a trace, ~ **харах** (~ **цараа харах**) to spy out the ground, to have a good look round, § **алсын** ~ **тасартал** till they were lost in the distance, **бүрий болж холын** ~ **тасран** with the light failing and the view closing in, **нилээд олон морьтой хүмүүсийн** ~ **харагдсан** several mounted men could be glimpsed, **хааны ирж явах бараанаар** as the khan hove in sight, **хүний бараа харсан тахь** a wild horse that has caught sight of a man, **шинэ арагны бараа эс хараад удаж байна** it's a long time since I've had a sight of a new dung basket, **бараагийн нь цөөхөн л харсан хүн дээ** he's not someone I've seen much of, ~ **туруу нь үзэгддэггүй зүйлүүд** things you never catch a sight of

**БАРАА:** ~ **болох** to be in attendance on, to attend, to be in the suite of, **ноёны** ~ **болох** to be in a nobleman's suite, ~ **бологч** attendant, courtier, ~ **бологсод** attendants, suite, ~ **сүүдэр** escort

**БАРААВТАР** darkish, rather dark-coloured

**БАРААГНАХ** to be seen in outline, to be seen in the distance

**БАРААГҮЙ** out of sight, not in sight, **малын** ~ not a beast in sight, ~ **болох** to be out of sight, to go out of sight

**БАРААДАХ 1.** to frequent, to stay near to, to stick close to, to haunt, **гэрээ** ~ to keep close to home, **бараадан дагах** to dog **2.** to be near, § **цементийн аж үйлдвэр бол түүхий эдээ бараадан байршина** the cement industry will be situated near its raw materials

**БАРААЖИХ** to get stocked up

**БАРААЖУУЛАХ 1.** to stock up **2.** to turn one's money into goods

**БАРААЛАХ** to show up darkly, to look dark, to stand out

**БАРААЛХАЛ** official call, call, audience

**БАРААЛХАЛТ** (see **бараалхал**)

**БАРААЛХАХ** to call upon, to be received by, to have an audience with, § **Гадаад яамны сайдад** ~ to be received by the Foreign Minister

**БАРААЛХУУЛАХ** to present, to introduce



**БАРААН** dark, dark-coloured, ~ газар (газрын ~) bare patch in snow-covered ground, ~ дүр залах to become a layman (*Buddh.*), ~ өвөл snow-free winter, ~ хүрэн dark brown

**БАРААНДУУ** dark, darkish

**БАРААНТАХ** to darken, to get dark, to show up dark (patches in snow-covered ground, etc.)

**БАРААНТУУЛАХ** to darken, to make dark

**БАРААТАЙ** looming, imposing, § Соёо уул алсаас ~ харагдана the Sayan mountains loomed up in the distance

**БАРААШИГ** home-brew

**БАРАВГАР** rough, coarse

**БАРАГ** 1. almost, nearly, ~ бүхэл жилийн турш for almost a whole year, ~ газар бүр almost everywhere, ~ төлөв for the most part, ~ үгүй hardly at all, not much, ~ ... шахам (~ ... шахуу) almost, nearly, ~ зэрэг шахам almost at the same time, almost together 2. most, most of, § баргий нь алж killing most of them, тэр муу ёрын томуу өвчнөөр хүрээнийхэн ~ нь өвдөж most of the Urga people were ill with that miserable influenza

**БАРАГ БҮРЭГ** dim

**БАРАГДАХ** to be dealt with, to be determined, to be settled, to be finished

**БАРАГДАШГҮЙ** inexhaustible, endless

**БАРАГДУУЛАЛТ** settlement, determination

**БАРАГДУУЛАХ** to deal with, to determine, to settle, to finish, өр төлбөр ~ to pay off a debt

**БАРАГЖАА** *Woodsia* (*bot.*)

**БАРАГЛАН** more or less, pretty well

**БАРАГЛАХ I.** to have an idea of, to guess, to estimate

**БАРАГЛАХ II.** to do for the most part, to almost finish off, to be almost over

**БАРАГТАЙ** 1. all right, not bad, OK 2. not too good, pretty poor, mediocre

**БАРАГТАЙ БОЛ** hardly, almost, mostly, for the most part

**БАРАГТАЙХАН** (see **барагтай** 2.)

**БАРАГЦАА** estimate, ~ таамгаар at a guess

**БАРАГЦААЛАЛ** estimate

**БАРАГЦААЛАХ** to estimate, барагцаалсан тоо estimated number, rough number, барагцаалан харах to glance over

**БАРАГЦААЛБАЛ** approximately, at a guess, § ажиллагсдын ~ тавин хувь an estimated fifty per cent of the workers

**БАРАГЦАХ** (see **бараглах** I.)

**БАРАГЧИН** High Mountain Vole, *Alticola*, Соёны ~ large-eared Vole, *A. macrotis*,

Тавшгар ~ Flat-headed Vole, *A. strelzowi*, Хадны ~ Silver-backed Vole, *A. argentatus*

**БАРАГШИН** 1. bitumen 2. asphalt (*Tib. brag-zhun*)

**БАРАГШИНДАХ** to asphalt

**БАРАГШУН** (see **барагшин**)

**БАРАЙ БҮРИЙ** twilight

**БАРАЙЛГАХ** to darken (*trans.*), царайгаа ~ to glower

**БАРАЙХ** 1. to darken, to show up darkly 2. (царай нь ~) to glower

**БАРАМ** someone (usually a woman) expelled as a scapegoat (*hist.*), барамд гаргах to expel as a scapegoat

**БАРАМИД** perfection, perfective virtue, зургаан ~ the Six Perfections (*Buddh.*) (*Skr.*)

**БАРАХ** 1. to finish, to use up, to come to the end of, to get through, байхаар ~ уу (ингэхээр ~ уу) of course, why not?, нас ~ (see **нас**), § адуу хужир иддэг үү. Идэхээр ~ уу do horses eat salt? Of course they do 2. to manage to

**БАРАХГҮЙ** 1. not only ... but also, түүгээр ч ~ and what is more 2. not to manage to

**БАРБОН** master-printer (*xyl.*) (*Tib. par-dpon*)

**БАРВАГАР** coarse, rough

**БАРГА I.** Barga (Mongolian area and people), ~ малгай hat with a pointed crown and velvet or fur surround, worn by high lamas

**БАРГА II.** (~ бүдүүн) rough, crude

**БАРГАР** gloomy, sullen, dull, ~ хар тэнгэр a lowering sky, ~ царайлах to glower, to look sullen

**БАРГИА** raucous, hoarse, harsh

**БАРГИЙН** most, most of, ~ хоол most of the food, ~ юм most things

**БАРГИЛ** 1. low, gruff 2. coarse 3. (~ хоолойтой) baritone

**БАРГИЛДУУ** (~ хоолойтой) baritone

**БАРГИЛТ ЧУЛУУ** marl-stone

**БАРГИХ** to be hoarse

**БАРДАА** 1. for sure, certainly, undoubtedly 2. ample

**БАРДААГААР** (see **бардаа** 1.)

**БАРДАГНАЛ** boast, boasting, bragging

**БАРДАГНАХ** to be boastful, to be cocky, to swank

**БАРДАМ I.** (ам ~) boastful, bragging, arrogant, cocky

**БАРДАМ II.** for sure, certainly, undoubtedly

**БАРДАМНАХ** to brag, to boast

**БАРДАРХАХ** (see **бардамнах**)

**БАРДАХ** to boast, to be proud, to be full of oneself, **бардвал балрана** pride comes before a fall

**БАРДУУ** (see **бардам I.**)

**БАРЖИН** rough, uneven

**БАРЗАЙЛГАХ** to roughen

**БАРЗАЙХ** to be rough, to be uneven

**БАРЗГАР** (~ **бурзгар**) rough, uneven, ~ **болгох** to roughen

**БАРЗГАРДУУ** roughish, rough

**БАРЗГАРХАН** roughish, rather uneven

**БАРИА I.** (**барианы газар, барианы шугам**) finishing line (in a horse-race, etc.), ~ **гарааны зааг дээр** between the finish and the start (of two five-year plans), **барианы жил** last year (of a plan), **бариад орох** to come in, to reach the finishing line

**БАРИА II.** pledge, security, ~ **барих** to seize (livestock) as security when pasture boundaries are infringed (*hist.*)

**БАРИА III.** (~ **засал**) manipulation (*med.*), ~ **засалч** manipulator

**БАРИАТАЙ I.** set up, built, erected

**БАРИАТАЙ II.** pledged, guaranteed

**БАРИАЧ** chiropractor, bone-setter, manipulator, masseur, ~ **илээч** manipulators

**БАРИВЧ I.** gown for a small child

**БАРИВЧ II.** sleeve (*mech.*)

**БАРИВЧИЛГАА** arrest (*jur.*), **нийтийн** ~ mass arrests

**БАРИВЧЛАГА** (see **баривчилгаа**)

**БАРИВЧЛАЛТ** (see **баривчилгаа**)

**БАРИВЧЛАХ** to arrest, to seize, to capture, to take prisoner, ~ **хуудас** arrest warrant

**БАРИГДАХ I.** to be kept, to be held **2.** to be arrested, to be seized, to be caught **3.** to be stricken by, to be affected by, **бөөсөнд** ~ to be infested with lice, **хог ургамалд** ~ to get overgrown with weeds, **чийг бамд** ~ to have scurvy

**БАРИГДАШГҮЙ** not to be caught

**БАРИГЧ** catcher, holder, **морь** ~ horse catchers (who catch and hold the horses at the end of a race), **щеток** ~ brush-holder (*dynamo*)

**БАРИЛ I.** knack, hang, way, method, ~ **байцыг олох** to get the hang (of), ~ **арга** (~ **дадал**) method **2.** grip, hold (bow, musical instrument, etc.)

**БАРИЛАХ I.** to smooth, to stroke, to finger **2.** palpation (*med.*)

**БАРИЛГА** (~ **байгуулалт, ~ байгууламж**) building (structure, construction-work), **их** ~ construction-work, **уран** ~ architecture, ~ **байшин** (~ **сав**) buildings, **барилгын ухаан** building science, architecture

**БАРИЛГАЖИЛТ** development (through building)

**БАРИЛГАЖИХ** to get built up, to get developed

**БАРИЛГАЖУУЛАХ** to provide buildings, to develop

**БАРИЛГАР** wide, broad

**БАРИЛГАЧИН** builder

**БАРИЛДАА** relationship, connection, union, **багш шавийн** ~ the relationship of teacher and pupil, **харилцан барилдаатай** mutually related

**БАРИЛДААН** wrestling, **сонгомол** ~ Greco-Roman wrestling, **чөлөөт** ~ freestyle wrestling

**БАРИЛДАХ I.** to have a mutual relationship, to be united, to be joined, **багш шавь** ~ to have the relationship of teacher and pupil **2.** to wrestle, **барилдахаасаа таахалзах нь** to count one's chickens before they are hatched

**БАРИЛДЛАГА I.** tie, bond, relationship, **багш шавийн** ~ the tie between teacher and pupil **2.** conjunction (of planet and constellation in Mongolian astrology)

**БАРИЛДЛАГААТАЙ** connected, related

**БАРИЛТ I.** hold, grip **2.** manipulation **3.** bag, haul **4.** construction

**БАРИЛЦАХ** to grasp each other, **гар** ~ to shake hands

**БАРИМ** (**мухар** ~) measurement equal to the width of the fist or the distance across four fingers, **үзүүр** ~ the same, plus the length of the outstretched thumb

**БАРИМАЛ I.** a sculpture, statue, **баримлын шавар** modelling clay **2.** sculpted

**БАРИМАЛЦАХ** to sculpt, to model

**БАРИМАЛЧ** sculptor

**БАРИМАЛЧИН** (see **барималч**)

**БАРИМЖАА I.** rough idea, outlines, **нүдэн баримжаагаар** at a visual estimate, ~ **хэмжээ** rough measurement **2.** landmark, bearings, ~ **авах** (~ **хийх**) to get one's bearings

**БАРИМЖААЛАЛ** estimation

**БАРИМЖААЛАХ I.** (**баримжаалан тодорхойлох**) to estimate, to get a rough idea of **2.** (**зүг чигээ баримжаалан олох**) to get one's bearings, to orientate oneself

**БАРИМИД** (see **барамид**)

**БАРИМТ 1.** fact, evidence, proof, ~ **нотолгоо** (~ **сэлт**) data, facts, information, evidence **2.** (~ **бичиг**) document, documentation

**БАРИМ ТАВИМ** (see **барин тавин**)

**БАРИМТЖУУЛАХ** to document, to enter up

**БАРИМТЛАГЧ** adherent, supporter, follower

**БАРИМТЛАЛ 1.** principle **2.** concept

**БАРИМТЛАХ** to follow, to act according to, to adhere to, to stick to, **баримтлан захирах** to control, § **хоолны дэглэмийг нарийн** ~ to keep strictly to one's diet

**БАРИМТТАЙ** proven, well-founded, documented, factual, definite

**БАРИН ТАВИН** straight out, direct, off the cuff

**БАРИНТАГ 1.** gown **2.** cloth wrapper for a book (*hyl.*), **цамцан** ~ small inner wrapper for a book

**БАРИНТАГЛАХ 1.** to wrap (a book, etc., in a wrapper) **2.** to freeze up (river)

**БАРИУ** tight, tight-fitting (boots, clothes, etc.)

**БАРИУВЧ** gown for a small child

**БАРИУЛ 1.** handle, **асаалтын** ~ starting handle, **хаалганы** ~ door handle **2.** (**шатны** ~) handrail (of stairs) **3.** hilt (of a sword) **4.** grip (of a bow) **5.** leaf-stalk, petiole

**БАРИХ 1.** to hold, to grasp, to keep, to wield, **дүрэм** ~ to stick to the rules, **замын баруун талыг** ~ to keep to the right **2.** to take, to catch, to pick up, **загас** ~ to catch fish, **морь** ~ to catch a horse; to catch the horses as they approach the winning line, **нэвтрүүлэг** ~ to pick up a broadcast **3.** to arrest **4.** to offer, to present **5.** to pitch (a tent), to build, **байшин** ~ to erect a building, **барьж байгуулах** to build, to set up, to construct **6.** to light, **зул** ~ to light a lamp (*Buddh.*), **лаа** ~ to light a candle **7.** **яс** ~ to bury a corpse **8.** to play, **хөгжим** ~ to play an instrument, to play music **9.** to restrain, to hold back, to keep in, **инээдээ** ~ to contain one's laughter, **нулимсаа** ~ to hold back one's tears, **барьж тогтоох** to contain (*polit.*) **10.** to manipulate (bones) **11.** to drive

**БАРЛАГ** servant, labourer, drudge

**БАРЛАМАЛ** block-printed, xylographed

**БАРЛАХ** to print from blocks

**БАРМНАС** fine dust

**БАРОН** Baron Ungern-Sternberg

**БАРС** Tiger, **Илдэн соёот** ~ Sabre-toothed Tiger

**БАРСАЙХ** to be rough, to be uneven, to be rugged

**БАРСГАР** rough, uneven, rugged

**БАРСХИЙХ** (**царай** ~) to glower

**БАРТАА 1.** rough ground, broken ground **2.** (~ **бэрхшээл**) obstacle

**БАРТААЛАГ** rough, rugged, ~ **газар** rough ground, broken ground

**БАРТААТ** rough, rugged, ~ **зам** a rough road, ~ **замаар уралдах** to run in a cross-country race

**БАРТААТАЙ** rough, rugged, ~ **газар** rough ground, broken ground

**БАРТААТАХ** to get rough, to get rugged

**БАРТААШИХ** (see **бартаатах**)

**БАРТАГ** rough, rough and ready, crude, clumsy

**БАРТАГЛАХ** to make a botch (of something), to botch up, to make a mess

**БАРУУГААР** to the west, to the right

**БАРУУЛАХ** to go westward, **нар баруулахад** towards sunset

**БАРУУН** west, western, right, right-hand, **гэрийн** ~ **тал** the right-hand or western half of the tent, ~ **гар** right hand; right, right-hand; close comrade, right-hand man, ~ **гар талд** on the right-hand side, ~ **гар тийшээ эргэх** to turn right (*traf.*, etc.), ~ **дамнуурчин** "Western Pedlars" (name of a district in Urga) (*hist.*), ~ **зүгийн орнууд** western countries, ~ **зүгийнхэн** westerners, ~ **өмнө** south-west, ~ **өмнөх** south-west (*adj.*), ~ **солгойгүй** furiously, regardless, ~ **солгойгүй гуядах** to lash mercilessly, ~ **солгойгүй худал хэлэх** to lie left and right, ~ **тийш** (~ **гар тийш**) to the right, to the west, ~ **урагшаа** towards the south-west, ~ **урд** south-west, **барууны үзэл** rightist views, ~ **хойд** (~ **хойт**, ~ **хойно**) north-west, ~ **хойшоо** towards the north-west, § **Араб бичгийг** ~ **гар талаас зүүн тийш нь бичдэг** the Arabic script is written from right to left

**БАРУУНАА** in the west, to the west

**БАРУУН ГАЗАР** Tibet

**БАРУУН ЗУУ** Lhasa

**БАРУУН ОРОН** Tibet

**БАРУУН ӨРГӨӨ** the "Western Pavilion" (the tent of Abtai Khan, originally erected at Erdene Zuu, incorporated into Urga at the time of the first Khutuktu, and moved to the site of Urga by the Selbe River in 1778. It was known as the Western Pavilion because it was pitched to the west of the Khutuktu's palace)

**БАРУУНТААХ** to the right of, to the west of (*adj.*)

**БАРУУНТАЙ** west, westwards, § **Улаанбаатар хотоос** ~ **далан гаруйхан километрийн тэртээ** a little over seventy kilometres west of Ulaanbaatar, **баруунтайгаасаа зүүн тийшлэх тутмаа** the further one goes from west to east

**БАРУУНТАЙХ** (see **баруунтаах**)

**БАРУУНТАН** rightist (*polit.*)  
**БАРУУНШ** towards the right, towards the west  
**БАРУУНШЛАХ** to go westwards  
**БАРХАГ** anchor (*Bur.*)  
**БАРХАН** xylographic printery (*Tib. parkhang*)  
**БАРХАСБАДЬ** (~ **гариг**) Jupiter (*Skr.*)  
**БАРХИРАА** noisy, strident  
**БАРХИРАЛДААН** shouting, yelling  
**БАРХИРАЛДАХ** to shout, to make a row  
**БАРХИРАХ** to shout, to scream, to yell, to roar  
**БАРЦАД** (~ **гай**) hindrance, obstacle, impediment, misfortune (*Tib. bar-chad*)  
**БАРЧГАР** rough, rugged  
**БАРЧИД** (see **барцад**)  
**БАРЧИЙХ** to be rough, to be rugged  
**БАРЧИН** xylographic printery worker  
**БАРЧИХ** to use up, to use out  
**БАРШГҮЙ** inexhaustible, **тоолж** ~ innumerable, **үнэлж** ~ inestimable, **эмгэнэвч** ~ cannot be too much regretted  
**БАРЬЦ I.** offering, gift (made by the faithful at a service)  
**БАРЬЦ II.** grip, grasp, ~ **авах** to get a grip, ~ **алдах** to lose one's grip, **барьцаа лавлах** to get a good grip (wrestling)  
**БАРЬЦАА I. 1.** pledge, caution, guarantee, security, pawning, **барьцаанд авах** to take hostage; to take as security, to take in pawn, **барьцаанд өгөх** to pawn, **барьцаат үйлчилгээ** (**барьцаат зээлийн үйлчилгээ**) pawnbroking service, **барьцааны хүн** hostage **2.** bail, **барьцаагаар суллагдах** to be released on bail  
**БАРЬЦАА II.** adjoining, ~ **өртөө** preceding or following relay station, ~ **харуул** adjoining or opposite watchposts (*hist.*)  
**БАРЬЦААЛАХ 1.** to guarantee, to cover, ~ **хөрөнгө** security **2.** to pawn **3.** to refer to  
**БАРЬЦАЛ** key (for plastering, etc.)  
**БАРЬЦАЛДАЛТ** adhesion, grip, § **дугуй замын хоорондох** ~ adhesion between wheels and road  
**БАРЬЦАЛЦАХ** to adhere, to be gripped, **мөстэй** ~ to be gripped by the ice, ~ **чанар** adhesion  
**БАРЬЦАЛДУУЛАХ** to bind, to bond  
**БАРЬЦАЛТ** adhesion, grip  
**БАРЬЦАХ** to contend  
**БАРЬЦҮГҮЙ** hard to grasp, elusive

**БАРЬЦТАЙ** substantial, tangible  
**БАРЬЦУУЛАХ** to pawn  
**БАРЫН ЧИХ** Hydrangea (*bot.*)  
**БАС** further, again, moreover, ~ **бус** all sorts of, ~ **л** still, still not, not yet, ~ **л тэр** same again, ~ **л хэд хоног** a few days more, ~ **ч үгүй** moreover, furthermore § **хотын хөл** ~ **л тасраагүй байлаа** the town traffic had not died down yet  
**БАСАМЖЛАЛ** scorn, contempt, derision  
**БАСАМЖЛАНГУЙ** scornful, disdainful  
**БАСАМЖЛАХ** to look down on, to scorn, to despise, to deride, **басамжлан сагсуурах** to be contemptuous  
**БАСАХ** to look down on, to scorn, to despise, to deride, **басан доромжлох** to humiliate, to insult, **бассан өвс бөгс хатгадаг** a slighted grass pricks one's behind (a warning against complacency)  
**БАСГАН** girl  
**БАСГАРАХ** to be thick (smoke, tea, etc.)  
**БАСГАХ** to swirl, to wreath (smoke)  
**БАСХҮҮ** furthermore  
**БАТ** (~ **нут**) strong, solid, firm, ~ **бэх** strength, solidity, toughness; strong, solid, tough, ~ **илэрхийлэх** membership book, ~ **оршил** a service performed for the benefit of the Jebtsundamba Khutuktu (the Mongolian version of **даншиг**), ~ **оршлын наадам** (see **даншигийн наадам**), ~ **оршил өргөх** (see **даншиг өргөх**), ~ **орших** to prevail, to hold good, to persist, to come true, **тэр ерөөл** ~ **оршугай** may that wish come true, ~ **орших чадвар** stability, durability, ~ **тогтвортой stable** (*chem., etc.*)  
**БАТАЛГАА 1.** proof, confirmation, corroboration, assertion **2.** guarantee, **гэрлэлтийн** ~ marriage, certificate, ~ **бичиг** certificate  
**БАТАЛГААЖИЛТ** confirmation, guaranteeing  
**БАТАЛГААЖИХ** to be confirmed, to be guaranteed  
**БАТАЛГАЖУУЛАХ** to confirm, to guarantee  
**БАТАЛГААТ** guaranteed, ~ **хугацаа** period of guarantee  
**БАТАЛГААТАЙ 1.** proven, certain **2.** guaranteed, covered **3.** registered (letter)  
**БАТАЛЬОН** battalion (*mil.*) (*Russ.*)  
**БАТАРЕЙ** battery (*elec.*) (*Russ.*)  
**БАТАТГАХ** to strengthen, to reinforce, to confirm, § **оношийг бататган нотлох** to confirm the diagnosis  
**БАТГА** spot, pimple, blackhead, acne  
**БАТГАНА** Fly, Midge, **батганын хошуу батгах зайгүй** not enough room to swing a cat in

**БАТГАНА ХОР** (Батганы хор, Батганын хор)  
*Aconite, Aconitum, A. barbatum* (see **Хорс**)

**БАТГАРАХ** to have spots, to have pimples, to have blackheads, to have acne

**БАТГҮЙ** unstable, infirm

**БАТ ГҮН** name of a prison in Uрга (*hist.*)

**БАТЖИЛ** stability

**БАТЖИЛТАЙ** stable, solid, ~ байдал stability

**БАТЖИХ** (батжин бэхжих) to grow strong, to grow firm

**БАТЖУУЛАХ** (батжуулан бэхжүүлэх) to strengthen, to reinforce, to make firmer, to fortify, to back up

**БАТЛАМЖ** confirmation, ratification, ~ жуух бичиг instrument of ratification

**БАТЛАМЖЛАХ** to confirm, to ratify

**БАТЛАХ** 1. to prove, to confirm, to approve, to ratify, to endorse, ~ бичиг certificate, батлан гаргах to promulgate, батлан даагч guarantor, батлан даал guarantee, батлан даах to guarantee, батлан хамгаалах to defend, to protect, to safeguard; defence, Батлан Хамгаалах Яам Ministry of Defence, Улсыг батлан хамгаалахад туслах нийгэмлэг Auxiliary Society for the Defence of the State, ~ хариу affirmative answer 2. certificate, membership card

**БАТРАШ** (~ өвс) Mint, *Mentha*

**БАТТАЙ** definite, firm, reliable, solid

**БАТХААЛГА** Bailingmiao (*p.n.*)

**БАТЦАГААН** Sycamore, Maple (*bot.*)

**БАХ** I. (~ мэлхий) Toad

**БАХ** II. resin

**БАХ** III. joy, pleasure, fun, ~ ханах to be pleased, to enjoy oneself, to have a good time; to gloat, бахаа хангах to indulge oneself

**БАХ** IV. 1. (хоолойн ~) quinsy 2. angina pectoris

**БАХАРДАНГИ** confused, embarrassed

**БАХАРДАХ** 1. to be confused, to feel harassed, to be hysterical 2. hysteria, бахардан унадаг өвчин epilepsy

**БАХАРДУУЛАХ** to confuse

**БАХАРХАЛ** admiration, pride, gratification, pleasure

**БАХАРХАЛТАЙ** 1. gratifying, pleasing 2. pleased

**БАХАРХАМ** gratifying, pleasing

**БАХАРХАНГУЙ** proudly, pleased with oneself

**БАХАРХАХ** to admire, to be proud of, to be gratified at, § эх орондоо ~ to be proud of one's country

**БАХАРХМААР** pleasing, gratifying

**БАХАРХУУ** pleased, happy

**БАХАРХУУЛАХ** to please, to delight

**БАХАРХУУШТАЙ** gratifying, ~ зүйл something to be proud of

**БАХДАЛ** joy, delight

**БАХДАЛТАЙ** pleasing, gratifying

**БАХДАМ** (see **бахдалтай**)

**БАХДАХ** to be pleased, to be gratified, to be delighted, to be proud

**БАХДУУЛАХ** to please, to gratify, to delight

**ВАХДУУШТАЙ** (see **бахдалтай**)

**БАХИАЛ ГУТАЛ** work boots (*Russ.*)

**БАХИМ** 1. short and stout, stubby, ~ хуруунууд stubby fingers 2. firm, tight, ~ барих to hold tightly

**БАХИРАХ** (see **бархирах**)

**БАХЛАЙ** Cudweed, *Filago*

**БАХЛУУР** I. (see **багалзуур**), ~ булчирхай (see **булчирхай**)

**БАХЛУУР** II. goitre

**БАХЛУУРДАХ** to have goitre

**БАХЛУУРТАХ** (see **бахлуурдах**)

**БАХТАЙ** pleasing, pleasant

**БАХУУ** goitre, нутгийн чанартай ~ endemic goitre, хорт ~ toxic goitre, Graves's disease, энгийн ~ simple goitre

**БАХЬ** pincers, pliers, forceps, бөөрөнхий хошуутай ~ round-nosed pliers, хавтгай хошуутай ~ flat-nosed pliers

**БАХЬ БАЙДАГ** the same old

**БАХЬ БАЙДГААРАА** as before, still the same, same as ever

**БАЦААН** (see **пацаан**)

**БАЦАГ** a day's fast, involving abstinence from meat (see **мацаг**), ~ барих to observe a fast

**БАЦАН** girl

**БАЧ** trickery, deceit

**БАЧИГНАХ** to keep up a noise

**БАЧИМ** (~ түгшүүртэй) urgent, pressing, critical

**БАЧИМДАЛ** agitation

**БАЧИМДАНГУЙ** (see **бачимдуу**)

**БАЧИМДАХ** to be flustered, to be worried, to feel harassed, цээж ~ to feel a tightness in the chest

**БАЧИМДУУ** flustered, worried, confused

**БАЧЛАЛ** deception

**БАЧЛАХ** to deceive, to act with cunning  
**БАЧТАЙ** cunning, tricky, crafty  
**БАЧУУ I.** (~ нарийн) tight, narrow, § бие барьсан ~ гутал хувцас tight body-hugging boots and clothes **2.** impatient, in a hurry  
**БАЧУУДАЛ** tightness, constriction  
**БАЧУУДАХ** to be constricted, to feel a tightness, цээжээр нь ~ to feel a tightness in the chest  
**БАЧУУРАХ I.** to be anxious, to be nervous, to be het up **2.** to be constricted, хоолой ~ to feel a tightness in the throat  
**БАШГАНА I.** Eyebright, *Euphrasia*, Эмийн ~ *E. officinalis* **2.** *Amethystea*  
**БАШИГ** gleanings  
**БАШИГА** *Odontites* (bot.)  
**БАШИЙХ** to thrive, to grow fat  
**БАШИР I.** pretence, trick, feigning, simulation, ~ арга (~ бааш) trick, ruse, ~ зальт cunning  
**БАШИР II.** (~ цэцэг) Pink, *Dianthus*, Алаг ~ *D. versicolor*, Жавхаалаг ~ *D. superbus* (also Емдүүжин, Согоо суман), Баширын овог (~ цэцгийн овог, ~ цэцэгтэн) Pink Family, Caryophyllaceae  
**БАШИРТ** cunning, tricky, crafty  
**БАЯГЗАВАА I.** *Lancea* (bot.) (also Ланцуй) **2.** local name for Milkwort (Зүрхэн цэцэг)  
**БАЯГЛАХ** to be happy, to be glad, to be pleased  
**БАЯД** Bait (west Mongolian people)  
**БАЯЖИГДАХ** to be enriched  
**БАЯЖИЛТ** enrichment, enhancement  
**БАЯЖИХ** to grow rich, to get rich, баяжсан холимог enriched mixture (auto.)  
**БАЯЖМАЛ** concentrate (min.)  
**БАЯЖУУЛАХ I.** to enrich, to make richer, баяжуулсан уран enriched uranium **2.** to concentrate (min.), ~ комбинат concentration plant  
**БАЯЛАГ I.** riches, wealth, resources **2.** rich, wealthy  
**БАЯЛАГЖУУЛАХ** to enrich, to make rich  
**БАЯН** rich, ~ айл a rich family, ~ бүрд (see баянбүрд), ~ нэг шуурганд баатар нэг суманд (~ хүн нэг зуданд) there is no armour against fate, no one is invulnerable (a warning against smugness), ~ тансаг plentiful, lavish, ~ ходоод last horse in a race, ~ холимог rich mixture (auto.), ~ цатгалан in the money, loaded, ~ чинээлэг affluent, ~ чинээлэгээр in affluence

**БАЯНБҮРД** oasis, watered spot in Gobi territory  
**БАЯН ТҮРҮҮ** vulva (livestock)  
**БАЯН ХОТ** uterus (livestock)  
**БАЯН ХУУР** accordion (Russ.)  
**БАЯН ХУУРЧ** accordionist  
**БАЯР I.** (~ бахдал) joy, happiness, ~ баясгалан happiness, rejoicing, ~ баясгалангүй unhappy, ~ зовлон joys and sorrows, ~ талархал thanks, gratitude, appreciation, ~ хөөр happiness, pleasure, ~ хөөртэй happy, ~ хүргэлт congratulation, ~ хүргэх to congratulate **2.** festival, ~ ёслол celebration, ceremony, цагаан сарын ~ ёслол New Year's festivities, ~ ёслолын ceremonial, ~ наадам festival, games, баярын өдөр festival, festival day, баярын үг greetings, ~ хийх to hold a festival, to celebrate, баярын хурал festival, celebration, ~ цэнгэл revelry, celebration, ~ цэнгэл болох to make merry, to celebrate  
**БАЯРЛАЛАА** thank you!  
**БАЯРЛАМААР** pleasing, gratifying  
**БАЯРЛАНГУЙ** happy, pleased  
**БАЯРЛАХ I.** to be happy, to be glad, to be pleased, баярласан хэрээ бахирав гэгчээр crowing over (something), баярлан цэнгэх to make merry **2.** (баярлаж гялайх) to thank  
**БАЯРТ** joyful, happy, ~ мэдээ joyful news  
**БАЯРТАЙ I.** cheerful, happy, ~ царай a cheerful face **2.** good-bye, ~ уулзъя good-bye, see you again  
**БАЯРХАЛ** ostentation, swank  
**БАЯРХАХ** to be ostentatious, to throw one's money about, to flaunt one's wealth  
**БАЯРХУУ** ostentatious  
**БАЯСАЛ I.** pleasure, joy, ~ цэнгэл amusement, pleasure  
**БАЯСАЛ II.** the trigram дui  
**БАЯСАЛТАЙ** happy, pleased, joyful  
**БАЯСАМ** pleasing, gratifying  
**БАЯСАНГУЙ** (see баясалтай)  
**БАЯСАНГУЙГААР** happily  
**БАЯСАХ** to be pleased, баясан цэнгэх to enjoy oneself  
**БАЯСГАЛАН** joy, happiness, pleasure  
**БАЯСГАЛАНТАЙ** (see баясалтай)  
**БАЯСТАХ** to please, to make happy  
**БАЯСУУЛАХ** (see баясах)  
**БАЯСУУН** (~ хөхүүн) cheerful, merry  
**БАЯЧУУД** rich people  
**БАЯЧУУЛ** (see баячууд)  
**БЕЙСБОЛ** baseball

**БЕЙСБОЛЧИН** baseball-player

**БЕМОЛЬТОЙ** flat, flattened (*mus.*) (*Russ.*)

**БЕНЗИН** petrol, ~ **заагуур** fuel gauge (*Russ.*)

**БЕРЗИНТ** (see **брэзент**)

**БЕТОН I.** concrete, **төмөр** ~ reinforced concrete, ~ **зуурагч** concrete mixer (*Russ.*)

**БЕТОН II.** can, milk can (see **бидон**), **сүүний** ~ milk churn (*Russ.*)

**БЕТОНДОХ** to concrete

**БЕТОНЧИН** concrete worker

**БИ I**, ~ **чи дээ хүрэх** to get at each other

**БИБЛИ** Bible, **Библийн нийгэмлэг** Bible Society

**БИВ** (*intensifying particle*), ~ **битүү** tightly closed, hermetically sealed

**БИВЛЭН I.** a species of Pepper (*Piper longum*)  
**2.** *Schizonepeta* (*bot.*) (*Tib.* pi-pi-ling)

**БИВЛЭНЦЭР** (see **Бивлэн 2.**)

**БИГНҮҮР I.** autoclave

**БИГНҮҮР II.** poultice

**БИГНЭХ** (see **бэгнэх**)

**БИД** we

**БИДНИЙ** our (*genitive of бид*)

**БИДНИЙГ** us (*objective of бид*)

**БИДНҮҮС** we

**БИДНЭЭР** through us (*instrumental of бид*)

**БИДНЭЭС** from us, than us (*ablative of бид*)

**БИДОН** can, jerrycan, churn (*Russ.*)

**БИДРЭХ** to search, to search for, to look for, to seek

**БИДЭН** (*oblique stem of бид*), ~ **шиг** like us

**БИДЭНД** to us (*dative-locative of бид*)

**БИДЭНТЭЙ** with us (*comitative of бид*)

**БИДЭР** spot, stripe

**БИДЭРЛЭХ** to speckle

**БИДЭРТ** spotted, striped

**БИДЭРТЭХ** to be speckled

**БИДЭХ** to wander

**БИЕ I.** body, figure, **их** ~ main part; body (animal, machine, etc.), bed (lathe), fuselage (aeroplane), trunk (*anat.*, tree, etc.); neck (stringed instrument); main part of a bow between the two guides, **номын** ~ absolute body (*Buddh.*), **нэгэн биеэр дуусах** to be for life only (an honour, etc.), **хувилгаан** ~ apparitional body (*Buddh.*), **биесийн амрыг харах** to take the easy way, **биесийн байдал** condition, state, ~ **барах** to die, ~ **барих** to be tight-fitting, ~ ~ each other, ~ **биедээ туслах** to help each other, ~ **биеэ хүндэтгэх** to respect each other, ~

**боловсорсон** having had smallpox (*hist.*), ~ **бүрэлдүүн** (~ **бүрэлдэхүүн**) personnel (*mil.*), ~ **бүтэц** anatomy, ~ **бүтэц судлал** anatomy (as a science), ~ **бялдар** physique, build, ~ **бялдаргүй** underdeveloped, ~ **бялдаржуулах** body-building, ~ **бялдын** physical, ~ **бялдын хүмүүжил** physical education, ~ **галбир** figure, form, shape, **биеэ гамнах** (**биеэ нөөх**) to spare oneself, to take it easy, ~ **гүйцэх** to become fully developed, ~ **гүйцсэн** fully grown, adult, **биеэ даан** to be independent, **биеэ дааж** (**биеэ даан**) independently, **биеэ дааж нэр дэвшигч** independent candidate, **биеэ даасан** independent, ~ **давхар** (~ **жирэмсэн**) pregnant, ~ **засах** to relieve oneself, ~ **засах газар** (~ **засах өрөө**) lavatory, toilet, **биеэ зорох** to wear oneself out, **биесийн зураг** portrait, ~ **махбод** body, constitution, physique, ~ **махбодийн** bodily, physical, ~ **мөнгө** (~ **тогрөг**) ready money, cash, ~ **муу** sick, unwell, **биеэр ойртох** to have intercourse, **биеэ оторлогч** slacker, skiver, **биеэ оторлох** to slack, to skive, ~ **судлал** physiology, ~ **султай** weakly, sickly, ~ **тавигдах** (~ **тавих**) to feel a bit better, to relax, to feel more at ease, **биесийн тамир** gymnastics, **биесийн тамирын танхим** gymnasium, ~ **түүхий** not having had smallpox (*hist.*), **биеэ угаах** to bath, **биеэ угаах онгоц** bath, **биеэ үзүүлэх** to put in an appearance; to present, to consult a doctor, **биеэ үнэлэгч** prostitute, **биеэ үнэлэн худалдах** (**биеэ үнэлж явалдах**, **биеэ худалдах**) to be a prostitute, to go on the game, **биеэ үнэлэх явдал** prostitution, ~ **хаа** figure, form, ~ **халаалт** warming-up, ~ **хамгаалагч** bodyguard, **биесийн хөдөлмөр** manual labour, ~ **хөнгөрөх** to feel better, ~ **хүнд болох** (~ **хүндрэх**) to be run down, to be in poor health, **биесийн хүчин үнэлэх** to work for wages, ~ **цогцос** body, constitution, physique, ~ **цогцсын хэл** body-language, ~ **чангарах** to build up one's strength, ~ **шалтагтай** (~ **шалтгаантай**) pregnant, **биесийн юм** menstruation, periods, ~ **эрхтэндээ гэмтэл учруулах** to cause a self-inflicted wound (*mil.*), § ~ **чинь ямар байна** how are you feeling? **2.** person, self, **миний** ~ I, **Дагва миний** ~ I, **Дагва, чиний** ~ you, **биеэ авч явах** to behave, **биеэ авч явах байдал** behaviour, **биеэ авч явах соёл** manners, good behaviour, **биеэ зөв авч явах** to behave properly, **биеэ зөв авч явахгүй** to misbehave, **биесийн байцаалт** documentation, personal papers, **биеэ барих** to control oneself, to take a grip on oneself, to restrain oneself, to hold oneself in, **биеэ бодож явах** to go carefully, to look after oneself, **биеэ засах** to reform, to correct one-

- self, **биеэ тоомтгой** bumptious, **биеэ тоох** to swank, to think a lot of oneself, **биеэ хөнгөлөх** to relieve oneself, ~ **хүн** individual, person, personality, ~ **хүний** personal, individual, ~ **хүний нэр төр** personal reputation **3.** person (*gram.*), **гуравдугаар** ~ third person, **нэгдүгээр** ~ first person, **хоёрдугаар** ~ second person **4.** side, part, **Туул голын урд** ~ the south side of the Tuul River, ~ **анги** part, **зэвсгийн** ~ **анги** parts of a weapon
- БИЕГҮЙ** sickly
- БИЕЖИЛТ** **1.** formation, maturing **2.** setting, hardening
- БИЕЖИХ** **1.** to develop, to form, to mature **2.** to set, to harden
- БИЕЖҮҮЛЭХ** **1.** to form (*trans.*) **2.** to harden, to strengthen
- БИЕЛГЭЭ** a type of static folk-dance § **монгол ардын бүжгийг дотор нь баруун монголын ~, зүүн монголын ардын бүжиг гэж хоёр хэсэгт хувааж болох юм** the Mongolian folk-dance can be divided into two types - the west Mongolian ~ and the east Mongolian folk-dance
- БИЕЛГЭЭЧ** биэлгээ-dancer
- БИЕЛҮҮЛЭХ** to fulfil, to carry out, to perform
- БИЕЛШГҮЙ** impracticable
- БИЕЛЭГ I.** (~ **өвс**) Meadow-grass, *Poa*, **Дэргэр** ~ *P. subfastigiata*, **Намгийн** ~ *P. palustris*, **Нугын** ~ *P. pratensis*, **Тагийн** ~ *P. alpina*, **Тужийн** ~ *P. nemoralis*, **Туужууны** ~ *P. botryoides*, **Эгэл** ~ *P. trivialis*
- БИЕЛЭГ II.** (see **биерхүү**)
- БИЕЛЭГДЭШГҮЙ** unrealizable
- БИЕЛЭЛ** fulfilment, implementation, realization, **биеллээ олох** to be realized, to come to fruition
- БИЕЛЭЛТ** (see **биелэл**)
- БИЕЛЭХ I.** to be fulfilled, to be realized, to be effected
- БИЕЛЭХ II.** to perform a **биелгээ** dance
- БИЕЛЭЭХ** (see **биелүүлэх**)
- БИЕЛЭЭЧ** (see **биелгээч**)
- БИЕМ** body, **шар** ~ corpus luteum (*anat.*)
- БИЕНЦЭР** corpuscle
- БИЕРХҮҮ** big-bodied, stout
- БИЕРХЭГ** (see **биерхүү**)
- БИЕТ I.1.** body, object **2.** material, substance, ~ **зүйлсийн орлого** income in kind
- БИЕТ II.** actual, factual, real, concrete
- БИЕТЭЙ** (see **биет II.**)
- БИЕЧИЛСЭН** personal
- БИЕЧЛЭН** personally, in person
- БИЕЭР** (see **биечлэн**)
- БИЖ** (~ **өвчин**, **хүүхдийн** ~) infant diarrhoea
- БИЖДЭХ** to have infant diarrhoea
- БИЖИРМЭГ** grain, granule, bead
- БИЖЛЭГХЭН** smallish
- БИЖРҮҮ** rash, eruption (*med.*)
- БИЗ** (~ **дээ**) (*final corroborative particle*) no doubt, surely, I suppose
- БИЗНЕС** business
- БИЗНЕСМЕН** businessman
- БИЗЭЭ** (see **биз**)
- БИЙ I.1.** to be, to exist, to be alive, being, existing, is, are, ~ **болгох** to create, to bring into existence, ~ **болох** to come to be, to come into being, § **гэвч бэрхшээл үлэмж бий** but there are considerable difficulties, **дэвтэр ч бий нь бий байхаа** well, yes, I suppose I've got a book, **надад** ~ I have one, **хэрхэн** ~ **болсон тухай** as to how it came into being **2.** to be (somewhere), § **ойрхон** ~ **Ширээтийн өртөө** the Shireet relay station which was nearby, **танайхан** ~ **юу** are your people in? **3.** (*бийвий*) (*auxiliary verb expressing hesitation or uncertainty*), § **Анваан арван есөн нас хүрэхээр** ~ **ажээ** Anwaan would have been coming up to nineteen, **эмээлий нь ойчих** ~ **гээд** thinking its saddle might fall
- БИЙ II.** a west Mongolian dance-form, **ад** ~ a type of ~ performed by two dancers
- БИЙВАА** (see **пийпаа**)
- БИЙВЛЭГ** a type of lute
- БИЙЛЭГ** (~ **дийлэг**) plentiful, in plenty
- БИЙЛЭГЖҮҮ** (see **бийлэг**)
- БИЙЛЭХ** to dance, **бий** ~ to perform the **бий**
- БИЙР** writing-brush (*Chin.*)
- БИЙЧИН бий**-dancer
- БИЛБҮҮРДЭХ** to blarney, to flannel
- БИЛГИЙН ЧАНАД ХЯЗГААРАА ХҮРСЭН** perfection of wisdom, Prajna-paramita (*Buddh.*)
- БИЛГҮҮН** wise
- БИЛЕТ** ticket, ~ **бүртгэх** to check in (*Russ.*)
- БИЛИГ I.** female, minor (*mus.*), lunar (*cf. apra 3.*), **билгийн тоо** (**билгийн улирал**) lunar calendar, ~ **эгшгийн хөг** minor scale
- БИЛИГ II.** (see **билэг I.**)
- БИЛИГ БАРИМИД** perfection of wisdom, Prajna-paramita (*Buddh.*)



**БИЛҮҮ I.** is it not?, § маргааш нь юм уу, нөгөөдөр нь ~ the next day or maybe the day after

**БИЛҮҮ II.** whetstone

**БИЛҮҮДМЭЛ** ground, honed

**БИЛҮҮДЭХ** to grind, to whet, to hone, билүүдэж өнгөлөх to grind smooth

**БИЛЧИР I.** junction, crossroads, confluence, Орхон-Туулын ~ the confluence of the Orkhon and the Tuul **2.** point for application of moxa

**БИЛЧИРЛЭХ** to join, to come together

**БИЛЧИХ I.** to graze, to pasture **2.** to scatter, to be scattered about

**БИЛЧЭЭР** (~ нутаг) pasture, pasture-land, grazing

**БИЛЧЭЭРГҮЙДЭХ** to be deprived of pasture-land

**БИЛЧЭЭРЛҮҮЛЭХ** to pasture, to drive to pasture, хонио ~ to pasture one's sheep

**БИЛЧЭЭРЛЭЛТ** grazing, pasturing

**БИЛЧЭЭРЛЭХ** to graze, to pasture, to feed

**БИЛЧЭЭХ** to take to pasture, to let graze, нүд билчээн харах to feast one's eyes (on)

**БИЛЭГ I.** (~ оюун, ~ чадвар) talent, capacity, abilities, ~ ухаан wisdom, intelligence

**БИЛЭГ II.** (see бэлэг III.)

**БИЛЭГГҮЙ** untalented, dim

**БИЛЭГДЭЛ** (see бэлэгдэл)

**БИЛЭГДЭХ** (see бэлэгдэх)

**БИЛЭГТ** talented, gifted

**БИЛЭГТЭЙ** (see билэгт)

**БИЛЭГШЭЭХ** (see бэлэгшээх)

**БИЛЭЭ** (*final corroborative particle*), § амьтан хүн юу гэж бодох юм ~ whatever will people think?, арга хэмжээ авсан бол, ийм хохирол учрахгүй ~ surely such damage would not have happened if measures had been taken, нэг талх ямар үнэтэй ~ what does a loaf cost, then?, одоо яадаг ~ what's to be done now, then?, хэрэв би эхнэртэйсэн бол гэр орон минь хаанаас ийм байх ~ if I'd had a wife, my home could never have got into this state, could it?

**БИН I.** (*intensifying particle*), ~ битүү tightly closed, hermetically sealed, ~ хар pitch dark

**БИН II.** a flattened cake, baked dry or in fat

**БИНДЭР** beryllium

**БИНДЭРБЯА** beryl, алтан ~ chrysoberyl, усан ~ aquamarine, хувилгаан ~ alexandrite (*Skr.*)

**БИНТ I.** bandage (*Russ.*)

**БИНТ II.** small circle, zero

**БИНЧИН** means, funds, resources (*Chin.*)

**БИОЛОГИ** biology

**БИОЛОГИЙН** biological

**БИОХИЙ** biogas

**БИОХЭМНЭЛ** biorhythm

**БИРААГА** Pennycress, *Thlaspi* (also Тольт өвс, Тэмээн тавхай), Халбаган ~ *T. cochleariforme*, Хөдөөний ~ Field Pennycress, *T. arvense*

**БИРВААЗ** (see бярвааз)

**БИРГА** the name of the sign placed above the first line on the recto side of a sheet (*xyl.*)

**БИРД** hungry ghost, preta (*Skr.*)

**БИРДААН БУУ** (see буу)

**БИРЖ** exchange, stock-exchange, commodity-exchange, market, сангийн ~ (хөрөнгийн ~) stock-exchange, биржийн брокер stockbroker (*Russ.*)

**БИРЖГЭР** rough, bumpy, knobbly

**БИРЖИЙХ I.** to become rough **2.** to come out in a rash

**БИРЖЭЭН** (see брезент)

**БИРЧГЭР** (see биржгэр)

**БИРЯНГУУ** (see Шимэлдэг II.1.)

**БИСААНЗ** name of a four-stringed bowed fiddle

**БИСМАН** (~ тэнгэр) Vaishravana (*Buddh.*) (*Skr.*) (also Намсрай)

**БИТГИЙ** do not, § та намайг бага гэж ~ бас do not despise me for being small, тэр ~ хэл and moreover, let alone that, үүнээс хойш ийм азгүй явдал ~ гараасай гэж бодож явж билээ I just hoped such an unfortunate thing would never happen again

**БИТИЙ** (see битгий)

**БИТҮҮ I.1.** (~ хүтүү) closed, нар ~ (see нар), хонины ~ толгой an intact sheep's head (with the chin-bone still in place), ~ дуу dull sound, ~ лонх tight-lipped, of few words, ~ систем closed system (*mech.*), ~ үсэг closed letters such as b in Mongolian script, ~ хоол dumpling-type food (бууз, хуушуур, etc.), ~ цагираг vicious circle **2.** thick, dense, close, ~ хууз thick whiskers, ~ цастай snow-mantled, ~ шугуй dense forest, ~ шүдтэй with a full set of teeth **3.i.** (~ далд) secret, mysterious **ii.** covert, veiled, ~ занах to utter veiled threats, ~ үг insinuation

**БИТҮҮ II.** (see битүүн), ~ гаргах to see out the old year

**БИТҮҮ III.** double handful

**БИТҮҮДЭЭ** in secret, covertly

**БИТҮҮЛЭГ I.** (lunar) New Year's eve feast, food for that feast

**БИТҮҮЛЭГ II.** deep, mysterious

**БИТҮҮЛЭХ I.1.** to cover up, to conceal, to seal up, to fill in **2.** to take in double handfuls

**БИТҮҮЛЭХ II.** to celebrate the last night of the old year

**БИТҮҮМЖ** seal (for sealing a box, etc.)

**БИТҮҮМЖЛЭЛ** sealing, freezing, impounding, sequestration (*jur.*)

**БИТҮҮМЖЛЭХ I.** to seal, to seal up, **тамга** ~ to enclose the seal (so as to suspend official business at the New Year) (*hist.*) **2.** to sequester (*jur.*), **хөрөнгө** ~ to sequester property

**БИТҮҮН** (битүүний өдөр) the last day of the lunar month, the last day of the year, **битүүний шөнө** the last night of the month or year

**БИТҮҮРЭЛТ** obstruction, blockage

**БИТҮҮРЭХ I.** to be closed (switch, circuit, etc.) **2.** to be blocked, **хамар** ~ to have a stuffed-up nose **3.** to heal, to close over (wound) **4.** to be closed over, to be obscured

**БИТҮҮХЭН** in secret, covertly

**БИТЭГ** (see **бэтэг**)

**БИФШТЕКС** steak (*Russ.*)

**БИЧ** Ape, Monkey, **бичин жил** year of the monkey

**БИЧВЭР** text, ~ боловсруулах text-processing, ~ судлал textology

**БИЧГИЙН I.** written, writing (*adj.*), ~ зүү pin, ~ зүүний толгой pin-head, ~ машин (see машин), ~ мэдээ written information, information in writing, ~ хадаас staple, ~ хэл written language, literary language, ~ цаас (see цаас), ~ ширээ desk, ~ шохой chalk **2.** civil (*hist.*), ~ түшмэл civil official

**БИЧГЭЭР** in writing

**БИЧИГ I.** writing, script, **авианы** ~ phonetic script, **дүрс** ~ hieroglyphics, **зургийн** ~ pictographs, **утгийн** ~ ideographs, **хичээнгүй** ~ calligraphy, calligraphic writing, **хуучин** ~ the old Mongol script, **шаантаг** ~ cuneiform, **шар** ~ "yellow script" (Tibetan letters used for writing Mongol), ~ мэдэх to be literate, to know how to read and write, ~ бага мэдэгчид sub-literates, ~ захидал letters, mail, ~ номгүй illiterate, without writing, ~ үл мэдэх явдал (~ үсэг үл мэдэх явдал) illiteracy, ~ үсэг writing, script, ~ үсэггүй illiterate, without writing, ~ үсэггүй хэл unwritten language, ~ үсэгтэй literate **2.** note, certificate, chit, **дагуул** ~ invoice, ~ тоот

letter, memo **3.** (~ баримт) document, papers, албан ёсны ~ баримт official documents, архивын ~ баримт archival documents, ~ баримт засах to cook the books, ~ хар documents, ~ хэрэг (~ сачиг) writings, papers, paperwork, ~ цаас paper, papers, ~ цаасны ажил paperwork **4.** book, **сурах** ~ text-book, ~ зохиол books, writings, ~ зохиолын literary, ~ судар books

**БИЧИГДЭЛ** writings, written form

**БИЧИГЛЭЛ I.** writing, writings, inscription **2.** description, account

**БИЧИГЛЭХ** to put into writing, to enter into correspondence

**БИЧИГТЭЙ** literate

**БИЧИГЧ** writer, захидал ~ letter-writer

**БИЧИЛ** micro, ~ амь судлал (see бичиламьсудлал), ~ амьтан microfauna, ~ бие (~ биетэн, ~ бие махбод, ~ организм) micro-organism, ~ бүтэц microstructure, ~ дуранбай microscope, цахим ~ дуранбай electron microscope, ~ махбод (~ язгуур махбод, ~ элемент) trace element, ~ мэс засал micro-surgery, ~ орчин micro-environment, ~ процессор microprocessor, ~ харуур microscope, электроны ~ харуур electron microscope, ~ хэлхээ microcircuit, ~ цаг уур micro-climate

**БИЧИЛАМЬСУДЛАГЧ** microbiologist

**БИЧИЛАМЬСУДЛАЛ** microbiology

**БИЧИЛАМЬСУДЛАЛЫН** microbiological

**БИЧИЛТ** writing, lettering, entry, notation

**БИЧИХ I.** to write, to write about **2.** to record, соронзон хальсанд ~ to tape **3.** to prescribe

**БИЧЛЭГ I.i.** writing, lettering, hand, машин ~ typing, typewriting, түргэн ~ shorthand **ii.** a piece of writing, түүх ~ historical writing **2.** recording, булчингийн цахилгаан ~ electromyograph, дүрс ~ video-recording, video, дүрс бичлэгийн магнитофон video recorder, дүрс бичлэгийн хальс video tape, дүрс бичлэгийн хуурцаг video cassette, зүрхний цахилгаан ~ electrocardiogram, магнитофоны ~ (соронзон ~) tape-recording, соронзон бичлэгийн аппарат tape-recorder, тархины цахилгаан ~ electroencephalogram **3.** notation, шатрын ~ chess notation

**БИЧМЭЛ I.** written, ~ хууль written law **2.** handwritten, ~ ном handwritten book **3.** manuscript

**БИЧҮҮЛЭХ I.** to get (something) written **2.** to get one's order taken, to get a bill to pay for a purchase **3.** to record, to make a recording

**БИЧЭЭН** pastry, biscuit (*Russ.* печень)

**БИЧЭЭС** inscription

**БИЧЭЭЧ I.** clerk, scribe, copyist, **бүтэн** ~ full clerk (*hist.*), **тал** ~ "half clerk" (young clerk employed together with another to do the work of an experienced man) (*hist.*) **2.** (машины ~) typist, **арван хурууны** ~ ten-finger typist

**БИШ I.** is not **2.** non-, **засаг** ~ тайж non-banner-prince taij **3.** is only ...but not, § **хоёр гуравхан зуун грамм архи уусан** ~, **шилээр нь уугаагүй** I only drank two or three hundred grammes of spirits, not by the bottle **4.** only, nothing for it but, § **буцахаас** ~ **дээ** better go back **5.** ~ болох to fail, to turn out badly

**БИШГҮЙ** a lot, lots, any amount, ~ **нэг** pretty often, § **нарийн урчууд** ~ **бий** there are plenty of skilled craftsmen, ~ **л их зүйл** ever such a lot of things

**БИШГҮЙДЭЭ** many a time

**БИШГҮҮР** flute, **багласан** ~ a composite wind instrument (*hist.*), **үелэх** ~ bassoon

**БИШГҮҮРДЭХ** to play the flute

**БИШГҮҮРЧИН** flautist

**БИШЦҮҮЛЭХ** to mess up, to spoil

**БИШЦЭХ** to be messed up, to be spoiled, to get bad, § **байдал бишдэхийг ойлгосон** realizing that things were turning nasty, **хэрэг бишидлээ дээ** it's all up!, **царай чинь нэг л бишдээд байх юм** you do look a bit off colour, **энэ ч хэрэг бишидлээ** this was serious, this meant trouble

**БИШРЭМ** admirable, worthy

**БИШРЭМТГИЙ** reverent, pious, respectful, devoted

**БИШРЭНГҮЙ** (see **бишрэмтгий**)

**БИШРЭХ I.i.** (бишрэн итгэх, бишрэн мөргөх, бишрэн шүтэх) to believe in, to worship, to adore **ii.** to swear by **2.** (бишрэн бахархах, бишрэн бахдах, бишрэн шүтэх) to admire, to respect

**БИШҮҮРХҮҮ** shy, bashful, timid

**БИШҮҮРХЭГ** (see **бишүүрхүү**)

**БИШҮҮРХЭНГҮЙ** (see **бишүүрхүү**)

**БИШҮҮРХЭХ** to be shy, to be bashful, to be timid

**БОБСЛЕЙ** bobsleigh

**ВОВ** (*intensifying particle*), ~ **бор** brown as a berry

**БОГ I.** (~ мал) small livestock (sheep and goats)

**БОГ II.** (~ өвс) wind-carried grass or foliage

**БОГВОЙХ** to perch (bird, etc.)

**БОГД I.** holy, sacred, divine **2.** (Ар ~, ~ Гэгээн, ~ Жавзандамба Хутагт) the Jebtsundamba Khutuku (Grand Lama, Living Buddha) of Uрга,

~ Хаан the King of Autonomous Mongolia, ~ хаант улс (~ эзэнт улс) the Autonomous Monarchy, 1911-1920

**БОГДГОР** stumpy, squat

**БОГД УУЛ** Bogd Uul, the Holy Mountain south of Uрга

**БОГДЫН ӨРГӨӨ** Uрга

**БОГДЫН ХҮРЭЭ** Uрга

**БОГИНО I.** short, ~ бодолтой (~ жолоотой) short-sighted (*fig.*), ~ долгион (see долгион), ~ дуу (see дуу **3.**), ~ жолоотой naive, ~ залгаас (~ холболт, ~ холбоо) short circuit, ~ өмд shorts, ~ хавирга short ribs, first ribs, ~ хугацаанд in a short space of time, ~ хугацааны (~ хугацаатай) short-term (loan, etc.) **2.** a short (in signalling)

**БОГИНОВТОР** quite short

**БОГИНОДОХ** to be too short

**БОГИНОСГОХ** to shorten

**БОГИНОСОЛТ** shortening

**БОГИНОСОХ** to be shorter, to get shorter, to last less time

**БОГИНОТГОХ** to shorten

**БОГИНОХОН** quite short, маш ~ very short

**БОГОЧ I.** a tie for tying up the front leg of a beast

**БОГОЧ II.** saddle (*geog.*)

**БОГОЧЛОХ** to tie the front leg of a beast in a bent position

**БОГТ** a gift promised from the side of the bridegroom to that of his intended bride (*hist.*)

**БОГТЛОХ** (богтлон гэрлэх) to marry, to get married, **богтлон буулгах** to marry off (a daughter), **богтлон өгөх** to give in marriage

**БОГТОГО** woman's headdress in mediaeval times

**БОГТОС** ulna (*cf.* шуу яс), **богтосны залаа** (богтосны залаа яс) olecranon, olecranon process of the ulna, ~ **ясны шөвөг сэртэн** styloid process of the ulna

**БОГЦ** saddle-bag, bag

**БОГЦЛОХ** to pack into a saddle-bag

**БОГШИРГО** Sparrow

**БОГШИХ I.** to get too thick and strong (**тараг**, etc.), to be overbrewed (tea)

**БОГШИХ II.** to be weary, to be jaded, to be worn out

**БОД I.** (~ мал) large livestock **2.** an accounting unit rating different sorts of livestock against the **бод** unit **3.** a chess-piece (excluding king and pawns)

**БЭЛТГЭЛ I.i.** preparation, **бэлтгэлийн өрөө** dressing-room **ii.** preparatory, ~ **уулзалт** preparatory meeting **2.** (~ **сургууль**) training, **цэргийн анхан шатны** ~ basic military training **3.** supply, procurement **4.** reserve, ~ **нөөц** reserves, ~ **офицер** officer on the reserve, ~ **тоглогч** (see **тоглогч**)

**БЭЛТГЭЛИЙН** reserve, spare

**БЭЛТГЭМЭЛ** a preparation

**БЭЛТГЭХ I.** to prepare **2.** to provide, to supply, **бэлтгэн нийлүүлэгч** supplier **3.** (**бэлтгэн гаргах**) to train

**БЭЛТГЭЭСТЭЙ** prepared, made ready

**БЭЛТРЭГ** Wolf-cub

**БЭЛТРЭГЛЭХ** to cub, to produce cubs

**БЭЛТЭЙ** affluent

**БЭЛТЭН** plutocrat

**БЭЛХНЭЭ** readily, clearly, well, § **бид** ~ **мэднэ** we well know

**БЭЛХҮҮС** waist

**БЭЛХЭЛЗЭХ** to waddle

**БЭЛХЭМЖ** belly-band, girth

**БЭЛХЭН** ready

**БЭЛХЭНЦЭГ I.** loins **2.** waist band, corset

**БЭЛЦГЭР** fleshy, plump, succulent

**БЭЛЦИЙХ** to be fleshy, to be plump

**БЭЛЦРҮҮ** vesicle, small blister

**БЭЛЧИР** (see **билчир**)

**БЭЛЧИХ** (see **билчих**)

**БЭЛЧЭЭР** (see **билчээр**)

**БЭЛЧЭЭРЛЭЛТ** (see **билчээрлэлт**)

**БЭЛЧЭЭРЛЭХ** (see **билчээрлэх**)

**БЭЛЧЭЭХ** (see **билчээх**)

**БЭЛЭГ I.** (~ **эрхтэн**) genitals, sexual parts, sexual organs, **дан бэлэгтэй** (**саланги бэлэгтэй**)

unisexual, declinuous (*bot.*), **хос бэлэгтэй** hermaphrodite, monoclinous (*bot.*), **эм** ~ female genitalia, **эр** ~ male genitalia, ~ **эрхтний** genital, ~ **эрхтнээ ил гаргах** to expose oneself, ~ **эрхтнээрээ оролдох** (~ **эрхтнээ хий тавих**) to masturbate

**БЭЛЭГ II.** gift, present, ~ **барих** (~ **болгон өгөх**) to offer a gift, to make a present, ~ **барьц** gift, offering, ~ **дурсгал** souvenir, ~ **зэлэг** (~ **сэлэг**) gifts, presents, **бэлгийн морны шүд үздэггүй** don't look a gift horse in the mouth, ~ **өгөх** to give a present, ~ **сэлт** gifts, presents ~ **хандив** gift, offering

**БЭЛЭГ III.** sign, symbol, token, ~ **дэмбэрэл** good omen, good sign, good augury, ~ **дэмбэрэлгүй** ill-omened, ~ **дэмбэрэлтэй** well-omened, auspicious, ~ **дэмбэрэлтэй үгс** blessings, recitations of good wishes, ~ **тэмдэг** sign, symbol, omen, ~ **тэмдэгтэй** symbolic

**БЭЛЭГГҮЙ I.** ill-omened

**БЭЛЭГГҮЙ II.** barren (flower)

**БЭЛЭГДЛИЙН** symbolic

**БЭЛЭГДЭЛ** symbol, ~ **зүй** symbolism

**БЭЛЭГДЭХ 1.** to prophesy, to foretell **2.** to symbolize

**БЭЛЭГЛЭХ** (**бэлэглэн өгөх**) to present, to donate, to give

**БЭЛЭГСҮЙН** genital, sexual

**БЭЛЭГТЭЙ** well-omened, auspicious

**БЭЛЭГШЭЭЛ** good omen

**БЭЛЭГШЭЭХ 1.** to consider as a good omen **2.** to symbolize

**БЭЛЭН** (~ **зэлэн**, ~ **зэхээтэй**) ready, ~ **байдал** readiness, preparedness, **өндөржүүлсэн** ~ **байдал** enhanced state of preparedness, ~ **бүтээгдэхүүн** finished product, ~ **мөнгө** ready money, cash, ~ **хувцас** ready-made clothes

**БЭЛЭНЧИЛГЭЭ** (see **бэлэнчлэл**)

**БЭЛЭНЧЛЭЛ** scrounging, cadging

**БЭЛЭНЧЛЭХ** to scrounge, to cadge, to rely on handouts

**БЭЛЭРХЭХ** to vaunt one's wealth, to be free with one's money

**БЭЛЭЭХЭН 1.** ready, available **2.** readily

**БЭМБИЙ** dough

**БЭМБИЙХ** to get swollen, to get puffy

**БЭМБЭГНЭХ** to tremble, to shiver, to shake

**БЭМБЭЛЗЭХ** (see **бэмбэгнэх**)

**БЭНТЭЙ** (~ **цэнтэй**) valuable

**БЭНЧИН** capital, funds, money

**БЭР I.** daughter-in-law, wife of the younger brother, bride, ~ **буулгах** to welcome a daughter-in-law, ~ **буух** to become a daughter-in-law, to marry into a family

**БЭР II.** skin of a boil

**БЭРГЭД** bridesmaid

**БЭРГЭЙ** (see **бэргэн I.**)

**БЭРГЭН 1.** wife of the elder son **2.** older women who assist at a wedding to settle the couple in and to admonish them

**БЭРГЭХ** to be scared, to fight shy of

**БЭРД** (see **бирд**)

**БЭРЖГЭР** (see **биржгэр**)

**БЭРЖИЙХ** to get rough, to come out in spots, to come out in pimples

**БЭРЖЭЭНХ** (see **брэзент**)

**БЭРЖЭЭХ** (see **брэзент**)

**БЭРИШ** Thorow-wax, Hare's-ear, *Bupleurum*, **Судлархаг** ~ *B. multinerve*, **Хависгананавчит** ~ *B. scorzonerifolium*, **Хоёр ишт** ~ *B. bicaule*, **Ямхан** ~ *B. pusillum*

**БЭРЛЭХ I. 1.** to be bashful, to be diffident **2.** to act as a dutiful daughter-in-law towards one's in-laws, ~ **ёс** the custom of behaving in this way

**БЭРЛЭХ II.** to receive a daughter-in-law

**БЭРМЭГ** Sea-Lavender, *Limonium*, **Улаан-үндэст** ~ *L. erythrorhizum*

**БЭРС** queen (chess)

**БЭРСҮҮ** lump, swelling

**БЭРТЭГЧИН 1.** philistine **2.** uncultured, vulgar

**БЭРТЭЛ** (~ **гэмтэл**) injury, **бэртэлд орох** (~ **гэмтэлд орох**) to be injured

**БЭРТЭЛТ** (see **бэртэл**)

**БЭРТЭНГЭ 1.** (~ **гэмтэл**) injury, **ясны** ~ fracture, bone-injury **2.** injured, maimed

**БЭРТЭХ** to hurt oneself, to get hurt, to get injured

**БЭРТЭЭХ** to injure

**БЭРХ 1.** (~ **хүнд**, ~ **хэцүү**) difficult, hard, **дөрвөн** ~ (see **дөрөв**) **2.** fierce, hard **3.** good at, competent

**БЭРХДЭЛ** difficulty

**БЭРХДЭХ 1.** to be too difficult **2.** to get into difficulties

**БЭРХТЭЙ** difficult, hard, **итгэхэд** ~ hard to believe

**БЭРХШЭЭЛ** difficulty, hardship, trouble, ~ **тарих** to make difficulties, to make trouble

**БЭРХШЭЭЛТЭЙ** difficult

**БЭРХШЭЭХ** to shirk, to avoid, to dodge, to fight shy of, **ажил хөдөлмөрөөс** ~ to shirk work, to be work-shy

**БЭР ЦЭЦЭГ 1.** *Delphinium grandiflorum*  
**2.** *Scabiosa comosa* **3.** Yellow Scabious,  
*S. ochroleuca*

**БЭРЧГЭР** (see **биржгэр**)

**БЭРЭВХИЙ** pastern

**БЭРЭЛХЭХ** to behave shyly like a new bride

**БЭРЭЭ** rod, stave (for beating), **гэсгүйн** ~ proctor's staff (in a lamasery)

**БЭРЭЭД** daughters-in-law

**БЭРЭЭДЭХ** to beat with a rod

**БЭРЭЭМЭГ** *Arnebia* (bot.) (plant containing a red dye which is extracted by boiling), **Шар** ~ *A. guttata* (Tib. 'bri-mog)

**БЭРЭЭС** boiled or steamed rice

**БЭСГЭХ** (see **бөсгөх**)

**БЭСРЭГ I.** middle-sized, smallish

**БЭСРЭГ II.** spirits made from mare's or camel's milk or kumis, mixed with that from other beasts

**БЭСРЭГЛЭХ** (**бэсрэглэн нэрэх**) to distil **бэсрэг**

**БЭСРЭГХЭН** smallish

**БЭСЭРГЭЛЭХ** (see **бэсрэглэх**)

**БЭТЭГ I.** (~ **хорхой**) echinococcus **2.** echinococcus, swelling produced in echinococcosis, ~ **өвчин** echinococcosis, ~ **өвчтэй** suffering from echinococcosis, **элэгний** ~ echinococcosis of the liver, **бэтэгний гэр** echinococcosis cyst (see **уйланхай**) **3.** longing, yearning, ~ **нь хагарах** to have a load taken off one's mind

**БЭТЭГРЭХ I.** to contract echinococcosis **2.** to pine away; to long for

**БЭТЭГТЭЙ** suffering from echinococcosis

**БЭТЭГШИЛ** echinococcus infestation

**БЭХ I.** (~ **бат**) strong, firm, secure

**БЭХ II.** ink

**БЭХДЭХ** to ink (xyl., etc.)

**БЭХЖИЛ I.** strengthening, reinforcement  
**2.** hardening, setting

**БЭХЖИЛТ** (see **бэхжил**)

**БЭХЖИХ I.** to grow stronger, to grow firmer, to be reinforced **2.** to go hard, to set, to go off (plaster, etc.)

**БЭХЖҮҮЛЭГЧ** fixer (photo.)

**БЭХЖҮҮЛЭХ I.** to strengthen, to reinforce, to consolidate, to harden **2.** to allow to set (cement, etc.)

**БЭХЛҮҮР** staple

**БЭХЛЭЛТ I.** fastening, securing **2.** fortification

**БЭХЛЭХ I.** to secure, to fix, to make fast **2.** to fortify, **бэхэлсэн хот** fortified town

**БЭХЛЭЭС** (see **бэхэлгээ**)

**БЭХЭЛГЭЭ** fastening, reinforcement, securing, fixing, anchorage, tie, pit-prop, **суудлын** ~ seat-belt, seat-harness, **бэхэлгээний мод** shoring, pit-prop

**БЭЭВГЭР** in poor shape, run down

**БЭЭВИЙХ** to cower, to shiver and shake from the cold, to be rundown with cold

**БЭЭЖИН** Peking, ~ **лам** a foppish lama

**БЭЭЛ** prince of the third rank in Manchu times (hist.) (Man.)

**БЭЭЛИЙ** glove

**БЭЭМЭЛ** bad, rotten, off

**БЭЭР I.** mile

**БЭЭР II.** (subject indicator) (gram.)

**БЭЭРЛЭХ** to fester, to suppurate

**БЭЭРТЭХ** to be frozen with cold

**БЭЭРЭГ** easily frozen, susceptible to cold

**БЭЭРЭЛТ** numbness

**БЭЭРЭХ** to be numb with cold, to be frozen stiff, to be chilled, to be frost-bitten

**БЭЭРЭЭ** chill, ~ **гаргах** to warm up (intrans.), **бээрээг гаргах** to take the chill off, to warm up

**БЭЭС** prince of the fourth rank in Manchu times (hist.) (Man.)

**БЭЭХ** to rot, to decay, to go off

**БЭЭХИЙХ** to firm up, to become sturdy

**БЭЭЦИЙХ** (see **бээвийх**)

**БЭЭЦЭГНЭХ** (see **бээвийх**)

**БЯД** sturdiness, bodily strength

**БЯДАЛ** (~ **чадал**) capability, capacity, power

**БЯДАЛТАЙ** capable

**БЯДАРХАГ** strong, powerful

**БЯДАРХУУ** (see **бядархар**)

**БЯДАХ** to wander, to roam

**БЯДГҮЙ** weak, feeble

**БЯДЖИХ** to develop, to get stronger

**БЯДЛАГ** strong, powerful

**БЯДРУУ** (see **бядлаг**)

**БЯДТАЙ** (see **бядлаг**)

**БЯДУУ I.** silly **2.** dense **3.** awkward, clumsy

**БЯЛАНГАЧ I.** flattering, fawning, ingratiating  
**2.** flatterer, toady, lickspittle

**БЯЛАР I.** shawm **2.** clarinet

**БЯЛАХ** to smear

**БЯЛБАЙХ** to get fat and flabby (Bur.)

**БЯЛДАР** physique, appearance, shape  
**БЯЛДАРЖИХ** to develop  
**БЯЛДАРТАЙ** well-built  
**БЯЛДАРХАГ** (see **бялдартай**)  
**БЯЛДАХ** to smear  
**БЯЛЦГҮЙ** feeble, weakly  
**БЯЛЦТАЙ** strong, powerful  
**БЯЛЦУУРХАХ** (see **бялдуучлах**)  
**БЯЛЦУУЧ** (see **бялангач 1., 2.**)  
**БЯЛЦУУЧЛАЛ** flattery, making up to, sucking up to  
**БЯЛЦУУЧЛАХ** to curry favour with, to suck up to, to ingratiate oneself with  
**БЯЛЗУУМАР** Short-toed Lark, *Calandrella cinerea*, **Орог Бор** ~ Lesser Short-toed Lark, *C. rufescens*  
**БЯЛЗУУХАЙ** small bird  
**БЯЛТ 1.** fuse **2.** percussion-cap, detonator **3. асаах** ~ sparking-plug  
**БЯЛУУ I.1.** pie **2. (амтат ~)** cake  
**БЯЛУУ II.** club, cudgel  
**БЯЛУУРАЛ** biliousness, flatulence  
**БЯЛУУРХАХ** to feel bilious, to feel queasy  
**БЯЛХАЙХ** to be overfull, to be pendulous  
**БЯЛХАЛЗАХ 1.** to quiver, to wobble **2.** to slop over  
**БЯЛХАЛТ** eruption (volcano)  
**БЯЛХАХ (бялхан гарах)** to overflow, to be full to overflowing  
**БЯЛХДАС** (see **бялхмаг**)  
**БЯЛХМАГ** lava  
**БЯЛХМАЛ** extrusive, effusive, ~ **чулуулаг** extrusive rocks, effusive rocks  
**БЯЛХУУЛАХ (бялхуулан дүүргэх)** to fill to overflowing  
**БЯЛЦРУУ** necrobacillosis (infectious disease of the hoof in sheep)  
**БЯМБА (~ гариг) 1.** Saturn **2.** Saturday (*Tib. spen-pa*)  
**БЯНТ** rifling, rifling groove (of a gun-barrel)  
**БЯР (~ тэнхээ, ~ чадал)** strength, power, might,

~ **тэнхээтэй (~ чадалтай)** strong, powerful, hefty, stalwart  
**БЯРАЛХАГ** powerful  
**БЯРАЛХАХ** to flaunt one's strength  
**БЯРАЛХУУ** (see **бяралхаг**)  
**БЯРВААЗ** ferry, ~ **онгоц (~ хөлөг)** ferry-boat (*Russ. перевоз*)  
**БЯРДАХ** to flaunt one's strength  
**БЯРМАН** Brahmin, **Бярманы шашин** Brahminism  
**БЯРТАЙ** strong, powerful, hefty, stalwart  
**БЯРУУ** calf in the second year, ~ **болоогүй байж бухын явдлаар аяглах** to try to run before one can walk, ~ **булчинтай даага далантай** with one's livestock in good shape, **бярууны сүүл даахгүй амьтан** weakling, ~ **сүүлдсэнээс бух сүүлдсэн дээр** as well be hanged for a sheep as for a lamb  
**БЯРУУ ХОТ** Jingpeng (town in Keshigten, Zuuud, Inner Mongolia)  
**БЯСАА** Bug, **ор дэвсгэрийн ~** Bed-bug, *Cimex lectularius*, **Бясааны баг** Bugs, Hemiptera  
**БЯСААНЗ** (see **бисаанз**)  
**БЯСАЛГАЛ** meditation, contemplation, ~ **бясалгах (~ хийх)** to meditate, to be in meditation  
**БЯСАЛГАХ 1.** to meditate, to contemplate, **ном** ~ to be in religious meditation, to meditate upon religion **2.** to think over, to work out  
**БЯСЛАГ** a kind of cheese made from raw or skimmed milk or from **ээдэм** which has been strained or squeezed, ~ **шахах** to press cheese  
**БЯСМАН (~ тэнгэр)** (see **Бисман**)  
**БЯЦ** crash, bang, ~ **үсрэх** to spring apart  
**БЯЦАРМАЛ** crushed  
**БЯЦАРХАЙ** (see **бяцармал**)  
**БЯЦЛАХ** to break, to smash, to crush  
**БЯЦРАХ** to get broken, to get smashed, to get crushed  
**БЯЦХАН 1.** little, small **2.** a little

**БАА** hey!, look at that! (*showing surprise or anger*)

**БААГЛАХ** to croak

**БААДАГНАХ** to wrap up in a (square) piece of cloth

**БААДАН 1.** a square of cloth for wrapping things in **2.** section of tent-cloth for a **майхан**

**БААР 1.** (дээврийн ~) roof-tile, **нөмрөг** ~ upper tile (of a lapped roof), **нүүр** ~ end tile, **тосгуур** ~ lower tile (of a lapped roof) **2.i.** pottery **ii.** (~ сав) pot, vase, ~ **маягтай** flask-shaped, narrow at the top (well, etc.) (*Chin.*)

**БААРАН** ceramic, ~ **материал** (~ эдлэл) ceramics

**БААРАНЦАР** ceramic, ~ **хавтан** ceramic tile

**БААРЛАХ 1.** to tile **2.** to make in the shape of a flask, to make narrow at the top (well, etc.), § **газар ваарлаж ухаад** digging out the ground narrow at the top

**БААРЧ** potter

**БААРЧИН** (see **ваарч**)

**ВАГИНДРАГИЙН ҮСЭГ** "Vagindra's Script" (developed in 1905 by the Buryat lama Agwadorj)

**ВАГОН** carriage, coach (*rail.*), wagon, **ачааны** ~ truck, goods wagon, freight car, **зоогийн** ~ restaurant car, dining-car, **унтлагын** ~ sleeping-car, **шууд харилцааны** ~ through coach (*Russ.*)

**ВАГОНЦОР** truck, trolley

**ВАКЦИНЖУУЛАЛТ** vaccination

**ВАКЦИНЖУУЛАХ** to vaccinate

**ВАЛЮТ** currency, foreign currency, **хатуу** ~ hard currency, **чөлөөт** ~ convertible currency, **валютын арилжааны гүйлгээ** currency dealing, **валютын дэлгүүр** (чөлөөт валютын барааны дэлгүүр) hard-currency shop, **валютын холбоо** monetary union (*Russ.*)

**ВАН I.** prince, king, **жүн** ~ prince of the second rank in Manchu times, **чин** ~ prince of the first rank in Manchu times (*hist.*) (*Chin.*)

**ВАН II.** power, empowerment (*Buddh.*), ~ **авьшиг** consecration, empowerment (*Tib. dbang*)

**ВАНАДИ** vanadium

**ВАНГИЙН** royal, ~ **нийгэмлэг** Royal Society

**ВАНГИЙН ХҮРЭЭ** name of a lamasery, now Bulgan Khot

**ВАНДАН 1.** (~ **ширээ**) bench **2.** wharf (coal) (*Chin.*)

**ВАНДУЙ** Pea (*Chin.*)

**ВАНДУЙХАЙ** Chick-pea, *Cicer*, *C. arietinum*

**ВАНЖИНГАРАВ** (see **Цагаан Дэгд**)

**ВАНЛИЙ** pretty, beautiful, handsome, splendid

**ВАНН** bath, **уурын** ~ sauna (*Russ.*)

**ВАНСЭМБЭРҮҮ** *Saussurea involucrata* (*bot.*) (also **Банцанбүрүү**, **Нөмрөгт Банздоо**)

**ВЕНА** vein, **хаалган** ~ (хаалган венийн судас, элэгний үүдэн ~) portal vein, **хөндий** ~ vena cava, **дээд хөндий** ~ superior vena cava, **доод хөндий** ~ inferior vena cava, **венийн судас** vein, **венийн цус** venous blood (*Russ.*)

**ВИВААНГИРД** prophecy, prediction, revelation (*Skr.*)

**ВИВАНГИРДИЧ** prophet

**ВИГТРООЛ** gramophone (proprietary name Victrola)

**ВИДЕО-КИНО** video film

**ВИЗ** visa (*Russ.*)

**ВИНАЙ** Vinaya section of the Tripitaka, rules of discipline (*Buddh.*)

**ВИНОКАМЕНИЙ ХҮЧИЛ** (see **хүчил**)

**ВИНТОВ** rifle, **жижиг калибрын** ~ small-bore rifle, **хийн** ~ air-gun (*Russ.*)

**ВИРУС** virus, **шүүрэгч** ~ filtrable virus, ~ **судлал** virology

**ВИСКИ** whisky

**ВИТАМИНЖУУЛСАН** vitamin-enriched, with added vitamins

**ВИТАМИНЛАГ** vitamin-rich

**ВИШАЙ** region, sphere (*Buddh.*) (*Skr.*)

**ВОК** washing-powder

**ВЭ** (interrogative particle used in a sentence containing an interrogative word), § **нэг сахар ямар үнэтэй байх** ~ what would a bag of sugar cost?



ГА hectare (Russ.)

ГАА (Гааг өвс) Mint, *Mentha*, Цагаан ~ (see Цагаан Гаа)

ГААГАЛАХ to crow, to caw

ГААЖТАЙ sharp, astute

ГААЗДАХ to gas

ГААЛИЙН customs (adj.), ~ газар custom-post, custom-house, ~ мэдүүлэг customs declaration, ~ түшмэл customs officer, ~ хураамж customs duty

ГААЛЬ customs, гүний ~ inland customs office, ~ татвар customs duty, duty

ГААЛЬЧ customs officer

ГААНС tobacco-pipe, pipe

ГААПУУ hoe

ГААРАМБА title of a lamaistic degree, суусан ~ a ~ who has studied at home, тушаагдсан ~ a ~ who has gained the right to be examined for the degree of гавж

ГААРАХ to grow, to intensify, to worsen

ГААРУУЛАХ to overdo

ГАВ I. (intensifying particle), ~ ганцаараа quite alone, all by oneself, ~ ганцхан single, one and only

ГАВ II. (~ цав) crack, split

ГАВ III. fetters, handcuffs, ~ гинж fetters and chains

ГАВАГ I. blessing, ~ тавих (~ хүртгэх) to bestow a blessing 2. beating, ~ хүртэх to get beaten up

ГАВАЛ I. skull, ~ аяга cup made of a skull, ~ тархины cranio-cerebral, ~ тархины гэмтэл head injury 2. cylinder head (Skr.)

ГАВАЛГҮЙТЭН Acrania (zool.)

ГАВАЛТАН Craniata (zool.)

ГАВАР I. Camphor (Tib. ga-bur)

ГАВАР II. cub (fox, etc.)

ГАВАРЛАХ to cub, to have cubs (vixen)

ГАВГА (see гавар)

ГАВДАХ to fetter, to handcuff

ГАВЖ a lamaistic clerical degree, above that of гэвш (Tib. dka'-bcu)

ГАВИАГҮЙ inferior, poor, nothing to boast about, nothing to write home about

ГАВИХ to help, to be any good, хичнээн ~ билээ what use would it be?, юу ~ вэ (~ юмгүй, гавьж гийгсэн юмгүй) (see гавиагүй)

ГАВИХГҮЙ (see гавиагүй)

ГАВЛАХ (see гавдах)

ГАВШГАЙ (~ шаламгай) quick, smart, brisk

ГАВШГАЙЛАХ to work at speed, to be a shock-worker, гавшгайлан ажиллах to work as a shock-worker

ГАВШГАЙЧ shock-worker, таван жилийн ~ "five-year shock-worker" (Russ. ударник пятилетки)

ГАВЪТАЙ special, particular

ГАВЪЯА merit, ~ байгуулах to deserve well (of), их гавьяаг улс оронд байгуулах to deserve extremely well of one's country, ~ зүтгэл merits, meritorious services

ГАВЪЯАТ honoured, merited, outstanding, урлагийн ~ зүтгэлтэн honoured artist, ~ зүтгэлтэн зураач honoured painter

ГАВЪЯАТАН person of outstanding merit

ГАГАДАЙ Amaranth, *Amaranthus*, Сүүлт ~ Love Lies Bleeding, *A. caudatus*, Урвуу ~ Common Amaranth, *A. retroflexus*

ГАГАЛЗАХ to be struck dumb, to be unable to speak (through fright, etc.)

ГАГНААС 1. soldering, soldered joint, joint 2. solder

ГАГНАХ 1. to braze, to solder, to weld 2. to seal, § мөсөнд засвар хийхэд хагалсан мөсийг цасан зуурмагаар гагнан хөлдөөнө to repair the ice (of a cold-store) seal and freeze the cracked ice with a snow-mix

ГАГНУУР 1. solder 2. brazing, soldering, welding, нуман ~ arc-welding, цэгэн ~ spot-welding, гагнуурын алх soldering-iron

ГАГНУУРЧИН welder

ГАГЦ (see ганц)

ГАГЦХАН (see ганцхан)

ГАГЦХҮҮ 1. only, just, § ~ таримал ургамлыг ашиглаад зогсохгүй бас зэрлэг ургамлуудыг ч хүмүүс өргөн ашиглана people make wide use not only of cultivated plants, but also of wild plants 2. however, but

ГАДАА 1. outside, ~ гандаж хөдөө хөхрөх to be exposed to all weathers, ~ гэртгүй inside and out, all over the place, ~ хөдөө outside, away 2. near, ~ айл neighbours

ГАДААД external, foreign, outer, ~ бодлого foreign policy, ~ далай ocean, ~ дотоодын foreign and home, external and internal, ~ Монгол Outer Mongolia, ~ монголын төрийг засах явдлын яам (see Их зургаан), ~ оронд

abroad, ~ **орчин** surroundings, environment, ~ **өр** foreign debt, ~ **харилцаа** foreign relations, ~ **Харилцааны Яам** Ministry of External Relations (Mongolia), ~ **хийцтэй** foreign made, ~ **худалдаа** foreign trade, ~ **хэл** foreign language, ~ **шүүрлийн булчирхай** (see **булчирхай**), ~ **Явдлын Яам** Ministry of Foreign Affairs (MPR, etc.)

**ГАДААДАД** abroad, ~ **гаргах** to export

**ГАДААДЫН** foreign, ~ **иргэд** aliens, ~ **орон** foreign country, ~ **түрэмгийчүүд** foreign aggressors

**ГАДААДЫНХАН** foreigners, aliens

**ГАДААЛАХ 1.** to go outside, **хурал ном** ~ to make a pause in a service **2.** to relieve oneself

**ГАДААХЬ 1.** outside (*adj.*) **2.** near (*adj.*)

**ГАДАГШ** out, outside, outwards

**ГАДАГШАА** (see **гадагш**)

**ГАДАГШААХ** outside, external

**ГАДАГШЛАЛ** emergence

**ГАДАГШЛАЛТ** (see **гадагшлал**)

**ГАДАГШЛАХ** to emerge, to come out, to be voided, to be excreted, to be expelled, to be eliminated

**ГАДАГШЛУУЛАХ** to bring out, to bring up, to excrete, to eliminate

**ГАДАР I.** metal bowl, metal basin, **мөнгөн** ~ silver bowl, **гадартай ус** a basin of water (*Tib. ka-to-ra*)

**ГАДАР II. 1.** outer, outside, ~ **тал** outside, outer surface **2.** outside, outer surface, **зөөлөн гадартай** soft-backed (book), **хатуу гадартай** hard-backed (book), § **ногоон гадартай нэхий дээл** a sheepskin gown with a green outer layer

**ГАДАРГА** surface (*n.*), **гадаргын таталцал** surface tension

**ГАДАРГУУ** surface (*n.*)

**ГАДАРГУУГИЙН** superficial, surface (*adj.*)

**ГАДАРГЫН** surface (*adj.*), ~ **ус** surface water

**ГАДАРЛАХ I.** (**гадарлан таамаглах**) to get a general idea of, to get a rough idea of, to make out

**ГАДАРЛАХ II.** to face, to cover, to line on the outside

**ГАДАС** stake, nail, peg, pile, **алтан** ~ (see **алтан гадас**), ~ **зоох** to drive piles, ~ **мод** stake, ~ **шаах** to drive in a stake

**ГАДАСЛАХ** to nail down, to peg down

**ГАДИЛЬ** banana

**ГАДИР** quince

**ГАДНА 1.** outside, ~ **байдал** external appearance, **гаднаа гяланцаг дотроо паланцаг** fair without false within, whitened sepulchre, ~ **тал** the outside, ~ **талын** external, outside **2.** nearby, close by, near at hand, near the tent **3.** apart from, besides, **дээр дурдсанаас** ~ apart from the above

**ГАДНАХЬ** external, exterior, outside, ~ **байдал** external appearance, ~ **жасаа** the duty-office at a particular place (*hist.*), **чуулган даргын** ~ **жасаа** the League Head's office

**ГАДНЫ** foreign, external, extraneous, unauthorized, ~ **биет** foreign body, ~ **хүн** outsider, ~ **хүмүүс** outsiders, § ~ **хүн орж үл болно** no admittance except on business

**ГАДНЫН** foreign, external, extraneous, ~ **зүйл** extraneous matter, ~ **нөхцөл** external factor, ~ **орчин** surroundings, environment, ~ **хөл** visits, visitors, ~ **хөрөнгө** foreign capital, ~ **хүн** stranger, ~ **юмс** extraneous items

**ГАДНЫХАН** foreigners, strangers

**ГАДУУР I. 1.** outside, external, outer, ~ **бүрээс нөмөргөх** to fit the outside covering of the tent, ~ **хувцас** outer clothing, ~ **хэрэглэх** to use externally, to apply externally **2.** outside, around outside, nearby, ~ **явах** to go out § **зун намрын бэлчээрийг ерөнхийд нь алсын, ойрын, ~ бэлчээр гэж гурав хуваана** summer and autumn pastures are generally divided into distant, nearer and close-by **3.** contrary to, opposed to

**ГАДУУР II.** washing-basing (*hist.*) (*Tib. ka-to-ra*)

**ГАДУУРХАЛТ** discrimination, **арьсны өнгөөр** ~ racial discrimination

**ГАДУУРХАХ** to look askance at, to discriminate against

**ГАДУУРХИ 1.** outer, outside, **хичээлээс** ~ extracurricular **2.** close by, § **бэлчээрээ алсын, ойрын, ~ бэлчээр гэж гурав хувааж** dividing their pastures into distant, nearer and close-by

**ГАДУУРЧЛАХ** (see **гадуурхах**)

**ГАЖ 1.** strange, abnormal, ~ **араншинтай** deviant, ~ **буруу** strange, odd, unusual, abnormal, unnatural, improper, ~ **ондоо** quite different, ~ **үзэгдэл** peculiarity, abnormality ~ **үйлчилгээ** side-effect **2.** anomaly

**ГАЖААХ** to bend, to distort

**ГАЖДАЛ** disorder (*med.*)

**ГАЖИГ** defect, disorder, anomaly, fault, **төрөлхийн** ~ congenital defect, **хэлний** ~ speech defect, ~ **согор** defect, ~ **согортой** defective, deficient

**ГАЖИГТАЙ** defective, deficient, handicapped

**ГАЖИЛ** distortion

**ГАЖИЛТ** (see **гажил**)

**ГАЖИХ 1.** to warp, to bend, to go out of shape, to be deformed, to be lopsided, **гажиж сэнсрэх** to warp **2.** to deviate (from), to break (a law, etc.), to go wrong, **гажиж зөрөх** to go wrong

**ГАЖУУ 1.** crooked, bent **2.** wrong, deviant, abnormal, contrary

**ГАЖУУД** wrong, deviant, abnormal, contrary

**ГАЖУУДАЛ 1.** offence, misdeed **2.** defect, deficiency, abnormality, irregularity, **ёс суртахууны** ~ perversion, moral turpitude

**ГАЖУУДАХ** to be distorted, to go wrong

**ГАЖУУДУУЛАХ** to distort, to break, **дүрмийг** ~ to break the regulations, **тангарагаа гажуудуулан няцах** to go back on one's oath, **хууль ёсны зарчмыг** ~ to pervert the course of justice

**ГАЖУУРХАХ** to behave badly

**ГАЗ** gas, ~ **эсэргүүцэгч** gas-mask

**ГАЗАР 1.** ground, earth, ~ **авах** to gain ground; to obtain and mark out the ground for a funeral, ~ **авах ёслол** the ceremony of obtaining and marking out the ground for a funeral (*hist.*), ~ **авахуулах** to allow (sickness, etc.) to gain ground, **газрын бэтэг** short person, **газрын гавд орох** to disappear, to vanish, ~ **ground** to ground (missile), ~ **доогуурхи** (~ **дорхи**) underground (*adj.*), ~ **доогуурхи гарц** subway, **газрын дүрс** physical features, ~ **дүрсийн зураг** map of physical features, ~ **дэлхий** earth, world, ground, ~ **дээр нь** on the spot, ~ **дээрх** above ground; aerial (stem), **газрын зураг** map, ~ **зүй** (see **газарзүй**), ~ **зүйч** (see **газарзүйч**), **газрын мухар** the back of beyond, ~ **мялаах** to hit the deck, ~ **нутаг** territory, ~ **орон** ground, land, territory, ~ **орны байдал** physical features, terrain, scenery, ~ **орон дээр** on the ground, on land, on earth, **газарт орох** to get the sack, ~ **сайгүй** here and there, all over the place, ~ **судлал** geology, ~ **судлалч** geologist, ~ **тавих** to put down, **газрын тагт** far distant, far away, ~ **тариалан** agriculture, cultivation, farming, ~ **тариалан үйлдвэрийн орон** an agricultural-industrial state, ~ **товчлох** to take a short cut, **газрын тос** (see **тос**), ~ **тэнгэр нийлсэн** blinding (battle, storm, etc.), ~ **ус** place, locality, ~ **усны нэр** place-name, ~ **усны нэр зүй** toponymy, **газар уснаа явагч** amphibious, **газрын хол усны уртаас** from far away, ~ **хөдлөл** earthquake, ~ **хөдлөл судлаач** seismologist, ~ **хөдлөл судлах станц** seismological station, ~ **хөдлөх** to have an earthquake, ~ **хэмжилзүй** geodesy, ~

**шинжээч** geomancer, ~ **шорооны ажил** earth moving, ~ **эдэлбэр** land use, ~ **эдэлбэрийн хууль** land use law, **газрын эзэн** landlord; (~ **орны эзэн савдаг**) local deities (*Buddh.*) **2.** place **3.** li, Chinese mile, **түмэн газрын урт цагаан хэрэм** the Great Wall of China, § **нэг газар нь 576 метртэй тэнцэнэ** one ~ equals 576 metres **4.** office, instance, **дөрвөн аймаг шавь таван** ~ the four khanates and the ecclesiastical estate (*hist.*) **5.** (*finally*) indeed, for sure, for a fact, the thing is

**ГАЗАРГҮЙ 1.** lacking a place **2.** there is no reason (to, for, why)

**ГАЗАРГҮЙДЭХ** to lack a place, **борлуулах** ~ to have nowhere to sell (something)

**ГАЗАРДАХ 1.** to land, to come down, to touch the ground **2.** to come to grief

**ГАЗАРДУУЛАХ 1.** to earth (*elec.*), ~ **утас** earth-wire **2.** to let down

**ГАЗАРДУУЛГА** earth, earthing (*elec.*)

**ГАЗАРЗҮЙ** geography, **физик** ~ physical geography

**ГАЗАРЗҮЙН 1.** geographical, ~ **байдал** geographical situation, ~ **ухаан** geographical science **2.** terrestrial, ~ **голдоч** (see **голдоч**)

**ГАЗАРЗҮЙЧ** geographer

**ГАЗАРЛАГЧ** (see **газардуулга**)

**ГАЗАРЧ** guide

**ГАЗАРЧИН** (see **газарч**)

**ГАЗАРЧЛАХ** to guide, to show the way, § **тэдэнд газарчилж хамт явж** going with them to show them the way

**ГАЗРЫН ДУНДАД ТЭНГИС** Mediterranean Sea

**ГАЙ** (~ **барцад**, ~ **барчид**, ~ **гарз**, ~ **зовлон**, ~ **зэтгэр**, ~ **тогтор**, ~ **төвөг**, ~ **түй**, ~ **түйтгэр**, ~ **цээр**) misfortune, bad luck, trouble, harm, ~ **болох** to be a nuisance, to become a burden, to be the cause of trouble, ~ **болоход** unfortunately, ~ **газар дороос, гахай модон дотроос** (~ **газар дороос, галзуу нохой салхин дороос**) you have to be on your toes, ~ **гамшиг** misery, misfortune, trouble, **байгалийн** ~ **гамшиг** natural disaster, ~ **гамшиг тарих** (~ **гамшиг учруулах**) to do harm, to do damage, **гайд нь гаргах** to sacrifice, to condemn to suffering, ~ **дайрах** to be struck by misfortune, to fall on hard times, ~ **тарих** to cause trouble, to do harm, ~ **татах** (~ **чирэх**) to bring trouble

**ГАЙГААР** at the hands of, through the fault of

**ГАЙГУЙ 1.** it doesn't matter, never mind, all right, ~ **хэвтэнэ** no go, that's just it, § **байхгүй юмгүй цаг ирнэ** ~ good times are coming all right **2.** pretty good, not bad, ~ **сайхан** really nice

**ГАЙК** nut (*mech.*) (*Russ.*)

**ГАЙМУУ** Shepherd's Purse, *Capsella bursa-pastoris*

**ГАЙМУУ БАЙЦАА** (see **Зэрлэг Хиж**)

**ГАЙТ** unfortunate, ill-starred, disastrous, fateful

**ГАЙТАЙ** (~ **лайтай**, ~ **түйтэй**, ~ **хөөтэй**) (see **гайт**)

**ГАЙТАХ** to come to grief, to meet with misfortune, to have bad luck

**ГАЙТУУЛАХ** to let go to ruin, to wreck, to waste

**ГАЙХАЛ 1.** amazement, wonderment **2.** strange, queer, odd **3.** a sight, a guy, a wretch, a miserable fellow

**ГАЙХАЛЗАХ** to wonder

**ГАЙХАЛТАЙ** surprising, strange, amazing, § **тийм ч ~ бишээ** it's not so surprising

**ГАЙХАМ** wonderful, marvellous

**ГАЙХАМШИГ** wonders, marvels, miracle, **дэлхийн долоон** ~ the seven wonders of the world

**ГАЙХАМШИГТ** wonderful, marvellous

**ГАЙХАНГУЙ** surprised, amazed

**ГАЙХАСХИЙХ** to wonder, to be surprised

**ГАЙХАХ 1.** to marvel at, to admire **2.** to wonder

**ГАЙХАШ** surprise, amazement, ~ **алдрах** (~ **барагдах**, ~ **тасрах**) to be at one's wits' end, **гайхшийг барах** to amaze, to bemuse, ~ **төрөх** to be surprised, to be amazed, ~ **төрүүлэх** to surprise

**ГАЙХАШРАЛ** (see **гайхаш**)

**ГАЙХМААР** amazing

**ГАЙХУУЛАХ** to show off, **хөрөнгө чинээгээ** ~ to make a display of one's wealth, to flash one's money around

**ГАЙХШРАХ** (see **гайхах**)

**ГАЛ 1.1.** (~ **хөл**, ~ **хөс**) fire, ил ~ open fire, ~ **авалцах** to catch fire, ~ **алдах** to start a fire, to let a fire spread beyond control; to run out of fuel; to let the fire go out, **галын аюулаас хамгаалах байгууллага** fire-service, **галаа бадрах** (~ **голомтоо асаах**, ~ **голомт бадрах**, ~ **голомт үүсгэх**) to start the first fire for the new household at a wedding, to set up home, ~ **бурхан** the Fire God, ~ **гарах** to break out (fire), ~ **голомт** hearth, hearth and home,

family, family line; source, ~ **голомтыг залгамжлагч** heir, next in line, ~ **голомтыг сахих** (~ **голомтыг залгах**) to continue the family line, **дайны ~ голомт** source of war, ~ **зуух** (~ **зуухны өрөө**) kitchen, ~ **команд** fire-brigade, ~ **манах** to bank up a fire overnight (with ashes), **галын наадам** fireworks, firework display, **галын өрөө** kitchen, ~ **руу тос цацах** to pour oil on the flames, ~ **сөнөөгч** fireman, ~ **сөнөөх газар** fire-station, ~ **тавих** to set fire to, to set on fire, to start a fire, **байшинд ~ тавих** to set fire to a building, ~ **таслах** to set up a home separately (from one's parents), **галыг татах** to reduce the heat, to take (something) off the fire, ~ **тахих** to worship the fire, ~ **тогоо** kitchen, ~ **тогооны байшин** cook-house, kitchen, ~ **тогоо барих** to do the cooking, ~ **тогооны гэр** kitchen tent, ~ **тогооны өрөө** kitchen, ~ **тогооны хэрэглэл** (~ **тогооны хэрэгсэл**) kitchen equipment, ~ **түймэр** fire (as a disaster), ~ **түймэр гарах** to break out (fire), ~ **түймрийг эсэргүүцэх эд бараа** fire-fighting equipment, ~ **түлэх** to light a fire; to tend a fire, **галд тэсвэртэй** fire-resistant, refractory, **галд тэсвэртэй шавар** refractory clay, ~ **улаан** fiery red, ~ **унтраагуур** (~ **унтраагч**) fire-extinguisher, **галын хайч** fire-tongs; household drudge, ~ **халуун** burning hot, ~ **хамгаалахынхан** fire-brigade, ~ **хамгаалагч** fuse (*elec.*); safety-catch (gun), **галын хор** fire extinguisher, ~ **цөцгий** pupil of the eye, **галын шилээвэр** poker; household drudge, § **автоматыг ~ хамгаалагч дээр тавих** to put the assault-rifle on safety **2.** fire (*mil.*), **хажуугийн** ~ enfilade, **шөргөн** ~ (**хайчин** ~) cross-fire, **галын боломж** (**галын хүч**) fire-power, **галын бэлтгэл** firing training, ~ **зогсоох** to cease fire, ~ **зогсоосон бүс** cease-fire zone, ~ **нээх** to open fire, **галын точик** emplacement (*mil.*) (*Russ.* *огневая точка*), ~ **удирдах багаж хэрэгсэл** fire-control equipment, **галын хэрэгсэл** ammunition, munitions, ~ **цацруулагч буу** (see **буу**), **галын шугам** firing line **3.** fuse (grenade, etc.) **4.** team (caravanning, droving), school (of drinkers, etc.), ~ **нэгдэх** to team up

**ГАЛ II.** real, true, proper

**ГАЛАВ** kalpa, era, epoch, period, **Кембрийн галбын үе** Cambrian epoch, **триасын** ~ Triassic period, **усан** ~ the Flood, **усан галавын өмнөх үеийн** antediluvian, ~ **юүлэх** the end of the world, ~ **юүлтэл** (~ **нөхцтөл**) till the end of time (*Skr.*)

**ГАЛАВ ШАЛАВ** nimble, smart

**ГАЛАЙ ДА** rank of commander in the watch-posts in Manchu times (*hist.*)

**ГАЛАЙХАН ЭХ** the deity of the fire

**ГАЛБА** (see **галав**)

**ГАЛБИНГА 1.** the "Indian Cuckoo" **2.** Kalavingka, a fabulous bird (*Skr.*)

**ГАЛБИР** shape, build

**ГАЛБИРААСАН МОД** the wish-granting tree (*Skr.*)

**ГАЛ ГАРИГ** Mars (*astr.*)

**ГАЛГИЛАХ** to go at a slow pace (horse)

**ГАЛГИУЛАХ** to ride at a slow pace

**ГАЛГИХ** to go slowly, to go deliberately

**ГАЛДАА** (see **галай да**)

**ГАЛДАХ** to burn, to set alight, to set on fire, **галдан шатаах** to burn, to burn down, to burn up; arson

**ГАЛЖИЙХ** to warp, to get crooked, to bend

**ГАЛЖИРДАХ** (see **галжийх**)

**ГАЛЖРАЛ** bending, twisting, warping

**ГАЛЖРАХ** to bend, to twist, to warp

**ГАЛЗУУ 1.** rabies, madness, ~ **өвчин** rabies **2.** rabid, mad, ~ **нохой** rabid dog, mad dog, ~ **солиотой** raving mad, ~ **улаан** a smoke, a fog, ~ **улаан тамхи** "fierce red tobacco" (*liter.*)

**ГАЛЗУУРАЛ** madness

**ГАЛЗУУРАХ 1.** to have rabies **2.** to go mad, to go crazy, **галзуурахад ганц хуруу дутуу** to be pretty well off one's rocker

**ГАЛИГ 1.** an alphabetic system developed by Ayush Güüsh for transcribing foreign words in Mongolian **2.** transcription

**ГАЛИГАА БУЛИГАА** uncertain, unpredictable, changeable

**ГАЛИГЛАХ** to transcribe, to transliterate

**ГАЛИГЧЛАЛ** transcription, transliteration

**ГАЛИГЧЛАХ** (see **галиглах**)

**ГАЛЛАГА** heating, **ердийн** ~ ordinary heating, open fires, **сайн галлагатай тасалгаа** a well-heated room

**ГАЛЛАЛТ** firing, shooting

**ГАЛЛАХ 1.** to light a fire, to light up the fires, to start heating, to heat, **зуухыг** ~ to heat the stove, to fuel the stove **2.** to fire, to shoot, **галла** (**галлаад**) fire!, **нэгээр** ~ to fire single shots **3.** to fib **4.** to give the wrong answer (in an exam)

**ГАЛСТУГ** neck-tie, tie (*Russ.*)

**ГАЛ СҮҮЛ** Redstart, *Phoenicurus phoenicurus*, **Мойлон** ~ Black Redstart, *Ph. ochruros*, **Улбагар** ~ Eversmann's Redstart, *Ph. erythronotus*, **Чээжмэгт** ~ Guldenstadt's Redstart, *Ph. erythrogaster*

**ГАЛТ** fire, firing, fiery (*adj.*), ~ **байр** firing position, ~ **зэвсэг** firearms, ~ **наадам** fireworks, firework display, ~ **тэрэг** train, **ачааны** ~ **тэрэг**

(**таваарын** ~ **тэрэг**) goods train, **илчит** ~ **тэрэг** diesel train, **уурын** ~ **тэрэг** steam train, **хурдан** ~ **тэрэг** express train, **цахилгаан** ~ **тэрэг** electric train, ~ **тэрэгний буудал** railway station, ~ **уул** volcano, **ажиллагаатай** ~ **уул** active volcano, **унтарсан** ~ **уул** extinct volcano, ~ **уулын бөмбөг** (see **бөмбөг 2.**), ~ **уул судлал** vulcanology, ~ **уулын чулуу** volcanic rock, ~ **хэрэглэл** (~ **хэрэгсэл**) ammunition, munitions, ~ **дох** Firefly, ~ **шил** burning glass, magnifying glass, lens

**ГАЛТАЙ** fiery, burning

**ГАЛТАС** name of a certain nocturnal creature

**ГАЛТ ГАЗАР** Tierra del Fuego

**ГАЛТМАР** pyrite (*min.*)

**ГАЛТ ЧУЛУУ** pyrope (*min.*)

**ГАЛУУ** Goose, **Бор** ~ Grey Lag Goose, *Anser anser*, **Буурал** ~ Bean Goose, *A. fabalis*, **Хошуу** ~ Swan Goose, *A. cygnoides*, **Хээрийн** ~ Bar-headed Goose, *A. indicus*, ~ **дууриаж хэрээ хөлөө хөлдөөх** to bite off more than one can chew, **галуун хүзүүт** carafe, **галуун цуваа** a flight of geese

**ГАЛУУН ТАВАГ 1.** *Chiazospermum* (*bot.*) **2.** *Panzeria lanata* (*bot.*)

**ГАЛУУТ НУУР** Goose Lake, Gusinoe ozero (*p.n.*)

**ГАЛУУЧИН** goose-herd

**ГАЛЧ** stoker

**ГАЛЧИН ҮЕ** epoch (*geol.*)

**ГАЛЫНХАН** firemen

**ГАМ I.1.** thrift, carefulness, frugality, ~ **аригтай** economical, sparing, ~ **хамгагүй** reckless, careless, ~ **хийх** (хоолны ~ хийх, ~ сахиx) to stick to a diet or regimen, to be careful about eating, ~ **цээр** regimen (*med.*) **2.** care, ~ **алдах** to be negligent

**ГАМ II.** a disease of horses characterized by a discharge from the nose and attributed to a foul tethering-line

**ГАМБАГАР** smart

**ГАМБИР** a sort of bread or cake made without fat (*Chin.*)

**ГАМГҮЙ 1.** careless **2.** unsparing

**ГАМИН** (see **гэмин**)

**ГАММ** scale (*mus.*), **аялгуулчилсан минорын** ~ melodic minor scale, **гармоничилсан минорын** ~ harmonic minor scale (*Russ.*)

**ГАМНАХ** to spare, to treat economically, to economize on, to save on, to go carefully with,

- to cherish, **биеэ** ~ to spare oneself, to take it easy
- ГАМТАЙ** careful, economical
- ГАМШИГ** (~ **зовлон**) disaster, calamity, **байгалийн** ~ natural calamity
- ГАМШИГТ** disastrous, ~ **байдал** disaster, state of disaster
- ГАН I.** steel, ~ **бат** firm, strong, ~ **зам** railway (*Chin.*)
- ГАН II.** tub, butt, barrel, cask, vat, **ганд нь орхих** (**ганд нь хаях**) to abandon, to chuck up, to ditch, ~ **торх** vat, § **харь үг замбараагүй ганд нь тавин хэрэглэх** to drop foreign words casually into one's conversation (*Chin.*)
- ГАН III.** drought, ~ **гачиг** (~ **гачаал**, ~ **зуд**) drought, fodder shortage resulting from drought, ~ **тайлах** to break, to come to an end (drought), ~ **тэсвэрлэх** drought-resistant, ~ **халуун нар** burning hot sun
- ГАН IV.** crack, split
- ГАН V.** tannin, tanning liquid, **гангийн ургамал** tanning plants
- ГАНАГАР** with an arched back
- ГАНАЙХ** to be arched, to be strained backwards (back, etc.)
- ГНАЛЗАХ** (see **ганайх**)
- ГАНГА I.** (~ **өвс**) Thyme, *Thymus serpyllum*
- ГАНГА II.** precipice, ~ **жалга** ravines
- ГАНГАЛАХ** to smarten up
- ГАНГАМСАГ** overdressed, foppish
- ГАНГА МӨРӨН** River Ganges
- ГАНГАМСУУ** (see **гангамсар**)
- ГАНГАН** (~ **гоё**, ~ **дэгжин**, ~ **хээнцэр**) smart, elegant, ~ **тансаг эд эдлэл** luxuries, fripperies, ~ **цэвэрч** neat and tidy, well turned-out
- ГАНГАНААН** yelping, whining (dog), calling (bird)
- ГАНГАНАХ** to yelp, to whine (dog), to call (bird)
- ГАНГАР I.** (~ **шаазан**) porcelain, china **2.** bowl (*resp.*)
- ГАНГАРАХ I.** to increase, to intensify
- ГАНГАРАХ II.** (see **гангархах**)
- ГАНГАР ГУНГАР** honking (geese, etc.), ~ **ярилцах** to chat, to natter
- ГАНГАРХАХ** to put on one's glad rags, to tart oneself up
- ГАНГАЧУУД** smart dressers, dandies
- ГАНГАЧУУЛ** (see **гангачууд**)
- ГАНГИА** *tyke*
- ГАНГИНАХ** (see **ганганах**)
- ГАН ГЭХ** (see **ган хийх**)
- ГАНДАН I.1.** trumpet made of a human thigh-bone **2.** shaft (of the femur, etc.)
- ГАНДАН II.** Gandang, name of a temple and district in Urga, and later a lamasery in Ulaanbaatar
- ГАНДАН ОРОН** the Tushita paradise (*Buddh.*) (*Tib.* *dga'-ldan-gyi gnas*)
- ГАНДАХ I.1.** (**гандан шарлах**) to fade, to wither, **гандан бууршгүй** never-fading, imperishable **2.** to get sun-tanned
- ГАНДАХ II.** (**гандаж идээлэх**) to tan
- ГАНДБАДРАА** Speedwell, *Veronica*, **Буурал** ~ *V. incana*
- ГАНДИБАДРАА** (see **Гандбадраа**)
- ГАНДИГАР** Elder, *Sambucus*
- ГАНДИРСАН БАЛГАС** mirage (*Skr.*)
- ГАНДМАЛ** withered, faded, weathered, parched, arid, ~ **цөл** arid desert
- ГАНДУУ** (~ **хуурай**) parched, dry, arid, ~ **бүс** arid zone
- ГАНДЬ МОД** wooden instrument used to summon lamas
- ГАНЖДАХ** to roll out
- ГАНЖИН** rolling-pin
- ГАНЖИР** finial (on a lamasery building) (*Tib.* *gan-dziri*)
- ГАНЖИРЛАХ** to make a finial
- ГАНЖУУР** Kanjur (*Tib.* *bka'-gyur*)
- ГАНЗАГА** saddle-thongs, ~ **дүүрэн** heavily laden, well supplied, ~ **дүүрэн антай** with saddle-thongs full of game, with a full bag of game, ~ **мялаах** (~ **тослох**) to get a good bag, **ганзгын наймаа** (**ганзгын худалдаа**) spivvery, **ганзгын наймаачин** (see **ганзагачин**), ~ **нийлэх** to pull together, to share and share alike, ~ **татуу** poor, unsuccessful, ~ **тахих** to worship the saddle-thongs, ~ **хоосон буцаж ирэх** to come back empty-handed
- ГАНЗАГАЛАА** something tied to the saddle
- ГАНЗАГАЛАХ** to tie with the saddle-thongs
- ГАНЗАГАЧИН** spiv (Mogolian huckster trading goods between Russia and China)
- ГАНЗАЙ** Chinese spirits
- ГАНИРАХ** to feel sad, to feel depressed, to feel downcast, to be morose
- ГАНИХРАЛ** grief, sadness
- ГАНИХРАХ** (see **ганирах**)
- ГАНЛИН** a fife, made usually of a human

femoral bone, though also of metal (Tib. rkang-gling)

**ГАНПАНЗ** pastry-board (*Chin.*)

**ГАНС** (see **гаанс**)

**ГАНСРАЛ** grief, sadness

**ГАНСРАНГУЙ** sad, melancholy

**ГАНСРАХ** to grieve, to be distressed

**ГАНТАЙ** arid, very dry

**ГАНТАХ** to crack, to split

**ГАНТИГ** (~ **чулуу**) marble

**ГАНТИГЖИХ** to turn to marble (limestone)

**ГАНУУ** vamp (of a boot) (west Mongol)

**ГАНХАЛЗАХ** (see **ганхал**)

**ГАНХАЛТ** swaying, swinging, rocking

**ГАНХАХ** to sway, to swing, to rock, to wobble,  
**ганхан гунхан алхах** to stagger

**ГАН ХИЙХ** to yelp, ~ **нохойгүй газар гишгэх малгүй** poverty-stricken

**ГАНХУУЛАХ** to swing, to rock, to cause to sway, to push backwards and forwards

**ГАНЦ** single, one, only one, only, just, ~ **бие** all alone, single, ~ **бие хүн** lonely person, single person, ~ **бие эмэгтэй** single woman, ~ **бие эх** single mother, ~ **биеэр** all by oneself, ~ **болж** (~ **болох нь тэр**) jolly good!, just the thing!, ~ **мод гал болдоггүй, ганц хүн айл болдоггүй** united we stand, divided we fall, ~ **нэг** single, just one, ~ **нэг хүн** one single man, ~ **нэгээр** singly, one by one, one at a time, ~ **сайн** properly, ~ **сайн чадах** to put one over on, ~ **сонгиныг сугалах** to take the last one left, to take the only one there is, ~ **сэдэвт зохиол** (see **сэдэв**), ~ **талын** unilateral, ~ **тоот** singular (*gram.*), ~ **үг газар гээхгүй** to go at it hammer and tongs, ~ **үг ган гэлгүй** without more ado, ~ **хоёр** one or two, ~ **хоёроор** in ones and twos, ~ **хүүхэд** single child

**ГАНЦААР** alone, on one's own, by oneself, ~ **захирах дэглэм** autocracy, autocratic régime, ~ **захирах хаант засаг** autocratic monarchy, **ганцаараа ярих** to talk to oneself; monologue, § **түүнийг ганцаарангий нь орхиоо бүр байв** they quite gave up leaving her by herself

**ГАНЦААРДАЛ** loneliness, isolation

**ГАНЦААРДАНГУЙ** lonely

**ГАНЦААРДАХ** (**ганцаардаж зожигрох**) to be isolated, to be on one's own, to feel lonely, to be solitary

**ГАНЦААРДМАЛ** (~ **зожиг**) lonely, isolated, solitary

**ГАНЦААРДУУЛАХ** to isolate

**ГАНЦААРЧИЛСАН** single, isolated, solitary, individual

**ГАНЦААРЧИЛАН** alone, on one's own, individually

**ГАНЦАХ** to be alone, to be isolated, to feel lonely

**ГАНЦЛАХ** to be single, to be individual

**ГАНЦХАН** 1. only, alone, just 2. just one

**ГАНЦХҮҮ** (see **гарцхүү**)

**ГАНЧ** alabaster

**ГАНШИХ** to whine, to whimper

**ГАНШМАЛ** dry, rainless

**ГАНЬ ГАЛЗУУ** mad, crazy (*Bur.*)

**ГАР** 1. hand, arm, **гарын авлага** reference-book, hand-book, guide, ~ **аргаар** by hand, ~ **ажиллагаа** manual work, ~ **ахар ганзага татуу** poor, unsuccessful, **гарын аяыг даах** (see **ая** 2.), **гарын аясаар** as easy as winking, ~ **барилцах** to take each other by the hand, to shake hands, ~ **бие оролцох** to lend a hand, to do one's bit, ~ **бичмэл** manuscript, ~ **бөмбөг** hand-grenade; volley-ball, ~ **буу** (see **буу**), **гарын бэлэг** small gift, **гарын бээлий хийх** to use (someone) as a cat's-paw, to use (someone) for one's own purposes, ~ **газар хөл хөсөр** in peace, **гараас гарах** to get off (someone's) hands, **гараа гаргах** to do one's best, to display one's skill, ~ **гранат** (see **гранат**), **гарыг даах** to stand up to, ~ **далавчтан** Chiroptera (*zool.*), ~ **дор** under the control of, **гарын дор** (**гарын дорхи**) to hand, available, **гарын дүйтэй** handy, skilful, clever, **өөрийн ~ дээр авах** to take charge of, **гар дээрээс худалдаа хийх** to sell on the streets, to push, to peddle, ~ **загатнах** to be impatient, to be itching (to do something), **гараа зангидах** to clench the fist, ~ **зөрүүлэх** to greet (in Mongol style); to come to blows, ~ **зураг** a drawing, ~ **мухар** handicapped, disadvantaged, at a loss, ~ **мухардах** to be handicapped, to be disadvantaged, to be at a loss, **гарыг мялаах** to pay a sweetener, ~ **нийлэх** to join hands, to get on together, ~ **нийлж ганзага дүйсэн** (~ **нийлэмжтэй**) in co-operation, working together, **гарыг нь ганзаганд хөлийг нь дөрөөнд хүргэх** to give (someone) a start in life, ~ **нь ганзаганд хөл нь дөрөөнд хүрэх** to grow up, **гарт орох** to fall into the hands of, **гараа өргө** hands up!, ~ **сул** generous, open-handed, ~ **сунгах** to lend a hand, to help out, ~ **сэрээ** hand fork, small fork, ~ **татах** to begrudge, to be grudging, **зардалд ~ татах** to begrudge the expense, ~ **татуу** stingy, mean, ~ **тулалдаан** hand-to-hand fighting, **гараа угаах** to wash one's hands; to squander, to play fast and loose with, **улсын**

**хөрөнгөөр гараа угаах** to squander state property, ~ **урлаг** (~ **урлал**) craft, applied art, ~ **урчууд** craftsmen, **гарын үзүүрээр** (~ **хурууны үзүүрээр**) as easy as winking, nothing to it, **гарын үзүүр хөдөлгөх** to fiddle about, **гарын үсэг** signature, **гарын үсэг зурах** to sign, to put one's signature, **гарын үсэгтэй** signed, **гар харах** to depend on, to look to, **хүний ~ харах** to depend on others, to look to others, ~ **хатаагуур сэнс** hand-drier, ~ **хийцийн** hand-made, ~ **хоосон** empty-handed, ~ **хоосон гахай явган** poor as a church mouse, ~ **хөдлөх** to bestir oneself; to be up in arms, ~ **хөдөлбөл ам хөдөлнө** one must work to eat, **гараа хөдөлгөх** to get on with it, ~ **хөл** arms and legs, hands and feet; agent, stooge, ~ **хөлийн үзүүр** maid of all work, ~ **хөлийн үзүүрт зарах** (~ **хурууны үзүүрээр зарах**) to employ for minor tasks, **гарын худалдаа** streettrading, pushing, peddling, **гараа хумхин суух** (see **хумжих**), **гарын хүн** right-hand man, ~ **хүршгүй** untouchable, ~ **хүрэх** to touch, to lay a hand on, ~ **хүрэлгүй онгон** untouched, pristine, **гартаа цавуутай** light-fingered, ~ **цайлгах** to tip, to give something; to grease someone's palm, ~ **чангатай** tight-fisted; heavy-handed, harsh, **гарын шүүс болох** to get beaten up, ~ **эсгэм** brand-new (notes, etc.), ~ **эх** manuscript copy (for typing, etc.) **2.** one of the five divisions of the imperial herds in Dariganga (*hist.*) **3.** keyboard (computer, etc.) **4.** handlebars (bicycle), **дугуйн гарыг сул тавих** to ride with no hands

**ГАРАА I.i.** start, beginning, **оны ~** the beginning of the year, **таван жилийн төлөвлөгөөний гарааны жил** the first year of a five-year plan, **гарааны газар** starting-point, point of departure (in a horse-race) **ii.** opening (chess) **iii.** début **2.** entrance (of a wrestler) **3.** sortie, exit (of a marmot from its lair, etc.)

**ГАРААЧ** (see **хараач**)

**ГАРААШ** garage (*Russ.*)

**ГАРАГ САА** (see **гариг саа**)

**ГАРАЛ** (~ **үүсэл**) genesis, origin, source, **амьтны гаралтай** of animal origin, ~ **зүй** genetics, ~ **үүсэлтэй** descended, **нэгэн өвгөөс ~ үүсэлтэй** descended from one ancestor

**ГАРАЛТ I.** occurrence (of disease, crime, etc.) **2.** yield, production **3.** emergence, appearance **4.** entry of wrestlers at a match **5.** exit, **гаралтын хүчдэл** output voltage

**ГАРАМ I.** (голын ~) ford, river-crossing, **гарман дээр морио солих** to change horses in mid-stream **2.** crossing, level-crossing, **төмөр замын ~ level-crossing**, **төмөр замын хаалтгүй ~**

level-crossing without barrier or gate, **төмөр замын хаалттай ~ level-crossing with barrier or gate** (*traf.*)

**ГАРАМГАЙ** outstanding, superior, excellent

**ГАРАМГАЙЛАХ** to distinguish oneself

**ГАРАН** over, more than, **зуу ~ жил** more than a hundred years, **сар гарангийн хойно** after more than a month

**ГАРАНГА I.** trap for small game

**ГАРАНГА II.** (see **аранга I.**)

**ГАРАНГА III.** (see **аранга II.**)

**ГАРАХ I.** to go out, to come out, to leave, to give up, **архинаас ~** to give up drink, to go on the wagon, **архинаас гарагчдын клуб** club for ex-alcoholics, **гадагш ~** to go outside, **хоолноосоо ~** to go off one's food **2.** to appear, to come out, to be on, ~ **хугацаа** frequency of publication, § **теарт юу гарч байгаа бол** I wonder what's on at the theatre? **3.** to be discharged, **эмнэлгээс ~** to be discharged from hospital, to leave hospital **4.** to be born, **охин гарлаа** it's a girl, **гарсан төл** young animals born **5.** to go up, to rise, **нар гарахын үеэр** at sunrise, **нас сүүдэр дээр гарах** to get old, **тэнгэр гартал магтах** to laud to the skies, **уулан дээр ~** to climb up a mountain **цахилгаан шатаар ~** to go up in a lift **6.** to happen, to occur, to break out, **гэмт хэрэг ~ явдал** occurrence of crime, **осол ~** to occur (an accident), **осол гарсан газар** scene of the accident, **түймэр гарсан** fire broke out, § **шарлах өвчин гарсан айл** a family where a case of hepatitis has occurred **7.** to cross, **зам ~** to cross the road **8.** to start, (*following a converb in ж, аад*) to start to, to begin to

**ГАРВАЛ** (~ **төрвөл**) genesis, origins, **гаж ~** heterogeneity, ~ **зүй** genetics

**ГАРГАЛГАА** conclusion, inference

**ГАРГАЛТ** output

**НИЛЭЭД** 1. quite, considerable, ~ цаг хугацаа some considerable time, § шөнө ~ орой болсон боловч although it had got pretty late

2. (~ хэд) a good many, quite a few, § одоогоос ~ хэдэн жилийн өмнө a good few years ago, эдний ~ нь a good few of them

3. quite a bit, some time, some while, § бид хотоор ~ дэмий хэслээ we wandered round the town for quite a while

**НИЛЭЭДГҮЙ** (see нилээд), ~ олон quite a lot, a good many

**НИЛЭЭН** (see нилээд)

**НИМБЭГ** lemon, ~ хүчил (нимбэгний хүчил) (see хүчил), ~ хүчлийн давс citrate

**НИМБЭГЭРХҮҮ** lemon-shaped

**НИМГЭВТЭР** thinnish

**НИМГЭДЭХ** to be too thin

**НИМГЭЛЭХ** 1. to make thin 2. to thin down, to reduce in size, нимгэлэн цөөлөх to reduce in number 3. to ease, to reduce (suffering, debt, etc.)

**НИМГЭН** 1. thin, ~ хувцас thin clothes 2. (~ мөчид) slight, feeble, weak, poor, § мэргэжил боловсролоор ~ poorly skilled and trained 3. shallow, ~ ус shallow water

**НИМГЭРЭЛТ** thinning, becoming thin (n.)

**НИМГЭРЭХ** 1. to get thin, to get thinner 2. to be reduced, хүч ~ to lose strength, § түрийвч нимгэрч with money getting low 3. to be eased (sadness, etc.)

**НИНГЭН** (see нимгэн)

**НИНГЭХЭН** pretty thin

**НИНЖ** 1. (~ сэтгэлтэй) cordial, warm-hearted, kind 2. kindness (Tib. snying-rje)

**НИНЖИЙН** (see нинж)

**НИНЖИН** (see нинж)

**НИНЧИН** meditation, contemplation (Buddh.)

**НИР**: ~ хийх to crack, to roar, to thunder, ~ нар хийх (~ ~ хийх) to go bang to go crash, § суудлаасаа нирхийн босоод rising thunderously from their seats, нирхийтэл инээд алдаж roaring with laughter

**НИРВААН** Nirvana, ~ болох (~ дүр олох, ~ дүр үзүүлэх, нирвааны хутгийг олох) to die (high lama), to achieve nirvana (Skr.)



**НИРГЭЛТ 1.** shattering blow **2.** exam

**НИРГЭЛЭХ** to bang, to clatter

**НИРГЭХ 1.** (аянга ~) to strike (lightning) **2.** to strike, бут ~ to smash, **ниргэсэн хойно хашгирах** to cry over spilt milk

**НИСВАНИС** defilement, corruption, sin (*Buddh.*)

**НИСГҮҮР** pappus, cotton (*bot.*)

**НИСГЭГЧ** airman, pilot

**НИСГЭХ** to fly (*trans.*)

**НИСЛЭГ** flight, flying, олон улсын ~ international flight, сансрын ~ space flight, чартер ~ charter flight, шөнийн ~ night flying, ~ зүй aviation, aeronautics, нислэгийн өндөр flight altitude, нислэгийн пүүс airline, нислэгийн удирдагч flight controller

**НИСЭГЧ** airman, pilot, туршин ~ test-pilot, хоёрдугаар ~ co-pilot

**НИСЭГЧГҮЙ** pilotless

**НИСЭЛТ** flight, flying, нисэлтийн хүрээ flying range, range of flight

**НИСЭХ** to fly, нисдэг алт gold leaf, нисч гарах to fly out, ~ загвар model aeroplane, ~ онгоц aeroplane, aircraft, plane, ~ онгоцны буудал airport, ~ онгоц тээгч хөлөг aircraft-carrier, нисдэг тэрэг helicopter, ~ хүчин air force, ~ хүчний парад fly-past, ~ цаг flight departure time

**НИТГЭЛ** dregs, grounds

**НИТГЭРЭЛТ 1.** twisting **2.** scraping **3.** working, manipulation

**НИТГЭРЭХ 1.** to twist, to turn around (*trans.*) **2.** to scrape **3.** to work, to manipulate

**НИШИНГЭ** (Чихрийн ~) Sugar-cane, Эгэл ~ (see *Шатшуурга*)

**НОВ** (*intensifying particle*), ~ ногоон bright green

**НОВШ 1.** rubbish, trash, ~ ноохой odds and ends, rubbish **2.** bloke, chap

**НОВШИЙН** wretched, damned, bloody

**НОВШИРХУУ** untidy, a mess

**НОВШРОХ** to be strewn around, to litter

**НОГДВОР** quotient

**НОГДОЛ** allotment, share, assessment, ~ ашиг dividend

**НОГДОЛТ** (see *ногдол*)

**НОГДОХ** to be allotted to, to fall to, ~ ашиг dividend, § насанд хүрсэн хүнд долоон ном ногдож байгаа there are seven books per adult

**НОГДУУЛАХ 1.** to impose **2.** to allot

**НОГОО** vegetation, идэшний ~ (нарийн ~, хүнсний ~, ~ цагаа) vegetables, greens, үндэст ~ root vegetables

**НОГООВТОР** greenish

**НОГООЛИН** malachite (*min.*)

**НОГООЛОХ** to graze

**НОГООЛУУЛАХ** to put out to graze, to let graze

**НОГООН 1.** green, ~ байгууламж green area, ~ бус green belt, ~ малгайтан secret policeman, internal security man; Green Beret, commando, ~ морь the Green Horse used in the Mairdar ritual, ~ морины дэг name of a type of hobby-horse performance, ~ морь цагаан болтол, нохойн толгой гурав болтол наргих to go on the binge, ногооны нам Green Party, ~ тугийн цэрэг (see *цэрэг*), ~ хурганы арьс, нохойн битүү туурай, туулайн эвэр, тугалын соёноос бусад бүх юм everything but the kitchen sink, ~ хурганы арьс нохойн битүү туурай харсантай адил you must be seeing things, ~ цаас greenback, dollar, ~ цаас шидэх to throw one's dollars around **2.** greenback, dollar

**НОГООНЖИХ** to become dollar-rich

**НОГООН ТОЛГОЙТ** Gadfly, Bot-fly

**НОГООНТОН** Greens (*pol.*), ногоонтны нам Green Party

**НОГООН ХОШУУНЫ АРЛУУД** Cape Verde Islands

**НОГООРОХ 1.** to turn green, to go green **2.** to be stupefied (by drink)

**НОГООРУУЛАХ 1.** to make green **2.** (ногооруулан тохижуулах) to plant with greenery, to plant up, ногооруулан зүлэгжүүлэх to plant up and turf, to green

**НОГООЧИН** vegetable grower, vegetable seller

**НОГТ** halter, ~ зангидах to make a halter

**НОГТЛОХ 1.** to halter **2.** to bind up criss-cross

**НОГТМОЛ** old wild boar (so-called because the tusks have grown round to meet over the snout like a halter)

**НОГТРУУ** Pallas's Sandgrouse, *Syrhaptes paradoxus*

**НОДНИН** (~ жил) last year

**НОЁД** (~ баяд) lords, princes, nobility

**НОЁЛОГ** (~ оргил, ~ уул) peak (*geog.*)

**НОЁЛОГДОГЧ** subject, ruled, dominated, ~ анги subject class

**НОЁЛОГЧ** ruling, dominant, ~ анги ruling class

**НОЁЛОНГУЙ** dominant, predominant

**НОЁЛОХ** to dominate, to predominate, to prevail, to rule, ~ анги ruling class, ~ салхи pre-

vailing wind, § Алтай нурууны ~ өндөрлөг газар the dominant heights of the Altai chain

**НОЁН 1.** lord, prince, chief, superior, gentleman, ~ багаж anvil, hammer and tongs **2.** king (chess, cards) **3.** Mr. (with name, usually of foreigner) **4.** extreme, ~ нуруу ridge-pole, ridge-piece; steadiness, solidity, stability, reliability, ~ нуруугаа алдах to waver, to be unsteady, ~ нуруугүй unsound, shaky, ~ нуруутай honest, upright, ~ оргил highest peak, ~ үзүүр extreme tip

**НОЁНТОН 1.** Sir! **2.** gentleman, амбан ~ Н.Е. the Governor (*hist.*)

**НОЁРХОГЧ** dominant

**НОЁРХОЛ** mastery, domination, dictatorship

**НОЁРХОХ** to predominate

**НОЁРХУУ** domineering, overbearing

**НОЗООРОНГУЙ** feeling the heat, overcome by the heat

**НОЗООРОХ** to feel the heat, to be overcome by the heat

**НОЙЛ** zero, § ссөн цаг ~ минут nine o'clock exactly (*Russ.* ноль)

**НОЙЛЛОХ** to zero (a meter, etc.)

**НОЙЛЫН** ignorant

**НОЙМЕР 1.** number **2.** size (*Russ.*)

**НОЙР I.** sleep, үлгэрийн баатрын ~ (шүлэг ~) deep sleep, sound sleep, ~ бүтэн яваа having had a full night's sleep, ~ сэргэх to be roused, to become wideawake, нойроо сэргээх to wake oneself up, ~ хулжаах to keep (someone) awake, нойроо хулжаах to stay awake, to fight off sleep. ~ хулжих to be unable to sleep, ~ хүрэх to feel sleepy, ~ хүрэхгүй (~ цэлмэх) to be unable to get to sleep, нойрын шар бөх sandman, нойрны эм sleeping medicine, sleeping pill

**НОЙР II.** (нойрын булчирхай) pancreas

**НОЙРГҮЙДЭХ** to suffer from insomnia

**НОЙРГҮЙТЭЛ** insomnia

**НОЙРМОГ** sleepy, drowsy, dozy

**НОЙРМОГЛОХ** to doze, to sleep fitfully

**НОЙРСОЛТ** sleep, sleeping

**НОЙРСОМТГОЙ** sleepy

**НОЙРСОХ** to sleep, to go to sleep (*resp.*)

**НОЙРСУУЛАХ** to cause to sleep, to let sleep, to put to sleep, to anaesthetize, ~ үйлчилгээ soporific effect, ~ эм sleeping medicine

**НОЙРШИЛТ** sleep, sleeping

**НОЙТ** wet, damp (*n.*)

**НОЙТОГНОХ** to get wet

**НОЙТОН** wet, damp (*adj.*), ~ модыг нэгшир-

тэл зодох to whip soundly

**НОЛЬ** (see нойл)

**НОМ 1.** book, том үсэгтэй ~ large-print book, ~ гэрээр олгох to lend out a book (library), номын ёсоор like clockwork, according to the book, as it should be, ~ заалгах to get taught, ~ зохиол (~ судар) books, ~ зүй (see номзүй), ~ олгогч issuing librarian, номын сан library, номын санч librarian, номын тавиур bookshelf, bookcase, ~ унших to read, ~ үзэх to study, ~ хэвлэл books, publications, the press, printing **2.** religious book, scripture, ~ лүн авах to take religious instruction, ~ унших to recite the scriptures, ~ хаялцах to hold a religious disputation; to argue, ~ хэлэлцэх to hold a religious disputation **3.** religion, doctrine, teaching, номт дээл (номын хувцас) vestments, lama's robes, номын их хурим хийх (see дом тавих), ~ тавих to preach, номын хаан (номон хаан) (see цорж), номын чуулган religious house (*Buddh.*) (*Tib.* chos-kyi 'dun-sa)

**НОМГОН** (see номхон)

**НОМГОРОХ** (see номхрох)

**НОМГОЧЛОХ** to push around, to ride roughshod over

**НОМГҮЙ 1.** irreligious, impious, without faith **2.** no need to, no reason for

**НОМЕР** number-plate (*Russ.*)

**НОМЗҮЙ** bibliography

**НОМЗҮЙН** bibliographical

**НОМИЛГОНО** *Anemarrhena* (*bot.*), Тансаг ~ *A. asphodeloides*

**НОМИН I.** lapis lazuli (*min.*), ~ хөх тэнгэр (~ цэнхэр тэнгэр) azure sky (*Tib.* mu-men)

**НОМИН II.** Mole-Rat, Rodent Mole, *Myospalax*, Дагуур ~ *M. aspalax*

**НОМИНТОХ** to look azure

**НОМЛОГЧ** teacher, advocate, apostle

**НОМЛОЛ** teachings, doctrine

**НОМЛОХ** to teach, to advocate

**НОМНОГЧ** (see номлогч)

**НОМНОЛ** (see номлол)

**НОМНОХ** (see номлох)

**НОМОЙ 1.** quiet, lethargic **2.** phlegmatic

**НОМОЙРЛОГ** depression, apathy

**НОМОЙРОЛТ** (see номойрлог)

**НОМОЙРУУЛАХ** to depress, § төв мэдрэлийн системийг ~ to depress the central nervous system

**НОМОНЦОР** booklet

**НОМОРХОГ** book-owning, book-loving

**НОМТОЙ** should, ought to

**НОМГОН** learned man, scholar

**НОМХОН** 1. gentle, quiet, peaceful, ~ борчууд "Gentle Greys" (name given to red Russian troops in Mongolia at the time of the revolution), ~ хүлцэнгүй patient, submissive 2.i. attention! (*mil.*), ~ болох (~ байдалд орох) to come to attention, ~ зогсох to stand at attention (*Russ. смирно*) ii. order to change to parade-step while on the march

**НОМХОН ДАЛАЙ** Pacific Ocean

**НОМХОН ДӨЛГӨӨН ДАЛАЙ** (see **Номхон Далай**)

**НОМХОТГОХ** to tame, to break, to pacify, ~ цамц straitjacket

**НОМХОЧЛОХ** (see **номгочлох**)

**НОМХРОХ** 1. to become tame 2. to calm down, to feel reassured

**НОМХРУУЛАХ** to tame, to break (horse, camel)

**НОМЧ** 1. learned, 2. scholar, ~ мэргэд scholars

**НОМЧИРХОГ** proud of one's knowledge, bookish, pedantic

**НОМЧИРХОЛ** pedantry

**НОМЧИРХОХ** to air one's knowledge, to be pedantic

**НОМЧИРХУУ** (see **номчирхог**)

**НООГДВОР** quotient (*arith.*)

**НООГДОЛ** allotment, share

**НООГДОХ** to fall to, to be related to, per, § нэг хүн амд ~ малын тоо number of animals per head of the population

**НООЛОРСОН** (see **ноолорхой**)

**НООЛОРХОЙ** ragged, torn

**НООЛОХ** to pull at, to bother, to pester

**НООЛУУР** 1. down, fluff 2. the undercoat, or main wool, of sheep or goat 3. cashmere

**НООЛУУРЛАГ** downy

**НООЛУУРТАХ** to be downy

**НООЛУУРЧ** Biting Lice, Mallophaga

**НООМОЙ** (see **номой**)

**НООН ГОЛ** Nonni River (*p.n.*)

**НООРОГ** 1. draft 2. copy (for typing, etc.)

**НООРОНХОЙ** tattered and torn

**НООРОХ** to be tattered, to be ragged

**НООРС** down (*n.*)

**НООРСЛОГ** downy

**НООРСОРХОГ** (see **ноорслог**)

**НООРХОЙ** tattered, torn, ragged, § ~ цоорхой байшин барилга tumbledown buildings

**НООС** wool, ахрын ~ (see **ахар**), бутархай ~ detached wool cut or plucked from the legs and belly (and defined as weighing less than 15 g.), бүтэн ~ fleece, тэмээний ~ camel hair, уртын ~ (see **урт**), үргэлж ~ wool taken off in one piece (and defined as weighing more than 15 g.), хогтой ~ dirty wool (defined as having more than two per cent impurities), хэвийн ~ standard wool (defined as having less than two per cent impurities), эм ~ (зөөлөн ~) fine wool from the body of the camel, эр ~ (ширүүн ~) coarse wool, from the knees, beard, top of the hump and top of the head of the camel, ноосон даавуу woollen cloth, ноосоо иддэг тэмээ шиг like a camel eating its own wool, greedy, rapacious

**НООСЛОГ** woolly

**НООСЛОЛТ** shearing

**НООСЛОХ** to shear (camel, sheep), to remove the wool

**НООСОРХОГ** woolly

**НООТ** note (*mus., etc.*), ~ бичиг note (diplomatic)

**НООХОЙ** nest (of a rodent), хархны ~ rat nest, хэвтэш ~ litter (for a nest), ~ хөөө (see **хөөө**)

**НООХОЙЛОХ** to make a nest (rodents)

**НОРГОХ** to wet, to make wet

**НОРМ** (~ горим, ~ дүрэм, ~ дэглэм) norm, standards, requirements, regulations, ~ хэмжээ proper amount, standard, limit

**НОРМЛОХ** to set a rate, to set a standard

**НОРМЧИН** rate-setter

**НОРМЧЛОЛ** regulation, rate-setting, хөдөлмөрийн ~ rate-setting, setting of work quotas

**НОРМЧЛОХ** to regulate, to set rates, хөдөлмөрийг ~ to set work rates, to set work quotas

**НОРОВ** (~ эрдэнэ) jewel (*Tib. nor-bu*)

**НОРОЛТ** wetting, dampening

**НОРОМТГОЙ** permeable

**НОРОХ** to get wet

**НОТ** I. firm, strong, solid

**НОТ** II. note (*mus.*), арван зургаат ~ semiquaver, бүтэн ~ semibreve, дөрөвт ~ crotchet, наймт ~ quaver, хагас ~ minim, ~ бичлэг notation, нотыг харж хөгжимдөх to play from music, ~ хуваарилал score

**НОТЛОЛ** notation (*mus.*)

**НОТЛОМЖ** proof

**НОТЛОХ** I. to prove, to confirm, ~ баримт

evidence, ~ баримт цуглуулах to collect evidence, нотлон тодорхойлох (нотлон үзүүлэх) to prove, to demonstrate

**НОТЛОХ II.** to notate (*mus.*)

**НОТОД** firmly, strictly, rigidly

**НОТОЛГОО** proof, evidence

**НОТТОЙ** positive

**НОУ-ХАУ** know-how

**НОХОЙ I.** dog, дөрвөн нүдтэй ~ a dog with hollows over each eye, мөрч ~ (үнэрч ~, эрэлч ~) police dog, хоньч ~ sheep-dog, хоточ ~ guard dog, ~ ам нийлүүлэх to join the tent-wall sections incorrectly (anti-clockwise), нохойноосоо гархи нь (нохойноосоо гинж нь) like the curate's egg, ~ гаслам халуун scorching hot, ~ гахайдаа хүрэх to get on abusive terms with each other, нохойн гуяар даллах to pick up (a girl) easily, ~ долоо damn it!, нохойн дуу ойртох to come to the end of a job, ~ морины хүч гаргах to toil away, to work hard, нохойн наадам child's play, ~ нь сүүлээ сүүл нь сангарцгаа passing the buck, ~ хамартаа хүрэхээр усч гэгч keeping one's head above water, ~ хорих to keep the dogs down (as a stranger approaches the tent), ~ худахын чинээ үл тоомсорлох not to care a damn about, to disregard completely, ~ шиншлэхгүй useless, rubbishy, ~ шуугиулах to disturb the dogs; to stir things up, нохойн шүд a tooth-like edging stitch, ~ явган гахай нүцгэн poor as a church mouse, Нохойн язгуур Dog Family, Canidae **2.** difficult, hard, troublesome, a beast, ~ ажил a devil of a job, **3.** crafty, cunning, ~ зан craftiness, cunning, ~ зан гаргах to be crafty, to be cunning, ~ санаа nasty thoughts, ~ хүн slyboots, cunning so-and-so

**НОХОЙБАР** Cheetah

**НОХОЙДОХ** to be artful, to be sly

**НОХОЙ ЗАГАС** name of a fish of the Cyprinidae family

**НОХОЙ ЗЭЭХ** (see Зээх)

**НОХОЙН ХОШУУ** Wild Rose (see Сарнай), Өргөст ~ *Rosa acicularis*, Сийрэг ~ *R. laxa*

**НОХОЙН ХЭЛ** *Panzeria* (*bot.*)

**НОХОЙТОХ** to be sly, to be foxy

**НОХОЙ ХАР ГӨРӨӨС** Black Bear

**НОХОЙЧЛОХ 1.** to chase **2.** to do a dog-paddle **3.** to be sly, to be foxy

**НОХОЙ ШИВЭЭ** *Aristida heymanii* (*bot.*) (also Нохой Бөөдий)

**НОХОЙ ШОГШОР** Kingfisher, *Alcedo atthis*

**НОХОЙ ШЭЭРЭН** (Нохойн Шээрэн) *Zygodium xanthoxylon* (*bot.*) (also Шар Хотир)

**НОЦОЛДЛОГО** fighting, scrapping

**НОЦОЛДОХ 1.** to fight, to scrap, to come to blows **2.** to struggle with, to toil away at, to busy oneself with, малаар ~ to busy oneself with the beasts

**НОЦОМ** burning, fit to burn, ~ халуун burning hot

**НОЦООГОНО** *Xanthium* (*bot.*), Эгэл ~ *X. sibiricum* (also Нохой Зангуу)

**НОЦООХ** to light, to ignite, гал ~ to light a fire, лаа ~ to light a candle

**НОЦОРГОНЫ ОВОГ** Borage Family, Boraginaceae

**НОЦОХ I.** to catch fire, to burn

**НОЦОХ II.** to pounce on, to grab

**НОЦТОЙ** serious, grave, important, significant

**НӨГӨӨ 1.** that, those, the ones concerned, ~ хүн that man **2.** the other, ~ ертөнц the other world, ~ талаар on the other hand, § ~ дөч гаруй хувь нь the other forty per cent and more, эдгээрийн нэгийг нөгөөгөөр сольж болохгүй one of them cannot be substituted for another

**НӨГӨӨДӨР** the day after tomorrow, ~ нь the next day but one

**НӨГӨӨДӨХ 1.** that one **2.** the other one

**НӨГӨӨДҮҮЛ** those people, them there

**НӨГӨӨТӨХ** (see нөгөөдөх)

**НӨГӨӨТЭЙГҮҮР** on the other hand

**НӨГӨӨТЭЭГҮҮР** (see нөгөөтэйгүүр)

**НӨГӨӨХ 1.** (see нөгөө 1., 2.) **2.** you know what

**НӨГЦӨӨХ** to pass, to spend, to let go by, цагийг ~ to pass the time, to kill time

**НӨГЦӨХ 1.** to pass, to go by (time) **2.** (нас ~) to die

**НӨГЧИХ** (see нөгцөх)

**НӨЖ 1.** blood-clot, clot of blood **2.** hell!

**НӨЖРӨЛТ** clotting (blood)

**НӨЖРӨХ** to clot (blood, *intrans.*)

**НӨЛӨӨ I.** (~ нөөлбөр, ~ нөөлөг) influence, ~ бүхий influential, нөлөөнд орох to come under the influence (of), to get into the clutches (of), ~ үзүүлэх to exert an influence

**НӨЛӨӨ II.** heat

**НӨЛӨӨЛӨЛ** influence, гадны ~ external influence, харилцан ~ mutual influence

**НӨЛӨӨЛӨЛТ** (see нөлөөлөл)

**НӨЛӨӨЛӨХ** to exert influence, to be influential, to affect, to have an effect, § нүдний хараанд

**муугаар** ~ to have a bad effect upon the eye-sight

**НӨЛӨӨЛӨХҮЙЦ** influential

**НӨЛӨӨЛЦӨЛ** (**харилцан** ~) mutual influence

**НӨЛӨӨТӨХ** to distort (mirror)

**НӨЛӨӨТЭЙ** influential

**НӨМГӨЛӨХ** to wear (one's **дээл**) thrown over the shoulders

**НӨМГӨН** beltless, without a belt

**НӨМӨР** 1. sheltered, **салхинаас** ~ **газар** a place sheltered from the wind, ~ **дулаан** warm and sheltered 2. (~ **нөөвч**, ~ **нөөлөг**, ~ **хорго**) shelter, sheltered place, ~ **саад** windbreak, ~ **хаацгай** sheltered, protected

**НӨМӨРГӨХ** to put over, to drape over, to cover

**НӨМӨРДӨХ** to shelter, to take shelter

**НӨМӨРДҮҮ** sheltered, ~ **газар** sheltered place, sheltered spot

**НӨМӨРЛӨГ** (see **нөмөрдүү**)

**НӨМӨРЛӨХ** to shelter, to shield

**НӨМӨРТЭЙ** (see **нөмөрдүү**)

**НӨМРӨГ** 1. overall, wrap, mantle, gown 2. mantle [oyster-shell] 3. cover, **ургамлан** ~ plant-cover

**НӨМРӨХ** 1. to drape over the shoulders, to cover oneself with 2. to overwhelm, to swamp (danger, etc.)

**НӨӨЛӨГ** 1. gust, down-draught, sudden whirlwind in a sheltered spot in a mountain 2. foehn-wind

**НӨӨЛӨГЛӨХ** to gust, to blow in gusts

**НӨӨМӨЛ** accumulated

**НӨӨХ** to put aside, to put by, to keep, to keep back, to keep in reserve, to retain, **биеэ** ~ (see **бие** 1.)

**НӨӨЦ** stocks, reserves, supplies, resources, ~ **баялаг** riches, resources, reserves, ~ **бололцоо** resources, **эрдсийн** ~ **бололцоо** mineral resources, ~ **газар** reservation, ~ **зам** siding, ~ **тоглогч** reserve (football, etc.)

**НӨӨЦЛӨЛТ** stocking-up, stock-piling

**НӨӨЦЛӨХ** to lay in, to keep in hand, to reserve, to keep in reserve, to set aside, to stockpile, to hoard, **татаж** ~ to stock up, to lay in, **нөөцлөн хадгалах** to keep, to store

**НӨӨЦНӨХ** (see **нөөцлөх**)

**НӨӨШ** tinned food, preserves

**НӨӨШЛӨХ** to preserve, to tin, to can

**НӨР** (~ **хичээнгүй**, ~ **шургуу**) protracted,

dogged, ~ **их хөдөлмөр** devoted labour, tireless work

**НӨРГӨС** Alder, *Alnus*

**НӨРЛӨХ** to be dogged, to be tenacious, to stick to it, **нөрлөн тулалдах** to fight doggedly

**НӨРӨӨ** pock-mark

**НӨРӨӨТЭЙ** pock-marked

**НӨСӨӨ** pigment (*anat.*)

**НӨСӨӨТӨХ** to be pigmented

**НӨСӨР** (see **нүсэр**)

**НӨХВӨР** supplementation, assistance

**НӨХӨГДӨШГҮЙ** irreparable, irrecoverable, ~ **баялаг** non-renewable resources

**НӨХӨД** friends, comrades

**НӨХӨЛТ** 1. patching, **арьс** ~ skin-graft 2. compensation

**НӨХӨӨС** (~ **халаас**) patch, **далан нөхөөст** covered with patches, ~ **тавих** to put on a patch, to patch

**НӨХӨӨСТЭЙ** patched, ~ **дугуй** a patched tyre

**НӨХӨР** 1. friend, companion, comrade (*also polit.*), ~ **ёсны** friendly, comradesly, ~ **ёсны сануулга** friendly warning, ~ **сүүдэр** boon companion, ~ **татах** to implicate, to involve 2. husband, **нөхөрт гарах** to marry a man, ~ **гэргий** husband and wife, ~ **хань** partner, spouse

**НӨХӨРГҮЙ** unmarried, without a husband

**НӨХӨРЛӨЛ** 1. association, group, band, troop, **үйлдвэрлэлийн** ~ production association, **хамтын** ~ community, commonwealth 2. comradeship, friendship

**НӨХӨРЛӨХ** to make friends, to be friends, **номтой** ~ to be a friend of books

**НӨХӨРСӨГ** friendly, comradesly, amicable, sociable, ~ **байдал** friendliness, amicability, ~ **тоглолт** (~ **уулзалт**) friendly match, a friendly, ~ **харьцаа** friendly relations, ~ **хамтрах** to work together amicably

**НӨХӨРТЭЙ** married, having a husband

**НӨХӨХ** 1. to patch, to mend 2. to make up, to make good, to replace, to restore, **орлогоороо зарлагаа** ~ to make income cover expenditure, **өртгөө** ~ to pay for itself, to cover the cost, **хохирол** ~ to make good a loss, to compensate for a loss, **нөхөн авах** to recoup, to recover, to regain, **нөхөн бичих** to fill in, to fill up (a form, etc.), **нөхөж болшгүй хор уршиг** irreparable consequences, **нөхөн бүтээх** to restore, **нөхөн захиалах** to re-order, **нөхөн ойжуулалт** re-afforestation, **нөхөн олговор** compensation, **нөхөн олгох** to refund, to compensate for, **нөхөн олох** to get back, to recover, **нөхөн өсөлт** regeneration, regrowth,

**нөхөн суулгах** to replant; to transplant, **ойг нөхөн суулгах** to reafforest, **эд эрхтэн нөхөн суулгах** organ transplant, **нөхөн сэлбэх** to repair, to restore, **нөхөн сэлбэх мэс засал** plastic surgery, **нөхөн сэргэлт** recovery, **нөхөн сэргэх** to recover, **нөхөн сэргээх** to restore, to make good, to rehabilitate (*med.*), **нөхөн сэргээгдэшгүй** non-renewable, **ойг нөхөн сэргээх** to reforest, **нөхөн тарилт** replanting, **нөхөн тарих** to replant, **нөхөн төлбөр** compensation, **нөхөн төлжилт** regeneration, **нөхөн төлжих** to be regenerated, **нөхөн төлжүүлэх** to regenerate, **нөхөн төлөх** to pay back, to repay, to compensate for, **нөхөн төлүүлэх** to get compensation, **нөхөн ургалт** regeneration, **нөхөн ургах** to be regenerated, **нөхөн ургуулах** to regenerate, **нөхөн үйлдвэрлэл** replenishment, regeneration

**НӨХӨШГҮЙ** irreparable, irrecoverable, ~ **хөнөөл** irreparable damage

**НӨХЦӨЛ** 1. condition, circumstance, factor, possibility, **говийн нөхцөлд** in Gobi conditions, **замын** ~ road conditions, **лабораторийн нөхцөлд** in laboratory conditions, ~ **алга** there is no chance, ~ **байдал** conditions, circumstances, state of affairs, situation, **гэрийн** ~ **байдал** home circumstances, **орон нутгийн** ~ **байдал** local conditions, ~ **бололцоо** conditions, possibility, ~ **бүрдүүлэх** to furnish the conditions (for), ~ **шалтгаан** factor 2. ending, suffix, **харьяалахын тийн ялгалын** ~ possessive suffix (*gram.*)

**НӨХЦӨЛГҮЙ** impossible, lacking the means (to), **амьдрах** ~ with no means of subsistence, unviable, **хэрэглэх** ~ unusable

**НӨХЦӨЛДӨХ** to be determined

**НӨХЦӨЛДҮҮЛЭХ** to determine, to contribute towards, **нөхцөлдүүлэгч хүчин зүйл** contributory factor, § **ядрах, өлсөж цангах нь дулааны цохилт болоход нөхцөлдүүлж өгдөг** fatigue and hunger and thirst contribute towards the occurrence of heat stroke

**НӨХЦӨЛТ** conditioned, ~ **рефлекс** conditioned reflex

**НӨХЦӨХ** 1. to become friends with, to take up with 2. to possess (demon, etc.)

**НУТА** I. meadow, stretch of grassland by a river, **татмын** ~ water meadow, **хуурай** ~ dry meadow, **чийглэг** ~ damp meadow

**НУТА** II. down, over, off, ~ **дарах** to bend over, to repress, to depress, to suppress, ~ **эргэх** to turn off, to break away

**НУГАЖУУ** meadow-like

**НУГАЛАА** I.1. crease, fold, pleat, folding 2. (~ **завхрал**) deviation (*polit.*)

**НУГАЛАА** II. (~ **хугалаа**) coloratura, melisma (*mus.*)

**НУГАЛААС** (see **нугалаа** I.1.)

**НУГАЛААТАН** deviationist (*polit.*), **зүүний** ~ leftist deviationist

**НУГАЛАГЧ** flexor, ~ **булчин** flexor muscle

**НУГАЛАМ** vertebra

**НУГАЛАМТАН** vertebrates, **дээд** ~ higher vertebrates

**НУГАЛАХ** 1. to bend, to fold, **нугалан хамарлах** to fold (a sheet of paper) 2. to dislocate 3. to do most of the work, **ажлын голыг** ~ to break the back of the work, to do the lion's share of the work, § **хот хөдөөгүй хамаг ажлыг нугалж байсан ГАЗ-69 машин** the Gaz-69 which has been the work-horse in town and country alike 4. to increase, § **төлөөгүй хүүгийн хэмжээг нэг дахин нугалж** doubling the level of unpaid interest 5. to separate joints, § **нурууг нэг эсвэл хоёроор** ~ to separate a backbone into single joints or pairs of joints

**НУГАЛБАР** folded, ~ **бичиг** "folded letter", despatch (*hist.*); pamphlet, ~ **ном** concertina book (*xyl.*)

**НУГАЛБАРЛАХ** to fold up

**НУГАЛМАЙ** (see **нугалам**)

**НУГАЛМАЙТАН** (see **нугаламтан**)

**НУГАЛПРАХ** to get creased

**НУГАЛУУР** I. pylorus (*anat.*)

**НУГАЛУУР** II. the thinner part of a **зайдас**

**НУГАН** boy, son

**НУГАРААЧ** (see **нугарагч**)

**НУГАРАГЧ** {**уран** ~} contortionist

**НУГАРАЛ** bend, crease, fold, **и-гийн** ~ the breaking of the "i" (*ling.*)

**НУГАРАЛДАХ** to be creased up

**НУГАРАЛТ** (see **нугарал**), **уран** ~ contortions

**НУГАРАМТГАЙ** bendy, flexible

**НУГАРАХ** I.i. to bend, to be bent, to be creased ii. to perform as a contortionist 2. to slacken off, to abate, to come towards the end

**НУГАРХАГ** meadow-like

**НУГАРХАЙ** bent

**НУГАС** I. Duck, **Бор** ~ Gadwall, *Anas strepera*, **Зэрлэг** ~ Mallard, *A. platyrhynchos*, **Зэрлэгшир** ~ Spotbill Duck, *A. poecilorhynca*, **Зээрд алаг** ~ Wigeon, *A. penelope*, **Ногоохон** ~ Teal, *A. crecca*, **Халбага** ~ Shoveler, *A. clypeata*, **Хумхин** ~ Goosander,

*Mergus merganser*, Цагаан хөмсөгт ~  
Garganey, *A. querquedula*, Шовтор алаг ~  
Pintail, *A. acuta*

**НУГАС II.** hinge, hinged joint, ~ бүхий hinged,  
нугасан холбоо hinged joint

**НУГАС III.** spinal cord, нугасны суваг spinal  
canal, нугасны халдварт саа poliomyelitis,  
нугасны шингэн spinal fluid

**НУГАСЛАХ** to kill with a cut or stab in the spinal  
cord

**НУГАСХИЙХ** to bend, to fold

**НУГАЧАА** fold, bend, wrinkle

**НУГДАГАНАХ** to duck, to duck down

**НУГДАЙХ 1.** to be short-necked **2.** to go limp,  
to flop

**НУГДАС ХИЙХ** to duck, to duck down

**НУГЖИЙХ** to nestle

**НУДАРГА 1.** fist, нударган зодоон punch-  
up **2.** cuff (of a Mongol gown, дээл) **3.** cam  
(*mech.*), нударган гол (нударгат гол,  
нударгатай хуваарилагч гол) camshaft (*auto.*)  
**4.** capability, experience

**НУДАРГАГҮЙ 1.** without cuffs **2.** clumsy, ham-  
handed

**НУДАРГАЛАХ** to punch

**НУДАРГАН** (~ баян) kulak (*polit.*)

**НУДАРГАТАЙ** handy, capable

**НУДРАГАЛАХ** (see нударгалах)

**НУДРАХ 1.** to push, to shove, to thump, to nudge  
**2.** to kill

**НУДЧИХ** to keep pounding

**НУЖИГНАХ** to crackle, to make a cracking  
sound, to crunch

**НУЛИМАХ** to spit

**НУЛИМС** tear, доголон ~ rolling tears, ~  
асгаруулагч хий (see хий 1.), ~ барих (~  
барьж тогтоох) to hold back one's tears,  
нулимсны булчирхай (see булчирхай), ~  
хамрын суваг tear-duct

**НУЛИМСТАХ** to be tearful

**НУЛМИС** (see нулимс)

**НУЛЬ** all over, § ~ шавар болсон covered with  
mud

**НУЛЬМУУР** spittle

**НУМ 1.** bow (weapon), нарийн хийцэт ~  
(нийлмэл ~, зүймэл ~) composite bow,  
энгийн хийцэт ~ self bow, нумын гэр bow-  
case, ~ сум bow and arrow **2.** bow (*mus.*)  
**3.** arc, цахилгаан ~ electric arc, нуман

холбоос tie (*mus.*) **4.** spring (*mech.*) **5.** a mea-  
sure of length equal to a fathom **6.** the bow-like  
stroke in letters such as b, k, in Mongol script  
**7.** shaft-bow, hame-tugs (connecting collar and  
shafts)

**НУМАВЧ** small bow, ~ өрөм bow drill

**НУМДАХ** to tease (wool) with a bow

**НУМЛАА** tetanus, lockjaw

**НУМЛАХ** to bend, to curve (*trans.*), нумлаж  
татах to get lockjaw

**НУМРАХ** to bow, to form a bow, to be bow-  
shaped

**НУМЧИН** bow-maker

**НУНЖ** (~ дорой) weak, feeble, decrepit

**НУНТАГ 1.** powder, угаалгын ~ (угаах ~)  
washing-powder **2.** powdered, powdery, ~  
сүү powdered milk, ~ хөрс powdery soil

**НУНТАГЛАЛТ** pulverization

**НУНТАГЛАХ** (нунтаглаж жижиглэх,  
нунтаглан талхлах) to pulverize, to reduce to  
powder

**НУНТАГРАХ** to be turned to powder, to be  
pulverized

**НУНТАГШИХ** (see нунтаграх)

**НУРАА** ruins

**НУРААХ** to knock down, to demolish

**НУРАГ** scree, ~ элс sand-slip

**НУРАЛ** (~ дарал) fall, subsidence, collapse,  
landslide

**НУРАЛТ** (~ даралт) (see нурал)

**НУРАМ** hot ashes

**НУРАМГАР** glum, depressed

**НУРАМТАХ** to glow, to burn

**НУРАМШИХ** (see нурамтах)

**НУРАНГИ 1.** ruins, remains **2.** ruined **3.** shifting,  
slipping, ~ элс shifting sand

**НУРАНХАЙ 1.** ruins, remains **2.** ruined

**НУРАХ** (нуран унах) to collapse, to fall into ruins,  
нурж хэмхрэх to be demolished

**НУРГИЛАХ** to rumble

**НУРГИХ** to buzz, to hum

**НУРДХИЙХ** to crackle, to rustle

**НУРМАЙХ 1.** to feel tired, to feel sleepy **2.** to  
be glum, to be depressed

**НУРМАЛАХ** to roast on hot ashes

**НУРСАН** ruined, ~ балгас ruins

**НУРУУ 1.i.** (~ зоо) back, backbone, spine, ~  
авах to hurt the back, to affect the back, to make  
the back sore (horse, etc.), нуруугаа авсан  
морь a horse with saddle-sores, ~ ачаа load

(for an animal), ~ ачаанд сургах to train (an animal) to carry a load, ~ ачих to use pack animals; to load an animal, тэмээг ~ ачих to load a camel, нурууны багана spinal column, ~ гарах spondylitis, ~ руу хутга шаах to stab in the back, ~ тэнийх to be at ease, нуруугаа үүрэх to stand with the hands behind the back ii. (~ туруу) stature, ~ туруугүй run-down, өндөр нуруутай tall iii. back (of a composite bow) 2. range, ridge (geog.) 3. ridge (of a roof), ноён ~ (see ноён 4.), ~ мод ridge-pole (of a tent, майхан) 4. (өвсний ~) haystack 5. the central vertical stroke in Mongol script 6. cross-piece of a hay rake 7. (~ төлөв) state, condition, outlook

**НУРУУВЧ** back-pad, back protector

**НУРУУЛАГ** tallish, tall

**НУРУУЛАХ** to stack, to heap up

**НУРУУЛЦААТАЙ** stacked

**НУРУУЛЦАХ** (see нуруулах)

**НУРУУНД** 1. slung (arms) (*mil.*) 2. sling arms!

**НУРУУТАЙ** all right, sound, ~ туруутай well-built, handsome, ~ улс good types, sound chaps

**НУР ХИЙХ** to creak, to grate

**НУРШАА** long-winded, garrulous, prolix

**НУРШИЛГ** pleonasm

**НУРШИХ** (нуршин өгүүлэх) to go on about, to make a lot of

**НУРШУУ** (see нуршаа)

**НУРШУУЛАЛ** long-windedness, garrulity

**НУС** nasal mucus, snot, ~ гоожих to run at the nose, нусаа татах to sniff up

**НУСГАЙ** 1. runny nose, catarrh 2. a cold, ~ хүрэх to get a cold

**НУСГАЙРАХ** to have a runny nose

**НУСТАХ** (see нусгайрах)

**НУТАГ** territory, area, locality, homeland, уг нутгаас зайлуулах ял banishment (*jur.*), хар ~ deserted campsite, ~ билчээр pasture-land, ~ буцах to go home; to die, ~ дэвсгэр area, territory, хамгаалах ~ дэвсгэр protected area, ~ дэвсгэрийн бүрэн бүтэн байдал territorial integrity, ~ дэвсгэрийн халдашгүй дархан байдал territorial inviolability, ~ заах (~ зааж суулгах ял) exile (to a specified locality) (*jur.*), ~ нута home, native land, ~ нугынхан local people, нутгийн нүдийг олох to find a good place to camp, ~ орон locality, ~ орны local, ~ ус land and water; neighbourhood, locality, нэгэн ~ усны ардууд people from the same locality, ~ усныхан local people

**НУТАГЛАХ** to dwell, to camp

**НУТАГЛУУЛАХ** to bury, to inter, to dispose of (a corpse)

**НУТАГШИЛ** acclimatization, localization

**НУТАГШИЛГ** (see нутагшил)

**НУТАГШИХ** (нутагшин идээших) to become acclimatized, to settle down, to feel at home

**НУТАГШМАЛ** acclimatized

**НУТАГШУУЛАЛ** acclimatization

**НУТАГШУУЛАХ** to acclimatize

**НУТГАРХАГ** parochial, favouring one's own locality

**НУТГАРХАХ** to favour people from one's own locality

**НУТГИЙН** local, ~ ард local people, ~ аялгуу local dialect

**НУТЛАХ** (see нотлох I.)

**НУУВАР** secret, secretive, surreptitious

**НУУВАРЛАХ** to be furtive, to be surreptitious

**НУУВЧ** foxhole, hideout

**НУУГААСТАЙ** hidden

**НУУГДАХ** to be hidden, to hide, ~ байр air-raid shelter, shelter

**НУУГДМАЛ** hidden, secret, concealed

**НУУГДУУЛАХ** to hide, to conceal

**НУУГИХ** to be well mixed, to be well blended, to be harmonious, to be smooth

**НУУДГАЙ I.** secret, unknown, nameless

**НУУДГАЙ II.** *Crypsis (bot.)*, Хатгуурт ~ Sharp-leaved Grass, *C. aculeata*

**НУУР** lake, ~ амар бол нугас амар if the lake is peaceful the ducks are at ease, if the state is peaceful the people are at ease, ~ судлаач limnologist

**НУУРЛАХ** to form a lake, to turn into a lake

**НУУРМАГ** pool, pond

**НУУСХИЙХ** (see нуух I.)

**НУУХ I.** (нуун далдлах, нууж хаах) to hide, to conceal, нуун даралдуулах to suppress, to hush up, нуувч нуруу нь нуутдавч шил нь ил sticking out a mile, нуун хаацайлах to conceal, to cover up

**НУУХ II.** rheum, matter, discharge, нууных нь авах гэж нүдийг нь цохлох to do a disservice

**НУУХ III. 1.** recess or surround for an inlay 2. slot for a nail in a horseshoe

**НУУХДАХ** to suppurate, to discharge pus (eyes)

**НУУХТАХ** (see нуухдах)



**НУУЦ 1.** secret (n.), **улсын** ~ state secret, ~ алдах (~ задраах, ~ задруулах) to give away a secret, to divulge a secret, ~ хадгалах to keep a secret **2.i.** secret (adj.), **маш** ~ top secret, ~ **ажиллагаа** covert operations, ~ **алба** secret service, ~ **байдал** secrecy, ~ **байдалд орох** to go underground, **нууцын зэрэглэлтэй** classified, ~ **нэр** pseudonym, false name, ~ **орон** private parts, ~ **түлхүүр** code, ~ **үе** (~ хугацаа) latent period, incubatory period (of a disease), ~ **цагдаагийн газар** secret police **ii.** secretly, in secret, ~ **ажиллах** to work secretly, to work in secret, ~ **далдуур** stealthily **3.** hide, hiding-place

**НУУЦГАЙ** secret, covert, furtive, clandestine

**НУУЦГАЙЛАН** secretly, in secret, covertly, furtively, clandestinely

**НУУЦГАЙЛАХ** to hush (something) up, to keep quiet about (something)

**НУУЦЛАГ** secret (adj.)

**НУУЦЛАГЦАХ** to be hidden, to be kept secret, **нууцлагдсан халуун** latent heat

**НУУЦЛАГЦМАЛ** hidden, kept secret

**НУУЦЛАЛ** secrecy

**НУУЦЛАХ 1.** to hide, to conceal, to keep secret, **нууцлан дарах** to hush up, **нууцлан хийх** to hide, to secrete **2.** to classify as secret

**НУХАЛТ** stirring, mixing

**НУХАХ 1.** to rub, to knead **2.** (нухаж хутгах) to mix, to stir **3.** to kill, to kill off **4.** to get down to, to have a go at

**НУХАЦТАЙ** careful, serious, with consideration, thoughtful, thorough

**НУХАШ** purée

**НУХЛАХ** to knead, to pound, to wring, **нүдээ нухлах** to rub one's eyes

**НУХМАЛ** ground, powdered, ~ **алт** powdered gold

**НУХМАШ** purée

**НУХУУР 1.** paddle, pestle, stick for stirring or mixing **2.** mortar

**НУХЧИХ** (нухчин дарах) to crush, to squash, to suppress, to stamp out

**НҮГҮҮРС** (see Нөргөс)

**НҮГЭЛ** (~ хилэнц) sin, crime, **нүглээ наманчлах** (~ хилэнцээ наманчлах) to confess one's sins, **нүглийн нүдийг гурилаар хуурах** to scamp, to make a show of doing, to do a slapdash job, ~ **нүдээ олох** (~ **нүдээр нь гардаг**) to be hoist with one's own petard, ~ **чивэлийн** wicked, sinful

**НҮГЭЛТ** sinful, wicked

**НҮГЭЛТЭЙ 1.** (see нүгэлт) **2.** terrifically, like nobody's business

**НҮД 1.** eye, **нийлмэл** ~ compound eye (insect), **энгийн** ~ simple eye, ocellus (insect); the naked eye, **энгийн нүдэнд үл үзэгдэгч** invisible to the naked eye, **энгийн нүдээр** with the naked eye, to the naked eye, ~ **алдам** broad, extensive, hard to take in, ~ **алдах** to be dazzled, ~ **алдрах** to tire one's eyes, **нүдний алим** eyeball, ~ **анх** to close the eyes; to die, **нүдний аяга** eye socket, **нүдэн багцаагаар** at a visual estimate, ~ **балай чих дүлий** turning a blind eye, ignoring, ~ **булаах** to be ravishing, to be delightful, **нүдний булай** (нүдний булай шүдний чигчлүүр) a disgrace, object of scorn, **нүднээс гал бутрах** to see stars, **нүднээс гарах** to look haggard, to look gaunt, to look drawn, **нүдний гэм** extremely rare, ~ **гялбам** dazzling, ~ **гялбам цэвэр** squeaky clean, ~ **далд** behind (someone's) back, on the sly, **нүдний даралт ихдэх** glaucoma, **нүдэнд дулаан** (нүдэнд бүлээн) attractive, likeable, ~ **дүүрэн** pleasant, pleasing, attractive, ~ **муутай** unobservant, ~ **нүүргүй** (~ **чихгүй**) blinding, ~ **нүүргүй шуурга** a blinding storm, **нүдээ олох** to turn out right, to fit the case, ~ **нь орой дээрээ гарах** to be scared stiff, to be amazed, ~ **орох** to be able to see, to get one's sight back, **нүдэнд орсон хог шүдэнд хавчуулсан мах** a pain in the neck, **нүдээ өгөх шахах** to give the earth (for something), ~ **сохлом** blinding, ~ **судлалын ухаан** ophthalmology, ~ **сэргэх** to beam, ~ **тавих** to pay attention, to keep one's eyes open, ~ **тайлаагүй** green, wet behind the ears, ~ **тайлах** to gain experience, ~ **тайлсан** experienced, **нүдэнд торох** to catch the eye, ~ **улаан мөнгө цагаан** with an eye to the main chance, greedy, grasping, ~ **унам** eye-catching, attractive, ~ **урвуулан** in the twinkling of an eye, **нүдний ус** aqueous humour, ~ **үзүүрлэх** (see үзүүрлэх), **нүдний үзүүрт тусах** to catch the eye, **нүдээр үзэх** to see with one's own eyes, ~ **халтирам** (~ **хальтирмаар**) unsightly, off-putting, ~ **хальтрах** to be unable to look at, to be unable to face, ~ **харнуулах** to keep an eye on, **нүдний хор гаргах** to have a nap, to doze off, **нүдний хор орох** to be a sight for sore eyes, ~ **хорсох** to detest, ~ **хужирлах** (see хужирлах), ~ **хуурах** to bamboozle, **нүднээ хүйтэн** offensive, an eyesore, ~ **цавчих** to blink, ~ **цавчихын зуур** in the twinkling of an eye, **нүдний цагаанаар үзэх** to ignore, to look down on, **нүдээ цагаанаар эргэлдүүлэх** to roll the eyes wildly, **нүдний шил** glasses, spectacles, **нүдний шилчин** optician, **нүдний эмч** ophthalmologist, § **ийм явдалд** ~ **балай чих дүлий сууж болох уу** can we just turn a

blind eye to such a state of affairs? **2.** eye (of a potato) **3.** compartment, slot, box, square (of a map-grid, etc.), **торны дөрвөлжин** ~ grid square, **ханын** ~ (see хана), **хүснэгтийн** ~ box in a table, **ширээний** ~ table drawer, **шүүгээгийн** ~ cupboard drawer **4.** spot, speckle, **шоогийн** ~ spot on dice

**НҮДГҮЙ** **1.** eyeless, blind **2.** unobservant **3.** blinding, ~ **харанхуй** pitch-dark, ~ **шуурга** blinding storm

**НҮДЛҮҮР** eyepiece (optical instrument)

**НҮДЛЭЛТ** sprouting

**НҮДЛЭХ I.** to recognise, to make out, to notice, **нүдлэн хамгаалах** to keep an eye on

**НҮДЛЭХ II.** to show, to be just coming up (plants), to sprout, **усан** ~ to be near to weeping, to have tears in one's eyes

**НҮДГЭЙ** **1.** with eyes **2.** with an eye for, observant, **малд** ~ with an eye for beasts **3.** useful

**НҮДҮҮР** pestle

**НҮДЭВЧ I.1.** mask **2.** peep-hole, slit

**НҮДЭВЧ II.** round punch for decorating metal

**НҮДЭЛЖ** Pondweed, *Potamogeton* (also **Усан Хөрш**), **Саман** ~ Fennel Pondweed, *P. pectinatus*, **Нүдэлжийн овог** Pondweed Family, Potamogetonaceae

**НҮДЭНЦЭР** **1.** eye-spot, stigma (in algae) **2.** ocellus (in an insect)

**НҮДЭХ** to pound, **нүдэж нунтаг болгох** (нүдэж нунтаглах) to pulverize

**НҮЖИГНЭХ** to rumble

**НҮЖИГНЭЭН** rumble, rumbling

**НҮНЖИГ** fat, fatty part (*Tib. snum*)

**НҮНЖИГГҮЙ** **1.** lean, un nourishing **2.** ignoble, disgraceful, unworthy

**НҮНЖИГТЭЙ** **1.** fatty, nourishing **2.** decent

**НҮРГЭЛЭХ** to rumble

**НҮРГЭС** (see **Нөргөс**)

**НҮРГЭХ** to rumble

**НҮРГЭЭ** noise, din

**НҮРГЭЭН** (see **нүргээ**)

**НҮРГЭЭНТ** **1.** noisy, resounding **2.** sensational, exciting

**НҮРГЭЭНТЭЙ** (see **нүргээнт**)

**НҮР ХИЙХ** (see **нүргэх**)

**НҮРШ** rubbish

**НҮСЭР** **1.** heavy, hard, cumbersome, massive, ~ **ажил** (~ **хөдөлмөр**) heavy work, ~ **том** massive **2.** many, numerous

**НҮСЭРДЭХ** to be unwieldy, to be cumbersome, to be too massive

**НҮҮГЭЛТЭХ** to come up in a mass, to surge up, to be massed

**НҮҮДЛИЙН** nomadic, itinerant, migratory, mobile, ~ **байдал** nomadic condition, nomadic state, ~ **кино** travelling cinema, ~ **мал аж ахуй** nomadic pastoralism, ~ **соёл иргэншил** nomadic civilization, ~ **соёлтон** people of nomadic culture, ~ **цахилгаан станц** mobile generator, ~ **шувуу** migratory bird

**НҮҮДЭЛ** **1.** move, moving, movement, **их** ~ (ард түмний их ~) *Völkerwanderung*, mass migration, ~ **суудал** (~ **зөөдөл**) migration **2.** move (chess)

**НҮҮДЭЛЛЭЛТ** nomadization, movement, migration

**НҮҮДЭЛЛЭХ** to nomadize, to move, to migrate **нүүдэллэн ажиллах** to do itinerant work

**НҮҮДЭЛЛЭХҮЙ** nomadization

**НҮҮДЭЛЧ** **1.** nomad **2.** nomadic

**НҮҮДЭЛЧИН** nomad

**НҮҮЛ** **1.** thick fallen tree **2.** big campfire

**НҮҮЛГЭХ** **1.** to move, to shift, **гэрээ** ~ to move one's tent, **нүүлгэн зайлуулах** to evacuate (people), **нүүлгэн шилжүүлэх** to transfer, to move **2.** to help (someone) to move **3.** to throw, to hurl, **чулуу** ~ to throw stones, **чулуугаар** ~ to stone, to pelt with stones

**НҮҮЛГ** movement, shifting, **элсний** ~ movement of sands

**НҮҮР** **1.** face (*anat.*), ~ **баатар** (~ **бардам**) unabashed, unashamed, ~ **буруулах** to turn one's eyes away, to turn one's back, **нүүрийн буянтай** of good repute, **нүүрэндээ галтай нүдэндээ догтой** splendid, glorious (*liter.*), ~ **дүүрэн инээмсэглэх** to smile all over one's face, **нүүрний засал гоёл** cosmetics, make-up, ~ **золгох** (~ **учрах**) to meet personally, to meet face to face, ~ **нүдгүй** blinding, blindly, ~ **нүдгүй ташуурдах** to whip savagely, ~ **нүдгүй уруудах** to stampede blindly, ~ **нүдгүй цасан шуурга** a blinding snowstorm, **нүүрэнд нь үс ургасан золиг** reprobate (*n.*), ~ **өгөх** (~ **шагнах**) to show favour to, to treat politely, ~ **тал засах** to act ingratiatingly, to make up to, ~ **тал олох** (~ **олох**) to find favour with, ~ **тал харах** to pull strings, **нүүрэн тал** front, front side, ~ **талтай** well in with, in favour with, ~ **тулах** to encounter, to come face to face with, ~ **түлэх** (~ **халаах**) to confuse, to embarrass, ~ **улайх** to blush, ~ **үзэх** to spend, to pass, to live through (a year, a sixty-year cycle, etc.), ~ **хагарах** to come out of one's shell, to break the ice, ~ **халах** (~ **шарах**) to be ashamed, ~

халуун (хүний ~ халуун) embarrassed, ~ хийх газаргүй болох to be very embarrassed, not to know where to hide one's face, ~ цайрах to turn pale, ~ царай face, appearance, § манай орны аж үйлдвэр үүсэж хөгжөөд нэгэн жарны ~ үзэж байна our country's industry has been flourishing for sixty years, уулзалгүй бараг дөрвөн жилийн ~ үзлээ almost four years went by without my seeing him, хоёр дахь жилийнхээ ~ үзэж байна it is facing its second year **2.** "face", dignity, reputation, ~ алдах (нүүрээ барах) to lose one's reputation, ~ тахлах to save one's face **3.** face (clock, watch, etc.), орны нүүр face-board of a Mongol bed **4.i.** title-page **ii.** outer front side of a case for a book (xyl.) **5.** page, side (newspaper, etc.)

**НҮҮРГҮЙ 1.** brazen **2.** without the face to, ~ болох to lose face, § хүний өөдөөс харах ~ unable to look people directly in the face

**НҮҮРДЭХ** to meet face to face, to confront

**НҮҮРЛҮҮР** interface

**НҮҮРЛЭХ 1.** to face, to confront **2.** to add a heading, to summarize an official document on its cover (*hist.*) **3.** to title, to address

**НҮҮРС 1.** (чулуун ~) coal, хүрэн ~ brown coal, lignite, ~ төрөгч (see нүүрстөрөгч), ~ ус carbohydrate, ~ устөрөгч hydrocarbon, нүүрсний уурхай coal-mine **2.** (модны ~, ~ мод) charcoal

**НҮҮРСЖИЛТ** charring

**НҮҮРСЖИХ** to be charred, to be carbonized

**НҮҮРСЖҮҮЛЭХ** to char, to carbonize

**НҮҮРСЛҮҮР** carburettor

**НҮҮРСТӨРӨГЧ** carbon, нүүрстөрөгчийн давхар исэл carbon dioxide, нүүрстөрөгчийн исэл (нүүрстөрөгчийн дутуу исэл) carbon monoxide

**НҮҮРСХҮЧИЛ** carbonic acid, нүүрсхүчлийн хий carbonic acid gas, carbon dioxide

**НҮҮРСЧИН 1.** coalman **2.** "coalman" (Mongolian professional thief preying on Mongolian travellers arriving in Moscow and elsewhere by rail)

**НҮҮРТЭЙ 1.** with a face, with a front, шилэн ~ glass-fronted **2.** (~ талтай) well-favoured, in favour **3.** indicated as (in divination), элдэв үйлс сэтгэлчлэн бүтэх ~ actions in general tending to turn out as wished

**НҮҮРЧЛЭХ** to be partial, to show favouritism

**НҮҮРЭВЧ** mask, face-guard, curtain

**НҮҮРЭЛДҮҮЛЭХ** to confront (*trans.*)

**НҮҮРЭЛДЭХ** to face each other, to confront each other

**НҮҮРЭМГИЙ** bold, brazen, saucy, pert

**НҮҮХ 1.** to move, to shift pastures, to migrate, нүүхээс өмнө буух газраа бод look before you leap, нүүн шилжих to be evacuated **2.** to move (chess, etc.) **3.** to run (ink, colour) **4.** to drift (sand)

**НҮХ 1.** (~ сүв) hole, opening, нүхэн гэр pit-dwelling, нүхэн зам tunnel, нүхэн зуух pit-kiln **2.** (~ оромж) hole, lair (of an animal, etc.), нүхээ алдсан оготно шиг like a lost sheep, нүхэн гэр hide-out **3.** (шооны ~) spot on dice, ~ шахах to match the pips (in playing dominoes)

**НҮХЛЭХ** (нүхлэн цоолох) to pierce, to make holes in

**НҮХТЭХ** to be holed, to have holes

**НҮХЭРХЭГ** pierced, perforated, porous

**НҮЦГЭЛЭХ** (нүцгэлж шалдлах) to strip, to strip naked, to bare, хөл ~ to go barefoot

**НҮЦГЭН** naked, bare, glabrous, толгой ~ bare-headed, хөл ~ barefoot, ~ үрт ургамал (~ үртэн) gymnosperms, ~ үртний хүрээ Gymnospermatophyta, ~ чавган (~ шалдан) naked

**НҮЦГЭН САЛС** Slug (*zool.*)

**НҮЦГЭН ХОВОЛ 1.** Tree of Heaven, *Ailanthus altissima* **2.** Ash-tree

**НҮЦГЭРЭХ** to become bare, to be exposed, to be denuded, to strip off, to become glabrous, нүцгэрч халцрах to be rubbed bare (grass)

**НҮЦЭГЛЭХ** (see нүцгэлэх)

**НЬ** (a possessive form of an obsolete third person pronoun) **1.** (acts as a subject indicator), § хэн дийлсэн ~ whichever is victorious, яваа ~ үзэгдэнэ he could be seen going along **2.** (completes a verb form), § та одоо хаачих ~ вэ where are you going now?, энэ хөөрхий болжморууд хөлдөж үхэх ~ ээ these poor little sparrows are going to freeze to death **3.** (indicates a possessive connection), § лам хар ~ үл мэдэгдэх хувцастай нэг хүн a man so dressed that one could not tell if he was a lama or a layman, маргааш ~ the next day, the day after that, өөрийнх ~ хэлээр in their own language, та нарт бүгдэд ~ эс боловч хоёрт ~ зөвшөөрөл олгох байх they may give permission to two of you if not to all of you, хооронд ~ арван метр зайтай модон шон wooden posts ten metres apart from each other

**НЭВСГЭНЭХ** to flutter, to flap about

**НЭВСГЭР 1.** shaggy, tousled, tattered, ragged **2.** thick, fluffy (snow)

**НЭВСИЙХ 1.** (нэвсийж хөвсийх) to be baggy

(clothes) **2.** to be ragged, to be dishevelled, to be untidy, to be all over the place, to be messy, **нэвсийн буух** to fall thickly (snowflakes)

**НЭВСРЭХ 1.** to look ragged, to lie about, § **нэвсэрсэн хар үүл** ragged black clouds **2.** to overdo it, **нэвсэртэл зодох** to give a real good hiding

**НЭВСЭЛЗЭХ** to lumber along

**НЭВТ** (~ **шувт**) through, right through, ~ **гэрэлтэх** to be translucent, ~ **норчихсон** wet through, ~ **хатгах** to pierce, to go right through, to stick through

**НЭВТГЭЛЗЭХ** to stitch together (from each side in turn)

**НЭВТЛЭХ** to penetrate, ~ **чадал** penetrating power

**НЭВТРҮҮЛЭГ** broadcast, programme, радио ~ radio programme, **телевизийн** ~ television programme

**НЭВТРҮҮЛЭГЧ** broadcaster

**НЭВТРҮҮЛЭЛТ** penetration

**НЭВТРҮҮЛЭХ 1.** to put into, to get into, to introduce, **практикт** ~ to put into practice, **үйлэ-вэрлэлд** ~ to put into production **2.** to broadcast, to transmit **3.** to send in, to allow to go through, to let pass, **ус нэвтрүүлэхгүй** waterproof

**НЭВТРЭЛТ** penetration

**НЭВТРЭЛЦЭХ** to communicate, to get through

**НЭВТРЭХ 1.** to penetrate, **сум нэвтрэхгүй** bullet-proof, **ус үл нэвтрэгч** waterproof **2.** to cross, **замыг нэвтрэн гарах** to cross the road, **хил** ~ to cross a frontier, ~ **бичиг** pass

**НЭВТЭРДЭГ** permeable

**НЭВТЭРХИЙ** thorough, deep, penetrating, ~ **толь бичиг** encyclopaedia

**НЭВТЭРШГҮЙ** impenetrable

**НЭВЧДЭС** invasion, infiltration, ~ **хэлбэрийн** invasive

**НЭВЧИЛТ** infiltration, percolation, intrusion, impregnation

**НЭВЧИМТГИЙ** permeable

**НЭВЧИМХИЙ** (see **нэвчимтгий**)

**НЭВЧИС** (see **нэвчдэс**)

**НЭВЧИХ** to seep, to percolate, to come through, to diffuse, to extravasate, to permeate, **цус нэвчсэн** bloodshot

**НЭВЧМЭЛ** infiltrating

**НЭВШИРТЭЛ** excessively, overdoing it, thoroughly, ~ **занчих** to give a real good hiding

**НЭВШРЭХ** to overdo it

**НЭГ 1.** one, **мэргэжил нэгт нөхөд** fellow specialists, **санал нэгтнүүд** like-minded persons,

**ӨГӨХ 1.** to give, **өгье гэвэл ганцаас** be generous in your giving **2.** (auxiliary verb showing that the action of the main verb is performed to the advantage of someone other than the subject), **§ замы нь зааж өгөөд явуулжээ** showed him the way and sent him off **3.** (auxiliary verb emphasizing the completion of an action or the failure to complete it), **§ түлхүүр нь олдож өгөхгүй байв** the key could just not be found, **чив чимээгүй яваад өгчээ** went off without a word

**ӨГРӨХ** to be weathered, to perish, to dry up

**ӨГСӨЛТ** (газрын ~) rise, ascent, up-gradient

**ӨГСӨӨХ** to move up

**ӨГСӨХ** to go up, to go uphill, **шатаар ~** to go upstairs, **§ уулыг өгсөн гарч** going up the mountain

**ӨГСҮҮ** going up, rising, upward

**ӨГСҮҮЛЭХ** to move up

**ӨГСҮҮЛЭЭД** from, starting from, **§ эмгэд хөгшдөөс ~ охид багачууд хүртэл** from aged women down to young girls

**ӨГСҮҮР** rising, sloping upwards, uphill

**ӨГҮҮЛБЭР** sentence (gram., mus.), **асуух ~** interrogative sentence, **бодлогын ~** statement of a problem (math.), **гишгүүн ~** subordinate clause, **дуудах ~** exclamatory sentence, **захирах ~** imperative sentence, **нийлмэл ~** complex sentence, compound sentence, **үгүйсгэх ~** negative sentence, **хүүрнэх ~** statement, **энгийн ~** simple sentence, **өгүүлбэрийн гишгүүн clause, ~ зүй** (see **өгүүлбэрзүй**)

**ӨГҮҮЛБЭРЗҮЙ** syntax

**ӨГҮҮЛЛЭГ** story, tale, short story (Russ. рассказ)

**ӨГҮҮЛШГҮЙ** unspeakable

**ӨГҮҮЛЭГДЭХҮҮН** subject (gram.)

**ӨГҮҮЛЭГЧ** speaker, narrator

**ӨГҮҮЛЭЛ** article (in a magazine, etc.), **тэргүүн ~** leading article

**ӨГҮҮЛЭМЖ** subject (liter., mus.)

**ӨГҮҮЛЭХ I.** to say, to state, to recount, to tell, to express, to speak, **дээр өгүүлсэн** the above-mentioned, the aforesaid, **дээр өгүүлсэнчлэн** (дээр өгүүлснээр) as stated above, as mentioned above, **~ нь** the story goes

**ӨГҮҮЛЭХ II.** to get given

**ӨГҮҮЛЭХҮҮН** predicate (gram.)

**ӨГЦӨӨ** debt

**ӨГЦӨӨТ** indebted

**ӨГЧИЛГӨХ** to send by someone else

**ӨД** feather, **сумны ~** fletching (of an arrow), **өдөт бөмбөг** badminton, **өдөн жинтүү** feather pillow, **өдөн маягийн** pinnate (leaf), **~ сөд** feathers

**ӨДГӨӨ** now

**ӨДГӨӨГИЙН** present, present-day (adj.)

**ӨДГӨӨЧЛӨХ 1.** to update **2.** to see the past in modern terms

**ӨДИЙ I.** not yet

**ӨДИЙ II.** so much, this much, so many, **~ болтол (~ хүртэл)** up to now, to date, **~ зэрэгтэй** to this degree, **~ төдий** quite a number of, quite a lot of, any number of, any amount of, **~ хирийн** this much, **§ ноднингийн ~ үе** this time last year, **эмчээр ажилласаар ~ хүрчээ** he has gone on working as a doctor up to now

**ӨДИЙД** now, at this time, **ноднингийн ~** (өнгөрсөн жилийн ~) this time last year

**ӨДЛӨГ I.1.** feathery **2.** pinnate (leaf), **өрөөсгөл ~ (хос бус ~)** imparipinnate, **салаавчилсан ~** interruptedly pinnate, **хос ~** paripinnate, **хошоод ~** bipinnate, **~ салбант** pinnately lobed **3.** pennate (diatom) (see **замаг**)

**ӨДЛӨГ II.** provocation

**ӨДЛӨСӨН** pinnate (leaf)

**ӨДЛӨХ 1.** to fletch (an arrow) **2.** to grow feathers **3.** to be pinnate (leaf), **өдлөн хуваагдсан** (өдлөн цуурсан) pinnately lobed

**ӨД МӨДЦӨӨ** soon

**ӨДӨЛТ** provocation

**ӨДӨӨХ** to instigate, to provoke, to excite, **өдөөн түлхэх** to incite, **гэмт хэрэг үйлдэхэд өдөөн түлхэх** to incite to commit a crime, **өдөөн хатгагч** (өдөөн турхирагч) trouble-maker, **өдөөн хатгалга** provocation, **өдөөн хатгасан явууллага** provocative acts, **өдөөн хатгах** to stir up trouble, to make a provocation

**ӨДӨР I.** day, **хорин тавны ~** on the twenty-fifth, **~ барах** to let time go by, to waste time, **~ бүр** every day, daily (adv.), **~ бүрийн (~ дутмын)** daily (adj.), **~ дундын** midday (adj.), **өдрөө олох** to select a lucky day, **~ өдөрт** (өдрөөс өдөрт) from day to day, **~ өнжилгүй** day after day, **~ өнжих сувилал** day-care, **~ өнжөөд** every other day, **~ өнжүүлэх бүлэг** full-day care group (at school), **өдрийн сайныг харах** (~ үзэх, ~ судар үзэх) to examine as to which are favourable or unfavourable days (for undertaking something), **~ судар** almanac, **~ тутам** every day, daily (adv.), **~ тутмын** every day, daily (adj.), **~ тутмын амьдрал** (~ тутмын ахуй амьдрал) daily life, **~ тутмын сонин** daily

paper, ~ хоног days, ~ хоногоор day by day, ~ хоног ирэх тутам from day to day, from one day to another, өдрөө хүлээх to be at death's door, ~ цаггүй at any time, all the time, ~ шөнөгүй day and night, ~ шөнийн тэнцэл equinox, ~ шөнө шиг ялгаатай as different as chalk and cheese **2.** during the day, by day

**ӨДӨРЖИЙН** a day's, нэг ~ газар a place a day's journey away, ~ зайтай (~ гэртээд) a day's journey away

**ӨДӨРЖИН** all day, ~ шөнөжин day and night, round the clock

**ӨДӨРЖИНГӨӨ** (see өдөржин)

**ӨДӨРЛӨГ** a day's meeting, a day session, a day of, эмнэлэг гэгээрлийн ~ day of medical education

**ӨДӨРЛӨХ** to date (a letter, etc.), § очигдрийн өдрөөр ~ to date with yesterday's date

**ӨДӨРТ** per day, a day, during the day, ~ нь that very day

**ӨДӨРТӨӨ** during the day, within the day

**ӨДӨРЧИЙН** (see өдөржийн)

**ӨДӨРЧИЛСӨН** daily, day to day

**ӨДӨХ 1.** to start, to begin, яриа ~ to start a conversation **2.** to stimulate, to provoke, to stir up өдөж сэдэх to stimulate

**ӨДРИЙН 1.** day-time, өдрийн арван хоёр цагт at noon, өдрийн бодол шөнийн зүүд болох to be constantly on one's mind, өдрийн од адил (өдрийн од шиг ховор) very rare, few and far between, ~ хоол midday meal **2.** daily **3.** today's

**ӨДТЭЙ** feathered, ~ бичиг urgent letter (hist.)

**ӨДҮҮЛЭХ** to commit (a crime), to wage (war), гэмт хэрэг ~ to commit a crime, дайн байлдаан ~ to wage war

**ӨЕГ 1.** filling, satisfying, nutritious **2.** well-fed, satisfied, ~ тавтай (~ хангалуун, ~ цаггалан) satisfied, ~ тарган fat **3.** honest, generous, decent

**ӨЕГШИХ 1.** to be nourishing, to be nutritious **2.** to be satisfied, сэтгэл ~ to feel satisfied

**ӨЕӨ** tilted, inclined, sloping away

**ӨЕӨДӨХ** to founder, to fall with exhaustion and be unable to get up (livestock)

**ӨЕӨСӨХ** (see өөдөх)

**ӨЕХ 1.** the part of an animal below the breast-bone **2.** a strip of skin from an animal, taken from the pubis to the chin

**ӨЕХИЙ** (see өөх)

**ӨЖИМХИЙ** rotting, putrid

**ӨЖИХ 1.** to rot, to go bad

**ӨЖИХ II.** to be obstinate, to be stubborn, to be wilful

**ӨЖҮҮН** obstinate, stubborn

**ӨЛ I.** grey, ~ халзан with a white patch (horse's face, felled area, etc.)

**ӨЛ II.** (~ хоол) food, nourishment, ~ алдах to hunger, to starve, ~ даах (~ хоол даах) to fast, to go without food, ~ дарах (~ залгах) to stave off hunger, ~ сайтай (~ шимтэй, ~ шим сайтай) nutritious, ~ хоолгүйдэх to lack food

**ӨЛ III.** (~ хөтөл) low pass (geog.)

**ӨЛБӨГӨР** (see үлбэгэр)

**ӨЛБӨЛЗӨХ 1.** to crane the neck **2.** to hunt for food

**ӨЛБӨН** (see үлбэн)

**ӨЛБӨРӨХ** to starve (intrans.), өлбөрч үхэх to starve to death

**ӨЛБӨРҮҮЛЭХ** to starve (trans.)

**ӨЛГИЙ 1.** cradle, wrapping for a new-born child, өлгийн дуу lullaby **2.** cradle, birthplace, ~ нутаг birthplace, native place, хувьсгалын ~ нутаг the birthplace of the revolution **3.** ingot, алтан ~ gold ingot

**ӨЛГИЙДӨХ** to wrap up (a new-born infant), to put in a cradle, to cradle

**ӨЛГӨӨСТЭЙ** hanging, hung up, suspended

**ӨЛГӨӨТЭЙ** (see өлгөөстэй)

**ӨЛГӨР** erect, sticking up (head, etc.)

**ӨЛГӨР ЗАГАС** name of a fish of the Cyprinidae family

**ӨЛГӨХ 1.** (өлгөн дүүжлэх) to hang up, to suspend **2.** (өлгөн авах) to pick up, to take up (a point)

**ӨЛГӨЦ** comment, rejoinder

**ӨЛГҮҮР 1.** (~ ээмэг) a hanging ornament forming part of a woman's traditional headdress **2.** stand (for a kumis-bag, for drying hay, etc.) **3.** (хувцасны ~) clothes-hanger, peg **4.** rack **5.** cloakroom

**ӨЛДӨХ I.** to be too loose, to be too slack

**ӨЛДӨХ II.** to starve, to be starving, to go hungry, өлдөн үхэх to starve to death

**ӨЛЗИЙ 1.** (~ хутаг) good fortune, blessings, well-being, ~ бус (~ муутай) unlucky, unfortunate, inauspicious, ~ буян дэлгэртүгэй may your fortune ever flourish, ~ утас (~ хээ) the endless knot (pattern denoting good fortune) **2.** name of a game of chequers

**ӨЛЗИЙЛӨХ** to be free from harm

**ӨЛЗИЙТ** (see **өлзийтэй**), ~ **өвчин** syphilis

**ӨЛЗИЙТЭЙ** 1. happy, fortunate, lucky, **чоно нохой** ~ unthreatened by wolves 2. auspicious 3. beneficial, good for, **өвчин бүхэнд** ~ good for all illnesses

**ӨЛЗИЙХҮҮ** scarecrow (esp. against wolves)

**ӨЛИЙЛГӨХ** to stick up and back, to cock (the head, etc.), **толгой** ~ to cock the head, to crane the neck

**ӨЛИЙХ** to lean back and crane the neck, **өлийн харах** to lean back and look up

**ӨЛЛӨХ** to take a little food

**ӨЛМИЙ** 1. foot (resp.), ~ **бататгах** to pray for the long life (of a high lama, emperor, etc.), **өлмийн линхуа** "lotus-feet" (resp. for a high lama, emperor, etc.), **өлмийн линхуа батад орших** to enjoy long life 2. (хөлийн ~) ball of the foot, ~ **дээр зогсох** to stand on the toes 3. foot (of verse), **бүжил** ~ trochee, **дэвхцмэл** ~ iamb, **тонгорол** ~ anapaest, **хосмолжин** ~ amphibrach, **хуруун** ~ dactyl 4. sole

**ӨЛМИЙДЭХ** to stand on the toes

**ӨЛМӨН ЗЭЛМЭН** (see **өлмүү зэлмүү**)

**ӨЛМҮҮ ЗЭЛМҮҮ** meagre, scanty, barely sufficient, § ~ **хоолтой явах** to have barely enough to keep body and soul together

**ӨЛМҮҮР ЗЭЛМҮҮРХЭН АМБДРАХ** to live from hand to mouth

**ӨЛӨВ ДОЛОВ ХИЙХ** to tighten one's belt

**ӨЛӨВС** Galingale, *Cyperus*, **Хүрэн** ~ Brown Galingale, *C. fuscus* (also **Сахал өвс**)

**ӨЛӨГ** I. thing, material

**ӨЛӨГ** II. chronic, wasting, ~ **хуучтай** chronically ill

**ӨЛӨГЧИН** female (dog, wolf, etc.), bitch, ~ **чоно** wolf-bitch

**ӨЛӨЛЗӨХ** to crane the neck

**ӨЛӨН** I. 1. fasting, without having taken food, with an empty belly, hungry, ~ **зөмөг амьдрах** to exist at starvation level, ~ **зэлмүүн** (~ **зэлмүүр**, ~ **зэлмэн**) hungry, ~ **зэлмүүр байдал** hunger, starvation, ~ **зэлмүүрчүүд** starvelings, ~ **нүдтэй** greedy eyed, ~ **саарал** hungry wolf; name for the Chinese troops in Urga after Autonomy, ~ **хоосон** hungry, ~ **элгэн дээрээ** on an empty stomach 2. intestines, ~ **гэдэс** (see **гэдэс**), **өлөнгийн завод** offal factory 3. jejunum 4. (~ **нарийн**) thin, fine, ~ **тоос** (~ **шороо**) fine dust, ~ **хир** dust, dirt, ~ **чийтэй** damp, moist

**ӨЛӨН** II. Sedge, *Carex* (see **Улаалж**), **Зогдор** ~ *C. pediformis*, **Өлөнгийн овог** Sedge

Family, Cyperaceae

**ӨЛӨНГӨ** Couch *Clinelymus* (*Elymus*), **Дагуур** ~ *C. dahuricus*, **Сибирь** ~ *C. sibiricus*

**ӨЛӨНЦӨР** Wood-rush, *Luzula*

**ӨЛӨРХӨХ** to be hungry, to be in want of food

**ӨЛӨРХҮҮ** hungry

**ӨЛӨХ** to raise, to push up

**ӨЛСГӨЛӨН** I. i. hunger, **өлсгөлөнгийн байдал** starvation, ~ **гачаал** (~ **ховор**) famine ii. hunger-strike, ~ **зарлагч** hunger-striker, ~ **зарлах** to go on hunger-strike 2. hungry, ~ **байх** to go without food, ~ **нүд** hungry eyes

**ӨЛСГӨХ** to starve (*trans.*)

**ӨЛСӨЛТ** hunger, lack of food

**ӨЛСӨХ** 1. to be hungry 2. to shrivel (vegetables, etc.)

**ӨЛТӨГ** (see **өртөг**)

**ӨЛҮҮР** lever, pole

**ӨЛХӨН** easily, with room to spare, without turning a hair

**ӨЛЧИР** able to stand the cold, resistant to cold, not afraid of the cold, ~ **чийрэг** tough, impervious to cold

**ӨЛЧИРЖИХ** to get hardened against the cold (livestock, etc.)

**ӨЛЧИРЖҮҮЛЭХ** to harden (livestock, etc.) against the cold

**ӨЛЧИРЛӨХ** to defy the cold, not to feel the cold

**ӨМ** down, off, to pieces, ~ **цөм нурах** to fall to pieces, to collapse in ruins

**ӨМБӨЛ** (**өвсөн** ~) grass hut (*hist.*)

**ӨМБӨРӨХ** to roll

**ӨМБҮҮ** 1. moo 2. moo-cow

**ӨМГӨНӨХ** to be pursed (lips)

**ӨМГӨНҮҮЛЭХ** to purse, **амаа** ~ to purse the lips

**ӨМГӨӨЛӨГЧ** advocate, counsel, lawyer

**ӨМГӨӨЛӨЛ** defence, protection

**ӨМГӨӨЛӨХ** (**өмгөөлөн хамгаалах**) to protect, to defend, to stand up for, ~ **байгууллага** the Body of Advocates (est. 1928), ~ **коллеги** the Board of Advocates (est. 1944)

**ӨМГӨР** tiny, narrow-mouthed

**ӨМД** (~ **хамд**) trousers, **өмдгүй байж өвдөг цоорхойг шоолох** the pot calling the kettle black

**ӨМИЙХ** to shrink, to get smaller

**ӨМЛӨХ** to chip (*trans.*)

**ӨМНӨ** 1. south, southern, ~ **зүг** the south, ~ **тал** the south side 2. in front of, ~ **нь** in front of it 3. before, above, ago, **юунаас** ~ above all, §

галт тэрэг явахаас хагас цагийн ~ half an hour before the train goes, **есөн жилийн ~ юмсан** it was nine years ago, **нар мандахаас ~** before sunrise, **сар хагасын ~** a month and a half before, **одоогоос арван жилийн ~** ten years ago, **хугацаанаас нь нэг сарын ~** a month before the due date **4. өмнөө барих** to lead, to be first-rate

**ӨМНӨД 1.** south, southern **2.** front (*adj.*)

**ӨМНӨД МЭСӨН ТИВ** Antarctica

**ӨМНӨӨ** other, different, ~ **юм** something else

**ӨМНӨӨС 1.** towards, ~ **нь** towards him **2.** in the name of, on behalf of, § **Моголын бүх ард түмний ~** in the name of all the Mongolian masses

**ӨМНӨТ** (see **өмнөд**)

**ӨМНӨТГӨЛ** briefing

**ӨМНӨХ** before, previous, earlier, in front (*adj.*), **хувьсгалын ~** pre-revolutionary, ~ **үг** (~ үгүүлэл) preface, § **гучин жилийн ~** явдал events of thirty years ago, **1921 оны ~** Монгол Mongolia before 1921, **сургуулийн ~** ба сургуулийн насны хүүхэд children of pre-school and school age, ~ **тээврийн хэрэгсэл** the vehicle in front

**ӨМНӨХӨН** just before, § **одоогоос гурван хоногийн ~** just three days before this

**ӨМНҮҮР 1.** in front (of) **2.** to the south (of)

**ӨМӨГ** protection, ~ **түшиг** defender, defence, support, protector

**ӨМӨГШИХ** to protect, to defend

**ӨМӨЛЗӨХ** to be pursued (lips)

**ӨМӨЛЗҮҮЛЭХ** to purse (the lips), **уруул ~** to purse the lips

**ӨМӨН** (~ **үү**) cancer, **анхдагч ~** primary cancer, **нэгдүгээр үеийн ~** үү first stage cancer, **суурин эсэн ~** үү basal cell cancer, rodent ulcer, **уушигны ~** lung cancer, **хавтгай эсэн ~** үү squamous cell cancer, ~ **үүсгэгч** (~ **үүсгэх**) carcinogenic, ~ **үүсгэгч бодис** carcinogen

**ӨМӨНГӨР** carcinoma

**ӨМӨӨРӨГЧ** protector

**ӨМӨӨРӨХ** to protect, to shield, to defend, to intercede for

**ӨМӨР ӨМӨР** chomp-chomp (noise of eating, etc.), working (lips) § **уруулаа ~** хөдөлгөөд working his lips

**ӨМӨРХИЙ ӨМӨРХИЙ** holes, punctures, leaks

**ӨМРӨХ** (**өмрөн унах, өмөрч цөмрөх**) to fall off, to crumble away

**ӨМСГӨЛ** (~ **зүүсгэл**) dress, costume, **ажлын ~** working clothes, **хурмын ~** garments given to

a new bride by her parents to take to her new home

**ӨМСГӨХ** to make (someone) put (something) on, to make (someone) wear (something), to fit over, to put over

**ӨМСӨХ 1.** to put on, to wear, **өмсөж үзэх** to try on **2.** to throw over one's shoulder (wrestling)

**ӨМХ** rotten, decayed

**ӨМХИЙ** (~ **самхай, ~ хамхай**) stinking, ~ **үнэр** stink

**ӨМХИЙ ӨВС** *Peganum* (*bot.*), **Харлаг ~ P. nigellastrum**, **Эгэл ~ P. harmala**

**ӨМХИЙРӨХ 1.** to rot, to decay **2.** to stink

**ӨМХРӨХ** (**өмхөрч ялзрах**) to rot, to decay

**ӨМХРҮҮЛЭХ** to rot (*trans.*)

**ӨМХТЭЙ** rotting, decaying

**ӨМЧ** property, ownership, possession, **амины ~** personal property, ownership, **амины өмчид байлгах** to retain in personal ownership, **амины өмчид байгаа эд хөрөнгө** property in personal ownership, **ард нийтийн ~** public property, public ownership, **төрийн ~** (**улсын ~**) state property, state ownership, **хувийн ~** private property, private ownership, **өмчийг задлан хувьчлах** to privatize, ~ **мал** (**өмчийн мал**) personally owned livestock, one's own beasts, ~ **таслах** to hand over property (to one's children at marriage), ~ **хөрөнгө** property, **нийгмийн ~ хөрөнгө** social property, public property, **улсын ~ хөрөнгө** state property, ~ **хувьчлал** privatization, **өмчийн эсрэг гэмт хэргүүд** crimes against property

**ӨМЧИЙН** personal, private, own

**ӨМЧИРХӨГ** possessive

**ӨМЧИРХӨХ** to be acquisitive, to be grasping

**ӨМЧЛӨГЧ** owner

**ӨМЧЛӨЛ** ownership

**ӨМЧЛӨХ 1.** to take possession of, to take over, to inherit **2.** to own, to hold, **хамтран ~** to hold jointly, to be in joint possession of, ~ **эрх** title (*jur.*)

**ӨМЧТӨН** owner

**ӨН** (~ **тарган**) rich, plentiful, ~ **баян билдээр** rich pasture

**ӨНГИЙН** coloured

**ӨНГИЙХ 1.** to peer over, to lean over to look, **өнгийж авлах** to hunt game by shooting from above **2.** to encroach upon, to threaten

**ӨНГИЙЦ** (~ **газар**) hide (for shooting a marmot, etc.)



**ӨНГӨ 1.** (~ будар) colour, бүрдмэл ~ pure colour, завсрын ~ intermediate colour, зэвхий ~ greyed colour, нийлмэл ~ intermediate colour, үндсэн ~ primary colour, ~ зохицол (~ зохицуулга) colour coordination, ~ зохицуулах to coordinate colours, ~ зүс colour, coat-colour (horse, etc.), ~ зүс нийлсэн of matching colour (horses), ~ нь наанаа өргөс нь цаанаа a wolf in sheep's clothing, ~ ялгарах to bleed (resp.) **2. i.** surface өнгөн дээрээ on the surface, superficially, өнгөн тал face, surface, right side, өнгөн үе surface layer **ii.** facing (of a gown), ~ татах to line (a gown) **iii.** white wool laid out for making felt **3.** (~ зүс, ~ төрх) appearance, looks, ~ жавхаа (~ жалх, ~ үзэсгэлэн) splendour, good looks, ~ зүс алдах to get shabby, ~ орох (~ зүс орох) to improve in appearance, to look better, ~ оруулах to improve the appearance (of something), ~ үзэмж look, appearance, nice look, ~ үзэмжгүй unsightly, ~ үзэмжтэй (~ үзэмж сайтай) attractive, good-looking, nice to look at **4.** lust, passion, ~ дарс (~ мөнгө) women and wine, өнгөний өвчин venereal disease **5.** tone, accent, timbre, quality, ~ амьсгал atmosphere (fig.), ~ аяс mode, tone **6.** tone (mus.), бүтэн ~ whole tone, гол ~ tonic, keynote, хагас ~ semitone

**ӨНГӨВЧ** superficial

**ӨНГӨГҮЙ** not coloured, ~ ертөнц the world without forms (*Buddh.*)

**ӨНГӨЖИХ** to flourish, to blossom

**ӨНГӨЛГӨӨ 1.** covering, coating, facing **2.** smoothing, surfacing

**ӨНГӨЛГӨӨНИЙ** abrasive, ~ машин sander, polisher

**ӨНГӨЛГӨӨЧИН** grinder, polisher

**ӨНГӨЛЗЛӨГ** encroachment, aggression

**ӨНГӨЛЗЛӨГӨ** (see өнгөлзлөг)

**ӨНГӨЛЗӨХ 1.** to keep peering **2.** to covet, to look with envy at **3.** (өнгөлзөн халдах) to encroach upon

**ӨНГӨЛЗҮҮР** depression below the Adam's apple

**ӨНГӨЛӨГ** bright, brilliant, colourful, shiny, good-looking, ~ бие chromosome

**ӨНГӨЛӨГЧ I.** smoothing tool, ~ дугуй sanding disc

**ӨНГӨЛӨГЧ II.** colouring, colouring agent

**ӨНГӨЛӨХ 1.** to colour, to decorate, өнгөлж будах to paint **2.** to cover, to face, алтаар ~ to gild, зуурмагаар ~ to plaster **3.** to put a surface

on, to polish, to grind, to sand, зүлгүүр цаасаар ~ to rub down with sandpaper, зүлгэж ~ to rub down, to sand, ~ дугуй sanding wheel, polishing wheel, ~ оо grinding powder, polishing powder **4.** to disguise, to mask, to camouflage, өнгөлөн далдлалт camouflage, өнгөлөн далдлах to camouflage

**ӨНГӨЛҮҮР** polishing tool

**ӨНГӨР** film, skin, deposit, furring, scale, ~ хусам crust (on sides of a pot, etc.)

**ӨНГӨРЖҮҮЛЭХ** to coat

**ӨНГӨРЛӨГ** coated

**ӨНГӨРЛӨХ** to descale, to clean off

**ӨНГӨРӨГЧ** last, past, ~ жил (~ он) last year, ~ шөнө last night

**ӨНГӨРӨӨХ** (see өнгөрүүлэх)

**ӨНГӨРӨХ 1.** to pass, § ес өнгөрч байна it's past nine **2.** to go by, to pass off, § би өнгөрсөн хүн I've had it **3.** to die **4.** to be left, to be the end of it, § анхаарахгүй өнгөрч болохгүй билээ it cannot be left unnoticed, буудаад алдчихвал ~ нь тэр if you shoot and miss that's that, бүртгэлд ороогүй ~ to be left unrecorded, гэм зэмгүй ~ to get off scot-free, эмч бүр хожуу ирж хүү нэгэнт сэхэхээ өнгөрсөн байв the doctor was very late coming and the boy was already beyond recovery, энэ бол тэвчиж өнгөрөхөөс өөр аргагүй тасалдал юм this is a loss which just has to be put up with

**ӨНГӨРСӨН** last, past, өнгөрсөн борооны хойноос цув нөмрөх to be wise after the event, to shut the stable door after the horse is gone, ~ долоо хоног last week, ~ одоо ирээдүй the past, the present and the future

**ӨНГӨРТӨХ** to become coated, хэл ~ to get a furry tongue

**ӨНГӨРҮҮ** over, more than, дөч ~ насны past forty

**ӨНГӨРҮҮЛЭХ 1.** to pass, to let pass **2.** to spend (time), амралтаа ~ to spend one's holidays **3.** to let (something) go, § яахан сонсохгүй өнгөрүүлсэн байж билээ how could he have failed to hear?, ямар ч зэмлэл хүлээлгүй өнгөрүүлж байв let them off quite unpunished

**ӨНГӨТ** coloured, colourful, bright, ~ ертөнц the world of forms (*Buddh.*), ~ хальс colour film

**ӨНГӨТЭЙ I.** i. coloured **ii.** of a certain colour **2.** good-looking, nice, beautiful, ~ зүстэй pretty, attractive, good-looking, ~ өөдрөг (~ өөдтэй) smart, good-looking, flourishing **3.** tinged with, § басамжлах ~ асуулт a rather derisive question

**ӨНГӨЦ I.** superficial, near the surface, skin-deep, insincere, ~ амьсгал shallow breathing,

~ **харахад** at first sight, ~ **хуудам** false, insincere

**ӨНГӨЦ II.** (~ **дэвсгэр**) narrow mat, narrow cushion

**ӨНГӨЦХӨН** superficial, shallow, skin-deep, ~ **амьсгалах** to breathe shallowly, ~ **харахад** at a casual glance

**ӨНГӨЧ I.** smart, elegant **2.** fawning, unctuous

**ӨНГӨШИЛТ** colouring

**ӨНГҮЙ** hard, cruel (winter)

**ӨНДГӨВЧ** ovary

**ӨНДГӨНЦӨР** egg-shaped, ovate

**ӨНДГӨРХҮҮ** (~ **хэлбэртэй**) egg-shaped, ovate

**ӨНДИЙЛГӨХ** to raise, to lift up, to elevate

**ӨНДИЙЛМӨЛ** decumbent (stem) (*bot.*)

**ӨНДИЙСХИЙХ** to raise oneself up, to rise

**ӨНДИЙХ** to raise oneself up, to rise

**ӨНДӨГ** egg, ~ **булагч эрхтэн** (~ **шахагч**) ovipositor (*anat.*), ~ **гаргах** to lay eggs, ~ **дамжуулагч** (~ **дамжуулуур**) oviduct, **өндөг дарагч** incubator, ~ **даралт** hatching, ~ **дарах** to hatch; to brood, ~ **дарах хугацаа** brooding period, ~ **даруулах цех** hatchery, **өндгөн жаврай** omelette, **өндгөн сүй тавих** to betroth as yet unborn children, **өндөгний хальс** eggshell, ~ **хэлбэрийн** (~ **хэлбэртэй**) egg-shaped, ovate, **өндөгний шар** yolk, egg-yolk

**ӨНДӨГЛӨГЧ** laying hen, layer

**ӨНДӨГЛӨЛТ** laying (eggs)

**ӨНДӨГЛӨХ** to lay (eggs)

**ӨНДӨЛЗӨХ** to keep getting up and down, to be like a cat on hot bricks

**ӨНДӨЛЗҮҮЛЭХ** to disturb, to turn upside down

**ӨНДӨР I.** high, tall, ~ **биетэй** (~ **нуруутай**) tall, **өндрийн мах** camel flesh, ~ **нам** height, ~ **настан** old person, old people, ~ **настны тэтгэвэр** old age pension, retirement pension **2.** height, altitude, ~ **авах** to gain height (plane), ~ **алдах** to lose height (plane), **өндрийн бөөнүүл** altocumulus cloud, **өндрийн давхраат үүл** altostratus cloud, **өндрийн тоот** spot height (*cart.*), **өндрийн хэмжүүр** altimeter

**ӨНДӨР БОГД** the "Lofty Saint" (title of the first Jebtsundamba Khutuktu)

**ӨНДӨР ГЭГЭЭН** the "Lofty Brilliance" (title of the first Jebtsundamba Khutuktu)

**ӨНДӨРДӨХ** to be too high

**ӨНДӨРЖИЛТ** height, elevation

**ӨНДӨРЖИХ** to be heightened, to be raised, to be enhanced, to rise

**ӨНДӨРЖҮҮЛЭХ** to heighten, to raise, to enhance

**ӨНДӨРЛӨГ I.** high, tall **2.** a height, an eminence

**ӨНДӨРЛӨХ I.** to raise, to make higher **2.** to draw to a close (year, feast, etc.), **найр** ~ **ерөөл** the closing **ерөөл** at a wedding feast

**ӨНДӨРСГӨХ** to raise

**ӨНДӨРСӨХ** to rise, to become high, to get built up, to become elevated

**ӨНДӨРШИЛ** height, elevation

**ӨНДӨРШИЛТ** (see **өндөршил**)

**ӨНДӨСХИЙХ** to come up, to climb, to jerk up

**ӨНДРӨӨШӨӨ I.** upwards **2.** in height

**ӨНЖИЛГҮЙ** without missing, **жил** ~ without missing a year, year after year

**ӨНЖИХ I.** to spend or to stop a day or a night, **өнжиж хоноглох** to spend the night, **өнжин хонон** day after day, for many a day, **өнжин хонон саатах** to stay some days **2.** to miss out, to do (something) every other time, **жил өнжиж** every other year, **хоёр өнжөөд** after two days, in two days' time **3.** to last **4.** to have a bye

**ӨНЖМӨЛ** year old, lasting from the year before, perennial, lasting from year to year, ~ **цэвдэг** year-long frost

**ӨНЖӨӨХ I.** to miss out, to skip **2.** to leave, § **хоёроос гурав** ~ to leave for two or three days **3.** to season (wood)

**ӨНЖҮҮТ** (~ **хонуут**) a whole day and night, overnight

**ӨНИЙН** of long ago

**ӨНӨ I.** ~ **эртний** ancient, ~ **эртнээс** long ago, from of old **2.** ~ **болох** to last a long time, ~ **ирээдүйн** (~ **мөнхийн**) everlasting, eternal, ~ **удаан** very long, for a long while, ~ **удтал** for a long time to come, ~ **урт** very long, ~ **хойчоо бодох** to think ahead, to look to the future, ~ **холын** distant, ~ **хугацаагаар** for a long period

**ӨНӨД** for ever

**ӨНӨДИЙН** eternal

**ӨНӨЖИХ** to last, to go on

**ӨНӨӨ I.** the present, nowadays, today, ~ **маргааш** (~ **маргаашгүй**) today or tomorrow, any time now, **өнөө маргаашийг аргацаах** (~ **маргаашийг бодох**, ~ **маргаашийг өнгөрөөх**) to live from hand to mouth, to keep one's head above water, ~ **маргаашаа бодсон арчаагүй арга барил** futile makeshift procedures, ~ **маргаашийг өнгөрөөсөн** makeshift, stopgap (*adj.*), ~ **маргаашийн** passing, transitory, short-term, ~ **сая** just now, ~ **үед** at the present time, nowadays, today, ~ **хир** to date, up to now,

**ӨНӨӨГ** хүртэл up to now, up to the present, ~ цагийн present-day, contemporary **2.** this, that, the same, ~ шөнийн дотор this very night

**ӨНӨӨГИЙН** present, present-day, of today, current

**ӨНӨӨДӨР** today

**ӨНӨӨДӨРЖИН** all day today

**ӨНӨӨДӨРХӨН** just today, this very day

**ӨНӨӨДРИЙН** today's, of today

**ӨНӨӨДҮҮЛ** those, those people, the others

**ӨНӨӨТӨХ** (see **нөгөөтөх**)

**ӨНӨӨХ 1.** that, those **2.** you know what

**ӨНӨР 1.** with many relatives, with many children, ~ бүл (~ гэр бүл, ~ өтгөн айл, ~ өтгөн ам бүл) a big family **2.** with a lot of, thick with, хөл хөдөлгөөн ~ thick with traffic

**ӨНӨРЖИХ** to have many children, to make a large family

**ӨНӨТЭЙ** serene, balmy (weather)

**ӨНТЭЙ** rich, fertile, өвлийг ~ давах to get through the winter in plenty, ~ билчээр rich pastures

**ӨНХРӨГЧ** roller

**ӨНХРӨХ 1.** to roll (*intrans.*), ~ үрэлт rolling friction, торго тосон дээр ~ to lie in the lap of luxury **2.** to fall, to take a tumble

**ӨНХРҮҮЛЭГ I.** roller

**ӨНХРҮҮЛЭГ II.** a milk food prepared from cream

**ӨНХРҮҮЛЭХ** to roll (*trans.*)

**ӨНЦӨГ 1.** (~ булан, ~ догол) corner, дэлхийн ~ булан бүрээс from every corner of the world, өнцгийг тойрох to turn the corner, to go round the corner **2.** angle, гурван өнцөгт triangle; triangular, дөрвөн өнцөгт quadrangle; quadrangular, зүглэлийн ~ grid bearing (*cart.*), мохоо ~ obtuse angle, олон өнцөгт polygon; polygonal, таван өнцөгт pentagon; pentagonal, тэгш ~ right angle, тэгш өнцөгт rectangle; rectangular, foursided, тэгш өнцөгт гурвалжин right-angled triangle, хурц ~ acute angle, хэвтээ ~ horizontal angle, чиглэлийн ~ bearing, ~ төмөр angle iron, ~ хэмжигч protractor, өнцгийн шилжилт parallax, § тавин градусын өнцөгтэйгээр at an angle of fifty degrees

**ӨНЦӨГДӨХ** to be at an angle

**ӨНЦӨГДҮҮ** angular

**ӨНЦӨГЛӨХ** to make a corner, to make an angle, to be in or at an angle

**ӨНЦЭЦЭГ** *Goodyera* (*bot.*), Мөлхөө ~ Creeping Lady's Tresses, *G. repens*

**ӨНЧИН** (~ өрөөсөн, ~ хүүхэд) orphan, хагас буюу бүтэн ~ lacking one or both parents, ~ ганцаар all alone, ~ сонгино one's ewe lamb, ~ тархи (see тархи), ~ хүүхэд асрах газар orphanage

**ӨНЧРӨЛ** (~ хагацал) orphanhood

**ӨНЧРӨӨХ** to orphan

**ӨНЧРӨХ** to be orphaned

**ӨНЧРҮҮЛЭХ** to orphan

**ӨНШИХ** to be rich, to be fruitful (pastures)

**ӨӨ I. 1.** defect, fault, bad point, ~ сэв fault, blemish, ~ сэвгүй faultless, flawless, ~ эрэх (~ сүлтэс олох, ~ хайх, ~ сэв хайх, ~ сэв эрэх, ~ сэв эрэлхийлэх) to find fault, to niggle, to pick on, бусдаас ~ эрэх to pick on others **2.** irregularity, roughness

**ӨӨ II.** oh!

**ӨӨВ** yes?, what's that?

**ӨӨВГӨР** teetering, precarious

**ӨӨВИЙХ** to teeter, to be perched insecurely

**ӨӨВЛӨХ** to call өөв өөв to a cow which has rejected its young to persuade it to accept it

**ӨӨВӨН** (~ гэр) shack

**ӨӨВӨР ЦӨӨВӨР** a little, patchily, here and there

**ӨӨГ** pad, cushion

**ӨӨГҮЙ** smooth, even, faultless

**ӨӨГШИХ** to feel encouraged, to be bolder, өөгшин дэврэх to go from bad to worse

**ӨӨГШҮҮЛЭЛ** encouragement

**ӨӨГШҮҮЛЭХ** (өөгшүүлэн өдөх) to encourage, to egg on, өөгшүүлэн дэмжих to promote, өөгшүүлэн тухирах to incite

**ӨӨД I.** up, upwards, мод ~ авирах to climb a tree, шат ~ өгсөх to go upstairs, ~ болооч deceased person, ~ болох to proceed, to go; to pass away, ~ газар rising ground, uphill, ~ татах to improve, to do up, ~ уруугүй in disorder, all over the place **2.** towards, ~ өөдөөс харан facing each other, ~ сөөргөө back and forth, this way and that

**ӨӨДГҮЙ** useless, rotten, wretched, nasty

**ӨӨДЛӨГ** thriving, prosperous, flourishing

**ӨӨДЛӨЛ** development, progress

**ӨӨДЛӨХ 1.** (өөдлөж өндийх) to flourish, to thrive **2.** to get on, to advance, § нас ~ тутам the older it gets

**ӨӨДЛӨШГҮЙ** incorrigible

**ӨӨДӨН** velveteen

**ӨӨДӨӨ** 1. upwards, ~ хаясан чулуу өөрийн толгойд hoist with one's own petard 2. towards, өөр ~ towards oneself, ~ сөөргөө back and forth

**ӨӨДӨӨС** towards, against, facing, at, § эмчийн ~ харуулан facing the doctor, ~ нь харахад looking at him

**ӨӨДӨС** (~ зүйдэс) scraps, chips, offcuts, өөдсийн чинээ охин a scrap of a girl

**ӨӨДРӨГ** (~ оргилуун) lively, cheerful, ~ үзэл optimism, ~ үзэлтэй optimistic, ~ үзэлтэн optimist

**ӨӨДРӨХ** to flourish

**ӨӨДТЭЙ** (~ өнгөтэй) all right, good, decent, positive

**ӨӨЖИН** cradle

**ӨӨЛД** Ölet ( West Mongolian people)

**ӨӨЛЛӨГӨӨ** (see өөлөлт)

**ӨӨЛӨЛТ** trimming, cutting round

**ӨӨЛӨМТГИЙ** carping, cavilling (adj.)

**ӨӨЛӨХ** 1. to trim, to cut round, to turn (lathe) 2. (өөлж зэмлэх) to find fault with, to carp at, to cavil at

**ӨӨНТӨГ** touchiness, sensitivity, ~ санах to feel put out

**ӨӨНТӨГЛӨХ** to find fault, to take offence

**ӨӨНТӨГЧ** touchy, sensitive

**ӨӨР** I. self, ~ зуураа mutually; inwardly, ~ өөдөө towards oneself, ~ өөрийн (~ өөрсдийн) own, individual, respective, ~ өөрийнхөөрөө individually, severally, ~ хоорондоо mutually, amongst each other, each other, ~ хоорондоо үйлчлэх to affect each other, ~ хоорондын mutual

**ӨӨР** II. 1. other, different, ~ бусад other, others, ~ ~ various, different, өөрөөр сэтгэгч dissident, өөрөөр хэлбэл in other words, to put it another way 2. apart from, үүнээс ~ apart from this

**ӨӨРГӨӨ СӨӨРГӨӨ** back and forth

**ӨӨРГҮЙ** no different from, nothing other than

**ӨӨРИЙГӨӨ** self, oneself (objective)

**ӨӨРИЙМСӨГ** like one's own, in a personally responsible manner, § эд хогшилд ~ хандах to treat equipment as if it were one's own

**ӨӨРИЙМСӨХ** to feel at home, to feel familiar, to treat as one's own

**ӨӨРИЙМСҮҮ** (see өөриймсөг)

**ӨӨРИЙМШҮҮЛЭХ** to assimilate, to make one's own

**ӨӨРИЙН** one's own, ~ биеэр personally, ~ гэх орон гэргүй without a home to call one's own, ~ дураар voluntarily, off one's own bat, ~ өртөг

prime cost, ~ толгой дээр байгаа тэмээг харахгүй байж бусдын толгой дээрх бөөсийг харах the pot calling the kettle black, ~ шүүмжлэл self criticism, ~ эрхгүй involuntary, forced, under compulsion, ~ эрхээр байх to be one's own master

**ӨӨРИЙНДӨӨ** at home (football)

**ӨӨРИЙНХ НЬ** own, § цэг нь уг нотыг ~ хагасаар уртасгана the dot lengthens the note concerned by half its own length, ~ нөхөд his own friends

**ӨӨРӨГ СӨӨРӨГ** (see өөргөө сөөргөө)

**ӨӨРӨӨ** oneself, personally, ~ ажиллагч automatic, ~ асрагч self-starter, ~ буулгагч tipper lorry, dumper truck, ~ засан тохинох эрх right of self-determination (polit.), ~ ойчсон хүүхэд уйлдаггүй as you make your bed so you must lie on it, ~ өөрийгөө үйлчлэх дэлгүүр self-service shop, ~ өөртөө үйлчлэх угаалгын газар laundrette, ~ өөрийгөө хамгаалах to protect oneself, ~ өөртөө шивгэнэх to whisper to oneself, ~ явагч self-propelled, § ~ эдгэрдэг байна it gets better by itself

**ӨӨРӨӨР НЬ** by oneself

**ӨӨРӨӨСӨӨ** from oneself, than oneself, ~ ах хүн someone older than oneself

**ӨӨРСДИЙН** one's own, ~ нь жинхэнэ нүүр царай their true face

**ӨӨРСДӨӨ** oneself, by oneself, ~ засан тогтнох эрх right of self-determination

**ӨӨРСНИЙ** one's own

**ӨӨРСНИЙГӨӨ** oneself (objective), ~ устгах self-destruction

**ӨӨРСНӨӨ** oneself

**ӨӨРСӨД** oneself, ~ хоорондоо amongst each other

**ӨӨРТ** to oneself, for oneself, § ~ нь томдох to be too big for one

**ӨӨРТӨӨ** to oneself, for oneself, ~ засах autonomy, self-determination, ~ засан тохинох эрх right of self-determination, ~ итгэдэг self-confident, ~ үйлчлэх дэлгүүр self-service shop

**ӨӨРЦ** different

**ӨӨРЦҮЙ** no different from, just like, just the same, § нохойг үр хүүхдээс ~ энхрийлнэ they pet the dogs just like children

**ӨӨРЦ ЮМГҮЙ** (see өөрцгүй)

**ӨӨРЧЛӨГДӨМТГИЙ** changeable, variable

**ӨӨРЧЛӨГДӨХ** to change, to be changed, to become different, өөрчлөгдөн хувирах (өөрчлөгдөн хувьсах) to be changed, to be

modified, to evolve, to vary, **өөрчлөгдөн шинэчлэгдэх** to be modernized, to be updated, to be brought up to date

**ӨӨРЧЛӨГДӨШГҮЙ** immutable, unchangeable

**ӨӨРЧЛӨЛ** change, alteration

**ӨӨРЧЛӨЛТ** (see **өөрчлөл**), **~ оруулах** to introduce changes, **~ хувирал** change, transformation

**ӨӨРЧЛӨЛТТЭЙ** changeable, variable, erratic

**ӨӨРЧЛӨНГҮЙ** changing, changeable

**ӨӨРЧЛӨХ** to change, to alter (*trans.*), **өөрчлөн байгуулалт** reconstruction, perestroika, **өөрчилж шинэчлэх** to revise, to bring up to date

**ӨӨСДИЙГӨӨ** themselves

**ӨӨТҮҮЛЭХ** to find fault with

**ӨӨТЭЙ** 1. defective, faulty 2. rough, uneven

**ӨӨХ** (**~ тос**) fat (*n.*), **өөхөнд ороосон бөөр шиг байлгах** to spoil, to pamper, **~ өгсөн хүнтэй өдөр шөнөгүй заргалдах** to bite the hand that feeds one, **~ тостой хоол** fatty food, **өөхөн сүүлт** fat-tailed (sheep), **өөхөнд хучсан бөөр шиг** mollycoddle, **өөхний хүчил** (see **хүчил**), **өөхөн цагаан (өөхөн чулуу)** quartz, **~ ч биш булчирхай ч биш** neither one thing nor the other

**ӨӨХЖИЛТ** adiposity

**ӨӨХЛӨГ** 1. fatty, **~ эд** fatty tissues 2. fat (*n.*)

**ӨӨХЛӨХ** (**өөхөлж таргалах**) to put on fat, to get fatty, **өөхөлж чөмөглөх** to put on weight

**ӨӨХШИХ ГҮВЭН** (**өөхших гүвэнгийн хатуурал**) atherosclerosis

**ӨӨЧ** critical, niggling

**ӨӨЧЛӨХ** to criticise, to get at

**ӨӨШ** bait

**ӨР** I. (**~ авлага**, **~ зээл**, **~ төлбөр**, **~ төлөөс**, **~ шир**) debt, **~ авах** to recover a debt, to get a debt repaid, **өрөнд баригдах** to be deeply in debt, **~ дарах** to repay a debt, **~ нэхэмжлэх** (**~ нэхэх**) to chase up a debt, to demand repayment of a debt, **өрөнд орох** to get into debt, **~ тавих** to run up a debt, **~ ширээ дарах** to pay off one's debts

**ӨР** II. the pit of the stomach, **~ зөөлөн** (**~ нимгэн**) tender-hearted, **~ зурх** heart, feelings, **~ өвдөх** to feel sorry (for), to pity, **~ хатуу** pitiless, hard-hearted

**ӨР** III. 1. (**тулганы ~**) the square frame holding the stove in the tent 2. centre, midpoint, **~ дунд** right in the middle

**ӨРВИЙХ** to bristle, to stand on end (hair)

**ӨРВӨГНӨХ** (see **өрвөлзөх**)

**ӨРВӨЛГӨ** 1. feather 2. long hair on the top of the head of a bull camel 3. comb (bird.)

**ӨРВӨЛЗӨХ** 1. to bristle, to be dishevelled, to stick out 2. to flare (flame)

**ӨРГӨГДӨЛ** elevation, altitude

**ӨРГӨГЧ** 1. jack 2. (**~ кран**, **~ цамхар**) crane 3. **~ машин** fork-lift truck

**ӨРГӨДӨЛ** petition, submission, suit, application

**ӨРГӨДӨХ** to be too broad, to be too wide

**ӨРГӨЖИХ** to get broader, to get wider, to grow in extent, to grow larger, to expand, **өргөжин тэлэх** to expand

**ӨРГӨЖҮҮЛЭХ** to broaden, to widen (*trans.*)

**ӨРГӨЛ** (**~ барьц**) offering, donation, gift, **~ мөргөл** worship, **~ өргөх** to make an offering, **~ хүндлэл** veneration (*Buddh.*)

**ӨРГӨЛТ** I. stress (*mus., ling.*)

**ӨРГӨЛТ** II. lifting, weight-lifting, **хүндийн ~** weight-lifting, **огцом ~** snatch, **түлхэлттэй ~** jerk

**ӨРГӨЛТ** III. petition, memorial

**ӨРГӨЛТГҮЙ** unstressed

**ӨРГӨЛТӨТ** stressed, **~ үе** stressed syllable

**ӨРГӨЛТТЭЙ** stressed

**ӨРГӨМЖ** 1. care, support 2. respect

**ӨРГӨМЖЛӨЛ** 1. honouring, conferment of honour 2. diploma, **навчит ~** a diploma placed on a stiff backing

**ӨРГӨМЖЛӨХ** to elevate in rank, to honour, to exalt, to confer (a rank, an honour, a reign-title), **өөрийгөө өргөмжлөн онгирох** to blow one's own trumpet, **өргөмжлөн мандуулах** to promote (dignity, fame, etc.), **§ түүнийг Чингис хаан гэж өргөмжилсөн байна** they raised him to be Genghis Khan

**ӨРГӨМӨЛ** foster, adoptive, adopted, **~ охин** adopted daughter, **~ хүү** adopted son, **~ эх** adoptive mother, foster mother

**ӨРГӨН** I. (**~ уудам**) wide, broad, **~ айлсалт** concentrated camping (of a number of herding units in one place), **~ дэлгэр** wide, widespread, general, **~ нэвтрүүлэг** broadcast, **~ олон** the broad masses, the public at large, **~ өнцөгт** wide-angle (*adj.*), **~ хэмжээгээр** on a wide scale, **~ хэрэглэх** to make wide use of, **~ хэрэглээний эд агуурс** (**~ хэрэгцээний бараа**) consumer goods 2. width

**ӨРГӨНӨӨР** 1. broadly, on a broad scale 2. widthways

**ӨРГӨӨ** I. pavilion, tent-residence of a high-ranking person, residence (*resp.*)

ӨРГӨӨЛӨХ to reside (*resp.*)

ӨРГӨӨШ (~ нь) widthways, from side to side, in width

ӨРГӨӨШӨӨ (see өргөөш), § ~ гурван метр three metres wide

ӨРГӨРӨГ 1. latitude, нам өргөргүүд low latitudes, өндөр өргөргүүд high latitudes 2. line of latitude

ӨРГӨС I. (~ хэргэс) barb, thorn, spine, splinter, өргөст тор barbed-wire entanglement, өргөстэй төмөр утас barbed wire 2. (цоожны ~) tongue (of a Mongolian lock)

ӨРГӨСГӨХ to broaden, to widen (*trans.*)

ӨРГӨСЛӨГ sharp, spiny, spiky, thorny

ӨРГӨСӨРХҮҮ (see өргөслөг)

ӨРГӨСӨХ to widen to get wider, to be dilated

ӨРГӨСТ АРЬСТАН Echinoderms, Echinodermata

ӨРГӨСТ ХАМХАГ Saltwort, *Salsola*

ӨРГӨСТ ХЭМХ Cucumber

ӨРГӨТГӨЛ enlargement, extension

ӨРГӨТГӨХ to broaden, to widen, to extend, to expand (*trans.*)

ӨРГӨХ 1. to lift, to raise, хундага ~ to raise one's glass, to give a toast, ~ цамхаг tower-crane 2. to adopt (a child), өргөсөн эцэг adoptive father 3. (өргөн барих) to offer, to present, сүү ~ to make an offering of milk, ~ бичиг petition, өргөн мэдүүлэх to represent

ӨРГҮҮР 1. lift, hoist 2. jack 3. crane

ӨРДӨЛ debt, indebtedness

ӨРДӨХ I. to get into debt, to incur a debt

ӨРДӨХ II. to stoke up (a big fire), гал ~ (их гал ~) to build up a big fire

ӨРЛӨГ I.1. hero, champion (*hist.*), ~ жанжин marshal (*mil.*), § Чингис хаан, түүний есөн ~ Genghis Khan and his nine paladins 2. matchless, victorious, undefeated

ӨРЛӨГ II.1. brickwork, bricklaying, өрлөгийн мэрэгжил bricklayer's craft 2. typesetting, халуун ~ hot metal setting

ӨРЛӨГ III. adoptive, ~ аав ээж adoptive father and mother, ~ эх adoptive mother; foster mother, wet nurse

ӨРЛӨГЧИН bricklayer

ӨРЛӨХ (өрлөн цоолох) to pierce the abdomen (of a sheep) at the epigastrium to slaughter or gut it

ӨРМӨГ coarse wool sacking, ~ таар sacking

ӨРМӨНЦӨР wafer

ӨР МӨРГҮЙ without a trace

ӨРНИЙН western

ӨРНӨ west, western ~ дахины western, ~ тийш westwards

ӨРНӨД west, western ~ Европын холбоо Western European Union

ӨРНӨДИЙН west, western, ~ салхи west wind, ~ хөрөнгөтөн орнууд western capitalist countries

ӨРНӨДИЙНХӨН westerners

ӨРНӨЛ growth, development, upturn

ӨРНӨЛТ (see өрнөл)

ӨРНӨХ (өрнөн бадрах, өрнөн хөгжих) to develop, to thrive

ӨРНҮҮЛЭХ to develop, to promote

ӨРНҮҮН flourishing, thriving

ӨРӨВГӨР wispy, fluffy

ӨРӨВДМӨӨР (see өрөвдөлтэй)

ӨРӨВДӨЛТЭЙ pitiful, pathetic, харваас ~ sad to see

ӨРӨВДӨМ (see өрөвөлтэй)

ӨРӨВДӨНГҮЙ kindly, sympathetic, warm

ӨРӨВДӨХ (өрөвдөн нигүүлсэх, өрөвдөн хайрлах) to pity, to feel sorry for, to take pity on

ӨРӨВЛӨГ (see өрөвлөг)

ӨРӨВСӨЛ (see үрөвсэл)

ӨРӨВСӨХ I. (see үрөвсэх)

ӨРӨВСӨХ II. (see өрөвдөх)

ӨРӨВТАС Stork, *Ciconia*, Хар ~ Black Stork, *C. nigra*

ӨРӨВТӨЛ rasp

ӨРӨВХИЙХ 1. to pounce 2. to gobble

ӨРӨВЧ (~ энэрэнгүй) sympathetic, compassionate

ӨРӨВЧХӨН sympathetic, kindly

ӨРӨГ I.i. targets set up for Mongol archery

ii. a round in archery 2. game, board (chess)

3. degree, interval (*mus.*), зонхилох ~ dominant, дэд зонхилох ~ sub-dominant

4. (тоосгоны ~) brickwork, bricklaying

ӨРӨГЧ 1. bricklayer 2. typesetter

ӨРӨЛ Apple, *Malus*, *M. pallasiana*

ӨРӨЛБӨ pincers, nippers

ӨРӨЛТ I.1. placing, arrangement 2. bricklaying 3. typesetting, фото~ photo-setting

ӨРӨЛТ II. wrestler's stance before coming to grips

ӨРӨМ I. drill (*mech.*), гар ~ hand-drill, мушгиа

~ twist-drill, **цохилтот** ~ hammer-action drill

**ӨРӨМ II.1.** (түүхий ~, ~ зөөхий) clotted cream, ~ байлгах to simmer milk and obtain clotted cream **2.** skin (on a liquid, etc.)

**ӨРӨМЦЛӨГ** drilling, **цохилтот** ~ percussion drilling, ~ суурь машин drilling machine, **өрөмдлөгийн чөмөг** drilling sample

**ӨРӨМЦМӨЛ** drilled, bored, ~ худаг bore-well, artesian well

**ӨРӨМДӨГЧ 1.** drill (mech.) **2.** driller

**ӨРӨМДӨЛ** drilling, **хайгуулын** ~ exploratory drilling

**ӨРӨМДӨХ** to drill, to bore

**ӨРӨМДҮҮЛ** (see **Өрөмтүүл**)

**ӨРӨМТӨХ 1.** (өрөмтөн тогтох) to settle (cream on milk) **2.** to form a skin (molten metal on cooling, etc.)

**ӨРӨМТҮҮЛ** Bedstraw, *Galium*, **Жинхэнэ** ~ Lady's Bedstraw, *G. verum*

**ӨРӨМТҮҮЛЭХ** to get cream to settle on milk

**ӨРӨМЧ** Urumchi (p.n.)

**ӨРӨМШИХ** to separate (cream from milk)

**ӨРӨНГӨ ГОЛ** Urungu River

**ӨРӨНШ** westwards

**ӨРӨӨ** (~ тасалгаа) room, compartment, **өрөөний цэцэг** house-plant

**ӨРӨӨЛ I.** a half of something divided down the middle, **үхрийн** ~ a side of beef, ~ саатай hemiplegic, ~ татуу болох to be paralysed down one side, to be hemiplegic

**ӨРӨӨЛ II.** a hobble for the front and back legs on one side of an animal, **модон сумтай** ~ a hobble for one side in which the main strap is replaced by a piece of wood, **өрөөлтэй морь** a horse hobbled on one side

**ӨРӨӨЛ III.** others, ~ бусад other; others, ~ бусад амьтан other creatures, § **өөртөө** ~ бусаддаа тусламж үзүүлэх to help oneself and others

**ӨРӨӨЛДӨХ 1.** to halve **2.** to hobble (a horse) on one side

**ӨРӨӨЛИЙН** other people's, someone else's, alien

**ӨРӨӨЛӨХ** to partition, § **барэг өрөөлж барьсан хоёр гэр** two tents pitched practically touching

**ӨРӨӨСГӨЛ 1.** odd (number) **2.** one-sided, idiosyncratic, biased, odd, ~ хандах to deal with in a biased way, ~ хандлага biased handling, prejudiced treatment

**ӨРӨӨСГӨЛДӨЛ** oddity, oddness, anomaly

**ӨРӨӨСГӨЛДӨХ** to be one-sided, to be out of kilter

**ӨРӨӨСӨН** one of two, one of a pair, **өнчин** ~ (see **өнчин**), ~ гаргүй with only one arm, ~ бөөр (~ гутал, ~ дугуй) one of a pair with, opposite number, § **энэ ч мөн л өнөөх хувилгаан ламын** ~ дугуй шив дээ this fellow looks like one of a pair with that high lama

**ӨРӨӨСТЭЙ** set out, displayed

**ӨРӨӨТЭЙ** (see **өрөөстэй**)

**ӨРӨХ I.** to arrange, to fit, to lay, to set (type, etc.), to set out, to set up (archery targets, etc.)

**ӨРӨХ II.** (өрж зогсох) **1.** to stand ready to wrestle **2.** to stand with one leg behind the other (**биэлгээ** position)

**ӨРСӨЛДӨГЧ 1.** rival, opponent, challenger **2.** competitor **3.** claimant, **хаан ширээнд** ~ claimant to the throne

**ӨРСӨЛДӨӨН** competition, rivalry, struggle

**ӨРСӨЛДӨӨНТЭЙ** competitive

**ӨРСӨЛДӨХ** to compete (with), to rival, ~ чадвартай competitive

**ӨРСӨЛДӨХҮЙЦ** competitive

**ӨРСӨХ 1.** to anticipate, to forestall **2.** to race, to compete with, **хугацаат хоногоос** ~ to be up against a deadline, **цаг мөчтэй** ~ (see **цаг 1.**), § **өвлөөс өрсөж хийгүүштэй зүйл** things which should be done before winter

**ӨРТ** indebted, in debt, debtor (adj.)

**ӨРТЛӨӨС** trouble

**ӨРТЛӨӨСТЭЙ** troublesome

**ӨРТӨГ** cost, **амьжиргааны** ~ cost of living, **анхны** ~ starting price, **өөрийн** ~ prime cost, ~ зардал costs, § **арван сая долларын** ~ бүхий costing ten million dollars

**ӨРТӨГДӨХ 1.** to be perceived, to be felt **2.** to be struck (by,) to fall a victim (to), to become a casualty (of), **фашизмд өртөгдөгсөд** victims of fascism

**ӨРТӨГТЭЙ** costing, valued at

**ӨРТӨМГГИЙ** susceptible (to), vulnerable (to), at risk (of), **зүрх судасны өвчинд** ~ susceptible to cardio-vascular diseases

**ӨРТӨМХИЙ** (see **өрөмтгий**)

**ӨРТӨН** debtor

**ӨРТӨӨ 1.** relay-service, post-service (hist.), **босго** ~ (see **босго 2.**), **буухиа** ~ (see **буухиа 2.**), **дамжлага** ~ (навч ~) a subsidiary relay-service branching from a **суман өртөө**, **өртлөг** ~ temporary relay-service, **суман** ~ banner relay-service, **өртөөний бүл** workers on the relay services, ~ **жиших** to set up a temporary

relay-service, ~ зам post-road, ~ улаа official transport (*hist.*) **2.** relay-station, уяа ~ local relay station **3.** the distance between two relay-stations (about 30 km.) **4.** railway-station, station, дэд ~ sub-station (*elec.*)

**ӨРТӨӨЛӨХ 1.** to travel by the relay-services, өртөөлөн дамжих to be forwarded by the relay-services; to be passed on (infection, etc.) **2.** to go from one to the other, to be passed on

**ӨРТӨӨЧИЛСӨН** staged, phased

**ӨРТӨӨЧИН** worker on the relay-services or relay-stations

**ӨРТӨӨЧЛӨН** stage by stage

**ӨРТӨХ 1.** to be perceived, to be felt, to be touched, гарт үл өртөм too small to feel, нүдэнд ~ to strike the eye, to be conspicuous, нүдэнд амархан ~ to be easy to pick out, хүний нүдэнд үл ~ жижиг too small for mortal eyes **2.** to be struck by, to be affected by, өвчинд ~ to be struck by illness **3.** to be involved in, to get caught up in, осолд ~ to be in an accident, цэвэрлэгээнд ~ to be involved in a purge

**ӨРТӨХҮЙЦ 1.** susceptible, vulnerable, ~ байдал vulnerability, § дайсны галд ~ vulnerable to enemy fire **2.** perceptible, нүдэнд ~ visible, plain to be seen

**ӨРТЭЙ 1.** indebted, owing, ~ орон debtor nation, ~ явахаар дөртэй яв stand on your own two feet, § хүнд таван зуун лангийн ~ байсан owed someone five hundred ounces **2.** obliged

**ӨРҮҮ (~ зөрүү)** crooked, awry, out of line

**ӨРХ I.** the felt used for covering the roof-ring of a tent, ~ тавих to fit the roof-flap (in setting up the tent), ~ татах (~ хойш татах) to pull back the roof-flap (and open the roof-ring), ~ тэгшлэх to pull the roof flap over

**ӨРХ II.** (~ айл, ~ ам) family, household, өрхийн бичиг (өрхийн данс) family record, ~ гэр home, өрхөөс ~ галаас гал тасрах to fly the nest, ~ тасарсан залуус young people who have set up their own homes, ~ толгойлох to be the head of a household, ~ тусгаарлах to set up a separate home, өрхийн тэргүүлэгч (өрхийн тэргүүн) head of the household

**ӨРХ III.** crater, pit, газрын ~ big steep-sided pits found in the Gobi

**ӨРХИЙН** household (*adj.*), ~ орлого family income

**ӨРХЛӨХ** to form a crater

**ӨРЦ** diaphragm (pump, *anat.*, *photo.*)

**ӨРЦӨГ** diaphragm (pump)

**ӨРШӨӨГӨӨРЭЙ** I beg your pardon

**ӨРШӨӨЛ 1.** favour, grace, mercy, ~ уучлал mercy, forgiveness, ~ уучлал гуйх (~ уучлал

эрэх) to ask for mercy, to ask for forgiveness, ~ энэрэл mercy **2.** amnesty (*jur.*), ~ үзүүлэх to amnesty

**ӨРШӨӨЛТ** gracious, merciful, kind

**ӨРШӨӨНГҮЙ** (see өршөөлт)

**ӨРШӨӨХ** to excuse, to forgive, to pardon, to spare, to amnesty, өршөөн хэлтрүүлэх to remit

**ӨС** hatred, vengeance, өсөө авах to take one's revenge, ~ өвөрлөлцөх to bear a grudge against each other, ~ хонзон spile, vengeance, revenge, ~ хорсол hatred, enmity, resentment

**ӨСВӨР** rising, growing, ~ үеийнхэн the rising generation

**ӨСВӨРИЙН** rising, coming, ~ дайчид young soldiers, ~ үеийнхэн the rising generation

**ӨСГИЙ 1.** heel (*anat.*) **2.** heel (boot), гадсан ~ stiletto heels, нам өсгийтэй low-heeled, өндөр өсгийтэй high-heeled

**ӨСГИЙДӨХ** to catch by the heel

**ӨСГИЙЛЦӨХ** to trip with the heel (wrestling)

**ӨСГИЙЛЭХ** to fit a heel (in boot-making)

**ӨСГӨВӨР** culture, эд эсийн ~ tissue culture, ~ ургуулах to grow a culture

**ӨСГӨВӨРЛӨХ** to grow, to cultivate, to breed

**ӨСГӨГЧ** amplifier, enlarger (*photo.*), ~ шил (see шил I.1.)

**ӨСГӨЛӨН** well-built

**ӨСГӨЛТ** magnification, amplification, enlargement, бага ~ low power magnification, их ~ high power magnification

**ӨСГӨЛҮҮН** (see өсгөлөн)

**ӨСГӨХ 1.** (өсгөн бойжуулах, өсгөн өндийлгөх, өсгөн хүмүүжүүлэх) to bring up, to rear, өсгөн үржүүлэх to rear, to keep (live-stock) **2.** to raise, to increase, to inflate, to jack up, өсгөн арвижуулах to increase, to enhance, өсгөн олшруулах to increase, өсгөн товойлгох to overemphasize, to overstress **3.** to magnify, өсгөдөг шил (see шил I.1.) **4.** to amplify, ~ буудал booster station

**ӨСГҮҮР 1.** raising agent, yeast **2.** amplifier

**ӨСЛӨХ** to hate, to loathe

**ӨСӨЛТ** (~ биежилт, ~ торнилт, ~ хөгжилт) growth, development, increase, өсөлтийн түүх child's medical record

**ӨСӨРХӨХ** to take umbrage, to bear a grudge

**ӨСӨХ 1.** (өсөн бойжих, өсөн бэхжих, өсөн дэгжих, өсөн өндийх, өсөн өөдлөх, өсөж томоожих, өсөн торних, өсөн төлжих, өсөн хүмүүжих) to grow, to grow up, to develop



**2.** (өсөн нэмэгдэх, өсөн олшрох) to increase  
**ӨСТ** vengeful, hostile  
**ӨСТӨН 1.** enemy **2.** hostile  
**ӨГ** (~ хорхой) maggot, grub, worm, утсан ~ wireworm, чийгийн улаан ~ earthworm, § шавьжийн авгалдай, хүүхэлдэйг монголчууд ~ хорхой гэж нэрлэдэг Mongols call the larvae and pupae of insects "grubs"  
**ӨТГӨВТӨР** thickish  
**ӨТГӨДӨХ** to be too thick, to be too strong (tea, etc.)  
**ӨТГӨН 1.** (~ нягт, ~ шигүү) thick, dense, ~ шингэн (~ сийрэг) density **2.** stools, faeces, өтгөнөөр бие засах to pass a motion, ~ хатах (~ хориглох) to be constipated, ~ шингэн faeces and urine, ~ шингэн мөр харах to relieve oneself, өтгөний ялгаралт defecation  
**ӨТГӨРӨЛ 1.** concentration, density **2.** viscosity  
**ӨТГӨРӨЛГ** (see өтгөрөл)  
**ӨТГӨРӨХ 1.** to thicken, to get thick **2.** to condense  
**ӨТГӨРҮҮЛЭХ 1.** to thicken, to allow to get thick **2.** to condense, өтгөрүүлсэн сүү condensed milk  
**ӨТГЭС** old people  
**ӨТГӨЦ** concentration, density  
**ӨТЛӨЛТ** (насны ~) ageing, growing old  
**ӨТЛӨНГӨ** aged  
**ЭЛБЭГЖҮҮ 1.** abundant, plentiful **2.** expansive **ЭЛБЭГЖҮҮЛЭХ** to make more plentiful, to make more prevalent

**ЭЛБЭГТЭЙ** rich in, загас ~ rich in fish

**ЭЛБЭГШИХ** (see элбэгжих)

**ЭЛБЭГШҮҮЛЭХ** (see элбэгжүүлэх)

**ЭЛБЭЛЦЭХ** (элбэлцэн туслалцах) to share in doing, to help with, **ажилд элбэлцэн туслалцах** to take a hand in the work

**ЭЛБЭНХ** Raccoon Dog, *Nyctereutes procyonoides*

**ЭЛБЭРЭЛ 1.** respect, filial respect **2.** (~ ачлал) care, parental care, ~ хайр loving care, § ~ төгс аав my father, full of kindness

**ЭЛБЭРЭЛТ 1.** filial, respectful **2.** benevolent

**ЭЛБЭРЭЛТЭЙ** (see элбэрэлт)

**ЭЛБЭРЭХ** to respect, to regard

**ЭЛБЭХ** to help, to work with

**ЭЛГЭВЧ** belly-band (for a new-born beast, a rider, etc.)

**ЭЛГЭВЧЛЭН** on the stomach, face-down, ~ хэвтэх to lie face-down

**ЭЛГЭВЧЛЭХ** to put on a belly-band

**ЭЛГЭГ** fine sieve

**ЭЛГЭМСҮҮ** (see элгэмсэг)

**ЭЛГЭМСЭГ** warm, intimate, fond, гэр бүлдээ ~ fond of one's family

**ЭЛГЭМСЭХ** to be warm, to be intimate, to be close

**ЭЛГЭН 1.** liver-like, ~ тарар (see тарар), ~ хүрэн chestnut, brown, ~ чулуу bloodstone **2.** closely related, related by blood, ~ садан (~ төрөл) relatives, ~ холбоотой closely linked **3.** dear, beloved, ~ нутаг native place, homeland, ~ сайхан орон минь my beloved country, ~ халуун warm, ardent, intimate, affectionate, ~ халуун найрамдал warm friendship **4.** steep, precipitous, ~ сарьдаг precipitous snow-covered peak, ~ хад sheer cliff

**ЭЛДВИЙН** various, all sorts of, a lot of, ~ дэмий үг a lot of nonsense

**ЭЛДВЭЭР** in all sorts of ways, every way one can

**ЭЛДМЭЛ** dressed, curried (skin)

**ЭЛ ДОЛ БОЛОХ** to get inured to

**ЭЛДҮҮР I.** dressing, currying (of a skin) **2.** pounding, banging

**ЭЛДҮҮР II.** rolling-pin

**ЭЛДҮҮРЧИН** tanner

**ЭЛДЭВ** (~ бусын, ~ хангай, ~ шалдав, ~ шидийн, ~ эсийн) various, all sorts of, элдвийг

**бодох** to worry, ~ **долоог амсах** to have seen everything, to have had a lot of experience, to have been through the mill, ~ **долоон зүйл** this and that, all sorts of things, ~ **төрлийн** heterogeneous, all sorts of, ~ **хоёр** this that and the other, ~ **хоёр зангүй** straightforward

**ЭЛДЭВЛЭХ** to do one's best, to contrive

**ЭЛДЭВ-ОЧИР** crossed thunderbolts design (also **нацагдорж**)

**ЭЛДЭВЧЛЭН** in every way

**ЭЛДЭВЧЛЭХ** to try everything possible, to try by hook or by crook

**ЭЛДЭЛТ** dressing, currying (of a skin)

**ЭЛДЭНШИЛ** softening (through dressing or currying, etc.)

**ЭЛДЭНШИХ** to get soft (through dressing or currying, etc.)

**ЭЛДЭНШҮҮЛЭГ** working, softening

**ЭЛДЭНШҮҮЛЭЛТ** working, softening, **хөрс** ~ tilling, breaking up of soil

**ЭЛДЭНШҮҮЛЭХ** to work, to soften (ground, hides, etc.)

**ЭЛДЭХ I.1.** to dress, to curry (a skin) **2.** to roll out (pastry), **гурил** ~ to roll out pastry

**ЭЛДЭХ II.** (элдэн хөөх) to chase, to pursue, to drive

**ЭЛЕКТРОН** electronic

**ЭЛЕКТРОНЖУУЛАЛТ** provision of electronic equipment

**ЭЛЕКТРОНЖУУЛАХ** to provide with electronic equipment

**ЭЛЕМЕНТ** element, **газрын ховор** ~ rare earth element (Russ.)

**ЭЛИЙ** (~ **балай**) confused, disturbed, wandering

**ЭЛИЙРЭХ** to be confused, to be disturbed

**ЭЛИТ** élite

**ЭЛМЭГ** (see **эмнэг**)

**ЭЛС** sand, **нүүдэг** ~ drifting sand, **элсэн говь** (элсэн цөл) desert, sandy waste, **элсээр дээс томох** to go on a wild goose chase, **элсэн манх** sand-dune, **элснээс төрж эрэгнээс унаагүй** being human beings and not beasts, **элсний ургамал** sand-plant, psammophyte, **элсэн цаг** sand-glass, hour-glass, **элсэн чихэр** granulated sugar, **элсэн чулуу** sandstone, **элсээр шүрших аппарат** sand-blasters

**ЭЛСЖИЛТ** sanding up, encroachment of sand

**ЭЛСЖИХ** to become sandy, to be sanded up

**ЭЛСЖМЭЛ** sandy, sanded up

**ЭЛСЛЭГ** sandy

**ЭЛСЛЭЛТ** stratification (of seeds)

**ЭЛСЛЭХ** to stratify (seeds, by storing in sand before sowing)

**ЭЛССЭГ** sand-loving, psammophytic

**ЭЛСТ I.** sandy

**ЭЛСТ II.** Elista (p.n.)

**ЭЛСҮҮЛЭХ** to enlist, to enrol, to admit, to recruit, **шинэ гишүүн** ~ to enrol new members

**ЭЛСЭГ I.** (see **элэгсэг**)

**ЭЛСЭГ II.** Stint, Sandpiper, **Савар** ~ Long-toed Stint, *Calidris subminuta*, **Сянби** ~ Broad-billed Sandpiper, *Limicola falcinellus*, **Темминцийн** ~ Temminck's Stint, *C. Temminckii*, **Ухаа** ~ Curlew Sandpiper, *C. ferruginea*, **Шар түрүүт** ~ Rufous-necked Sandpiper, *C. ruficollis*

**ЭЛСЭГДЭХ** to be recruited

**ЭЛСЭГЛЭХ** to be on good terms

**ЭЛСЭГЧ** recruit, new entrant

**ЭЛСЭЛТ 1.** recruitment, enrolment, **элсэлтийн уралдаант шалгалт** entrance examination, entrance competition **2.** intake

**ЭЛСЭНЦЭР** (~ **хөрс**) sandy soil, sandy loam

**ЭЛСЭРХҮҮ** sandy

**ЭЛСЭРХЭГ** (see **элсэрхүү**)

**ЭЛСЭХ** to join, to enrol, to join up, to enlist, **намын гишүүнээр** ~ to become a party member, **нэгдэлд** ~ to join a co-operative, **цэрэгт** ~ to join up

**ЭЛТЛЭХ** to chip

**ЭЛТРЭХ** to be chipped away, to crumble

**ЭЛТЭС** (see **илтэс**)

**ЭЛ ХУЛЬ** abandoned, deserted, remote, unfrequented, desolate, cheerless

**ЭЛЧ I.** messenger, emissary, courier

**ЭЛЧ II.** (see **илч**)

**ЭЛЧИЛГҮЙ** deserted, uninhabited, desolate

**ЭЛЧИН 1.** (~ **сайд**) ambassador, ~ **сайдын яам** embassy **2.** embassy

**ЭЛЭГ I.** (~ **доог**) mockery, derision, ~ **барих** to deride, to treat with contempt, ~ **доог боллох** шоолох to deride, to laugh to scorn

**ЭЛЭГ II.1.** liver, sides, belly, breast, **өнчин** ~ the small lobe of the liver, ~ **буруу** (~ **муутай**) disparaging, ~ **буруулах** to disparage, ~ **бүтэн** with all the family in good health, **элэгний дутагдал** liver-failure, **элгийг дэвтээх** to relieve, to solace, ~ **зүрхний** intimate, dear, ~ **зүрхний хайрт** dearly beloved, ~ **нимгэн** tender-hearted, ~ **нэгтэй** friendly, at one with, ~ **нэгтэн** friend, sympathizer, ~ **татах** to be fond

of one's own, ~ татуу fond of one's own, элэгний тахалт үрэвсэл epidemic hepatitis, Botkin's disease, элгээ тэврэх to huddle up, to cower, ~ хатаах to treat badly, ~ хатах to long for, to miss; to be parched, ~ хатгал гомдох to feel deep resentment ~ хатуурал (.. хатуурах өвчин) cirrhosis of the liver, элгээ хөштөл инээх to split one's sides with laughter, элгээрээ хэвтэх to lie on one's belly, ~ цайх whitening of the liver (stage in the development of a beast, also сэмж суух), элгээ эвхэх to be huddled up, элгээ эмтлэх to distress oneself, ~ эмтрэх (~ зүрх эмтрэх, ~ өвдөх) to be distressed 2. belly (of a composite bow), эвэр элэгтэй нум bow with a horn belly

ЭЛЭГГҮЙ uncaring, heartless

ЭЛЭГДМЭЛ worn (by use)

ЭЛЭГДҮҮЛЭХ to wear away, to rub away

ЭЛЭГДЭЛ wear, wearing away, erosion, салхины ~ wind erosion, хөрсний ~ soil erosion, хөрс гадаргын ~ surface erosion, элэгдэлд орох to be subject to erosion, ~ хорогдол wear and tear, ~ хорогдлын шимтгэл depreciation, ~ хуучрал deterioration, wearing out, ~ эвдрэл erosion

ЭЛЭГДЭЛТ (see элэгдэл)

ЭЛЭГДЭХ to wear, to get worn down, to get dilapidated, to be eroded, элэгдэж дуусах (элэгдэж хуучрах) to get worn out, элэгдэж мөлийх to get worn down with use (printing-block, etc.), элэгдэж муудах to deteriorate, элэгдэж урагдах to be worn out, to be worn through, элэгдэж эвдрэх to be eroded

ЭЛЭГЛҮҮЛЖ БУУЛГАХ to make a belly-landing

ЭЛЭГЛЭЛ ridicule, mockery, элэглэлт дууриал parody

ЭЛЭГЛЭХ I. to lie or crawl on the belly, элэглэн хэвтэх to lie face down

ЭЛЭГЛЭХ II. 1. to ape, to imitate 2. (элэглэн хочлох, элэглэн шоолох) to mock, to make fun of

ЭЛЭГЛЭХ III. to face (the belly of a composite bow with horn)

ЭЛЭГЛЭХ IV. to be of the consistency of liver (тарар, etc.)

ЭЛЭГРҮҮЛЭХ to process тарар to the consistency of liver

ЭЛЭГРЭХ to be processed to the consistency of liver (тарар)

ЭЛЭГСЭГ (~ дотно) friendly, intimate, amiable, affectionate

ЭЛЭГСЭГЛЭХ to like, to be fond of

ЭЛЭГСЭХ to like, to be fond of

ЭЛЭГТЭЙ devoted to, keen on, well-disposed towards, § малд ~ малчин хүмүүс herdsmen devoted to their beasts

ЭЛЭГШИХ (see элэгсэх)

ЭЛЭНХИЙ worn-out

ЭЛЭНЦ: ~ өвөг (~ эцэг) great-grandfather, ~ хуланц forebears, ~ эмэг (~ эх) great-grandmother

ЭЛЭНЦЭГ 1. (see элэнц эцэг) 2. whatever, what the dickens, § элэнцгийн чинь чихэр вэ.

Чулуу байхгүй юу what the dickens do you mean, sugar? Stones more like it

ЭЛЭХ I. to wear out, to rub away (*intrans.*)

ЭЛЭХ II. to soar, to be wafted, элэн халих to soar, to be wafted; to pass away, to die

ЭЛЭЭ Kite, *Milvus*

ЭЛЭЭЛТ wear, erosion

ЭЛЭЭХ I. to wear out, to wear away, to erode, жил ~ (он ~ ) to go on from year to year, to let the years go by 2. to undergo, to experience

ЭЛЭЭ ХАЛАГ oh dear!, oh my goodness!

ЭМ I. (~ дом) medicine, ~ барих to doctor, to act as a doctor, ~ бичүүлэх to get a prescription, ~ бэлдмэл medicinal preparation, ~ залах to ask for medicine (from a lama, etc.), ~ засал medical treatment, ~ засалч medical man, doctor, ~ зүйч pharmacologist, ~ найруулагч pharmacist, ~ найруулах ухаан pharmacy, pharmaceuticals, ~ судлагч pharmacologist, ~ судлал pharmacology, ~ судлалын pharmacological, ~ тан (~ тариа) medicine, medications

ЭМ II. 1. (~ хүн) woman 2.i. female, ~ хонь ewe, ~ цэцэг female flower, ~ ямаа nanny goat ii. front (*ling.*), ~ үг word of the front vowel series, ~ эгшиг front vowel, vowel of the front vowel series

ЭМГЭГ I. sickness, ailment, ~ сорог defect, ~ төрүүлэгч pathogen 2. morbid, pathological, ~ анатоми morbid anatomy, ~ жам pathogenesis, ~ судлаач pathologist, ~ судлал pathology, ~ төрхтөн pervert, deviant, ~ төрхтэй perverted, deviant

ЭМГЭГЗҮЙ pathology

ЭМГЭГИЙН pathological, ~ хугарал pathological fracture, spontaneous fracture

ЭМГЭГЛҮҮЛЭХ to harm (someone's) health

ЭМГЭГЛЭХ to ail

ЭМГЭГШИЛ ailment

ЭМГЭГШҮҮЛЭХ (see эмгэглүүлэх)

ЭМГЭЛЖ I. shamanist effigy usually of felt

**ЭМГЭЛЖ II.** name of a hard knotty wood probably the Spindle Tree, *Euonymus*

**ЭМГЭН** old woman

**ЭМГЭН ТУУР** chestnut (*n.*) (horse)

**ЭМГЭН ХУМС** Snail

**ЭМГЭНШИЛБЭ** *Atraphaxis* (*bot.*), **Сөөгөн** ~ *A. frutescens*, **Шивүүрт** ~ *A. spinosa*

**ЭМГЭНЭЛ 1.** sorrow, grief, sadness **2.** (~ **гашуудал**) mourning, **эмгэнэлийн өдөр** day of mourning **3.** condolence, sympathy, ~ **илэрхийлэх** to express sympathy

**ЭМГЭНЭЛТ** tragic, sad, ~ **байдал** tragic situation, ~ **жүжиг** tragedy (theatre), ~ **явдал** tragic events, tragedy

**ЭМГЭНЭНГҮЙ** tragic

**ЭМГЭНЭХ** (**эмгэнэж гашуудах**) to mourn, to grieve

**ЭМГЭРЭХ** to get old (woman)

**ЭМГЭЭ** old woman, old lady

**ЭМЖИХ 1.** to hem, to trim (a dress, etc.) **2.** to edge, to border, to line, § **гудамж** ~ **цэцэрлэг** gardens bordering the streets **3.** to skirt, to go along by, § **голын эрэг эмжин** skirting the river bank

**ЭМЖЭЭР** border, edging, surround

**ЭМЖЭЭРЛЭХ** to surround with a border, to border

**ЭМЗҮЙ** pharmacology

**ЭМЗҮЙН** pharmacological

**ЭМЗЭГ 1.** (~ **нарийн**, ~ **онгон**, ~ **энхрий**) delicate, fragile, frail **2.** painful, sensitive to pain

**ЭМЗЭГЛҮҮЛЭХ** to irritate, to touch, to affect

**ЭМЗЭГЛЭЛ** tenderness, sensitivity, pain

**ЭМЗЭГЛЭЛТ** (see **эмзэглэл**)

**ЭМЗЭГЛЭХ 1.** to be sensitive, to be touchy, **сэтгэл** ~ to be upset, § **томчууд дэмий юмнаас эмзэглэдэг юм** grown-ups are touchy about little things **2.** to be tender

**ЭМЗЭГХЭН 1.** fragile **2.** sensitive

**ЭМЗЭГШИЛ 1.** sensitivity, sensitiveness **2.** susceptibility (to illness)

**ЭМЗЭГШИЛТЭЙ 1.** sensitive **2.** susceptible (to illness)

**ЭМЗЭГШИХ** to be sensitive

**ЭМИЙН** medicinal, ~ **аптек** medicine-chest, first-aid kit, ~ **бодис** medicaments, ~ **бэлдмэл** medicinal preparation, ~ **зүйл** medicinal substance, medicine, ~ **сан** pharmacy, chemist's; medicine-chest, first-aid kit, ~ **санч** pharmacist, chemist, ~ **ургамал** herb, medicinal plant

**ЭМЛЭХ I.** to treat (*med.*)

**ЭМЛЭХ II.**(эрийг ~) **1.** to bugger **2.** buggery

**ЭМНЭГ** (~ **догшин**, ~ **онгон**, ~ **хангал**) unbroken, untamed, wild, ~ **адуу** (~ **хангал морь**) unbroken horse, ~ **сургалт** horse-breaking, ~ **сургах** to break in a horse, ~ **тэмээ сургах** to break in a camel

**ЭМНЭГШИХ** to turn wild (a beast which has been broken-in), to run wild, to go back to a wild state

**ЭМНЭЛГИЙН** medical, ~ **газар** hospital, clinic, ~ **мэдээ** medical bulletin, ~ **спирт** surgical spirit, ~ **үзлэг** medical inspection, ~ **хуудас** sick-note, doctor's certificate

**ЭМНЭЛЗҮЙ** therapeutics

**ЭМНЭЛЗҮЙН** clinical

**ЭМНЭЛЭГ 1.** (**хүн** ~) medical treatment, treatment, medicine, **ардын** ~ folk medicine, **мал** ~ veterinary medicine **2.** hospital, **айргийн** ~ kumis sanatorium, **нэгдсэн** ~ polyclinic, **эмнэлэгт хэвтүүлэх** to admit to hospital, **эмнэлэгт хэвтэх** to go into hospital

**ЭМНЭХ** to treat (an illness, a person), **эмнэж домнох** to doctor

**ЭМС** women, **эмсийн хүрээлэн** brothel

**ЭМСГИЙ** gappy, lacking some teeth

**ЭМСГЭР** (see **эмсгий**)

**ЭМСЭХ** to want a female (animal)

**ЭМТ** medicated

**ЭМТГИЙ** (see **эмтэрхий**)

**ЭМТЛЭХ** to chip, to nick, to break off

**ЭМТРЭЛТ** chipping, nicking

**ЭМТРЭХ** to be chipped, to be nicked, to be broken off, **сэтгэл** ~ (**элэг** ~) to be deeply distressed, to be heartbroken

**ЭМТЭРХИЙ 1.** chip, nick **2.** chipped, nicked

**ЭМХ** (~ **дэглэм**, ~ **журам**) good order, order, system, ~ **замбараагүй** (~ **журамгүй**, ~ **замхгүй**) disorderly, нийтийн ~ **замбараагүй байдал** public disorder, public disturbance, ~ **замбараагүйтэл** disorder, ~ **замбараатай** in a regular manner, in an orderly manner, ~ **цэгц** good order, ~ **цэгцгүй** untidy, ~ **цэгцтэй** tidy, well-ordered, ~ **цэгцтэй болгох** to tidy up, to put in order

**ЭМХГҮЙ** chaotic, disorganized

**ЭМХЛЭХ** to arrange, to put in order, to put straight, to systematize, **эмхлэн байгуулах** to form, to arrange, to build up, to make up

**ЭМХРЭХ** to get right, to get into order

**ЭМХТГЭГЧ** compiler

- ЭМХТГЭЛ** collection, compilation
- ЭМХТГЭХ** (эмхтгэн нэгтгэх) to collect, to put together, to compile
- ЭМХТЭЙ** tidy, orderly
- ЭМХЭРДЭХ** to hem, to secure an edge
- ЭМХЭТГЭЛ** (see эмхтгэл)
- ЭМЧ** doctor, **бага** ~ assistant doctor, **малын бага** ~ veterinary assistant, **хүний бага** ~ assistant doctor, **бага эмчийн салбар** medical station with an assistant doctor, **гэрлийн** ~ radiologist, **зөвлөх** ~ consultant, **их** ~ fully qualified doctor, **малын их** ~ veterinary surgeon, **их эмчийн салбар** medical station with a fully qualified doctor, **малын** ~ vet, veterinary surgeon, **нарийн мэргэжлийн** ~ specialist, **нойрсуулагч** ~ anaesthetist, **өрхийн** ~ (өрх гэрийн ~) family doctor, GP, **хүүхдийн** ~ paediatrician, **эмэгтэйчүүдийн** ~ gynaecologist, ~ **домч** doctor, practitioner, medical man, **эмчид очих** to go to the doctor
- ЭМЧИЛГЭЭ** (~ үйлчилгээ) treatment, therapy, **ардын** ~ folk medicine, **өдрийн эмчилгээ** day care, **усны** ~ hydrotherapy, **химийн** ~ chemotherapy, **хөдөлгөөний** ~ kinesotherapy, **хөдөлмөр** ~ work-therapy, **цацраг** ~ radiotherapy, **цочир** ~ shock therapy, shock treatment, **эмийн бус** ~ drug-free treatment, ~ **авахгүй** untreatable, ~ **бичих** to prescribe treatment, ~ **зүй** therapeutics, ~ **сувилал** (~ **сувилгаа**) treatment and nursing, **эмчилгээний хоол** diet
- ЭМЧИЛГЭЭГҮЙ** untreatable
- ЭМЧИЛГЭЭТЭЙ** treatable
- ЭМЧИРХЭХ** to act as a quack, to pose as a doctor
- ЭМЧЛҮҮЛЭГЧ** patient (*n.*)
- ЭМЧЛҮҮЛЭХ** to get treated
- ЭМЧЛЭХ** (эмчилж сувилах, эмчлэн тордох, эмчлэн эдгэрүүлэх, эмчлэн эдгээх) to treat, to doctor, **эмчлэхүй ухаан** therapeutics
- ЭМШИХ** to become feminized
- ЭМЭГ ЭХ** grandmother, grandma, **өндөр эмэг** great-great-grandmother
- ЭМЭГТЭЙ** 1. woman, female, **эмэгтэйчүүд** women, **эмэгтэйчүүдийн өвчин судлал** gynaecology, **эмэгтэйчүүдийн эмч** (see эмч) 2. female (*adj.*), ~ **хүн** woman, ~ **хүний** women's
- ЭМЭГЧИН** female (animal)
- ЭМЭГ ЭЭЖ** (see эмэг эх)
- ЭМЭЭ** old woman, old lady, grandma, ~ **ээж** grandma

- ЭМЭЭЛ** saddle, **Боржгин** ~ Borjgin saddle (type of saddle used in central and southern Mongolia), **Самбуу** ~ Sambuu-saddle (type of saddle with high bows named after the maker), **эмээлээсээ өндөр даваа даваагүй эхнэрээсээ өөр хүн таниагүй** of limited horizons, inexperienced, **эмээлтэй хазаартай** saddled and bridled, **эмээлийн хонх** the hollow of a saddle-bow which fits the horse's back, **эмээлийн хэрэглэл** saddle-fittings
- ЭМЭЭЛГҮЙ** without a care in the world, with nothing to fear
- ЭМЭЭЛЛЭХ** to saddle, **морио** ~ to saddle one's horse
- ЭМЭЭЛЧИН** saddler
- ЭМЭЭНГҮЙ** anxious
- ЭМЭЭХ** to be afraid, to be fearful
- ЭН I.** very, most, ~ **түрүү** (~ **тэргүүнд**) first of all, at the very beginning, ~ **түрүүний** (~ **тэргүүний**) the very first, immediate
- ЭН II.** width, area, size, ~ **зэрэгцүүлэх ёс** parallelism (*lit.*), ~ **зэрэгцэх** to stand alongside, to be on a level with, **эн зэрэгцэхүйц** comparable, ~ **сацуу** (~ **тэнцүү**, ~ **чацуу**) equal in size, ~ **чацуурах** to be equal in size
- ЭН III.** edge, ~ **зах** edge, limits
- ЭНГИЙН** ordinary, simple, ~ **болох** to be demobilized; to be laicized (lama), ~ **даруу** simple, modest, unassuming, ~ **жирийн хүн** ordinary people, ~ **зүгээр** ordinarily, quietly, without fuss, ~ **ойлгомжтой** clear and simple, ~ **хувцастай** plain-clothes (*adj.*), ~ **хүн** civilian, ~ **хэрэг** ordinary matter, ~ **хялбар** simple, ~ **яриа** everyday language, ~ **ярилцах** to chat
- ЭНГИЙНШИХ** to be simplified
- ЭНГИЙНЭЭР** simply, § ~ **томьёолох юм бол** to put it in simple terms
- ЭНГҮЙ** 1. immeasurable, endless 2. extremely, exceedingly, ~ **сайн** extremely good, extremely well
- ЭНГҮҮН** (see энгийн)
- ЭНГЭР** 1. flap of a Mongol gown, lapel, ~ **задгай** (задгай ~ **заамтай**) open necked, low necked, ~ **задгайрах** to sleep around, ~ **зөрүүлэгч** bed-fellow, ~ **зөрүүлэх** to go to bed together, **энгэрээ мялаах** (энгэрээ цоолох) to get a medal, to wear a medal, **энгэрийн тэмдэг** badge, **энгэрийн хараа** the corner at the top of the flap of a gown, **энгэрийн цаг** pocket watch 2. the southern or eastern lower slopes of a hill
- ЭНГЭРЛЭГ** sloping to the south
- ЭНГЭРЛЭХ** to follow the southern or eastern slopes of a hill

**ЭНГЭСГЭДЭХ** to put on rouge, to put on make-up

**ЭНГЭСЭГ** rouge

**ЭНД** here, **танай** ~ at your place here, ~ **тэнд** here and there, ~ **тэндгүй** everywhere, all over the place

**ЭНДҮҮ** erroneous, mistaken, wrong, ~ **ташаа** erroneous, mistaken, ~ **ташаа зүйл** error, mistake

**ЭНДҮҮЛЭХ** to mislead

**ЭНДҮҮРЭЛ** error, mistake, slip

**ЭНДҮҮРЭЛГҮЙ** infallible

**ЭНДҮҮРЭЛТ** erroneous

**ЭНДҮҮРЭХ** **1.** to be mistaken, to make a mistake, to go wrong **2.** to mistake (for)

**ЭНДХИЙН** (see **эндэх II.**)

**ЭНДХИЙНХЭН** the people here

**ЭНДЭГДЭЛ** **1.** mistake, error, **эндэгдлээ хүлээх** to admit one's error **2.** death, mortality, **нялхсын** ~ infant mortality

**ЭНДЭГДЭХ** **1.** to make a mistake, to be mistaken **2.** to come to grief, to die

**ЭНДЭЛ** **1.** (~ **ташаарал**) mistake, error **2.** accident, **тэрэгний** ~ car accident

**ЭНДЭХ I.1.** to make a mistake, to be in error, to go wrong **2.** to come to grief, to die

**ЭНДЭХ II.** here, which is or are here, ~ **хүмүүс** the people here

**ЭНЕРГИ** energy (Russ.)

**ЭНИЙГ** (see **үүнийг**)

**ЭНТЭЙ** whole, big, great

**ЭНТЭЭ** this side, over here, ~ **тэртээ** this side and that

**ЭНҮҮГЭЭР** here, around here

**ЭНҮҮН** (an oblique stem of **энэ**), ~ **шиг** like this

**ЭНҮҮНИЙ** (see **үүний**)

**ЭНҮҮНТЭЙ** (see **үүнтэй**)

**ЭНҮҮХЭН** **1.** just here, not far, nearby, ~ **баруунтай** just to the west here **2.** just this

**ЭНҮҮХЭНД** **1.** just here, not far, nearby **2.** common, commonplace, usual, ordinary, **энүүхэндээ гэхэд** amongst ourselves, speaking privately

**ЭНҮҮХЭНТЭЙ** close by, not far

**ЭНХ** peace, tranquillity, well-being, ~ **амгалан** peace; peaceful, ~ **амгалан байдал** peace, state of peace, **энхийн гэрээ** peace treaty, **энхийн дайралт** (энхийн довтолгоо) peace offensive, ~ **жаргал** a board-game played on a board with 24 squares, each player having six counters, ~ **тайван** peace, ~ **тайвны бага**

**хурал** (энхийн бага хурал) peace conference, ~ **тайван байдал сэргээн тогтоох** to restore peace, ~ **тайвныг дэмжиж сахиулах хүчин** (~ **сахиулах хүчин**) peace-keeping force, ~ **тайвнаар зэрэгцэн орших зарчим** principle of peaceful co-existence, ~ **тайвны корпус** Peace Corps, ~ **тайвны хэрэг** the cause of peace, ~ **тайвныг эрхэмлэгч гадаа бодлого** peace-loving foreign policy, ~ **тайванч** peace-loving, ~ **талбиун** calm, peaceful, ~ **товшин** peace, ~ **туух** hale and hearty, ~ **туух цаг** a peaceful time, ~ **туух, эрүүл саруул** alive and well, ~ **цаг** peacetime

**ЭНХ АМГАЛАН** reign title of the emperor Kangxi

**ЭНХЖИН** lasting peace, **энхжингийн орон** paradise

**ЭНХЖИХ** to become peaceful, to become calm

**ЭНХРИЙ** **1.** (~ **хайрт**) dear, beloved **2.** tender, delicate

**ЭНХРИЙЛЭЛ** tenderness

**ЭНХРИЙЛЭХ** to cherish, to caress, to fondle, **энхрийлэн хайрлах** to love tenderly

**ЭНХЭЛ ДОНХОЛ** humps and hollows, uneven, rough

**ЭНХЭЛ ТУНХАЛ** (see **энхэл донхол**)

**ЭНХЭР** (see **энхрий**)

**ЭНХ ЭРДЭМТ** reign title of the emperor Kangde (1934-1945)

**ЭНХЭТ БЯЛЗУУХАЙ** Waxwing, *Bombycilla*, *B. garrulus*

**ЭНЭ** this, ~ **мэтчилэнгээр** like this, in this way, similarly, ~ **тэр гэж** and so on, ~ **хир** up to now, till today, by now

**ЭНЭЛЭЛ** (~ **шаналал**) distress, grief, suffering

**ЭНЭЛЭЛТ** distressed, unhappy

**ЭНЭЛЭХ** to be distressed, to be grieved, to be unhappy, **энэлж шаналах** to suffer

**ЭНЭМЭТЧИЛЭН** like this, this way

**ЭНЭНИЙ** (see **үүний**)

**ЭНЭНЭЭС** (see **үүнээс**)

**ЭНЭРЭЛ** kindness, compassion, mercy, **энэрэлийн тусламж** humanitarian aid

**ЭНЭРЭЛГҮЙ** merciless

**ЭНЭРЭЛТ** (see **энэрэлтэй**)

**ЭНЭРЭЛТЭЙ** **1.** kind, merciful **2.** pathetic

**ЭНЭРЭНГҮЙ** kind, sympathetic, compassionate, charitable, ~ **ёс** (~ **үзэл**) compassion, humanity, ~ **ёсны** humanitarian, ~ **үзэлтэн** humanist, ~ **үйлс** support

**ЭНЭРЭХ** to take pity (on), to show compassion (towards), to be sympathetic (to), to be kind (to), **энэрэн асрах** to look after, to take care of, **энэрэн туслах** to give kind help to

**ЭНЭТХЭГ** India, ~европ хэл Indo-European language

**ЭНЭТХЭГ-ХЯТАД** Indo-China, **Энэтхэг-хятадын хагас арал** Indo-Chinese peninsula

**ЭНЭТХЭГЧҮҮД** Indians (of India)

**ЭНЭХҮҮ** this, this very

**ЭНЭХЭН** just this, ~ **тэрхэн** this and that

**ЭНЭЧЛЭН** in this way, thus

**ЭР 1.** man, male, **сайн** ~ Robin Hood type robber or bandit, bold bandit, popular hero, **Хандгайн** ~ male elk, **эрд гарах** to get married (woman), **эрийг нас, уулыг цас дарна** age weighs down a man, snow weighs down a mountain, to feel one's age, ~ **нөхөр** husband, ~ **нэг энддэг эрэг нэг нурдаг** even Homer nods, ~ **охиноо үзэлцэх** to take (someone, each other) on, to have it out, ~ **өсөж эсгий сунадаг юм** time will tell, ~ **эм болж суух** to live as man and wife, ~ **эмийн** sexual, ~ **эмийн ёс** sexuality, ~ **эмийн ёсны үйлдэл** (~ **эмийн явдал**) sexual intercourse, ~ **эмийн ёсны хүмүүжил** sex education, ~ **эмийн харьцаа** sexual relations, ~ **эмийн холбоо тогтоох** to have a sexual relationship **2.** male, masculine, ~ **бие өсөх** to grow up, ~ **биесийн** (~ **бярын**) physical, bodily, ~ **биесийн хүч чадал** bodily strength, ~ **газар** hard ground, bare earth, ~ **зориг** courage, ~ **зоригтой** courageous, ~ **сувай** gelded and barren (livestock), ~ **сур** hard leather, tough leather, ~ **үг** word of the back vowel series, ~ **үхэр сааж элгэн тараг бүрэх** to attempt the impossible, ~ **хонгор дуу** sonorous voice, ~ **хүн арван гурван мэхтэй** there are more ways of killing a cat than choking it with cheese, ~ **хүний дотор эмээл хазаартай морь буй** to have big ideas, ~ **хүний замын хүзүү урт** a man has a long way to go, ~ **хүн санасандаа үрээ морь харайсандаа** (~ **морь зорисондоо** ~ **хүн хэлсэндээ**) to achieve one's purpose, to get there in the end, ~ **цэрэг** soldier, ~ **цэргийн алба** military service, ~ **цэцэг** male flower, **эрийн цээ** (~ **төөлүүрийн цээ**) maturity, man's estate, **эрийн цээнд хүрэх** (**эр цээлэх**) to reach man's estate, ~ **чадал** strength, power, ~ **эгшиг** back vowel, vowel of the back series **3.** manliness, ~ **муутай** feeble, effete

**ЭРВИЙХ** (**эрвийж сэргийх**) to stick out, to stick up, to be ragged, ~ **дэргийхээр** with might and main, with all one's strength, as hard as one

can

**ЭРВЭГНЭХ** to wriggle

**ЭРВЭГЭР** (~ **сэрвэгэр**) sticking out, sticking up, bristling

**ЭРВЭЛЗЭХ** (**эрвэлзэн дэрвэлзэх**) to be lively, to be sprightly, to be spry

**ЭРВЭН:** ~ **дэргэн нисэх** to flutter, ~ **сэрвэн** sticking out, rough, ragged

**ЭРВЭЭЛЖ 1.** saddle **2.** child's saddle

**ЭРВЭЭЛЖЛЭХ** to saddle

**ЭРВЭЭХЭЙ** Butterfly, **Бүгэг** ~ Owllet Moths, *Noctuidae*, **Заарт** ~ Goat Moth, *Cossus cossus*, **Заарт идэмхий** ~ Leopard Moth, *Zeuzera pyrina*, **Төөлүүрч** ~ Loopers, Stick Caterpillars, *Geometridae*, **Хүр** ~ Eggars, Lackeys, *Lasiocampidae*, **Цагаан** ~ *Pieridae*, **Байцайн цагаан** ~ Large White Butterfly, *P. brassicae*, **Долоогоны цагаан** ~ Black-veined White Butterfly, *Aporia crataegi*, **Манжингийн цагаан** ~ Small White Butterfly, *P. rapae*, ~ **нас** one's childhood days, ~ **хээ** "butterfly pattern"

**ЭРГҮНЭ** Argun River

**ЭРГҮҮ I.** (тэнэг ~, ~ тэнэг) stupid

**ЭРГҮҮ II.** (~ **өвчин**) the staggers

**ЭРГҮҮ БОР** Nightjar, *Caprimulgus europaeus*

**ЭРГҮҮЛ I.** patrol (person, activity), ~ **хийх** to go on patrol, **эргүүлийн хөнгөн хөлөг онгоц** patrol-boat, **эгүүлийн цагдаа** policeman on the beat

**ЭРГҮҮЛ II.** rack, stand

**ЭРГҮҮЛГЭН** turning, revolving, ~ **сандал** revolving chair, ~ **шат** spiral staircase

**ЭРГҮҮЛДЭХ** to importune, to harass

**ЭРГҮҮЛЭВЧ** winding gear

**ЭРГҮҮЛЭГ I.** thread, twist, turn, spiral

**ЭРГҮҮЛЭГ II.** windlass, winch

**ЭРГҮҮЛЭГ III.** swivel

**ЭРГҮҮЛЭГ IV.** whirlpool, vortex, eddy

**ЭРГҮҮЛЭГ V.** rack, stand

**ЭРГҮҮЛЭГ VI.** trochanter (*anat.*)

**ЭРГҮҮЛЭГ VII.** a cord helping to secure the roof-ring of the tent

**ЭРГҮҮЛЭГ VIII.** roundabout, merry-go-round

**ЭРГҮҮЛЭЛТ** turning, rotation

**ЭРГҮҮЛЭХ 1.** to turn, to turn round, to turn over to turn up, **архи дарс** ~ to have a drop or two, **морь** ~ (see **морь I.**), **хөрсийг** ~ to turn up the soil, **хүний толгойг** ~ to turn someone's head **2.** to return, to send back, to give back, to restore, **эргүүлэн авах** to get back, to recover, to take back, **эргүүлэн ашиглах** to re-cycle,

эргүүлэн сэргээх to rehabilitate (*med.*), эргүүлэн татах жуух бичиг letter of recall **3.** to round up, to turn back (livestock), to drive (gazelles) towards hunters **4.** хүүхэн ~ to make up to a girl **5.** to dial

ЭРГҮҮР knob, dial

ЭРГҮҮТЭХ **I.** to be foolish, to be silly

ЭРГҮҮТЭХ **II.** to get the staggers

ЭРГЭВЧ bearing (*mech.*), мөхлөгт ~ ball-bearing

ЭРГЭДЭХ (see эрэгдэх)

ЭРГЭЛ (~ мөргөл) worship

ЭРГЭЛДҮҮЛЭХ to turn, to rotate, нүдээ ~ to roll the eyes

ЭРГЭЛДҮҮР **1.** rotor **2.** (бортгоны ~) cylinder-block

ЭРГЭЛДЭГЧ rotating, rotary, revolving

ЭРГЭЛДЭХ **1.** to turn, to rotate, to revolve, to go around, to circle, ~ хөдөлгөөн rotary motion **2.** to be in turmoil (waves, etc.)

ЭРГЭЛЗМЭЭР doubtful

ЭРГЭЛЗЭЛ doubt

ЭРГЭЛЗЭЛТЭЙ doubtful

ЭРГЭЛЗЭНГҮЙ sceptical

ЭРГЭЛЗЭХ to doubt, to hesitate, to wonder

ЭРГЭЛЗЭЭ doubt, food for thought, ~ төрүүлэх to give rise to doubts

ЭРГЭЛЗЭЭГҮЙ without doubt, undoubted

ЭРГЭЛЗЭЭТЭЙ (see эргэлзэлтэй)

ЭРГЭЛТ **i.** turning, rotation, turn-around, дөрвөн цагийн ~ the passage of the four seasons, он жилийн эргэлтэд in the course of the years, тариалангийн ~ rotation of crops, ~ буцалтгүй irreversible, эргэлтийн радиус turning radius (*auto.*) **ii.** rounding up, driving (hunted gazelles) **2.** revolution (*mech.*), § минутад мянган ~ хийх to do a thousand revolutions a minute **3.** cycle (*mech.*, etc.), амьдралын ~ life-cycle **4.** change, revolutionary change, turn, coup (*polit.*, etc.), төрийн ~ coup d'état, цэргийн ~ military coup **5.** turn (*mech.*), § шураг бүрийг нэг бүрэн эргэлтээр суллана slacken off each screw one complete turn **6.** about-turn (*mil.*) **7.** circulation, цусны ~ circulation of the blood, цусны бага ~ pulmonary circulation, цусны их ~ systemic circulation, эргэлтэнд оруулах to put into circulation (currency, etc.) **8.** bend (*traf.*), замын огцом ~ sharp bend **9.** turnover, ачаа тээврийн ~ freight turnover, худалдаа ~ trade turnover **10.** i. visit, (doctor's) rounds **ii.** visit, sending in of gifts (to a prisoner, a patient), ~ орох to have a visit, ~ оруулах to visit, эргэлтийн цаг visiting hours **11.** circulation,

economic use, аж ахуйн эргэлтэд оруулах to put to economic use, эргэлтээс хасах to take out of use

ЭРГЭЛТГҮЙ irreversible

ЭРГЭЛТИЙН **1.** returnable, re-usable (packing), нэг ~ non-returnable, one-trip, ~ лонх returnable bottle **2.** ~ хөрөнгө working capital

ЭРГЭЛЧИН МӨРГӨЛЧИН pilgrim, worshipper, devotee

ЭРГЭЛЭГ turn, spiral

ЭРГЭМ around, about, § тавь эргэм насны нэг овгон an old fellow of around fifty years of age

ЭРГЭН ТОЙРОН **1.** around, all around **2.** surroundings

ЭРГЭНЭГ stand, rack, cupboard

ЭРГЭХ **1.** to turn, to go round, to rotate, to circle, сав ~ inversion of the uterus, ~ гэрэл дохио direction indicators (*auto.*), ~ дөрвөн улиралд season after season, all the year round, ~ дөрвөн цаг the returning seasons, ~ зам orbit, ~ замын жил astronomical year, эргэдэг тоглоом roundabout, merry-go-round, ~ хөдөлгөөн rotary motion, эргэж хөрвөх to toss and turn **2.** to turn round, баруун тийш хагас эрэг half right turn! (*mil.*), буцаж эргэх to return, to go back; to make a U-turn (*traf.*), буцаж эргэхийг хориглоно no U-turns, эргэж бодох (эргэж дурсах, эргэн санах, эргэн харах) to think back, to look back, to review, to recall, to take a look at, эргэж ирэх to come back, to return **3.** i. to visit (prisoner, patient, etc.) **ii.** to call on, to frequent, to haunt, to see

ЭРГЭЦ turnover, turnaround

ЭРГЭЦҮҮЛЭЛ consideration, thought

ЭРГЭЦҮҮЛЭХ (эргэцүүлэн бодох, эргэцүүлэн санах) to think over, to consider, to go over, to examine

ЭРГЭЦЭХ **1.** to hang around, to loiter, to keep going round **2.** to think things over, to have one's doubts

ЭРГЭШГҮЙ irreparable

ЭРДМИЙН academic, scientific, ~ зэрэг higher degree

ЭРДСИЙН mineral (*adj.*), ~ бордоо (see бордоо **2.**), ~ тос mineral oil, ~ ухаан mineralogy

ЭРДҮҮ **I.** dashing, spirited

ЭРДҮҮ **II.** alto (*mus.*)

ЭРДЭМ **1.** (~ боловсрол) education, learning, culture, ерөнхий ~ general education, ~ бичиггүй uneducated, ~ мэдлэг knowledge, learning, ~ ном learning, ~ номгүй un-



educated, ~ **номтой** educated, learned, ~ **соёл** culture, ~ **сурах** to study, ~ **шинжилгээ** research, ~ **шинжилгээний ажил** research work, ~ **шинжилгээний өгүүлэл** learned article, ~ **шинжилгээний хайгуул** scientific expedition, ~ **шинжилгээний хүмүүс** research workers **2.** skill, ability, art, **харвуулын** ~ the art of archery, ~ **ухаан** knowledge, skill, ~ **чадал** (~ **чадвар**) talent, ability

**ЭРДЭМТЭЙ** learned

**ЭРДЭМТЭН** scholar, learned man, **дэд** ~ (see **дэд**), ~ **мэргэд** scholars, learned men

**ЭРДЭНЭ** jewel, gem, precious thing, treasure, **долоон** ~ (see **долоо**), **есөн** ~ (see **ес**), **эрдэнэсийн сан** treasury, treasure-house, **эрдэнэсийн уран дархан** jeweller, **эрдэнийн чулуу** (эрдэнэсийн чулуу) precious stone, jewel, gem

**ЭРДЭНЭ ЗУУ** Erdene Zuu (lamasery near the site of Karakorum)

**ЭРДЭНЭ ЦАГААН** (see **Цагаан Түрүү**)

**ЭРДЭНЭТ** precious

**ЭРДЭНЭ ШИШ** Maize

**ЭРДЭС** mineral (*n., adj.*), **ааг** ~ accessory mineral, ~ **бодис** (~ **минерал**) mineral, minerals, ~ **бордоо** (see **бордоо 2.**), ~ **давсууд** mineral salts, ~ **судлал** mineralogy, ~ **судлалын** mineralogical, ~ **хөвөн** mineral wool

**ЭРДЭСЖИЛТ** mineralization

**ЭРДЭСЖИХ** to become mineralized

**ЭРДЭСЖСЭН** mineralized

**ЭРДЭСЛЭГ** mineral (*adj.*)

**ЭРДЭСТ** mineral (*adj.*), ~ **ус** mineral water

**ЭРДЭХ** to calculate on, to count on, to take advantage of, to make unscrupulous use of

**ЭРЖГЭР** rough, uneven

**ЭРЖИЙХ** to be rough, to be uneven

**ЭРЖИН** mother-of-pearl

**ЭРЗЭЭН** rubber (*Russ.*)

**ЭРИЙХ** to be lined up

**ЭРИН** (~ **зуу**, ~ **үе**) era, age, **атомын** ~ atomic age, **дундад төрмөл** ~ Mesozoic era, **манай эриний өмнө** before our era, **сансрын** ~ space age, **шинэ төрмөл** ~ Cainozoic era, **эртний төрмөл** ~ Palaeozoic era, ~ **үеийн** of the present era, contemporary, **эринийг эзэлсэн** epoch-making

**ЭРИХ** (see **эрх 1.**)

**ЭРЛИЙЗ** cross, cross-bred, hybrid, **нэгдүгээр**

**үеийн** ~ first generation hybrid, F<sub>1</sub> hybrid, ~ **хурлийз** hybrid, mongrel

**ЭРЛИЙЗЖИЛ** crossing, hybridization

**ЭРЛИЙЗЖИХ** to be hybridized

**ЭРЛИЙЗЖҮҮЛЭГ** crossing, hybridization

**ЭРЛИЙЗЖҮҮЛЭЛТ** (see **эрлийзжүүлэг**)

**ЭРЛИЙЗЖҮҮЛЭХ** to cross, to hybridize, **эрлийзжүүлж хурлийзжуулах** to make mongrels of

**ЭРЛИЙЗЛЭХ** to be neither one thing nor the other

**ЭРЛЭГ 1.** (~ **хаан**, ~ **номон хаан**) Erlig (the king of the underworld), **Эрлэгийн орон** the underworld, **Эрлэгийн очих** to die, ~ **рүү явуулах** to kill **2.** a demon of the underworld, **үхлийн** ~ (**Эрлэгийн элч**) angel of death **3.** enemy, bane

**ЭРЛЭГЭР** great big (eyes)

**ЭРМЭГ I.** (~ **зоримог**) manly, vigorous, bold

**ЭРМЭГ II. 1.** sterile **2.** barren

**ЭРМЭЛ** fossil, ~ **амьтан** fossil animal, ~ **ургамал** fossil plant

**ЭРМЭЛЗЛЭЛ** (see **эрмэлзэл**)

**ЭРМЭЛЗЭЛ** striving, aspiration, aim, bid, attempt

**ЭРМЭЛЗЭХ** to strive (to), to strive (for), to aspire (to), **ардын намын** ~ **арван зүйл** the Ten Aims of the People's Party (*hist.*)

**ЭРС I.** neutral (vowel, etc.)

**ЭРС II. 1.** straight, straight out, direct, resolute, decided, abrupt, sharp, ~ **тууштай** radical, resolute, ~ **тэс** severe, extreme, ~ **тэс уур амьсгал** (~ **тэс цаг уур**) extreme climate, ~ **харш** totally opposed, ~ **шийдэмгий** resolute, ~ **шулуун** directly, straight out, ~ **ялгаатай** completely different **2.** steep, vertical, § **туурганы эрсний тэн хагас хүртэл** half way up the side of the wall, **ханын эрстэй нь тэндүү** the height of the tent-wall, as high as the tent wall

**ЭРСДҮҮЛЭХ** to ruin, to destroy, to do for

**ЭРСДЭХ** to be ruined, to be lost, to be destroyed, to come to grief, to be done for, to lose one's life

**ЭРСЛЭХ** to be resolute, to be determined, to dare, **санаа** ~ to make up one's mind

**ЭРСТЭХ** (see **эрсдэх**)

**ЭРТ** early, ~ **балар** primitive, ~ **галбын** primaeval, ~ **дивангарын** ancient, antediluvian, ~ **дээр үеийн** (~ **урьдш**) ancient, old-time, ~ **дээр үес** (~ **цагаас**) from of old, ~ **орой хэзээ боловч** sometime, sooner or later, ~ **төрмөлийн** palaeozoic, ~ **ургацын** early (potatoes), ~ **урьд цагт** once upon a time, ~ **эдүүгээийн** (~ **өдгөөгийн**) past and present (*adj.*)

**ЭРТГЭР** sticking up, turned up, raised up

**ЭРТДЭХ** to be premature, to be too early

**ЭРТЖҮҮЛЭЛТ** bringing forward (seed potatoes), **тариалах төмсний** ~ bringing forward of seed potatoes

**ЭРТЖҮҮЛЭХ 1.** to make earlier **2.** to bring forward (seed potatoes, etc.)

**ЭРТЛЭХ** to be early, to start early, to get up early, **эртлэн босох** to get up early

**ЭРТНИЙ** ancient, archaic, ~ **балар цагийн** pre-maeval, ~ **бодис судлал** palaeontology, ~ **дэлхий дахины түүх** history of the ancient world, **эртнийг судлагч** archaeologist, ~ **судлал** archaeology, ~ **судлалын** archaeological, ~ **төрмөлийн** palaeozoic, ~ **үеийн түүх** ancient history,

**ЭРТНЭЭС** (~ **нааш**) from of old

**ЭРТСЭХ** to be early

**ЭРТҮҮД** (see **эртээр**)

**ЭРТҮҮР** (see **эртээр**)

**ЭРТҮҮРИЙН** (see **эртээрийн**)

**ЭРТХЭН** pretty soon, straightaway

**ЭРТЭЙ** manly, virile, capable, strong

**ЭРТЭСГЭХ** to advance (*trans.*)

**ЭРТЭЧ 1.** early rising **2.** early (potato, etc.)

**ЭРТЭЭДИЙН** recent

**ЭРТЭЭР** not long ago, some time ago

**ЭРТЭЭРИЙН** recent

**ЭРҮҮ I.** chin, jaw, **давхар эрүүтэй** double chinned, **доод** ~ lower jaw, **дээд** ~ upper jaw, **эрүүний доорх булчирхай** (see **булчирхай**), ~ **өвдөг нийлсэн** (~ **өвдгөө тулсан**) bent with age, long in the tooth, **эрүүний сахал** beard, ~ **хамхих** to shut up, to stop talking

**ЭРҮҮ II. 1.** torture, **есөн** ~ (**есөн** ~ **шүүлт**) the nine types of torture (*hist.*), ~ **тулгах** to torture, ~ **шүүлт** torture, interrogation under torture, ~ **шүүлт тулгах** to torture **2.** criminal case, criminal proceedings, ~ **үүсгэх** to bring criminal charges against

**ЭРҮҮВЧ** bib

**ЭРҮҮВЧЛЭХ** to tie under the chin, **малгай** ~ to tie one's hat under the chin

**ЭРҮҮГИЙН** criminal (*adj.*), ~ **алба** criminal investigation department, ~ **байцаан шийтгэх эрх** criminal procedure law, ~ **гэмт хэрэг** (~ **хэрэг**) crime, criminal offence, ~ **төлөөлөгч** criminal investigator, detective, ~ **хариуцлагад татах** (see **хариуцлага**), ~ **хууль** (~ **эрх**) criminal law, criminal code, ~ **хууль тогтоомж** criminal legislation, ~ **хэрэг** criminal case, ~ **хэргийн танхим** Criminal Division (of the Supreme Court), ~ **хэрэг үүсгэх** to take crimi-

nal proceedings, ~ **ял шийтгэл** criminal conviction

**ЭРҮҮДЭХ I.** to torture, to interrogate under torture

**ЭРҮҮДЭХ II.** to rest one's chin (on something)

**ЭРҮҮЛ 1.** (~ **мэнд**, ~ **энх**) health, ~ **ахуй** hygiene, ~ **ахуйн** healthy, hygienic, ~ **ахуйч** hygienist, ~ **мэндийн үзлэг** medical examination, check-up, **эрүүлийг хамгаалах ажил** health care, **эрүүлийг хамгаалах байгууллага** health service **2.** (~ **мэнд**, ~ **энх**) healthy, ~ **бие саруул ухаан** a healthy body and a healthy mind, ~ **бус** unhealthy; insane, ~ **саруул** healthy, in good health, sound, ~ **чийрэг** strong and healthy, ~ **энх элэг бүтэн** safe and sound **3.** virgin, ~ **газар** virgin soil **4.** sober, ~ **саруул** sober, sensible, sane, ~ **ухаан** good sense, sobriety, ~ **ухаантай** sensible, sober **5.** fresh, ~ **агаар** fresh air, ~ **салхи** fresh wind

**ЭРҮҮЛЖИХ 1.** to improve in health, to be restored to health **2.** to sober up (*intrans.*)

**ЭРҮҮЛЖҮҮЛЭХ 1.** to make healthy, to restore to health, **олон улсын харилцааг** ~ to normalize international relations **2.** to sober up (*trans.*), ~ **байр** (~ **газар**) sobering-up station

**ЭРҮҮЛЧ** detective, sleuth

**ЭРҮҮЛШИХ** (see **эрүүлжих**)

**ЭРХ I. 1.** rosary, ~ **татах** (~ **эргүүлэх**) to tell one's beads **2.** beads, counters (on an abacus, etc.)

**ЭРХ II.** (~ **танхи**, ~ **эмзэг**) spoiled, delicate, coddled, ~ **марзан** capricious, flighty,

**ЭРХ III. 1.** rights, power, authority, **төрийн** ~ state power, **хүний** ~ human rights, ~ **ашиг** interests, ~ **баригч нам** ruling party, ~ **баригчид** authorities, **эрхийн бичиг** permit, licence, authority; coupon, certificate (*fin.*), ~ **бүхий** competent, ~ **бүхий байгууллага** competent authority, ~ **дарх** privilege, prerogative, exemption, ~ **дархтай** privileged, entitled, ~ **дархтан** privileged person, ~ **дураараа** (~ **зоргоороо**) arbitrarily, wantonly, ~ **жаргал** happiness, ~ **мэдэл** competence, authority, ~ **мэдэлтэн** person in authority, boss, ~ **олгох** to empower, **эрхэндээ оруулах** to subordinate to oneself, to get (someone) into one's clutches, **эрхийг сурахаар бэрхийг сур** learn by working not by playing, ~ **сур** authority, **эрхийн тасалбар** permit, licence, ~ **тушаал** authority, position, ~ **тэгш** equality; on equal terms, **эрхийн үнэмлэх** (see **үнэмлэх 2.**), ~ **тэгш хэлэлцээр** equal treaty, ~ **үүрэг** rights and duties, **эрхийг хасах** to disqualify, ~ **хэмжээ** competence, rights, **эрхээ хэтрүүлэх** (~ **хэмжээгээ хэтрүүлэх**) to

- exceed one's authority, ~ **чөлөө** freedom, ~ **чөлөөнд дуртай** freedom-loving, ~ **чөлөөний төлөө тэмцэгч** freedom fighter, ~ **ямба** privileges, ~ **ямбатан** privileged person, high-up
- 2.** law, **иргэний эрх** civil law, **эрүүгийн** ~ criminal law, ~ **зүй** law, ~ **зүйн** legal, ~ **зүйн арга хэмжээ** legal steps, legal measures, ~ **зүйн байдал** legal status, ~ **зүйн шинжлэх ухаан** jurisprudence
- ЭРХБИШ** without fail, inevitably
- ЭРХГҮЙ 1.** without power to, not empowered to, not allowed to **2.** (**өөрийн** ~) involuntarily, in spite of oneself, perforce, willy-nilly
- ЭРХИЙ** (~ **хуруу**) thumb, ~ **мэргэн харваач** a skilled archer
- ЭРХИЙВЧ** archer's thumb-ring
- ЭРХИЙВЧЛЭХ** to take between the thumb and the first finger
- ЭРХИЙН** legal, ~ **туслалцаа** legal assistance, ~ **шинжлэх ухаан** jurisprudence
- ЭРХЛҮҮЛЭХ** to gratify, to spoil (a child), to let (a child) have its own way, **хэт** ~ to overindulge (a child), **эрхлүүлэн илбэх** to pet, to fondle
- ЭРХЛЭГЧ** chief, manager, director, person in charge, **самбарын** ~ score-keeper (archery), **сонины** ~ newspaper editor
- ЭРХЛЭНГҮЙ** coy, flirt
- ЭРХЛЭХ I.** to run, to manage, to deal with, to be in charge of, to engage in, **эрхэлсэн ажил** one's job, **эрхэлсэн ажилгүй** out of work, **эрхэлсэн тодорхой ажилгүй** with no concrete employment, **эрхлэн байгуулах** to set up, to establish, **эрхлэн гаргах** to issue, to publish, **эрхлэн удирдах** (**эрхлэн хөтлөх**) to run, to manage, **эрхлэн явуулах** to practise, to carry on
- ЭРХЛЭХ II.1.** (**эрхлэн тоглох**) to play, to play about **2.** to make up to, to fawn on, to be petted
- ЭРХТЭЙ** competent, entitled, empowered, authorized
- ЭРХТЭН I.** organ, limb, **дотор** ~ internal organs, **ургал** ~ (see **ургал**), **үржил** ~ (see **үржил**), **харах** ~ (see **харах I.1.**), **хоол боловсруулах** ~ digestive organs, **цул** ~ "solid" internal organs (heart, liver, spleen, lung, kidney, pericardium), **хөндий** ~ "hollow" internal organs (small and large intestines, gall-bladder, stomach, bladder, the three cavities), ~ **бүтэн** sound in limb, ~ **гажигтай хүүхэд** handicapped child, ~ **дутуу** maimed, crippled, disabled
- ЭРХТЭН II.** арван хоёр ~ the twelve branches or twelve animals used in reckoning time
- ЭРХТЭН ДАРХТАН** high-ups, aristocracy, privileged ones, nobles
- ЭРХҮҮ** Irkutsk (p.n.)
- ЭРХШИХ** to assert oneself, to gain power, **эрхшин дасах** to settle in, to make oneself at home
- ЭРХШЭЭЛ** domination, sway, hold, **бусдын эрхшээлд автагдах** to come under the domination of others
- ЭРХШЭЭЛТ** dependent
- ЭРХШЭЭХ** to dominate
- ЭРХЭМ I.1.** (~ **дээд**) honoured, respected, distinguished, noble, ~ **нандин** noble, sacred, ~ **уншигчид** dear readers, ~ **хүндтэй** honourable, ~ **хүндэт доктор** honorary doctor **2.** important, **эрхэмд үзэх** to value, to view as most important, ~ **чухал** essential, highly important
- ЭРХЭМ II.1.** gentleman, **энэ** ~ this gentleman **2.** sir, you sir, § **хүүе** ~ ээ I say, sir!
- ЭРХЭМЛЭЛ** respect
- ЭРХЭМЛЭХ I.** (**эрхэмлэн дээдлэх**, **эрхэмлэн хүндлэх**, **эрхэмлэж хүндэтгэх**) to honour, to respect, to esteem, to revere **2.** to put first, to prefer, to favour, **хувийн ашгийг** ~ to put private interests first
- ЭРХЭМНЭХ** (see **эрхэмлэх**)
- ЭРХЭМСЭГ I.** honourable, noble, venerable, ~ **ноён** His Excellency, Your Excellency **2.** affected, conceited
- ЭРХЭН** (see **эрхэм I.**)
- ЭРХЭНД** (see **эрхээр**)
- ЭРХЭС** (**тэнгэрийн** ~) heavenly body
- ЭРХЭХ I.** (**эрхэж дургүйцэх**) to feel put out
- ЭРХЭХ II.** to get worse, to get complicated (med.)
- ЭРХЭЭР** due to, because of the need to, needing to, in the course of, **амьдрах** ~ so as to get a living
- ЭРЧ I.** twist, turn, lay (of a rope), **давхар эрчтэй дээс** two-ply rope, ~ **харих** to unravel, to unlay (rope)
- ЭРЧ II.** (~ **хүч**) vigour, energy, intensity, **хар эрчээрээ явах** to go at full speed, to go full tilt, ~ **далайцтай** vigorous, energetic, ~ **мэдэн** full tilt, ~ **хүчээ авах** to gather momentum
- ЭРЧИЛМЭЛ** twisted
- ЭРЧИМ I.** twist, turn, lay (of a rope)
- ЭРЧИМ II.** vigour, energy, intensity, ~ **далайцтай** vigorous, ~ **хүч** energy, **дулааны** ~ **хүч** thermal energy, **нарны** ~ **хүч** solar energy, **сэргээгдэх** ~ **хүч** (**дахин сэргээгдэх** ~

хүч) renewable energy, ~ хүчний нөхөн сэргээгдэх эх үүсвэр renewable source of energy

**ЭРЧИМГҮЙ** sluggish

**ЭРЧИМЖИЛ** intensification

**ЭРЧИМЖИЛТ** (see **эрчимжил**)

**ЭРЧИМЖИХ** to be intensified, to be promoted vigorously

**ЭРЧИМЖСЭН** (see **эрчимт**)

**ЭРЧИМЖҮҮЛЭЛТ** intensification

**ЭРЧИМЖҮҮЛЭХ** to intensify, to promote, to stimulate, **эрчимжүүлэн хөгжүүлэх** to develop vigorously

**ЭРЧИМТ** intensive, vigorous, energetic, active ~ **эмчилгээний тасаг** intensive care unit

**ЭРЧИМТЭЙ** (see **эрчимт**), ~ **эмчилгээ** intensive care

**ЭРЧИС МӨРӨН** River Irtysh

**ЭРЧИТ** intensive

**ЭРЧЛҮҮР** (~ **дугуй**) flywheel

**ЭРЧЛЭХ I.1.** to twist (rope, etc.) **2.** to spin round, to whirl (dust, whirlwind, etc.)

**ЭРЧЛЭХ II.** to intensify, to become more intense

**ЭРЧЛЭХ III.** to reach man's estate

**ЭРЧЛЭЭС I.** twist, turn, lay (of a rope) **2.** thread

**ЭРЧҮҮД** men, males

**ЭРЧҮҮЛ** (see **эрчүүд**)

**ЭРШИХ I.** to become like a man **2.** virilism

**ЭРШҮҮД** resolute, determined

**ЭРЭВГЭР** (see **эрвэгэр**)

**ЭРЭГ I.** bank, shore, coast, ~ **орчмын** coastal, ~ **орчны улс** maritime state, ~ **хавийн** coastal, **эргийн хамгаалалтын алба** coastguard service, **эргийн шугам** coastline

**ЭРЭГ II.1.** screw, bolt, nut, **эрвээхэй** ~ butterfly nut, ~ **нь суларсан** rickety, shaky, ~ **шураг** screw, ~ **шураг нь хөдлөх** to have a screw loose, to be off one's rocker **2.** thread (mech.)

**ЭРЭГДЭХ I.** to screw, **эрэгдэж авах** to unscrew and take off, **эрэгдэж оруулах** (эрэгдэж суулгах) to screw in, **эрэгдэж таглах** to screw shut, **эрэгдэж тогтоох** to screw down **2.** to dial, **тоотыг** ~ to dial the number

**ЭРЭГЛЭХ** to form a bank

**ЭРЭГНЭГ** (see **эргэнэг**)

**ЭРЭГТЭЙ I.** man, male **2.** male (adj.), ~ **хүн** man, male

**ЭРЭГТЭЙЧҮҮД** men, males

**ЭРЭГЦҮҮЛЭХ** (see **эргэцүүлэх**)

**ЭРЭГЦЭГ** face, scarp (geog.)

**ЭРЭГЦЭХ** (see **эргэцэх**)

**ЭРЭГЧИН** male (animal), ~ **эмэгчнээ үзэх** (see **эр охиноо үзэлцэх**)

**ЭРЭЛ** (~ **сурал**) search, ~ **болох** (~ **хийх**) to go in search of, to seek, **эрлийг сургаар олох** to find out by asking, ~ **туршиц** experimentation, **эрлийн үзүүрт** at the end of the day, ~ **хайгуул** prospecting,

**ЭРЭЛТ** demand, ~ **нийлүүлэлт** supply and demand, ~ **хүсэлт** demand, request, wants, ~ **хэрэгцээ** demand, demands, needs, requirements, ~ **хэрэгцээтэй** in demand, ~ **шаардлага** demands, wishes

**ЭРЭЛХИЙЛЭХ** to look for, to be on the look-out for, to search for

**ЭРЭЛХЭГ** manly, virile, brave, ~ **баатарлаг** heroic, ~ **зориг** courage, ~ **зоригтой** courageous

**ЭРЭЛХЭХ** to lord it over

**ЭРЭЛЧ** seeker, searcher, ~ **нохой** tracker dog, ~ **хайгуулч** prospector

**ЭРЭЛЧИН** (see **эрэлч**)

**ЭРЭМБЭ** (~ **дараа**, ~ **дараалал**, ~ **дэс**) rank, order, precedence, sequence, **насны эрэмбээр** in order of age, ~ **дараагаар** (= **дараалан**) in order, in sequence, ~ **дараалалтай** (~ **дараатай**) methodical, systematic, in order, ~ **замбараа** order, good order (Tib. rim-pa)

**ЭРЭМБЭЛЭХ** to arrange in proper order

**ЭРЭМБЭТЭЙ** systematic, well-ordered, in order

**ЭРЭМГИЙ** intrepid, bold, daring

**ЭРЭМДЭГ** (~ **зэмдэг**, ~ **зэрэмдэг**) crippled, maimed, mutilated, invalid

**ЭРЭМДЭГЛЭХ** to cripple, to maim, to mutilate

**ЭРЭМЦЭЛТ** romantic

**ЭРЭМЦЭХ** to be devoted to, to be attached to, to be fond of

**ЭРЭМШИХ** to be arrogant, to lord it, to act with impunity, **эрэмшин даврах** to get above oneself, to be uppish

**ЭРЭНДЭЭ** Castor-oil plant

**ЭРЭХ I.1.** to search for, to look for, to seek, **эрж сураглах** (эрж сурах, эрэн сурвалжлах, эрэн сүвэгчлэх) to search for, to enquire about, **эрэн сурвалжлага** search, **эрж хайх** to search for, to prospect for, **эрэн шинжлэх** to search, to make a search **2.** to ask for, to request, **амрыг** ~ to greet, to ask after, **зөвшөөрөл** ~ to request permission

**ЭРЭХ II.** to twist, to wind

ЭРЭХ III. (see эрх I.)

ЭРЭЭ restraint, shame, эрээгээ алдах to be shameless, эрээгээ барсан shameless, ~ бараагүй (~ цэрээгүй, ~ цээргүй) frank, straight out, natural, unreserved

ЭРЭЭВЭР ХУРААВАР all sorts of, of all sorts and sizes, jumbled up

ЭРЭЭГОМБО *Rhodiola quadrifida* (bot.) (see also Мүгээ)

